Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд, Эдийн засаг хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, мөн хэлтсийн мэргэжилтэн Б.Амина нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, Б.Нандингэрэл, референт Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Мэдээллийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд, Эдийн засаг хөгжлийн сайд Ж.Энхбаяр танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, С.Эрдэнэбат, Ө.Шижир, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд, Эдийн засаг хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Б.Заяабал үг хэлэв.

Байнгын хорооны гишүүд Эдийн засгийн нөхцөл байдал болон үнийн өсөлтөөс сэргийлэх чиглэлээр авах арга хэмжээний талаар Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 18 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Ес.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, Б.Нандингэрэл, референт Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулах горимын санал гаргав.

Горимын саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг санал хэлэв.

Б.Заяабал: Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	14
Татгалзсан:	12
Бүгд:	26

53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэхийг хойшлуулав.

Байнгын хорооны хуралдаанаар 9 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 7 цаг 30 минут үргэлжилж, 32 гишүүнээс 26 гишүүн хүрэлцэн ирж, 81.3 хувийн ирцтэйгээр 18 цаг 57 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.ЗАЯАБАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхимд 11 цаг 27 минут

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Заяабал: Байнгын хорооныхоо эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая аа. Өнөөдрийн хуралдаанд ирсэн гишүүдээ танилцуулъя. Ринчиндоржийн Батболд гишүүн, Отгоншарын Батнайрамдал, Пүрэвийн Батчимэг, Хүрэлбаатарын Булгантуяа, Батжаргалын Заяабал, Мэндбаярын Мандхай, Загджавын Мэндсайхан, Баатаржавын Мөнхсоёл, Ганбатын Очирбат, Бадамдоржийн Пунсалмаа, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Ренчинбямбын Сэддорж, Агваанлуvsангийн Ундраа, Болдын Уянга, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Мөнхчулууны Энхцэцэг, Сүхбаатарын Эрдэнэбат, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Шинэбаярын Бямбасүрэн гишүүд хуралдаандаа хүрэлцэн ирсэн байна аа.

Хуралдааны байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 59.4 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2026 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Хуралдаандаа бүртгүүлсэн гишүүдийгээ хуралдааны танхимдаа хүрэлцэн ирэхийг урья. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хуралдааны тов дараалалд орсон дарааллын дагуу нэгд байнгын хорооны тогтоолын төсөл батална. Эндээ Монгол банкны тэргүүн дэд ерөнхийлөгчийн нэр дэвшигч ирсэн байгаа. Ингээд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төсөл эхний асуудлаар хэлэлцэнэ ээ.

1.Байнгын хорооны тогтоолын төсөл байнгын хороогоор 6 сард хэлэлцэх асуудлын цаглаварыг батлах тухай асуудлыг хэлэлцэнэ ээ.

3.Байнгын хорооны тогтоолын төсөл Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийг байгуулах тухай тогтоолын төслийг хэлэлцэнэ

4.Төрийн болон орон нутгийн өмчийн орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаарх анхны хэлэлцүүлгийг явуулна.

5.Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг зохион байгуулна.

6.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг мөн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг зохион байгуулна.

7.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг мөн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг зохион байгуулна.

8.“Чиглэл өгөх тухай” Их Хурлын 2025 оны 124 дүгээр тогтоолын биелэлтийг эрчимжүүлэх хүрээнд тогтоолд заасан арга хэмжээний хэрэгжилтийг хангах чиглэлээр хууль тогтоомжийн уялдаа холбоо, зөрчилтэй эрх зүйн зохицуулалтыг судалж санал дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн санал дүгнэлтийг танилцуулна.

9.Эдийн засгийн нөхцөл байдал болон үнийн өсөлтөөс сэргийлэх чиглэлээр авах арга хэмжээний талаарх Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг сонсох ийм 9 асуудлыг хэлэлцэхээр дараалалд оруулсан байгаа.

Ингээд хэлэлцэх асуудалдаа өөр саналтай гишүүд байвал нэрс авъя. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байхгүй байна.

Манай өнөөдрийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын 4 дүгээрт орсон энэ төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийг болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд дээр хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг маань одоо яг хуралдаж байгаа учраас байнгын хорооны хуралд бэлтгэл хангагдаагүй байгаа учраас энэ асуудлыг хойшлуулж, сүүлийн асуудал тийм түр хойшлуулъя гэсэн ийм саналтай байна аа.

Тэгээд Дэгийн тухай хуулийн байнгын хорооны даргын чиг үүрэг дээр байнгын хорооны хуралдааны бэлтгэлийг хангаж зохион байгуулах гэсэн ийм үндсэн үүрэгтэй байгаа. Тэгээд энэ үүргийн дагуу бэлтгэл нь хангагдаагүй учраас 4 дэх асуудлыг түр хойшлуулах саналыг оруулж байгаа юмаа гэдгийг бас нэмэлт мэдээлэл өгье өө.

Ингээд хэлэлцэх эсэх асуудлын эхний асуудлаа хэлэлцэж эхэлье ээ.

Нэг.“Нэр дэвшигчийн томилгооны сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Тогтоолын төслийг уншиж эхлэхээс өмнө манай байнгын хорооны эрхэм гишүүд маань байнгын хорооны хуралдаандаа хүрэлцэн ирэхийг урья.

Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг, 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1. Монгол банкны тэргүүн дэд ерөнхийлөгчид нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголыг 2026 оны 6 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2. Нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Монгол Улсын Их Хурлын гишүүн, ТББХ-ны дарга Болдын Жавхланг томилсугай.

3. Нэр дэвшигчээс асуух асуулт саналыг 2026 оны 6 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн хүлээн авахаар тогтоосугай.

4. Нэр дэвшигчийн сонсголын зарыг нийтэд мэдээлэх, сонсголын бэлтгэл хангах ажлыг холбогдох хууль журамд заасны дагуу зохион байгуулахыг Эдийн засгийн байнгын хороо Заяабалд даалгасугай. Эдийн засгийн байнгын хорооны дарга гэсэн ийм байнгын хорооны тогтоолын төсөл байна аа.

Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүдийн нэрсийг авъя аа. Гишүүд нэрсээ өгнө үү.

Эдийн засгийн гишүүд асуулт асуух, үг хэлэх гишүүд байна уу? гишүүд байхгүй байна. Одоо санал хураалт явуулж эхэлье. Байнгын хорооны гишүүдийг танхимдаа ирэхийг урья. Зэрэгцээд бас 2 ажлын хэсгийн хурал явагдаад байгаа учраас гишүүдийг урьж байна. Ингээд саяын уншсан томьёоллоор санал хураалтыг явуулна аа. Гишүүдийг санал хураалтдаа бэлдэхийг хүсье. Саналын томьёоллыг дахин уншъя аа.

Монгол банкны тэргүүн дэд ерөнхийлөгчийг нэр дэвшигч тэргүүн дэд ерөнхийлөгчид нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэдэг томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт бэлтгэгчхэв үү гишүүд, бэлтгэгчихсэн байна уу? Санал хураалт явуулъя.

Уг санал 71.4 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

11.44 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Хоёр. Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Дараагийн асуудал. Цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя аа.

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай 235 дугаар захирамжид заасан Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх цаглаварыг хавсралтаар баталсугай.

2.Хэлэлцэх хугацааг хуульд тусгайлан заасан асуудал болон бусад Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд энэ цаглавар хамаарахгүй ээ.

3.Энэ тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороонд хэлэлцэх асуудлын бэлтгэл хангах, мэргэжил арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газарт үүрэг болгосугай. Эдийн засгийн байнгын хороо гэсэн ийм тогтоолын төсөл байна аа.

Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүдийн нэрсийг авъя аа. Гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух, санал хэлэх гишүүд алга байна.

Санал хураалт явуулж эхэлье. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Саналын томъёоллыг уншиж танилцуулъя аа.

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

81 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг явуулж дууслаа.

11.49 цаг

Дараагийн асуудал.

Гурав “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье ээ. Тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя аа.

Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа нарын 19 гишүүнээс 2026 оны 5 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн

төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Батчимэг, Мандхай, Пунсалмаа, Уянгахишиг.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулж ажиллахыг ажлын хэсэгт зөвшөөрсүгэй. Эдийн засгийн байнгын хороо гэсэн ийм тогтоолын төсөл байна аа.

Уг тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү. Асуулт асуух гишүүд алга байна.

Санал хураалт явуулж эхэлье. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Саналын томъёоллыг уншиж танилцуулъя аа.

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

76.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоолын төсөл батлагдлаа.

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг явуулж дууслаа.

11.52 цаг

Дараагийн асуудал.

Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж эхэлье ээ. Ажлын хэсгийн гишүүдийг оруулъя.

Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйл дээр байнгын хорооны хуралдааны бэлтгэлийг хангаж зохион байгуулах ийм чиг үүрэг байгаа. Энэний дагуу яг одоо Ерөнхийлөгч дээр бас Засгийн газрын хэд хэдэн гишүүд дуудагдаж уулзалттай байгаа юм байна. Ийм учраас Бизнесийн эрх чөлөөний тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуулийг уулзалт дууссаны дараагаар үргэлжлүүлж явуулахаар түр хойшлуулъя.

Дөрөв.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд нарын 13 гишүүн 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Ингээд дараагийн асуудал болох Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Хууль санаачлагч Соронзонболд гишүүнийг урьж байна. Соронзонболд гишүүн байна уу? Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчийн илтгэлийг Монгол

Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн танилцуулна аа. Соронзонболд гишүүний микрофоныг нээе.

Л.Соронзонболд: Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, тэгш шударга хүртээхэд чиглэнэ гэж 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын иргэн нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй байхаар заасан.

Үндсэн хуульд заасан төрийн нийтийн өмч газрын хэвлийн баялаг болох газрын тос байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийг улсын төсөв, үндэсний баялгийн төрөлжсөн сангууд, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан газрын тосны ашиглалтын нөлөөлөлд өртөж буй тухайн бүс, аймаг, сумдын төсөвт хуваарилах, мөн газрын тос, байгалийн хий олборлох, боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмшлийн хувьд ногдох ногдол ашгийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулаагүй байна аа.

Иймд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Газрын тосны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт заасан нөөц ашигласны төлбөрийн 30 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, 70 хувийг улсын төсөвт тус тус төвлөрүүлнэ гэснийг газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, тэгш шударгаар хүртээхэд чиглэнэ гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчимд нийцүүлж, хуулийн төслийг дараах байдлаар боловсрууллаа.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр 31.3 дахь хэсэгт хэсгийг нөөц ашигласны төлбөрийг улсын төсөвт 25 хувь, Үндэсний баялгийн төрөлжсөн санд 35 хувь, орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд 10 хувь, Тухайн тусгай зөвшөөрлийн талбай байрлах Бүсийн хөгжлийн санд 10 хувь, Тухайн тусгай зөвшөөрлийн талбай байрлах аймаг, нийслэлийн төсөвт 10 хувь, тухайн тусгай зөвшөөрлийн талбай байрлах сум, дүүргийн төсөвт 10 хувь тус тус хуваарилахаар зохицуулсан хуулийн төслийг боловсруулсан бөгөөд дагалдах хуулийн төслөөр дараах 4 хуулийн төслийг боловсруулсан.

Дагалдах хуулийн төслийн агуулгыг хуулийн төрөл тус бүрээр тодорхойлбол 1 дүгээрт, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 4 зүйлтэй байхаар боловсруулсан.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд үндэсний баялгийн төрөлжсөн санд газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийг төвлөрүүлэх болон газрын тос, байгалийн хий олборлох, боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувь, ногдол ашгийн хувь хэмжээг дараах байдлаар нэмэхээр тусгасан. Ирээдүй өв санд газрын тос байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 25 хувь, хуримтлалын санд Газрын тос байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувь, Газрын тос байгалийн хийн олборлох боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувь 34 хувь хүртэлх бол

түүний төрийн эзэмшилд ногдох бүх ногдол ашиг. Газрын тос, байгалийн хий олборлох, боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувь 34 хувь ба түүнээс дээш бол түүний төрийн эзэмшлийн хувь 34 хувьд ногдох ногдол ашгийн, хуулийн төслийн 2 дугаар зүйлд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12.4 дэх хэсгийн уул уурхайн олборлолт, 12.6 дахь хэсгийн уул уурхайн олборлолт гэсний дараа газрын тос, байгалийн хий гэдгийг нэмэлтээр тусгаж өөрчлөн найруулахаар боловсруулсан.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.3 дахь заалтыг өөрчлөн найруулсан. Хөгжлийн санд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ашигтай гарсан тохиолдолд гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ тухайн жилийн төсөвт тооцон тэнцвэржүүлсэн үнээс өндөр байснаас нэмэгдэж орох төсвийн орлогын 50 хувь, газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувиас тус тус бүрдэхээр тусгасан.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд энэхүү хуулийн төслийн хүчин төгөлдөр болох журмын зохицуулалтыг тусгасан болно оо.

2.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 3 зүйлтэй байхаар дараах байдлаар боловсруулсан.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд Төсвийн тухай хуулийн холбогдох заалтад дараах агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмэх асуудлыг тусгасан. Үүнд:

1 дүгээрт төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд Бүсийн хөгжлийн сан гэсэн тодорхойлолтыг нэмж, энэхүү сангийн эх үүсвэрийн асуудлыг 59 дүгээр зүйлийн 59.10 дахь хэсгээр зохицуулахаар.

2.Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 6 дугаар хэсэг аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын орлогод хамаарах орлогод газрын тос, байгалийн хий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг харьяалах сумын төсөвт тухайн аймгийн нутаг дэвсгэрээс төвлөрүүлсэн газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 10 хувийг гэж.

3.Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 8 дугаар хэсэг сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын орлогод газрын тос, байгалийн хий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг харьяалах сумын төсөвт тухайн сумын нутаг дэвсгэрээс төвлөрүүлсэн газрын тос, байгалийн хий ашигласны төлбөрийн орлогын 10 хувь байхаар тус тус нэмсэн болно оо.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл. Төсвийн тухай хуулийн 23.4.11, 59.1.5, 59.5 дахь хэсгүүдийг дараах байдлаар өөрчлөн найруулахаар тусгасан. Үүнд:

Төсвийн тухай хуулийн 23.4.13 дахь заалт Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 70 хувь гэснийг хуулийн төсөлд газрын тос байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн 25 хувь гэж, Төсвийн хуулийн 59.1.5 дахь заалт газрын тос нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь гэснийг хуулийн төсөлд газрын тос байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 10 хувь гэж, Төсвийн тухай хуулийн 59.5 дахь хэсэг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн

хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлалыг Засгийн газар батална гэснийг хуулийн төсөлд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, Бүсийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлалыг Засгийн газар батална гэж тус тус өөрчлөхөөр боловсруулсан.

3.Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 3 зүйлтэйгээр оруулж байна аа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд бүс тус бүр бүс орон нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, бүс нутгийн чанартай болон бүсийн хэлэлцээрээр тохиролцон тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн төсөл арга хэмжээг санхүүжүүлэх зорилготой Бүсийн хөгжлийн сантай байх хуулийн зохицуулалтыг тусгасан бөгөөд 2 дугаар зүйлд энэ хуулийг Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгасан болно оо.

4.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2 зүйлтэй байхаар боловсруулсан.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд газрын тосноос гадна байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг Татварын ерөнхий хуульд тусгаагүй байсныг нэмж зохицуулсан бөгөөд 2 дугаар зүйлээр энэхүү хуулийн хүчин төгөлдөр болох асуудлыг тусгасан болно оо.

Дээрх байдлаар газрын хэвлийн баялаг болох газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийг үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан, уул уурхайн олборлолтын улмаас сөрөг нөлөөлөлд өртөж буй ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайг харьяалах бүс, аймаг, сумын төсөвт хэрхэн хуваарилах болон газрын тос, байгалийн хий олборлох, боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд төрийн өмч эзэмшлийн ногдол ашгийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх харилцааны эрх зүйн үндсийг бий болгосноор байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш шударга хүртээхэд чиглэнэ гэсэн Монгол Улсын үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан суурь зарчимд нийцэж байгаа болно оо.

Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Та бүхэн энэ Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжиж өгнө үү. Баярлалаа.

Б.Заяабал: Баярлалаа. Хуулийн төсөл санаачлагчдыг бас уншиж танилцуулъя аа. Уг хуулийн төслийг нийт 13 гишүүн санаачилсан байгаа. Соронзонболд гишүүн, Бадамсүрэн гишүүн, Бямбасүрэн гишүүн, Г.Ганбаатар гишүүн, Ганхүлэг гишүүн, Дэлгэрсайхан гишүүн, Идэрбат гишүүн, Мөнхбаясгалан гишүүн, Мөнхбат гишүүн, Наранбаатар гишүүн, Отгонбаяр гишүүн, Сэддорж гишүүн, Эрдэнэбүрэн гэсэн нийт 13 гишүүний гишүүн уг хуулийн төслийг санаачилж өргөн барьсан байгаа.

Ингээд хууль санаачлагчдаас ирүүлсэн ажлын хэсгийн гишүүнийг танилцуулъя. Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны БХЗГ-ын дарга. За баярлалаа.

Хуулийн төслийн талаар хууль санаачлагчдаас асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя аа. Гишүүд нэрсээ өгнө үү? Анар гишүүнээр тасалъя. Батнайрамдал гишүүний микрофон нээе.

О.Батнайрамдал: Та бүхэндээ өглөөний мэнд хүргэе ээ. Хэд хэдэн асуултууд байна аа. Яах вэ ер нь байгалийн баялгийг тухайн орон нутагт нь бас илүү өгөөжтэй байх энэ чиг хандлагыг дэмжинэ ээ. Ер нь тэгж байж бас орон нутагт байгаа иргэд илүү бас өгөөж авах ёстой. Гэхдээ энэ хууль дээр бас хэд хэдэн зүйлүүд байна л даа. Одоо 1 дүгээрт, бүсийн хөгжлийн сан гээд дахиад нэг шинэ сан байгуулах болчихлоо. Бид нар чинь орон нутгийн уул нь орон нутаг хөгжлийн нэгдсэн сан байгаа тиймээ. Тэгэхээр дахиад бүсийн хөгжлийн сан гээд одоо газрын тостой аймгуудын зүүн 3, 4 аймаг хамаарах уу тиймээ. Тэгэхээр одоо бусад бүсүүд дээр гээд л энэ чинь дахиад буцаад нэгдсэн төсвийн бодлого энэ дээр яг яаж уялдахыг нь сайн харахгүй байна л даа. Тэгээд бид нарт дахиад нэмэлт сан байгуулах үнэндээ хэрэг байгаа юм уу. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаараа хуваарилалтууд нь явж болохгүй юм уу гэсэн нэг асуулт байгаа юм.

2 дугаарт, энэ бас дахиад баялгийн сангийн дахин хуваарилалтыг энэ дээр хийх өөрчлөлтүүд орж ирээд байна л даа. Тэгэхээр ер нь том зургаараа газрын хэвлийн баялаг гэж байгаа. Энэ дотор газрын тос орно, зэс орно, алт орно, ер нь газрын хэвлийд олдож байгаа Монголын баялаг. Тэгэхээр энэний хуваарилалтыг бол нэгдсэн бодлогоор бид нар ер нь хийх ёстой л доо. Энэ дээр яг Баялгийн сангийн тухай хууль байгаа. Тэгэхээр зөвхөн газрын тос дээр нь нэг тусгай хуваарилалт яваад, бүсийн хөгжлийн сан байгуулаад тэгээд бусад аймгууд дээр тэгэхээр одоо яана гэсэн үг вэ? Бусад бүсүүд дээр.

3 дугаарт энэ чинь бас төсөв рүү шууд нөлөө үзүүлнэ л дээ. Энэ дээр тэгэхээр төсөв рүү үзүүлэх тийм нөлөө судалгаа тооцоон дээр та нар юу гэж энэ дээр харсан юм бол оо? Улсын төсөв дээр 25, баялгийн сан дээр 35, орон нутгийн хөгжлийн сан дээр 10 дахиад бүсийн хөгжлийн сан гэж шинэ сан байгуулаад тийшээгээ 10, аймаг руу 10, сум руу ингээд 10 гээд хуваарилчхаж байгаа юм л даа. Тэгэхээр уул нь яг иймэрхүү баялгийн санд орж байгаа төсвийн томоохон хуваарилалтууд дээр нэгдсэн бодлого баймаар байна л даа. Яг Засгийн газар энэ дээр юу гэж бодож байгаа юм. Яг ямар хуваарилалтыг явна гэж харж байгаа юм. За тэгээд баялгийн сан дээр бид нар энэ Үндсэн хуулийн 6.2-ын хуваарилалт бас ямар хэлбэрээр явах юм. Тэрнээс биш газрын тос дээр нэг тусдаа баялгийн сангийн тухай хуулийн зохицуулалт, зэс, алтан дээр тусдаа зохицуулалт гэж ер нь байхгүй шүү дээ. Газрын хэвлийн баялаг бол газрын тос нь байна уу, алт нь байна уу, зэс нь бүгд газрын хэвлийн баялаг байхгүй юу. Үндсэн хуулийн 6.2-роо зохицуулагдах ёстой ард түмний өмч юм байгаа юм. Тэгэхээр энэ дээр тодорхой хариултаа аваад нэмж тодруулъя аа.

Б.Заяабал: Хууль санаачлагч Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: За энэ эхлээд энэ төсөвт үзүүлэх нөлөөний талаар эхлээд ярьаа. Тэгэхээр энэ нөгөө хуваарилалтыг хийхдээ газрын тосны нөөц ашигласны төлбөрөөс хуваарилалт хийх гэж байгаа гэдгийг бас анхааруулж хэлмээр байна.

Одоогийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс бол Үндэсний баялгийн сан руу хуваарилж байгаа. Газрын тосны нөөц ашигласны төлбөрийг бол Үндэсний баялгийн санд хуваарилахгүй байгаа асуудлыг, мөн байгалийн хийг хуваарилахгүй байгааг Үндэсний баялгийн санд хуваарилъя, хуваарилдаг болъё оо гэдэг ийм асуудал яригдаж байгаа.

Дээрээс нь болохоор ерөнхийдөө одоогийн байдлаар яах вэ Газрын тосны нөөц ашиглалын төлбөр төлж байгаа орлого маань ойролцоогоор жилдээ нэг 30-40 тэрбум төгрөгийн хооронд байдаг юм байна. Тэгэхээр одоо газрын тосны талбайн үйл ажиллагаа явагдаж байгаа сумын төсөвт бол 3 тэрбум төгрөг хуваарилагдана гэсэн одоогийн байдлаар гэсэн үг шүү дээ ойролцоогоор. Аймагт нь 3 тэрбум төгрөг, бүсийн хөгжлийн санд 3 тэрбум төгрөг. Тэгээд орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд 3 тэрбум төгрөг хуваарилагдаад үлдсэн нь болохоор улсын төсөв рүү 25 хувь нь, үлдсэн нь болохоор үндэсний баялгаасаа хуваарилагдана гэсэн ийм томъёоллоор саналыг бэлдсэн гэдгийг та бүхэнд хэлье.

Тэгээд газрын хэвлийн баялгийн хуваарилалт зөвхөн газрын тосны тусдаа явах нь зөв үү гэдэг асуудал. Угаасаа яах вэ АМНАТ-тай холбоотой асуудал маань орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас бол явж байгаа. Тэгэхээр энэ дээр бол энэ газрын тосыг зөвхөн одоо ингэснээрээ зүүн бүсийн аймгуудад давуу тал бий болох гээд байгаа юм уу гэдэг асуудал яригдаж байна. Тэгэхээр энэ дээр бол ямар асуудал байдаг вэ гэхээр ер нь манай зүүн бүсийн ялангуяа энэ газрын тосны олборлолт, хайгуул хийхтэй холбоотой асуудлууд дээр, сумдууд дээр яг нөгөө тухайн сум орон нутагт нь бас ийм үр өгөөж нь харагдахгүй байдаг учраас сумын ард иргэд бас нэлээн эсэргүүцэлтэй байдаг аа. Гэтэл Монгол Улс маань бол одоо газрын тосны үйлдвэрээ барьж байдаг, бензин шатахууныхаа 50 хувийг өөрсдөө дотоодоосоо хангадаг болъё гэж зорилт тавьж байгаа. Энэ ажлыг биелүүлэхэд бол бас энэ хуулийн өөрчлөлт маань нэлээн том хөшүүрэг болж өгнө гэж үзэж байгаа учраас энэ саналыг оруулсан гэдгийг хэлье. Тэгээд Бадамсүрэн гишүүн бас дээрээс нь нэмээд саяын асуултууд дээр нэмэх зүйл байвал хэлчихмээр байна.

Б.Заяабал: Хууль санаачлагч ажлын хэсгээс нэмэх үү? Бадамсүрэн гишүүний микрофоныг нээе.

М.Бадамсүрэн: Ер нь цаашдаа бүсчилсэн хөгжлийг дэмжихийн тулд тодорхой ийм зохицуулалтыг хийх зайлшгүй шаардлага байгаа гэж үзэж байгаа.

2 дугаарт нь, Үндэсний баялгийн санд ерөөсөө хөрөнгө энэ газрын тос байгалийн хийгээс орохгүй байгаа. Харин өнгөрсөн онд энэ цацраг идэвхт ашигт малтмалаас АМНАТ-ийн төлбөрөөс оруулдаг болох ийм хууль зохицуулалт оруулсан. Өмнө нь бол хатуу ашигт малтмалаас ордог байсан. Тэгэхээр энэ Үндэсний баялгийн сангаас энэ нэг ч төгрөг эндээс авахгүй. Харин энэ газрын тосны нөөцийн төлбөр, байгалийн нөөцийн төлбөрөөс Үндэсний баялгийн санд нэмж оруулдаг болж байгаа. Өөрөөр хэлбэл энэ салбар нь орхигдчихоод байгаа юм. Хатуу ашигт малтмал болон цацраг идэвхт гэдэг нь Үндэсний баялгийн санд оруулдаг, нөгөө үлдсэн шингэн байгалийн хийн ашигт малтмал нь энд хамрагдахгүй байгаа. Ийм учраас энийг бол зохицуулахыг зорьсон байгаа гэдгийг Батнайрамдал гишүүнд хариулъя. Баярлалаа.

Б.Заяабал: Энэ Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн холбогдох заалтыг би уншиж өгье өө гэж бодож байна. 35 дугаар зүйл дээр байнгын хорооны

хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулах тухай бүлэг байгаа. Энэний 35.8.6-д гишүүд хууль санаачлагчаас асуулт асуух ийм дэгтэй юм байна аа. Энэ хүрээндээ хууль санаачлагчийн зүгээс ажлын хэсэгт гэж нэр өгсөн ажлын хэсгийн гишүүдээс асуулт асуух ийм дэгтэй юм байна гэдгийг танилцуулъя. Батнайрамдал гишүүний микрофон.

О.Батнайрамдал: Тэгэхээр Бадамсүрэн гишүүн ээ, би тантай санал нэг байна. Нөөц ашигласны төлбөр газрын тосон дээр нөөц ашигласны төлбөр гэж байгаа. Бусад нь бол АМНАТ бид нар АМНАТ гэж ярьдаг. Яагаад гэх юм бол энэ Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулаад газрын тос нь болохоороо Газрын тосны тухай хуулиар зохицуулагддаг тиймээ. Тэгэхээр энэ концептууд бүгдээрээ нэг нэгдэх хэрэгтэй байна аа. Бүгдээрээ адилхан АМНАТ л гэсэн үг байхгүй юу. Бүгдээрээ адилхан АМНАТ. Тэгэхээр одоо Ашигт малтмалын тухай хууль дээр ч гэсэн орон нутгийн хөгжлийн сан руу илүү хуваарилалт орно гээд ороод ирж байгаа юм. Тэгэхээр энэ концептууд одоо та бүхний энэ газрын тосны нөөц ашигласны төлбөрийг хуваарилах концепт эд нар бүгдээрээ нэгдэх ёстой байхгүй юу. Нэгдсэн бодлоготой байх ёстой. Энэ буцаад баялгийн сантайгаа зөв уялдах ёстой. Үүгээрээ дамжаад хамгийн гол нь том утгаараа энэ Баялгийн сангийн тэр үндсэн хуулийн 6.2 нь хамтдаа ажиллаж байх ёстой юм. Тэгэхээр ингэхэд тэр дахиад л Бүсийн хөгжлийн сан гэж шинэ сан яг яагаад байгуулах гээд байгаа юм бэ. Шаардлага байгаа юм уу л гээд асуугаад байгаа юм л даа.

Тэгээд энэ хуваарилалт 25, 35, 10, 10 гэсэн хуваарилалт яг ямар үндэслэлтэй...

Б.Заяабал: Хууль санаачлагчаас хариулах уу? Соронзонболд гишүүний микрофон нээж өгье.

Л.Соронзонболд: Энэ газрын тосны нөөц ашигласны төлбөр, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 2 адилхан ойлголттой гэдэгтэй би бол Батнайрамдал гишүүнтэй санал нэг байна аа. Гэхдээ өнөөдрийн яг хуулийн өнөөдрийн зохицуулалтаар болохоор чинь Үндэсний баялгийн санд зөвхөн АМНАТ нь л орж байгаа шүү дээ гэдгийг л түрүүн тайлбарлаж хэлсэн тийм ээ. Тэгээд дараагийн асуудал юу байна вэ гэхээр энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу бид нар чинь зүүн бүсийг гэхэд жишээлбэл тэргүүлэх чиглэл нь түүхэн аялал жуулчлал тиймээ, эрчимжсэн МАА байна гээд заачихсан. Тэгсэн мөртөө яг энэ чиглэлээрээ тодорхой ажлууд хийх гэхээр яг аль аймгийнх нь тодорхой төсвөөс гарах нь тодорхойгүй байдаг. Тийм учраас бүсчилсэн хөгжлийн хүрээнд бүсийн аймгууд нь ярилцаад манай тэргүүлэх чиглэл ийм байна аа. Тэгэхээр энэ чиглэлийн хөрөнгө оруулалтууд ийм чиглэлийн юмнууд хийхэд энэ сангаас гаргадаг байх зохицуулалттай байхаар бодож энэ саналыг гаргасан гэдгийг хэлмээр байна.

2 дугаарт болохоор энэ тухайн сумдад очиж байгаа хувилбар...

Б.Заяабал: Тайлбараа бүрэн өгье. Нэг минут нэмж өгье. Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Яах вэ бид бол бүгдээрээ мэдэж байгаа. Манай ялангуяа энэ говийн бүсийн нэлээн хэдэн сумдын одоо төсвийн орлого бол жишээлбэл зарим сумынх жилийн 100 тэрбум төгрөг байдаг. Жилийн 200 тэрбум төгрөгийн ч төсөвтэй сум байна. Гэтэл зарим аймгийн маань төсвийн хэмжээ нэг 20-30 тэрбум төгрөгтэй

байдаг. Гэтэл одоо яг уул уурхайн энэ газрын тос олборлоод хайгуул хийх ажиллагааг явагдаж байгаа тухайн сум, аймгийнх нь төсөв нь бас ингээд хангалттай байхгүй байгаад байгаа юмаа. Тийм учраас бол энэ суманд нь 10 хувь, тэр аймагт нь 10 хувь гэдэг энэ саналуудыг оруулж ирж байгаа юмаа гэж хэлэх гэсэн юм.

Б.Заяабал: Баярлалаа. Уянга гишүүний микрофон нээе.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе ээ. Сая яг Батнайрамдал гишүүний асуусан асуултаас л хөгжүүлээд асуучихъя. Бүсийн хөгжлийн сантай холбоотой. Тэгээд Бүсийн хөгжлийн сан гэж байгуулж байгаа гол шалтгааныг нь таны сая тайлбараас Үндэсний баялгийн санд яг энэ газрын тосны төлбөр ордоггүй юмаа гэсэн хариулт байх шиг байна л даа. Үндэсний баялгийн сандаа харин энэ газрын тосны төлбөрийнхөө тодорхой хувийг оруулдаг болчихвол яадаг юм. Тэгээд тэнчээнээсээ зарцуулалт нь хийгдээд явдаг байвал давхар давхар өөр олон сан үүсэхгүй байх юм биш үү гэсэн асуулт байна. Тэгээд Засгийн газраас яг ямар санал ирсэн бэ танай хууль дээр. Тэрийгээ бас яг одоо хэлээд өгөөрэй тэгээд тодруулъя.

Б.Заяабал: Хууль санаачлагч Соронзонболд гишүүний микрофон нээе.

Л.Соронзонболд: Тэгэхээр юун дээр Бүсчилсэн хөгжлийн сан гэдэг саналыг оруулсан тийм үү. Тэгэхээр одоо бид нар чинь өнөөдөр хэлэлцэх эсэхээ ярьж байгаа. Хэрвээ одоо энийг хэлэлцэх эсэх нь дэмжигдээд, ажлын хэсэг байгуулагдах юм бол энэ бүсчилсэн хөгжлийн санг үндэсний баялгийн сангаар орлуулах тэр боломжийг нь ажлын хэсгийг хэлэлцэх явцдаа шийдэх ч боломж нээлттэй байгаа л гэж харж байгаа юм.

Дээрээс нь болохоор Үндэсний баялгийн санд бол бид нар чинь 35 хувийг нь хуваарилъя гэдэг ийм санал оруулчихаад байгаа шүү дээ тиймээ юун дээр төсөл дээрээ бол. Тэгээд Үндэсний баялгийн сангаас дараагаар нь нөгөө түрүүний ярьсан нэг зорилго байсан шүү дээ. Бүсчилсэн хөгжлийн сан руу яагаад оруулаад байгаа юм бэ гээд. Бүсийг одоо тэргүүлэх чиглэлийн гол гол томоохон хөрөнгө оруулалттай холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд энэхүү сангаас зарцуулах боломж нь бий болох үүднээс тийм шинэ сан шинээр бий болгоё оо гэдэг ийм санал гаргасан. Хэрвээ үнэхээр Үндэсний баялгийн сангийн зарцуулалт дотроос тодорхой хэмжээнд бүсийн тэргүүлэх чиглэл рүү зарцуулах боломжтой байхаар тооцоолоод хэрвээ өөрчилж болно оо гэвэл тэгж бас тэр нь бол нээлттэй байя л гэж хэлмээр байна.

Б.Заяабал: Засгийн газрын саналтай холбоотой асуудлаар нэмэлт тайлбар гэж байна. Ажлын хэсгийн 6 дугаар микрофон нээе.

Ч.Хишигдалай: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны зүгээс бол хуулийн төслийг бол дэмжсэн санал явуулсан. Яагаад вэ гэвэл яг өнөөдөр газрын тосны олборлолт ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа Дорнод аймаг, Дорноговь аймагт газрын тосны салбараас ирж байгаа өгөөж нь бол бодитоор одоо ялангуяа төрийн захиргааны байгууллага орон нутагт бол харагдахгүй байна аа. Тиймээс энэ орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуримтлуулж байгаа мөнгөнөөс тодорхой хувийг нь тухайн аймаг сумын төсөвт зарцуулдаг болооч ээ гэдэг санал хүсэлтийг бол олон жилийн туршид тавьж ирж байсан. Энэ иргэдийн болон орон нутгийн захиргааны байгууллагын хүсэлтээр дөрөөлж газрын тосны салбарыг эсэргүүцсэн маш олон юу гэдэг юм орон нутагт

төрийн бус байгууллагууд иргэдийн хөдөлгөөнүүд бий болсон. Тэгэхээр тухайн аймаг, сумын төсөвт суугдаж байгаа мөнгө нь тодорхой болж өгвөл бас ард иргэд өгөөжийг нь ойлгоод энэ салбарын хөгжил, газрын тосны хайгуул, ашиглалтыг цаашдаа...

Б.Заяабал: Баярлалаа. Ундраа гишүүний микрофоныг нээе.

А.Ундраа: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. 2 асуулт байна. Нэгдүгээрх нь ер нь Газрын тосны хуульд өөрчлөлт оруулж байгаа. Тэгээд тэр утгаараа нөгөө Газрын тосны хуулийн шинэчилсэн найруулга билүү нэмэлт, өөрчлөлт хэлэлцэж байх үед өмнө нь дагалдах бүтээгдэхүүн жишээлэхэд нүүрсний орд олборлож байгаа үед нүүрсний давхаргын метан хий олдоод тэр хийгээ олборлож эхлээд тэр нь дагалдах бүтээгдэхүүн байдлаар тэгээд прогрессив рояалти авах уу эсвэл бүтээгдэхүүн хуваах гэрээ хийх үү гэдэг иймэрхүү үл ойлголцох юм уу, тодорхойгүй байдал үүсээд, тэрийг зохицуулалт хийгдэж байсан.

Тэгэхээр одоо нүүрсний давхаргын метан хий ашиглах тухай энэ ярьж эхэлж байгаа энэ цаг үед энэ асуудлыг энэ хуульд тусгасан уу зарчмын хувьд. Нөгөө талдаа яах вэ занар, занарын хий, занарын тос гээд бусад газрын тосны бүтээгдэхүүнүүдийг ашиглах талаар бас энэ дээр тусгасан байх нь газрын тосны үнэ тодорхой хэмжээнд очихоор эдийн засгийн хувьд үр өгөөжтэй болно зарим ордууд. Тэгээд тэр ашиглалтыг нээх бололцоо гарах гэж харагдаад байгаа юм. Тэгээд энэ дээр тийм үг өгүүлбэр алга л даа. Тэгэхээр далд энэ цаанаа ойлгогдох байдлаар давхар явж байгаа юм болов уу л гэж би тааж байна. Тэгэхээр тэгээд нэмэлт тайлбар Засгийн газраас сонсмоор байна.

2 дугаар асуулт бол энэ бүсийн хөгжлийн сан гэж шинээр томъёолол гаргаж ирж байгааг бол зарчмын хувьд дэмжиж байна аа. Тэгэхээр тухайн орон нутагт үр өгөөж нь мэдрэгдэж байж сая одоо орон нутгийн ард иргэдийн хувьд байгалийн баялаг ашиглахад бол зохистой юм байна аа. Энэ амьдралд нь үр өгөөж нь ирж байна аа гэдгээ ингэж тодорхой харах бололцоо үүснэ. Тэгэхдээ засаглалын асуудал их чухал байгаад байгаа. Бид маш олон төрлийн сан байгуулдаг. Сангийн ашиглалт дээр ил тод бус байдлаас болоод тэр сангийн нэр хүнд унах тиймээ, эс үгүй бол цаана нь авлигал албан тушаалтай холбоотой хэрэг гарах зохисгүй зарцуулалт гарах ийм явдал маш их байгаа л даа. Тэгэхээр бүсийн хөгжлийн сангийн засаглалыг яаж харж байна. Энэ бол зөвхөн орон нутгийн удирдлагууд байх юм уу, тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүд нь өөрсдөө засаглал дотроо сонгуульт байдлаар бие даасан ийм гишүүдийг төлөөлж оруулах юм уу, ард иргэдээс төлөөлөл байх юм уу, тайлагнал нь яаж явах юм. Энэ дээр хууль санаачлагчийн зүгээс асуумаар байна аа.

Б.Заяабал: Хууль санаачлагч Бадамсүрэн гишүүн, дараа нь нэмээд ажлын хэсэг бэлдэж байгаарай. Бадамсүрэн гишүүний микрофоныг нээе.

М.Бадамсүрэн: Ундраа гишүүний асуултад хариулъя аа. Газрын тосны тухай хуулиар байгалийн хийн асуудлыг бас зохицуулсан байгаа. Уламжлалт ба уламжлалт бус газрын тос гэж ангилсан байгаа. Тэгэхээр байгалийн хийтэй холбоотой зохицуулалтууд энд орсон байгаа гэдгийг танд хэлэх нь зүйтэй. Энэ нөгөө нэг хуулийн хүрээнд явж байгаа учраас.

2 дугаарт нь Бүсчилсэн хөгжлийн санг заавал байгуулах шаардлагагүй ч байж болно. Гол нь нөгөө энэ чинь манайх цаашдаа бүсчилсэн хөгжлийг гол удирдлага болгоно оо гэж байгаа. Тэгэхээр тухайлбал Өмнөговь аймгийн тухайд гэхэд зөвхөн л Өмнөговь аймагт энэ хуваарилагдах биш Дорноговь, Дундговь, Говьсүмбэр гээд энэ аймгуудтай зөвхөн Дорнод аймагт биш Хэнтий, Сүхбаатартаа хуваарилагддаг, яагаад гэвэл бид цаашдаа ер нь бүсчилсэн бодлогоор л хөгжье гэж зорьж байгаа учраас тэгээд энэ нь одоо зүйтэй юм уу гэж хууль санаачлагчид хамтарч боловсруулсан. Тэгээд энэ дээр нэг онцлох зүйл нь зүүн бүсээс сонгогдсон Улсын Их Хурлын 6 гишүүн, говийн бүсээс сонгогдсон 7 гишүүн, 13 гишүүн хамтарч энэ хуулийн төслийг боловсруулсан. Яагаад гэвэл түүхий эдийн нөөц нь зүүн бүс нутагт байгаа мөртөө үйлдвэр нь говийн бүсэд байгаа.

Тэгэхээр цаашдаа ер нь зөвхөн бүс дотроо биш, аймаг дотроо биш, сум дотроо биш ийм бүс дамнасан ийм томоохон эдийн засгийн үйл ажиллагааг хамтарч бид ер нь санаачилъя. Харилцан ашигтай байх зарчим руу оруулъя гэж бодож нэг шинэ ийм ололт болсон болов уу гэж манай бас говийн бүс, зүүн бүсийн гишүүд үзэж байгаа гэдгийг энд онцолж хэлье.

Сангийн хувьд бол бүсчилсэн хөгжлийн санг ажиллуулах журмыг Засгийн газар батална гэж бид нар энэ хуулийн төсөл дээрээ тусгасан байгаа. Ер нь аль болох уул нь журмаар зохицуулахгүй байхыг зорьж байгаа. Гэхдээ сая гэхэд нэг сан байгуулагдсан Засгийн газрын тусгай сангийн тухай хууль дээр. Энэ бол өөрөө нөгөө эдийн засгийн хувьд илүү том. Өөрөөр хэлбэл газрын тосны үйлдвэрээ түүхий эдээр хангах гэдэг ийм урт хугацааны эдийн засгийн аюулгүй байдлын том бодлого явж байгаа учраас энийг цогцоор нь авч үзэхийг л бид нар зорьсон гэсэн үг. Өөрөөр хэлбэл бүсийн сан гэдэг нь энэ утга агуулга руугаа явна. Тэгээд энэ бол Засгийн газрын дэргэд байх сан. Энэ орон нутгийн орон нутагт байх сан биш. Одоо орон нутгийн хөгжлийн сан гэдэг нэг том уут байгаа. Энд ашигт малтмалын нөөцийн төлбөрийн орлогын жилдээ нэг 4-6 их наяд төгрөг орж байна. Нэг 400-аас 600 тэрбум төгрөг буюу 10 хувь нь хуримтлагдаад энийгээ 21 аймаг нийслэлдээ яг тэнцүү шахам хуваагаад байгаа юм. Тэгэхээр нөгөө уул уурхайн нөлөөлөлд өртөж байгаа бүс нутагт нь арай илүү хуваарилахад гэдэг энэ зарчмыг илүү бид нар энэ дээр ийм нарийвчилж оруулж өгөхийг л зорьсон байгаад байгаа юм.

Мөн Хөгжлийн сан бол огт хөрөнгөгүй байгаад байгаа. Яагаад гэвэл хөгжлийн сан төсөв ашигтай гарсан тохиолдолд мөнгө хуримтлуулъя гэж байгаа. Энэ дээр бид нар энэ газрын тосны нөөц ашигласны төлбөрийн байгалийн нөөцийн төлбөрийн орлогын 5 хувь нь орохоор өөрөөр хэлбэл хөгжлийн санг мөнгөтэй болгох. Энэ хөгжлийн сан нь тухайн бүс нутгийн болон улс орны хэмжээний томоохон түвшний дэд бүтэц хөгжлийн төслүүдийг санхүүжүүлэхээр ийм баялгийн сангийн хууль дээр заасан боловч энэ ерөөсөө амилахгүй байгаа. Өөрөөр хэлбэл энэ хөгжлийн санд огт мөнгө байхгүй. Хуримтлалын санд энэ төрийн өмчит газрын тосны үйлдвэр цаашдаа төрийн өмчит ийм газрын тосны олборлолтын компани байгуулагдах юм бол энэний орлогынх нь төрийн өмчид ноогдох орлогынх нь ноогдол ашиг нь энэ рүү ордог байхаар зохицуулсан байгаа.

Өөрөөр хэлбэл нүүрс хатуу ашигт малтмалын салбар дээр Эрдэнэс Монголоор дамжуулж энэ хуримтлалын санд хөрөнгө төвлөрч байна. Энэ жилдээ нэг 500 орчим тэрбум төгрөг. Энийг ипотекийн зээлийн эх үүсвэрт зарцуулж явж байгааг манай байнгын хорооны гишүүд бас мэдэж байгаа. Тэгэхээр ийм эдийн засгийн агуулгаар нь илүү ийм нөгөө баялгийн сангаа илүү ийм тэтгэдэг сан болгох.

Энэ нь бол газрын тосны ч бай, байгалийн ийм бай, хатуу ашигт малтмал, цацраг идэвхт бүгдэнгээс нь үндсэн хуулийн 6.2 заалтын дагуу оруулъя гэдэг ийм суурь ингээд бүх талаас нь харж энэ Газрын тосны хууль дагалдуулж Үндэсний баялгийн сангийн хууль, Төсвийн тухай хуулийг боловсруулсан байгаа гэдэг онцлогийг бас та бүхэндээ тайлбарлая аа. Баярлалаа.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 6 дугаар микрофоныг нэмж тайлбар өгье.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэрийн Эрдэс баялгийн яам Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. Газрын тосны тухай хууль дээр орж байгаа нэмэлт өөрчлөлтөөр бол газрын уламжлалт бус газрын тос, байгалийн хий, нүүрсний давхаргын метан хий, занар бүгд энэ нөөц ашигласны төлбөрийг хэрхэн хуваарилах асуудал дээр бол хамрагдаад явж байгаа. Харин Төсвийн тухай хууль дээр бол тодруулж өгөх шаардлагатай байх аа. Энийг ажлын хэсгээрээ шийдээд явах боломжтой байх гэж бүүр тодруулж өгвөл.

Б.Заяабал: Баярлалаа. Булгантуяа гишүүний микрофоныг нээе.

Х.Булгантуяа: Би нэг ийм хэдэн асуулт асуух гэсэн юм. 1 дүгээрт, энэ Засгийн газрын санал ерөөсөө байхгүй байгаад байна. Ди парламент дээр ч тэр, ирүүлсэн материал дээр ч гэсэн тэр. Орж ирж байгаа ер нь энэ ашигт малтмал, газрын тос ч бай энүүний хуваарилалт дээр ямар нэг өөрчлөлт оруулах гэж байгаа бол тэр тусмаа Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яамны санал бол их чухал байх аа гэж би бодож байна. Тэгэхээр энэ Засгийн газраас Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яамнаас ямар санал ирсэн юм бэ? 1 дүгээрт. Газрын тосон дээр хэрвээ ингээд хийчих юм бол миний бодлоор бусад олон дээр олон юмнууд дээр бас аягүй бол баялаг дээр ийм хуваарилалтууд хийх санал санаачилга дараагийн гишүүдээс гарах байх. Тэгэхээр үүн дээр Засгийн газрын байр суурь 1 дүгээрт ямар байна вэ гэдгийг.

2 дугаарт ер нь яах вэ энэ газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах ийм хэрэгцээ шаардлага байгаа юу гэвэл байгаа. Тэгээд энүүнийг уг нь манай Улсын Их Хурлын гишүүдээр ингэж хэлэхээс илүүтэйгээр би Уул уурхай, аж үйлдвэрийн яамыг өнөөдрийг болтол энүүн дээр нэг жоохон санал санаачлагчтай байж болдоггүй байсан юм уу? Тун удахгүй наад газрын тосны үйлдвэр чинь ашиглалтад орох гээд байдаг. Газрын тосны түүхий тосны эх үүсвэр хангалттай биш байгааг та бүхэн өөрснөө мэдэж байгаа. Тэгээд энэ чинь Оросоос бид нар түүхий тос импортолж бараг оруулж ирэх хэмжээнд хүрэх гээд байна аа гэж үйлдвэрийнх нь захирал хүн өөрөө тэгж ярьж байна лээ шүү дээ. Тэгэхээр энүүнийхээ хайгуул энэ тэрийг нэмэгдүүлэх тал дээр уг нь газрын тосны асуудлыг нэг нийгмийн анхаарлын төвд оруулж байгаа бол хэлэлцэж байгаа бол энэ хуулиа хамтад нь өргөн бариад энэ тэр хэлэлцэх боломж бололцоо байхгүй юм уу?

Одоо ахиад тун удахгүй Петро Чайнатай байгуулсан төсөлтэй холбоотой бас асуудал Эдийн засаг, хөгжлийн яамнаас оруулж ирэх юм шиг байна лээ. Тэгэхээр ер нь нэг ийм газрын тосны асуудлыг авч хэлэлцэх цаг болсон уу гэвэл болсон. Танай яамнаас энэ газрын тосны хуультай холбоотой ялангуяа хайгуул олборлолтыг нэмэгдүүлэхтэй холбоотой эрх зүйн орчны шинэчлэлийг хэзээ хийх гэж байна вэ гэдэг ийм 2 асуултыг асуух гэсэн юм.

Бүсийн хөгжлийн сан бол хэрэгтэй байж магадгүй ээ. Яагаад гэвэл энэ зөвхөн тухайн аймагт нь үлдэнэ гэхээр одоо нэг зовлон манай Дундговь аймаг болчихоод

байгаа юм. Байгалийн баялгийг нь бүс говийн бүсэд гээд тэгж байхад Дорноговь аймаг, Өмнөговь аймаг маш их баялагтай. Орон нутгийн хөгжлийн сан нь их улсын төсөвт төвлөрүүлдэг аймгууд байдаг. Гэтэл Дундговь аймаг ингээд Говьсүмбэр аймаг гээд яг тэг дунд нь байдаг бараа ачаа тээвэрлэлтийг нь хийдэг, зам нь дандаа эвдэрдэг тэгсэн мөртөө хөгжил нь аягүй хүнд ийм аймгууд энэнээс ингээд хоцорч үлдээд байдаг. Тэгэхээр бүсийн хөгжлийн сан нь магадгүй байх ёстой бол байх ёстой байх. Гэхдээ үүнийг маш их зөв эхнээс нь томъёолж оруулж ирэх. Эдийн засаг хөгжлийн яаман дээр бас энүүнийг юу гэж харсан юм бол оо? Тэгээд би Эдийн засгийн байнгын хорооны дарга аа. Энэ асуудлыг хэлэлцэж байхад ийм том татварын хуваарилалтуудыг хэлэлцэж байхад яагаад Эдийн засаг хөгжлийн яамнаас, Сангийн яамнаас хүн байхгүй байгаа юм.

Б.Заяабал: Хууль санаачлагчаас хариулаад явъя. Бадамсүрэн гишүүний микрофон, дараа нь нэмэлтээр Соронзонболд гишүүний микрофон.

М.Бадамсүрэн: Газрын тос бол технологийн хувьд ингээд ер нь зөвхөн дамжуулах хоолойгоор тээвэрлэж байж л түүхий тосыг тээвэрлэж үйлдвэрт авчирч байж эдийн засгийн хувьд үр ашигтай. Тэгэхээр бол гадаадаас ингээд вагон тос хэрнээ газрын тосыг тээвэрлээд ирээд энэ үйлдвэртээ боловсруулаад тэгээд эдийн засгийн хувьд өрсөлдөнө, ашигтай байна гэдэгт бол би мэргэжлийн хүний хувьд энэнд итгэхгүй байгаа. Тэгэхээр дотоодын түүхий эдээр хангах бодлого нь л өөрөө хамгийн чухал бодлого болж байгаа юм. Тийм учраас би Булгантуяа гишүүнтэй санал нэг байгаа нь ер нь энэ асуудлыг цогцоор нь ингээд авч үзэх хэрэгтэй. Яах вэ энэ нөгөө зүүн бүс, говийн бүс 2 талд нефть олборлож байгаа. Дээр нь зүүн бүсэд хамгийн их олборлолт 95 хувь нь явагдаж байна. Говийн бүсэд 5 хувь нь. Үйлдвэр нь говийн бүсэд байгаа. Тэгэхээр энэ бүсийн гишүүд санал нэгдсэн гэдгийг би түрүүн хэлээд байгаа. 13 гишүүн санал нэгдээд бид бас энэ сонгогдсон гишүүнийхээ хувьд бүс нутгийн энэ ирээдүйд үүсэх энэ үйлдвэрийг ажиллуулах, ажлын байр гаргах, дотоодын түүхий эдээ зөв зохистой ашиглах гээд энэ зүйл дээр их санаа зов зовж байна л гэсэн үг.

Засгийн газраас санал ирсэн байгаа. Тэрийг манай Соронзонболд гишүүн танилцуулах байх.

Б.Заяабал: Соронзонболд гишүүний микрофоныг нээе.

Л.Соронзонболд: Засгийн газраас бол Засгийн газар бол 2026 оны 3 дугаар сарын 4-ний өдрийнхөө 8 дугаар хуралдааны тэмдэглэлээр саналаа ирүүлсэн. Энд бол ерөнхийдөө ингээд 4 санал ирсэн байгаа. 1 дүгээрт бол газрын тос байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс шууд хуваарилах нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтад заасан төсвийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ үндэсний баялгийн хүн ам, нийгмийн бүлэг болон өнөө ба хойч үеийнхэндээ шударга тэнцвэртэй хуваарилах зарчимтай нийцэхгүй байх бөгөөд орлогын дийлэнх хэсэг ашигт малтмал газрын тос олборлож байгаа цөөн тооны аймаг сумдад ноогдох орлогын тэгш бус хуваарилалт үүсэх үр дагавартай байна. Иймд газрын тос байгалийн хийн нөөц төлбөрийн орлогыг улсын хэмжээнд бүс нутаг, иргэн бүрд тэгш хүртээмжтэй хуваарилах зарчмыг баримтлан орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаар дамжуулан тухайн аймгийн төсөвт хуваарилах нь зүйтэй.

2.Газрын тосны тухай хуулийн төсөлд нөөц ашигласны төлбөрийн 35 хувийг Үндэсний баялгийн санд, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд газрын тос байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 25-ыг ирээдүй санд тус тус хуваарилахаар тусгасныг Монгол Улсын Үндсэн хуулийн...

Б.Заяабал: Соронзонболд гишүүний микрофоныг нэг минутаар нэмж өгье.

Л.Соронзонболд: Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж одоо ба ирээдүйн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, тэгш шударга хүртээхэд чиглэнэ гэж заасантай нийцүүлэх.

3 дугаарт, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Бүсчилсэн хөгжлийн удирдлагыг зохицуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан Бүсийн хөгжлийн сан нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28 дахь заалтад заасан орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн зохистой байдлыг хангах зорилго бүхий орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, мөн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад заасан газрын хэвлийн баялгийн үр өгөөж одоо ба ирээдүй үеийн иргэн бүр тэгш шударга хуваарилах зорилгоор Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан хөгжлийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий хөгжлийн сантай адил зориулалт, зорилготой байх тул бүсийн хөгжлийн сан байгуулах шаардлагагүй.

4.Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төслийн бүтэц сэдвээр тавигдах шаардлага мөн хуулийн төслийн үр нөлөө зардлын тооцооны тайланд хуульд заасан шаардлагыг...

Б.Заяабал: Тэр энэ Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйл дээр Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хууль тогтоомжийн төсөл Засгийн газар санал дүгнэлтийг авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх тухай ийм 21 дүгээр зүйлийн нийт 14 заалт байгаа. Мөн Улсын Их Хурлын Дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйл дээр байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх хэлэлцүүлэг явуулах бүлгийн зүйлийн 35.8.6 дахь заалтад гишүүд хууль санаачлагчаас асуулт асуух гэсэн ийм дэгтэй юм байна аа. Тэгээд энэ дэгийн дагуу хууль санаачлагчид хариултаа бүрэн өгч яваарай гэдгийг хэлье. Булгантуяа гишүүн нэмэлт.

Х.Булгантуяа: Тэгэхээр 1 дүгээрт ингэмээр байна аа. Тамгын газар Засгийн газраас ирүүлсэн саналыг заавал Ди парламент дээр оруулж баймаар байна. Яагаад гэвэл бид нар бас хармаар байгаа байхгүй юу. Бид нарт тийм нарийн тооцооллууд нь Засгийн газар шиг нарийн тооцооллууд Улсын Их Хурлын гишүүдэд байдаггүй. Бид нар дандаа албан бичгээр хандаж байж тэр нь удаж байж энэ тэр ирдэг учраас нэгэнт саналыг нь авчихсан байгаа бол бид нарт давхар ажил удахгүйгээр тэр саналыг нь байршуулж баймаар байна.

2 дугаарт яах вэ Засгийн газар дэмжсэн дэмжээгүй Улсын Их Хурлын гишүүд хуулиа өргөн бариад хэлэлцүүлэх эрхтэй. Тэгэхдээ энэ бол нэг ийм төсвийн том

харилцаанд маш том хэмжээний өөрчлөлт оруулах гэж байгаа учраас үүн дээр бас нэлээн Эдийн засгийн байнгын хороо нэлээн нухацтай авч үзэх ёстой гэж бодож байна. Тэгээд хамгийн чухал нь Уул уурхай, аж үйлдвэрийн яам энэ хуулиа та бүхэн маань нэг энэ салбарын ирээдүйн хөгжлийг харж нэг хуульдаа өөрчлөлт оруулах цаг болсон юм биш үү. Нэг АМНАТ-аар оролдоод суугаад байх биш ирээдүйн салбарын хөгжил дээр хүн болгон санаа зовж байгаа шүү дээ. Ашигт малтмалын олборлолтыг нэмэгдүүлэх юмсан ашигтай бол байгаль орчинд ээлтэй...

Б.Заяабал: Булгантуяа гишүүн санал хэллээ. Жаргалан гишүүний микрофоныг нээе.

Б.Жаргалан: Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай гээд ганцхан заалттай ийм зохицуулалт орж ирж байгаа боловч дагалдах хуулиараа бол түрүүний гишүүдийн хэлдгээр энэ Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гээд ерөнхийдөө бол энэ эдийн засгийн болон энэ төсөв татвартай холбоотой маш том том хуулиудад суурь харилцаануудыг бас хөндсөн ийм хуулийн төсөл орж ирсэн. Тэгээд маш авсаархан юм шиг хэрнээ яг дагалдаж байгаа, энэ хөндөж байгаа харилцаанууд нь нэлээн суурь шинж чанартай ийм харилцаанууд байгаад байна л даа.

Тэгээд энэ Засгийн газраас ирсэн саналд нь болохлоор дараах үндэслэлээр дэмжих боломжгүй гэсэн санал хүргүүлсэн байгаад байгаа юм байна. Тэгээд Засгийн газраас харин хэрэв хүн байгаа харин ер нь яг энэ хуулийн төсөл дээр Засгийн газар дээр ямар яриа хэлэлцээр болсон бэ? Тэгээд Уул уурхайн яамны яг өөрийнх нь байр суурь ямар байгаа юм. Тэгээд ер нь цаашдаа энэ асуудлыг ер нь та хэд бодлогын түвшинд яаж зохицуулъя гэсэн бодолтой байгаа юм гээд энэ салбарын яамных нь бөгөөд энэ Засгийн газрын төлөөллийн саналыг сонсмоор байгаад байгаа юм.

Миний хувьд болохлоор өмнө нь асуулт асуусан гишүүдтэй юун дээр санал нэг байгаад байгаа вэ гэхлээр энэ Үндэсний баялгийн сангийн тухай хуульд бид нар ингэж хамаагүй гар хүрмээргүй л байгаад байгаа. Энэ Үндэсний баялгийн сангийн хууль тогтоомж бол маш олон жилийн туршид л ингээд л янз бүрээр сэглэгдээд л, сэглэгдээд л явж байгаа. Тэгээд энэ бүсийн хөгжлийн сан гээд нэг ийм бас тусдаа зүйл оруулаад ирэх гэж байна. Ер нь бол яг нэг дэмжих боломжгүй л харагдаад байгаа юм.

Тэгээд энэ Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудалтай холбоотой энэ бүсийн хөгжлийн сантай байна аа гээд энэ гишүүдийн шүүмжлээд байгаа зүйлтэй нэг санал нэг байгаад байгаа юм л даа. Тэгээд энэ бүсийн хөгжлийн санд орлого хуваарилчихлаа гэж бодоход тэрийг нь яг яаж зарцуулах нь бас маш тодорхой бус яг тийм бүтэц зохион байгуулалт байна уу, их тийм ерөнхий байдлаар л зохицуулчихсан харагдаад байгаа. Тэгэхээр энэ бүсийн хөгжлийн сангаа ер нь та бүхэн яаж төсөөлж байгаа юм бэ. Ер нь энэ одоо бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд энэ бүсийн хөгжлийн сан байх шаардлагатай байлаа гэж үзэхэд ер нь энэ бүсийн хөгжлийн сан чинь ямар зарчмаар шийдвэр гаргах юм, ямар одоо удирдлагын бүтэцтэй байх юм, засаглал нь ямар байх юм гэдэг дээрээ бас нэг хууль санаачлагч нь нэг тодорхой тайлбар хэлчихмээр байна. За баярлалаа.

Б.Заяабал: Хууль санаачлагч Соронзонболд гишүүний микрофоныг нээе.

Л.Соронзонболд: Сангийн зарцуулалт дээр угаасаа нөгөө тусдаа Засгийн газрын тусгай сангийн тухай хууль байгаа шүү дээ тиймээ. Тэр сан хуулийн дагуу дээрээс нь болохоор энэ бүсчилсэн хөгжлийн сан хэрвээ байгуулахаар болох юм бол энэ сангаас ямар байдлаар зарцуулалт хийгдэх вэ гэдэг дээр тусдаа Засгийн газраас тогтоол гаргаж, журам гаргаж явах байх аа гэж харж байгаа.

Дээрээс нь бүсчилсэн хөгжлийн асуудал маань өөрөө Шадар сайдын харьяанд байгаа шүү дээ. Тэгэхээр тэр хүрээндээ зохицуулагдах болов уу гэж харж байгаа юм. Яагаад үндэсний баялгийн санд өөрчлөлт оруулж байгаа вэ гэхээр нөгөө газрын тос байгалийн хий чинь Үндэсний баялгийн санд өөрөө юу нь очихгүй байгаад байгаа байхгүй юу. Газрын тос нөөц ашигласны төлбөр чинь. Тийм учраас л өөрчлөлт оруулж байгаа юм. Зүгээр яах вэ тэр нөгөө юуны хуримтлалын сан, Ирээдүйн өв сан юу руу нөгөө хөгжлийн сан руу оруулж байгаа хувь нь болохоор газрын тос нөөц ашигласны төлбөрөөс 5 хувийг нь оруулъя л гэдэг иймэрхүү л саналууд байгаа шүү дээ. Тэгэхгүй болохоор нөгөө хуримтлалын санд чинь төрийн өмчийн компанийн нөгөө ноогдол ашиг 34 хувиас дээш эзэмшиж байгаа компанийн ноогдол ашиг орж байгаа шүү дээ. Гэтэл газрын тос байгалийн хийн чиглэлийн төрийн өмчийн компани байх юм бол орохооргүй байгаа байхгүй юу. Тийм учраас ийм өөрчлөлтүүд оруулж байгаа шүү гэдгийг л хэлэх гэсэн юм.

Б.Заяабал: 6 дугаар микрофон. Ажлын хэсгийн 6 дугаар микрофоныг өгье.

Ч.Хишигдалай: Газрын тосны салбарыг дэмжих хүрээнд орон нутгийн иргэдийг идэвхжүүлэх, орон нутагт тодорхой хэмжээний ашгийн хуваарилалтыг өгөх зорилгоор бид нар бол хуулийн төслийн ялангуяа тэр тухайн аймгийн орон нутгийн хөгжлийн нэг сан тухайн сумын орон нутгийн хөгжлийн санд тодорхой хувиудыг яг зоож өгч байгааг бол бид дэмжсэн санал өгсөн. Түрүүн бол Засгийн газрын ерөнхий нэгдсэн байр суурийг бол уншиж танилцуулсан. Бидний хувьд бол Газрын тосны тухай хууль болон Газрын тосны бүтээгдэхүүний хуулиуд дээр яг шинэчилсэн найруулгын төслөө бичээд өнөөдөр зөвлөх үйлчилгээ аваад ингээд явж байна. Болж өгвөл хаврын чуулганаар баталж Улсын Их Хуралд өргөн барихаар бэлтгэл ажлаа хангаад явж байна. Үзэл баримтлалын хувьд боловсруулагдсан зүйл заалт дээр ажиллаад явж байна аа.

Б.Заяабал: Анар гишүүний микрофоныг нээе.

Ч.Анар: Бид нар чинь нөгөө 2024 онд нэг газрын тосны үйлдвэрийн санхүүжилт бөөн хэл юм болж батлаад байсан. Тэгээд одоо 2026, 2027 онд ашиглалтад орно оо яг таг гээд амлаад байсан. Тэгээд одоо газрын тосны эх үүсвэр нь байхгүй байгаа шүү дээ. Ямар ч эх үүсвэр байхгүй үйлдвэр бариад байдаг. Чуулган дээр Их Хурлын гишүүдэд яг газар дээр нь очоод танилцахаар бол худлаа танилцуулга өгөөд байгаа шүү дээ. Одоо тэгээд эх үүсвэргүй Газрын тосны үйлдвэр бариад байгаа. Тэгээд энэ газрын тосны үйлдвэрийн эх үүсвэр байгаа юм уу, байхгүй юм уу?

Зүүн бүсийн гишүүд энэ хууль санаачилж байгаа гишүүд маань яг энэ дээр нэг тайлбар өгөөч. Яг бодит байдал дээр. Одоо энэ одоо тэр газрын тосны үйлдвэрийн өөрийн үйл ажиллагаанд ашиглагдах хэмжээний нефтийн ч эх үүсвэр байхгүй. Тэгээд Казахстангаас зөөнө, Оросоос зөөнө гээд яриад байгаа энэ бодит

байдлыг нэг танилцуулмаар байна. Одоо яг үнэн мэдээллийг гишүүд өөрснөө газар дээр очиж танилцсанаа хувьд.

Хоёрдугаарт тэр Булгантуяа гишүүн, Батнайрамдал гишүүний ярьж байгаатай санал нэг байгаа ч гэсэн энэ хуулийг ер нь зарчмын хувьд дэмжээд байгаа юм. Хэрвээ тэр бүх ашигт малтмалаа цогцоор нь ингэж оруулж ирээд энэ хуулиа явна гэх юм энэ хууль чинь бараг энэ 2028 оноос өмнө батлагдахгүй. Тэгээд тэр газрын тосны үйлдвэр гээд нэг ямар ч хэрэггүй байшингууд балгас болоод дуусах эрсдэл байгаа гэж харж байна.

Ажлын хэсгээс бас нэг ийм санал байна. Энэ орон нутаг бүсийн сангийн хуваарилах гэж байгааг нь бол одоо ер нь зарчмын хувьд дэмжиж байгаа ч гэсэн энэ зохицуулалтыг нь нарийн зааж өгмөөр байгаа юм зориулалтыг нь. Яг юунд зориулах гээд байгаа юм. Энэ бүсийн хөгжлийн сан, орон нутгийн санд. Энэ зорилго нь өөрөө байгаль экологийг хамгаалах, бас орон нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх гэх мэтчилэн яг зөвхөн яг орон нутагтаа зориулсан нарийвчилсан заалттай оруулахгүй бол журмаар гээд зохицуулчихсан байна. Энэ журмыг чинь өөрөө буцаагаад энэ чинь яг зарцуулалт нь яг орон нутагтаа очих, бүсийн хөгжилдөө яг зарцуулах эсэх нь тодорхойгүй орж ирсэн байна. Энийг орон нутаг бүсийн хөгжлийн сангийн зориулалтыг нарийвчлан заах шаардлагатай байна аа гэж үзэж байна. Энэ 3 асуулт дээр хариулт авъя.

Б.Заяабал: Ажлын хэсгийн хууль санаачлагч Бадамсүрэн гишүүний микрофон нээе. Дараа нь ажлын хэсэг нэмж өгөөрэй.

М.Бадамсүрэн: Анар гишүүнтэй санал нэг байгаа. Ер нь түүхий эдийг дотоодоосоо л хангах нь энэ үйлдвэрийн хувьд хамгийн 1 дүгээр л зорилт. Тэгж ер нь анх бодож энэ тооцооллыг ТЭЗҮ-ийг хийсэн юм билээ. Гэхдээ одоо бодвол гадаадын хөрөнгө оруулалттай компани 3 талбай дээр буюу Дорнод аймагт 2, Дорноговь аймагт 1 талбай дээр олборлолтын үйл ажиллагаа явагдаж байгаа. Гэхдээ энэ хэмжээ бол жил ирэх тусам буурч байгаа. Яагаад буурч байна гэхээр шинээр нэмж хөрөнгө оруулалт хийх буюу шинээр нэмж өрөмдлөг хайгуулын ажил хийгдэхгүй байгаа. Энд нэг бас нэг том шалтгааны нэг нь орон нутагт энэ АМНАТ-ын төлбөр газрын тосны ноогдол ашгаас хуваарилагдаж байгаа хөрөнгө бараг байхгүйтэй адил гэсэн үг. Өөрөөр хэлбэл энэ өмнө нь Газрын тосны тухай хууль дээр 2014 онд батлагдахдаа юу гэж заасан байсан гэхээр газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 70 хувь нь улсын төсөвт, 30 хувь нь тухайн орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд гээд орчихсон байсан юм.

Тэгээд би нөгөө нэг аймгийн дарга байхдаа энэ дээр Захиргааны хэргийн шүүхэд хүртэл хандаж байсан. Тухайн гэдэг үг чинь өөрөө тэр тухайн аймгийнх нь орон нутгийнх нь хөгжлийн санд гэсэн чинь харин энэ маргаан маань бүр сүүлдээ Улсын Их Хурал дээр 2 мянга хэдэн онд билээ дээ харин бүүр эсрэгээрээ тухайн гэдэг үгийг нь хасаад хаячихсан байсан юм. Бид нар чинь орон нутагт байгаа мэдэхгүй энэ парламент дээр ямар хэлэлцүүлэг явж байсан юм. Тэгээд ингээд үндсэндээ бол ингээд өмнөх хугацаанд ерөөсөө орон нутагт энэ өгөөжийг хуваарилах талаар огт санаачилгагүй ажиллаж ирсэн. Одоо энэ Засгийн газрын өгч байгаа санал ч гэсэн адилхан. Тэгээд үйлдвэр 2028 онд ашиглалтад орно гээд байдаг. Цаашид дотоодын эдийн засгийн аюулгүй байдлаа хангана гээд байдаг. Энэ дээр ерөөсөө энэ орж ирэхгүй байгаа учраас ядаад зүүн бүс, говийн бүсээс сонгогдсон гишүүд энийг оруулж ирж байгаа юм.

Тэгээд энэ бол дэмжих эсэх нь байнгын хорооны л асуудал. Бид нар үүргээ биелүүлж байгаа. Газрын тосны үйлдвэрийг ажиллуулахын тулд дотоодын түүхий эдээр үйлдвэрээ хангахын тулд орон нутагт нь нөлөөлөлд өртөж байгаа бүс нутагт нь энэ өгөөжөөс нь тодорхой хувийг нь хуваарилдаг болооч ээ л гэж байгаа юм. Энэ дээр бол их юм хуваарилагдахгүй. Жилдээ нэг 30 гаруй тэрбум төгрөгийн л АМНАТ-ын төлбөр орж байгаа. Энэ чинь Дорнод аймагт байдаг 2 талбай гэхэд Матадын талбай дээр нь 19 дүгээр талбай дээр нь роялти тооцдоггүй. Яагаад гэвэл хууль батлагдахаас өмнө байгуулагдсан гэрээ. 21 дүгээр талбай дээр нь тооцдог. Тэр Дорноговьд 1 талбай тооцдог. Энэ ердөө 30 гаран тэрбум төгрөг. Эндээс 10 хувь гэхээр нэг 3 тэрбум төгрөг тухайн суманд нь хуваарилах л асуудал яригдаж байгаа байхгүй юу. Жилдээ 200 гаруй тэрбум төгрөг Засгийн газрын ноогдол ашиг буюу бүтээгдэхүүн авах гэрээний дагуу 200 гаруй тэрбум төгрөг орж байгаа. Энэнээс орон нутагт нэг ч төгрөг хуваарилагддаггүй.

Тийм учраас хамгийн их нөлөөлөлд өртөж байгаа бүс нутагтаа энийгээ хуваарилахгүй байж байж энийг орон нутаг дэмжихгүй байна аа гэдэг бол угаасаа яагаад ч боломжгүй зүйл. Бүх л улс оронд энд нөөцийн төлбөрийн орлогоос нь тодорхой хувийг тухайн нөлөөлөлд өртөж байгаа бүс нутгуудад хуваарилдаг ийм л жишигтэй юм байна лээ. Тэгээд энийг одоо яах вэ нөгөө орон нутагт бид нар чинь ингээд дунд нь байсан учраас хамгийн сайн ойлгоод байгаа учраас та бүхэндээ ойлгуулах гээд л ингээд л олон талаас нь тайлбарлаад байгаа юмаа. Тэгээд та бүхэн энийг...

Б.Заяабал: Ажлын хэсэг нэмэлт өгөх үү? нэмэлт ажлын хэсгийн 6 дугаар микрофон нэмчихье.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай. Монгол Улс геологийн 333 сая тонн нөөцтэй. Үүнээс ашиглалтын баталгаат нөөц 43 сая гэж батлуулсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр нөөцөд хүлээж авсан. 1998-2025 оны хооронд бол бид нар 12 сая тонныг нь олборлоод экспортод гаргаж улсын төсөвт нэг 3 орчим их наяд төгрөгийн орлого оруулсан байна. Үлдэгдэл ашиглалтын баталгаат нөөц бол одоо нэг 31 сая тонн байна. Үүнийг хэрхэн үр ашигтай олборлох вэ, үйлдвэрийг хэрхэн нөөцөөр хангах вэ гэдэг бол орон нутгийн дэмжлэгээс шууд хамааралтай байдаг. Олборлолтыг хэрхэн нэмэгдүүлэх вэ гэдэг асуудал дээр орон нутгийн иргэдийн дэмжлэг маш их шаардлагатай байдаг. Энэ утгаар нь бид нар уг санаачилсан хуулийн төслийг салбарын хувьд бол дэмжиж саналаа өгсөн. Засгийн газрын байр суурийг бол түрүүн албан бичгээр тодорхой дурдсан байна аа.

Б.Заяабал: Анар гишүүн нэмэлт тодруулга нэг минут.

Ч.Анар: Энэ хууль санаачлагчийн зүгээс тайлбарлаж байгаа 200 тэрбум жилд улсын төсөвт бүрдүүлдэг юм байна. Тэгээд сая ойлгосноор нэг ч төгрөгийг нь орон нутагт нь тавьдаггүй гэж хариуллаа. Зөв үү? Тэгэхээр 1 ч төгрөг тавихгүй байгаа юм бол орон нутаг нь яагаад өөрсдийн газар нутгаа ашиглуулахыг зөвшөөрөх юм. Тэгэхээр одоо энэ хуулийн өөрчлөлт орсноороо энэ хандлага наашлах юм уу?

Дараагийн асуулт нь Дамдинням сайдаас асууя. Энэ салбарынх нь сайд нь энэ Засгийн газар дэмжээгүй гэх юм. Та болохоороо олон нийт хэвлэлээр өөр байр

суурь яриад байх юм. Гэтэл яг Засгийн газар чинь одоо энэ хуулийн төслийг уул уурхайн баялгаа эдийн засгийн оруулалтад оруулахыг дэмжинэ, эрчимжүүлнэ гээд байгаа. Тэгэхээр сайдынх нь байр суурийг бас сонсьё.

Б.Заяабал: Хууль санаачлагч Соронзонболд гишүүн хариулах уу? Ажлын хэсгийн 5 номер.

Г.Дамдинням: Манай энэ олборлох салбар гэж нэрлэдэг юм даа. Газрын тос уул уурхайн салбарт олборлолтыг олж байгаа орлогоос тухайн орон нутагт нь энэ АМНАТ газрын тосны энэ орж ирж байгаа төлбөрөөс орон нутагт өгөх энэ зарчим зөв гэж үзэж байгаа юм. Манай яамны санал бол. Тэгэхдээ Засгийн газрын шийдвэр бол Засгийн газраараа гардаг. Тэгээд Засгийн газрын төлөөлж байгаа учраас би бол одоо яамныхаа байр суурийг хэллээ. Тэгэхдээ Засгийн газрын шийдвэр бол энийг дэмжихгүй гэдгээр гарсан.

Ер нь орон нутагт байгаа энэ уул уурхай энэ газрын тосны салбарын эсэргүүцлийн гол суурь нь бол орон нутагтаа юм хуваарилагддаггүй байгаатай л холбоотой байхгүй юу. Тэгэхээр шинээр орж ирж байгаа энэний дараа хэлэлцэгдэх Ашигт малтмалын тухай хуулийн хамгийн том өөрчлөлтүүдийн нэг ч гэсэн энэ байгаа. Хариуцлагатай ААН-үүдийн үйл ажиллагааг дэмжиж хамтарч ажиллаж байвал АМНАТ-аас өгдөг байя гэж байгаа.

Б.Заяабал: Гишүүд асуулт асууж дууслаа. Одоо хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Бямбасүрэн гишүүнээр тасаллаа. Уянгахишиг гишүүний микрофон. Ирцийн дарааллаар Очирбат гишүүний микрофоныг нээе.

Г.Очирбат: Ингээд Монгол төрийн ажил яг ингэж л явж байна л даа. Дамдинням сайд тэнд суучаад манай яам дэмжиж байгаа, засаг бол дэмжээгүй гээд байгаа. Юу гэж ойлгох юм танай наад Засгийн газрыг чинь. Нэг сайд нь орж ирчхээд манай салбар бол манай яам дэмжээд байгаа юмаа гэж байгаа юм. Тэгсэн мөртөө Засгийн газар дэмжээгүй ээ гээд байгаа юм. Харин тийм. Тэгэхээр та хэд кабинетын зарчмаар ажиллаж байвал шийдвэрээ нэгтгэ ээ. Тэгээд алин дээр чинь явах юм. Танай Засгийн газар чинь дэмжээгүй гэхихсэн байна шүү дээ. Тэгээд салбар нь дэмжье гээд байна шүү дээ. Үгүй харин тийм тэгэхээр ийм ийм нэг сонин тайлбар битгий өг л дээ. Нэгдсэн бодлого байвал бодлогынхоо дагуу л яв. Ашигт малтмалын одоо энэ хар аа. Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр яг тийм юм болж байна лээ шүү дээ. Мэргэжилтнүүд нь сүүлдээ хаашаа чихдэг вэ гэхээр Их Хурлын гишүүд рүү чихдэг болчихсон. Улсын Их Хурал дээр шийдээд унагаавал унагаана биз, боливол болино биз. Үгүй ямар ч бодлого байхгүй, толгой байхгүй, толгойгоороо хөлөө хийчихсэн, хөлөөрөө толгой хийчихсэн. Ийм нөхцөл байдалтай л явж байна шүү дээ. Эдийн засгийн байнгын хорооны энд сууж байгаа даргаас авхуулаад бүх гишүүд ер нь сонссон биз. Сайд нь орж ирчхээд яам бол дэмжээд байгаа гээд байдаг, Засгийн газар дэмжихгүй байгаа гээд байдаг. Ийм бодлогогүй Монгол төр цаашдаа явж болохгүй ээ.

Хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа юм. Тухайн орон нутаг дээр ажил хөдөлмөр хийгээд тэнд нэмүү өртөг шингээгээд тэнд хөрөнгө оруулалт хийж байгаа бол тэр орон нутаг аймаг нь юмаа хүртэж байх ёстой зарчмынхаа дагуу. Энийг Их Хурлынхаа гишүүний хувьд дэмжиж байгаа юм. Засгийн бодлого салбарын бодлого 2 нь дотроо зөрчихсөн ийм нөхцөл байдалтай дараа дараагийн

асуудлуудаа Дамдинням сайдаа оруулж ирмээргүй байна шүү. Одоо Ашигт малтмалын тухай хууль орж ирнэ. Дахиад танд зориулсан танай салбарт засагт чинь зориулсан нэг хэдэн асуултууд байгаа. Тэгээд тухайн асуудал дээр нь асууя. Энийг бол зарчмын хувьд дэмжиж байгаа. Тэгээд хэлж байгаа ярьж байгаа юм Засгийн газраа кабинет нэг шийдвэртэй байх бодлогоо барьж яваарай. Сайд нь салбарын сайд нь орж ирчхээд би дэмжсэн, Засгийн газар Учрал дэмжээгүй гээд л хэлчихлээ шүү дээ ер нь түрүүн. Тэгээд ийм байдалтай цаашаа засгийн шийдвэр гарч явах юм бол Монгол төр тогтворгүй байдал руу орохоор байна шүү. Тэгээд өөрсдөө та хэд энийгээ өдөр тутамдаа хийж үйлдлээрээ харуулж байна шүү гэдгийг хэлье. Баярлалаа.

Б.Заяабал: Баярлалаа. Бямбасүрэн гишүүний микрофон нээе.

Ш.Бямбасүрэн: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүддээ өдрийн мэнд хүргэе ээ. Энэ Ашигт малтмалын тухай бишээ газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хамтран өргөн барьсан. Тэгээд өнөөдөр манай энэ Монгол Улс чинь ер нь уул уурхай дээр ер нь бол ийм 2 туйл болоод л хуваагдчихлаа л даа. Нэг хэсэг иргэд нь бол ерөөсөө улдан эсэргүүцдэг, нөгөө талд нь эдийн засгаа өөд нь татъя, энэ уул уурхайн төслүүдийг явуулъя гээд байдаг. Одоо бүүр газрын тос дээр ялангуяа газрын тосны боловсруулах үйлдвэрээ өөрсдөө барья, хараат бус байдлаасаа гаръя гээд ингээд төр засаг нь бодлого гаргаад явж байдаг. Гэтэл түүхий эд нь байхгүй. Тэгээд манай Дорнод аймагт бол сүүлийн 30 орчим жил яг энэ газрын тосны олборлолтыг бол хийж байгаа. Тэгээд орон нутагт нь юу ч хуваарилагдахгүй байгаа болохоор тэнд бол ерөөсөө иргэд бол үнэхээр улдан эсэргүүцэж байгаа байхгүй юу. Тэгээд энэ нэг үе цаг үед бол 1 сая орчим тонн түүхий газрын тосыг экспортолдог байсан. Өнөөдөр бол нэг 300 мянган тонныг экспортлохоор одоо төлөвлөгөө гаргачихсан ажиллаж байгаа юм байна энэ 2026 онд.

Тэгэхээр цаашдаа бид нар энэ түүхий тосныхоо нөөцийг дотоодоосоо хангана гэвэл яалт ч байхгүй энийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Тэгэхээр орон нутагт нь юм хуваарилахгүй байхаар орон нутгийн иргэд бухимдах нь яалт ч байхгүй аргагүй. Тэгээд өмнө түрүүн энэ Анар гишүүн бас хэлж байсан. Энэ орон нутгийн хөгжлийн сангаар нэгдсэн сан руу ингээд хуваарилагддаг байсан. Яах вэ нэг ч төгрөг биш л дээ. Нэг ч төгрөг хуваарилдаггүй бас биш л дээ. Энэ чинь нөгөө нэг 21 аймагт ингээд нэгдсэн байдлаар хуваарилчхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь ингээд одоо яг нэг бүс нутаг нь өртөж байгаа тэр иргэдэд бол үнэхээр юм бол очихгүй байгаад байгаа юм. Тэгээд одоо энэ хэрвээ хууль батлагдах юм бол орон нутаг тухайн төслийг улам илүү дэмжиж ажиллах, ард иргэддээ зөвөөр ойлгуулах, цаашдаа энэ улсын энэ бие даасан байдлыг хангахад чухал ач холбогдолтой гэж үзэж байгаа юмаа.

Тэгээд ер нь энэ АМНАТ-ыг бол ашигт малтмалын оруулж ирж байгаа шинэ хуулиар бол бүх өртөж байгаа аймгууд, бүс нутгууд илүү авахаар байгаа шүү дээ. Тэрэнтэй л нийцүүлж энэ газрын тосыг адилхан болгоё оо л гэж байгаа юм. Тэгээд энэ төсөвт ямар нэгэн дарамт болохгүй. Нэгдсэн байдлаар улсын төсөвт орж байгаа одоо энэ орлогыг л бид нар хуваарилалтыг нь л арай өөрөөр хийж өгч байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ дээр бол ямар нэгэн байдлаар орлого талдаа, зарлага талдаа ямар нэгэн асуудал үүсгэхгүй гэж бодож байгаа. Тэр гишүүдийн анхааруулж хэлж байгаа бүсийн сан гэдгийг бол бид нар эргэж харж болно оо. Тэрийг бол заавал гүйцэлдүүлэх гээд байх шаардлагагүй гэдгийг түрүүн хууль санаачлагч манай

Бадамсүрэн гишүүн тайлбарласан. Тэгээд тийм учраас энэ салбарын хөгжилд чухал ач холбогдолтой энэ хуулийг бол гишүүдийгээ дэмжиж өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

Б.Заяабал: Баярлалаа. Уянгахишиг гишүүн үг хэлнэ.

Г.Уянгахишиг: Энэ хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа. Яагаад гэхээрээ хэлэлцээд эхэлсний дараа бид нар яг хуваарилалт нь яаж явах вэ, үнэхээр шинэ сан бий болгох уу, баялгийн сан руугаа хуваарилалтаа хийх үү буюу одоо яг тэр төсөв рүү орох мөнгөө засаг яаж зохицуулах вэ гэдэг тал дээр бол энийг нь бид нар эргэж харж болох байх аа гэж бодож байна. Тэгээд ер нь зарчмын хувьд бол яг ингээд сүүлийн үед нэлээн их хөндөгдөж яригдаж байгаа зүйл ер нь сүүлийн үе гэсээд байх юм байхгүй ер нь байдаг. Яагаад энэ нөгөө хайгуулын талбай ихсэхгүй байгаа юм. Яг нөгөө уул уурхай яагаад явахгүй байгаа юм. Одоо энэ газрын тосны хайгуул гэхэд өчнөөн олон талбай байгаа боловч одоо ингээд эрэл хайгуул нь идэвхтэй явж байгаа талбай байхгүй. Тэгээд нөгөө орон нутгийнхантай тулдаг. Гэтэл өнөөдөр яг ингээд нөхцөл байдлыг харахаар гол төсөв чинь өөрөө уул уурхайн бүтээгдэхүүнүүдээс бий болоод байдаг. Ашигт малтмал хэрвээ газрын тос ингээд ашиглагдаад явах юм бол энэ газрын тосноос чинь маш их мөнгө хөрөнгө мөнгө төсөв рүү орох ёстой. Гэтэл энийг орон нутагт үнэхээр яг хамгийн их өртөж байгаа ард иргэдийн хувьд тэнд хуваарилагддаг мөнгө нь тодорхойгүй байгаад байхаар нөгөө том тогоо руугаа орчхоод буцаж тэнчээнээсээ хуваарилагддаг байгаад байхаар орон нутгийнхан бол тэрэн дээр эсэргүүцэх шалтаг шалтгаанууд нь бол нэлээн их гарч ирээд байгаа гэж ажиглагдаад байгаа юм.

Тэгэхээр яг энэ утгаараа одоо салбарын сайд ч тайлбарлаж хэлж байна. Яг одоо мэргэжлийн гишүүд ч гэсэн тайлбарлаж хэлж байна л даа. Тийм болохоор энэ дээр яг орон нутгийн буюу тухайн аймаг тухайн суманд очих тэр хувь хэмжээг нь арай өндөр ахиу байдлаар тавьж өгөөд тэр зохицуулалтыг бий болгоод, үүнийхээ үндсэн дээр тэр эрэл хайгуулын ажлыг илүү идэвхжүүлснээрээ нөгөө төсөвт орох нөлөөлөл нь дам нөлөөлөл гэж байгаа юм л даа. Дам нөлөөлөл нь сайжрах ийм зураг харагдаж байгаа юм болов уу гэж харж байгаа юм. Тэгэхээр энэ хуулийг бол гишүүдийн зүгээс санаачлаад явж байгааг бол дэмжээд байгаа юм. Тэгээд хэлэлцэх эсэхийг нь дэмжээд харин ажлын хэсэг дээр гэдэг юм уу яг зарчмын зөрүүтэй саналаар магадгүй тэр бүсийн хөгжлийн сан гэж заавал байх ёстой юм уу, Баялгийн сан руу заавал хуваарилах ёстой юу гэдгээ эргээд хэдүүлээ ярилцаж болох байх аа гэж бодож байна.

Б.Заяабал: Баярлалаа. Анар гишүүний микрофон нээе.

Ч.Анар: Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Тэгээд манай энэ Их Хурлын баталдаг хуулиудыг харахаараа бүх хууль нь ийм зэлтэрийн гацаа. Нэгнийхээ хийж байгаа ажлыг гацаагаад гацаагаад үр дүн гардаггүй. Одоо энэ орон нутгийн хөгжлийг дэмжих сангийн энэ зохицуулалт чинь сангийн хуримтлал цуглуулсан нөлөөлөлд өртөж байгаа бүс нутагтаа хуваарилагддаггүй. Одоо энэ Бадамсүрэн гишүүнийг би санаж байна. 2024 оноос хойш л Дорнод аймгийн нөлөөлөлд өртөж байгаа сум болох Матад сумын сургуулийн дээврийн төсвийг яриад л яваад байсан, яриад л яваад байсан. Одоо шийдэгдсэн үгүй нь тодорхойгүй. Тэгтэл 200 тэрбум төгрөг төвлөрүүлдэг сум. Гэтэл нөгөө сангийнх нь хуваарилалт дээр нь улс төрийн лобби сайтай тойргийн гишүүд нь өөрсдийнхөө нөгөө орон улсын төсөвт хуримтлал бүртгүүлдэггүй газраасаа төсөв хуваарилуулчихдаг орон нутгийн хөгжлийн сан гээд гоё гоё шалтаг эдийн засгийн аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал энэ тэр гээд.

Тэгэхээр энэ хууль дээр би энэ зэлтэрийн гацаануудыг нь засах ёстой гэж үзэж байгаа юм. Уянгахишиг гишүүн сая ярьж байна. Энэ сангийн зориулалтыг яг тодорхой зааж өгөх ёстой. Тэгэхгүй бол энэ ерөөсөө дахиад эргээд л бас асуудал шийдэгдэхгүй. Энэ хууль дээр өөрчлөлт орлоо гээд орон нутгийн иргэд нөлөөлөлд өртөж байгаа бүс нутгийн асуудал шийдэгдэхгүй болоод ирэнгүүт эргээд нөлөөлөлд өртөж байгаа бүс нутгийн малчид ард иргэд дэмжихгүй байх нь аргагүй шүү дээ. Тэгээд эргээд нефтийн эх үүсвэр байхгүй, эргээд нефтийн үйлдвэр нь ажилладаггүй, эргээд нефть нь байдаггүй, эргээд нөгөө сайд нь Оросоосоо очоод царай алдаад явдаг нэг ийм үхлийн тойрогт ингээд оруулж байгаа юм нь дандаа энэ зэлтэрийн гацаа хийсэн хуулиуд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хуулийг зарчмын хувьд явуулах нь дэмжиж байгаа. Энэ цаашаагаа аягүй олон асуудлын гацаа гаргана. Гэхдээ энэ сангийн хуваарилалтын асуудлыг яг энэ хэлэлцэх эсэхийг нь дэмжиж байгаад нэлээн нарийн сайн сууж зэлтэрийн гацаа болгохгүйгээр л хийхгүй бол бас нэг үр дүнгүй л хууль болох вий л гэдэг айдас байна. Тэгэхээр ажлын хэсэг дээрээ л сайн ажиллаад энийг гацааг нь гаргах шаардлагатай байна гэж үзэж байна.

Б.Заяабал: Баярлалаа. Батнайрамдал гишүүний микрофон нээе.

О.Батнайрамдал: Сая Дамдинням сайд. Дамдинням сайдын асуудлыг ойлгоод байна л даа. Гэхдээ ер нь Уул уурхайн яам, Сангийн яам 2-ын хооронд угаасаа зөрчилдөөн байдаг шүү дээ. Тэр бол байдаг л зөрчилдөөн байхгүй юу. Сангийн яам төсвөө л хардаг гэтэл УУЯ болохоороо энэ чинь уул уурхайн салбараа хөгжүүлэхээ л харна шүү дээ. Тэгээд тэр битгий хэл Баялгийн сангийн хуулийг анх ингээд бичээд драфт нь явж байхад энэ газрын тосны нөөц ашигласны төлбөрийг баялгийн санд оруулах уу, оруулахгүй юу гээд бөөн юм болж байсан юм. Энэ өнөөдөр хэлэлцэгдэж байгаа ч юм биш олон жил угаасаа бас л Сангийн яам нь болохоороо төсөв дээр нөлөө үзүүлэхгүй юм чинь нөлөө үзүүлэх учраас баялгийн сангийн хуваарилалт руу оруулахгүй гээд л.

Зарчмын хувьд Үндсэн хуулиа 6.2-оо харах юм бол тэр газрын тос байна уу, алт, зэс байна уу энэ чинь бүгд газрын нийт газрын хэвлийн баялаг байхгүй юу. Бүгд Үндсэн хуулиараа ард түмний өмч. Тэгэхээр энэ дээр орон нутаг руу хуваарилалт нь илүү очих ёстой гэдэг дээр зарчмын хувьд тэрийг бол дэмжихгүй байна гэж байхгүй. Тэрийг заавал дэмжих ёстой. Харин том зургаараа баялгийн сангийн хуваарилалтаасаа бүр эхлэх ёстой юм л даа. Том зургаараа үндсэн хуулийн хүрээнд энэ газрын хэвлийн баялгийн үр өгөөж яаж хуваарилагдах юм, яаж доошоогоо урсгал нь орох юм. Орон нутаг руу ямар сангаар дамжиж очих юм. Тэрэн дээр нь дахиад нэг бүсийн хөгжлийн сан гээд нэг шинэ сан байгуулах юм уу, эсвэл одоо байгаа орон нутгийн хөгжлийн сангаараа дамжуулаад хуваарилалтын механизмыг нь зөв болгох уу. Тэгэхээр энэ дээр л бид нар илүү анхаарах ёстой юм л даа.

Тэгэхээр миний бодлоор бол Бүсийн хөгжлийн сан гээд шинэ сан байгуулаад энэ асуудал шийдэгдэнэ гэж бодохгүй байна. Харин орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалттай одоо сая Ашигт малтмалын тухай хууль дээр бас орон нутгийн хөгжлийн сангийн асуудлыг хөндөөд ороод ирж байгаа шүү дээ. Тэгэхээр яг тэрнийхээ зарчимтай уялдуулаад энийг цогцоор нь шийдэх ёстой л доо. Зөвхөн ашигт малтмалыг нь шийдчихээд алт зэсийг нь шийдчихээд газрын тосыг нь хаяж болохгүй юм.

Тэгэхээр би юу гэж харж байна вэ гэхээрээ энэ хуулийг оруулж ирж байгаа гишүүдийг ойлгож байгаа юм. Яг асуудал бол байгаа. Шийдье л дээ одоо хүртэл шийдэгдээгүй яваад байна. Тэгэхээр зарчмын хувьд хэлэлцэх эсэхийг нь шийдээд харин энэ ажлын хэсэг нь буцаад яваад Ашигт малтмалын тухай хуулийнхаа ажлын хэсэгтэй бараг нэгдэх ёстой гэж бодоод байна энэ дотроо, нэг малгайн доор. Яагаад гэх юм бол орон нутгийн хөгжлийн сан чинь энэ чинь адилхан асуудал шийдэх гээд яваад байгаа байхгүй юу. Тэрэн дээр алт, зэс газрын тос гэж ялгаагүй шүү дээ. Адилхан зарчим яригдах ёстой. Гэхдээ энэ дээр бас дахиад төсвийн бодлоготойгоо хэр уялдах юм. Баялгийн сангийн суурь зарчимтайгаа хэр уялдах юм гэдэг асуудал шийдэгдэж байж орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалтуудын асуудал бас доошоогоо шийдэгдэх ёстой байхгүй юу. Тийм болохоор хуулиа яах вэ зарчмын хувьд хэлэлцэх эсэхийг нь дэмжчихье.

Тэгээд энэ дээр тэр бүсийн хөгжлийн сангаас өгсүүлээд хуваарилалтын тэр 35, 25, 10, 10 гээд яг үнэнийг хэлэхэд хаанаас ч гарсан тоо юм. Тэгэхээр тэрэн дээр маш нухацтай хандаж маш том судалгаан дээр үндэслэж энэ шийдэх ёстой байгаа юм. Тэгэхээр тэрийг ажлын хэсгийн хүрээнд ер нь бол Дамдинням сайд аа, энэ дээр нэлээн том Их Хурал дээр ажлын хэсэг гараад Ашигт малтмалын тухай хуулийн явж байгаа тэр орон нутгийн хөгжлийн сангийн тэр хуваарилалт ч гэсэн бас нэгдсэн цогц байдлаар шийдэх ёстой байхгүй юу. Тэгэхгүй ингээд тус тусдаа газрын тос нэг тусдаа шийдээд, алт, зэсэн дээрээ нэг тусдаа шийдээд ингээд яваад байж болохгүй. Тэгэх юм бол энэ чинь буцаад л том агуулга чинь алдагдаад одоо сэглэгдээд яваад байна гэсэн үг байхгүй юу. Сэглэгдэх тийм эрсдэлтэй харагдаад байгаа юм. Тэгэхээр энийг тэгж цогцоор нь шийдэх нь зөв болов уу. Яг энэ цаг мөчид бас Ашигт малтмалын тухай хууль орж ирж байгаа учраас тэр хуультай уялдуулаад хэлэлцэх эсэхийн хүрээнд дэмжье л гэж бодлоо.

Б.Заяабал: Баярлалаа. Үүрийнтуяа гишүүн үг хэлнэ.

Д.Үүрийнтуяа: Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Бид бүсчилсэн хөгжил яриад багагүй хугацаа өнгөрч байна. Их олон жил бүсчилсэн хөгжлийг ярьж байгаад хамгийн сүүлд 2024 оны сонгуулийн тогтолцоондоо уяж бүсчилсэн. Гэхдээ өнөөдөр бид нар энэ бүсчилсэн хөгжлийн асуудлыг зөвхөн сонгуулийн тойргоор харж болохгүй байгаа юмаа. Хөгжлийн тойрог болгож харах цаг нь болсон байна аа. Хэрвээ бид нар бүсчилсэн хөгжлийн асуудлыг бодлогоор бусад үйл ажиллагаа хууль тогтоомж эрх зүйн орчноор нь уялдуулж авч явж чадах юм бол эдийн засгийн өсөлтөд тодорхой ахиц дэвшил авчрах боломж бидэнд байна гэж харж байгаа юм. Тухайн бүсийн асуудлыг ярихад аль нэг аймгийг нь сугалж аваад ярьчихдаг байхаараа л энэ өөрөө үндсэн логик шинж чанараа алдчихаад байгаа юм л даа.

Би энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Аливаа ашигт малтмалыг ашиглаж байгаа, олборлож байгаа, тэр орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа энэ компанийн үйл ажиллагааг орон нутгийн ард иргэд огт ойлгож дэмждэггүй. Ойлгох боломж ч өнөөдөр байхгүй байгаа. Яагаад гэхээр орон нутгийн хөгжлийн сан өнөөдрийн байдлаар энэ АМНАТ-ийг нь бүгдийг нь авчирч эндээс авч байгаа татвар хураамжуудыг нь нэгтгэж төвлөрүүлэнгүүтээ нэг индексээр бодож байна гээд бүх орон нутагт адилхан хуваарилж байгаа. Гэтэл хамгийн их ашигт малтмалын төлбөр төлж байгаа газрын хэвлийн баялгаа ашиглуулж байгаа тухайн орон нутгийн иргэд өөрсдийнхөө амьдрах орчин нөхцөлд нөлөө үзүүлж байна гэж байгаа энэ газар нутагт тодорхой мөнгө, ашиглах эрх хязгаар байдаггүй. Гэтэл хамгийн лобби сайтай улс төрчтэй аймгууд нь энэ орон нутгийн хөгжлийн сангаас харьцангуй илүү давуу

тал гаргаад аваад явчихдаг. Тэгээд ийм байгаа нөхцөлд тэр уул уурхайн компаниудын тэр газрын тос ч бай, ашигт малтмал газрын хэвлийн баялгийг ашиглаад явж байгаа компаниудын үйл ажиллагааг ард иргэд ойлгохгүй байгаа юм. Тухайн компаниуд өөрөө үүрэг хариуцлагаа биелүүлээд орон нутагт өгөх зүйлээ дамжуулаад өгчхөж байгаа гэж бодтол тэрийг орон нутаг нь юу гэж ойлгодог вэ гэхээр манай улс төрч манай тойргоос сонгогдсон гишүүн сайн ажилладаг учраас олж ирсэн мөнгө гэж ойлгодог шүү дээ одоо яг ний нуугүй үнэнийг хэлэхэд.

Тийм учраас энэ уул уурхайн салбараас газрын хэвлийн баялгийг ашиглаад олж байгаа салбараас орж ирж байгаа орон нутгийн өгөөжийг ард иргэдэд ойлгуулж нэмэгдүүлэхийн тулд тодорхой хувиар олгодог байх зохицуулалт нь зүйтэй. Энэ зөвхөн газрын тосон дээр ч биш бусад газрын хэвлийн баялгууд дээр хамт яригдах ёстой. Ашигт малтмалын тухай хууль дээр яг энэ асуудал орж ирж байгаа үед энийг хамтад нь ярих нь зөв, хамтад нь ярих нь зөв. Зарчмын нэг асуудал болгож авч явах ёстой гэж харж байгаа. Энэ 2 асуудлын хуулийн уялдаа холбоог хангаж ер нь бид нар энэ Үндсэн хуулийн 6.2-т заасан энэ өмчийнхөө асуудал дээр, нийтийн өмчийн асуудал дээр газрын хэвлийн баялгийн асуудал дээр тодорхой бодлогын асуудлыг барьж явах зайлшгүй шаардлага бий болж байна аа. Зарим орон нутагт бол тухайн стратегийн ач холбогдолтой ордыг ашиглаад орон нутгийн өмчит компани байгаад байдаг. Зарим нь болохоороо тэндээсээ ямар ч үр өгөөж хүртэх боломжгүй шууд бүх ашгийг нь хуу хамж авч явчхаад орон нутагт ч нэг төгрөг ч өгдөггүй ийм ялгаатай зохицуулалт байгаа нь өнөөдөр энэ үл ойлголцол нь энэ салбарын асуудлыг, салбарын хөгжлийг гацаагаад байгаа юмаа. Уул уурхайн салбарын хөгжлийг.

Тийм учраас энэ салбарыг зөв ойлгуулах ард түмэнд зөв ойлгуулах энэ салбарын ажлыг бодлогоор дэмжих хамтдаа байх асуудал нь өөрөө энэ хувь өгөөж яаж очиж байгаагаас л хамаарна. Тэгэхээр ард иргэддээ мэдээж энэ чинь нийтийн өмч Монголын ард түмний бүх Монголын ард түмний өмч гэж байгаа бол эндээс үр өгөөж нь баялгийн сангаараа дамжиж очоод харин тухайн орон нутаг уул уурхайн салбарыг газрын хэвлийн баялгийг ашиглах тэр салбарыг бодлогоор дэмжсэнийхээ хувьд тодорхой эрх мэдэл нь орон нутагтаа очдог байх ёстой гэдэг энэ зарчмын асуудал дээр санал нэг байгаа учраас энэ хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, Ашигт малтмалын хуулийнхаа бас тодорхой заалтуудтай уялдуулаад, шаардлагатай бол бараг дагасан хуулийн түвшинд ч гэсэн авч үзэж явах нь зүйтэй гэж үзэж байна.

Б.Заяабал: Баярлалаа Үүрийнтуяа гишүүнд. Дамдинням сайдын микрофон өгье. 5 номер.

Г.Дамдинням: Эдийн засгийн байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. За яах вэ дээ нэг ийм л юм байгаа юм. Түрүүн бас жоохон зөрүүтэй ойлгоод явчих шиг боллоо. Анар гишүүн надаас асуусан асуулт танай яам яг юу гэж үзээд байгаа юм бэ гэдэг асуулт асуусан. Тэгээд би бол манай яам бол энийг зарчим нь зөв юмаа гэдэг санал өгсөн гэж байгаа юм. Засгийн газрын шийдвэр Очирбат гишүүн ээ, нөгөө гарахдаа бүх яамдаас санал аваад тэгээд танхимын хурлаараа шийдээд гардаг. Тэгээд Засгийн газрын байр суурийг надаас асуувал Засгийн газар дэмжихгүй байгаа. Ийм л байр суурь хэлье. Түүнээс биш нөгөө зөрөөд байсан юм байхгүй. Яг танай яам ямар санал өгсөн юм бэ гэж Анар гишүүн асуусан болохоор манай яамны өгсөн саналыг л би хэлсэн юм. Яг Засгийн газрын байр суурь өөрөөр хэлбэл бүтэн манай Засгийн газрын байр суурь бол дэмжихгүй байгаа тийм.

Б.Заяабал: Дамдинням гишүүнд баярлалаа. Мөнхсоёл гишүүний микрофон нээе.

Б.Мөнхсоёл: Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр энэ одоо энэ Ашигт малтмалын тухай хуулийн төсөл энэний дараа яригдана. Тэгээд миний бодлоор бүгдээрээ нэг асуудлыг заримдаа шийдэхдээ тал талд давхардуулах эсвэл орхигдуулах ийм явц ажиглагдаад байх юмаа. Тэр тал дээр санаа зовж байна. Зохион байгуулалтын асуудал гэх үү, уялдаа холбооны асуудал гэх үү зүйлүүд байна. Тэгээд зарим гишүүд маань ч гэсэн хэлж байна. Нэг талдаа бүсчилсэн хөгжлийн асуудал буюу орон нутгийн хөгжлийн асуудал. Мөн хариуцлагатай уул уурхайн асуудал гээд асуудлууд маш их байна. Анхаарах ёстой тиймээ. Нөгөө талдаа сангууд энийг зохицуулах гээд олноороо байгаа. Орон нутгийн хөгжлийн сан. Тэрнээс гадна Үндэсний баялгийн сан гэж байна. Одоо тэр хууль нь бас дахиад ажлын хэсэг үүсчихсэн, өөрчлөгдөхөөр явагдаж байгаа, явж байгаа. Ирээдүй өв сан, Төсвийн тогтвортой байдлын сан гээд. Тэгээд түүнээс гадна нийтдээ нэг 26, 28 сан байгаад сангуудын менежмент оновчтой зарцуулалт асуудалтай байна гээд цөөрүүлэх тал руугаа явуулж байгаа шүү дээ, явж байгаа шүү дээ. Гэтэл одоо ингээд тэлээд байдаг.

Тэгээд байгалийн баялагтай орон нутгийн хөгжлийн асуудал яригдаж байгаа. Тэрийг шийдэх зорилгын бас нэг сан нь орон нутгийн хөгжлийн сан. Орон нутагт амьдарч байгаа иргэд өөрсдөө тэр амьдарч байгаа хэсгийнхээ хөгжлийн асуудлыг, тулгамдсан асуудлыг шийдэх зорилготой ийм орон нутгийн хөгжлийн сан байгаа шүү дээ. Төвлөрөөд 60, 40-өөр доошоо хуваарилж байгаа. Аймгийн түвшинд 40, доошоо 60 хувь байна уу ийм сан байна. Тэгээд тэрэн дээр нэг утгаар хуваарилдаггүй шүү. Итгэлцүүр гэж байдаг. Тухайн орон нутагт амьдарч байгаа иргэдийн тоо гэж байгаа. Тухайн орон нутгийн алслагдмал байдал ойр бол арай бага хуваарилна, хол илүү хуваарилна. Татварын санаачилга гэж байгаа. Хэр их мөнгө босгож чадаж байгаа юм тухайн орон нутаг. Тэгээд хөгжлийн индекс гэж байгаа гэх мэт. Тэгэхээр чухал итгэлцүүрүүд байгаа. Би тухайлбал орон нутгийн хөгжлийн сан дээр жишээлээд яриад байгаа юм. Тэгэхээр зарим гишүүдийн гаргаж байгаа саналтай би санал нэг буюу одоо тэр Ашигт малтмалын тухай хууль дээрээ бас энэ асуудлыг нэгтгээд аваад үзвэл ямар вэ гэс гэсэн ийм саналыг дэвшүүлж байгаа юм товчхон ингээд үг хэлчихье. Баярлалаа.

Б.Заяабал: Баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх хэсэгт заасныг үндэслэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна аа. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Санал хураалт хууль тус бүрээр явагдана аа.

1.Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

62.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2.Хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

66.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

3.Хамт өргөн мэдүүлсэн Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

54.2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

4.Хамт өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

66.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

5.Хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

66.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулж дууслаа.

Уг хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд танилцуулах уу? Хууль санаачлагч Соронзонболд гишүүн танилцуулна.

Хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа. Хууль санаачлагч болохгүй юм уу. Анар гишүүн сая гар өргөсөн үү? Анар гишүүн уг хуулийн төслийг танилцуулна аа.

Хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудалд оръё.

13.12 цаг

Тав.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Б.Заяабал: Дараагийн асуудал Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя аа.

Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Гонгорын Дамдинням танилцуулна аа. Сайдын микрофоныг нээе. 5 номер.

Г.Дамдинням: Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж заасан. Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийн 1.1-д Ашигт малтмалын тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Ашигт малтмалын тухай хууль нь геологи уул уурхайн салбарын харилцааг зохицуулдаг, салбарын оролцогч талуудын эрх ашгийг тэгш хангах салбарын гол хууль бөгөөд бусад хуультай нийцүүлэн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах шаардлага хэдийнээ үүсээд байна аа. Тухайлбал ХЗДХЯ-тай хамтран хийсэн геологи уул уурхайн салбарын харилцааг зохицуулж буй 10 голлох хуульд дүн шинжилгээгээр хийснээс 2006 онд батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийт 153 өөрчлөлт 111 удаагийн нэмэлт, хүчингүй болсон 29 зүйл заалт байгаа бөгөөд үүний үр дүнд нийт 267 давхардал, 150 зөрчил, 150 хийдэл байгааг тогтоосон байна аа.

Өнөөгийн байдлаар Монгол Улсын эдийн засаг уул уурхайгаас ихээхэн хамааралтай бөгөөд нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийг ашиглах бодлого нь уул уурхайн салбарын шууд болон дам нөлөөг дагасан эдийн засгийн бусад салбарыг дэмжих замаар улс орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, иргэдийн амьдралыг, амьдралын чанарыг дээшлүүлэх шаардлагатайг хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тодорхой заасан байдаг. Иймд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараах асуудлуудыг тусгасан болно оо.

1 дүгээрт, Геологи уул уурхайн салбар нь төрийн урт хугацааны тогтвортой, оновчтой, хариуцлагатай бодлого шийдвэртэй байхаас хамааран хөрөнгө оруулалт хариуцлагатай уул уурхайг дэмжсэнээр иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, байгаль орчныг нөхөн сэргээх, тусгай зөвшөөрлийг зохистой түвшинд эдийн засгийн эргэлтэд оруулах зэрэг эерэг үр дүнг бий болгох нь чухал алхам юм. Өнгөрсөн 25 жилийн хугацаанд 16880 гаруй тусгай зөвшөөрөл олгогдсоноос өнөөгийн байдлаар нийт газар нутгийн 4.6 хувийг хамарсан 2830 ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна аа. Үүнээс нийт газар нутгийн 3.4 хувийг хамарсан 1069 хайгуулын тусгай зөвшөөрөл, 1.2 хувийг хамарсан 1761 ашиглалтын тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байгаа буюу хайгуулын тусгай зөвшөөрөл нь ашиглалтын тусгай зөвшөөрлөөс 2.8 дахин бага байна.

Өнгөрсөн хугацаанд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр болон сонгон шалгаруулалтаар олгох зохицуулалттай байсан хэдий ч Ашигт малтмалын тухай хууль 2006 онд батлагдсанаас хойш 20 жилийн хугацаанд тусгай зөвшөөрөл олголтыг 2010-2013 онд 3 жилийн хугацаагаар, 2019 оны эцсээс 1 жилийн хугацаагаар нийт 4 жил зогсоосон байдаг аа. Энэ нь одоогийн мөрдөгдөж байгаа хуульд хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг бүрэн зохицуулаагүйгээс хөрөнгө оруулагчдад эргэлзээ үүсгэх, хайгуулын ажил зогсонги байдалд орох,

салбарын хөрөнгө оруулалтыг хумих нөхцөлийг бий болгосон бөгөөд нарийвчилсан, оновчтой зохицуулалтыг сонгон шийдвэрлэх шаардлага зүй ёсоор үүсээд байна аа.

Иймд хайгуулын тусгай зөвшөөрлийг олон төрлөөр олгох зохицуулалтыг тусгалаа.

2 дугаарт, одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Ашигт малтмалын тухай хуулиар ААН-үүдийн нэгжүүд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэхээр тусгасан бөгөөд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх бодлого тодорхойгүй байна. Иймд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал баяжуулах үйл ажиллагаа эрхэлж байгаа харилцааг эрх зүйн зохицуулалттай болгох, Ашиглалт баяжуулалтын тусгай зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанаас үүссэн үүсмэл ордыг бусад этгээд ашиглах тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглахаар тусгалаа.

3.Цэвэр эрчим хүч үйлдвэрлэлийн хэрэгцээ нэмэгдэхийн хэрээр чухал ашигт малтмал критикал минералын ханган нийлүүлэлт эрсдэлтэй тулгарч байгааг улс орнууд анхааралдаа авч, бодлого стратегия шинэчлэх, хэрэгжилтийн арга хэрэгслүүдээ өргөжүүлэх, үндэсний болон үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн аюулгүй байдлыг баталгаажуулагдсан арга хэмжээг эрчимтэй эрэлхийлсээр байна. Үүний улмаас чухал ашигт малтмалын эцсийн хэрэглэгч улс орнууд төдийгүй түүний ханган нийлүүлэлтийн гинжин хэлхээнд оролцогч олборлогч боловсруулагч улс орнууд ч чухал ашигт малтмалын бодлого стратегия тодорхойлсоор байна аа. Одоогоор дэлхийн улс орнууд 30-35 элементийг чухал ашигт малтмалын жагсаалтад хамруулсан бөгөөд Монгол Улсад эдгээр элементүүдийн хуримтлал бүхий цэгүүд тогтоогдсон байна. Иймд манай улс чухал ашигт малтмалын бодлогоо тодорхойлж, олон улсад танилцуулснаар энэ төрлийн ашигт малтмалын судалгааг гүнзгийрүүлэх, шинээр орд газруудыг нээх, эдийн засгийн эргэлтэд оруулах, хөрөнгө оруулалт татах, технологийн дэвшлийг нутагшуулах, бэлдэц бүтээгдэхүүн үйлдвэрлэх, дотоодын дэд бүтэц, хүний нөөцийн чадавхаа бэхжүүлэх боломж нээгдэнэ гэж үзлээ.

4 дүгээрт, АМНАТ-ийг бүрдүүлж буй хувь хэмжээнээс хамаарч тухайн орон нутагт нь илүү хуваарилах зорилгоор Төсвийн тухай хуульд өөрчлөлт орууллаа. Тухайлбал орон нутагт уул уурхайн үйл ажиллагааг дэмжих, орон нутгийн хөгжлийн сангаар дамжуулан уурхайн олборлолт хийгдэж буй аймагт түлхүү хуваарилах бодлогыг баримталж, Төсвийн тухай хуулийн 59.7-д заасан АМНАТ-өөс төвлөрсөн орлогыг орон нутаг дахин хуваарилдаг хувь хэмжээг нэмэгдүүлэх болон АМНАТ-өөс орон нутгийн хөгжлийн санд хуваарилагддаг хувь хэмжээг нэмэгдүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.

5.Зэсийн салбарт томоохон тооцогдож буй улс орнуудын тухайд дунджаар 8-10 хувийн АМНАТ-ийг ногдуулж байна аа. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэгт заасан зэсийн ашигт малтмалын боловсруулалтын түвшингээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах АМНАТ-ийн хувь хэмжээг хэт өндрөөр тогтоож өгсөн нь Монгол Улсад шинээр зэсийн ордыг ашиглалтад оруулах нөхцөлийг бууруулж байна аа.

Иймд зэсийн ашигт малтмалын боловсруулалтын түвшингээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн

хэмжээг хувь хэмжээг олон улсын жишигт нийцүүлэн тусгасан бөгөөд төсвийн орлогыг бууруулахгүй байх зорилгоор Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газрын төсөвт төвлөрүүлж байгаа АМНАТ-ийг хэвээр үлдээхээр зохицуулсан.

Хуулийн төсөл батлагдсанаар одоо үйлдвэрлэж байгаа 2.1 сая тонн зэсийн баяжмал үйлдвэрлэл хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор 3.3 сая тонн хүртэл буюу 47 хүртэл хувиар, АМНАТ ноогдуулалтыг 2.25 их наяд хүртэл буюу 37 хүртэл хувиар нэмэгдүүлэх боломж бүрдэнэ. Мөн 2028 оноос 2032 оны хооронд хайгуулын ажил гүйцэтгэж, нөөцийг тогтоосон 20 төсөл хэрэгжих боломж бүрдэж, нийт 5.7 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж улс орон нутгийн төсөвт 13.5 их наяд төгрөгийн татвар хураамж, үүнээс АМНАТ-аар 4 аравны их, 1 их наяд төгрөг төвлөрүүлж шинээр нийт 6986 шууд ажлын байр бий болохоор байна гэсэн тооцоололтой байна аа. Гэвч ОТ төслийн бүлэг ордын харьяанд байгаа Онтре-гийн хэлэлцээр үргэлжилж байгаа учраас Шивээ толгой болон Жавхлант лицензийн талбай дээр хөрөнгө оруулалтын гэрээ хийх ажил бэлтгэл ажил хийгдэж байгаатай холбоотойгоор дээрх зэсийн салбарын АМНАТ-ийг түр хугацаанд хойшлуулах хүсэлттэй байгаа.

6.Уул уурхайн салбарт хувийн хэвшлийн оролцоо нээлттэй болсон сүүлийн 30-аад жилийн хугацаанд нөхөн сэргээлт, хаалтын эрх зүйн зохицуулалт хангалтгүй, тунхагийн шинжтэй, ёс төдий хэв шинжийг агуулсан цөөн тооны зохицуулалттайгаас эзэнгүй орхигдсон, эвдэрсэн газрын хэмжээ 8 мянга орчим га талбайд хүрч хариуцлагагүй уул уурхайн нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдийн бухимдлыг төрүүлэх болсон ба ард иргэдийн эрх ашиг, байгаль орчноо хамгаалах, иргэний нийгмийн байгууллагуудын уул уурхайн эсэргүүцэх үйлдлүүд удаа дараа гарах болсон. Хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэх зорилтын хүрээ уурхайн болон баяжуулах үйлдвэрийн хаалтын эрх зүйн зохицуулалтыг тусгаж, уг харилцааг боловсронгуй болгоно оо.

Ашиглалтын болон баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгоход хаалтын урьдчилсан төлөвлөгөөг ТЭЗҮ-д тулгуурлан боловсруулсан байхыг шаардах бөгөөд олборлолт, баяжуулалтын үйл ажиллагааны туршид хаалтын төлөвлөлтийг бодит нөхцөл байдалд нийцүүлэн тодорхой давтамжтайгаар тодотгож байхаар зохицууллаа. Зарчмын хувьд явцын нөхөн сэргээлтийг дэмжих ба хаалтын санхүүжилтийг бүрдүүлэх болон гүйцэтгэсэн нөхөн сэргээлт, олборлосон ашигт малтмалын хэмжээнд үндэслэн тооцож жил бүрийн уулын ажлын болон баяжуулалтын тайлангийн хамт тайлагнах горимыг нэвтрүүлнэ ээ.

Тус хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу салбарын оролцогч талууд болох иргэд, ААН төрийн болон ТББ олон улсын байгууллагуудад танилцуулан хэлэлцүүлсэн бөгөөд 21 аймгийн иргэд нутгийн болон орон нутгийн байгууллагуудад хэлэлцүүлж нийт 1448 санал авч нийт саналыг нэгтгэн боловсрууллаа.

Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Заяабал: Баярлалаа. Ашигт малтмалын тухай хуульд хуулийн ажлын хэсгийг танилцуулъя. Гонгорын Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Буриадын Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ТНБД, Пүрэвжавын Буянбаатар АМГТГ-ын дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга, Намсрайн Мөнхбилэг УГА-ны дарга, Хүрэлбаатарын Санчигдорж Аж үйлдвэр эрдэс баялгийн яамны Геологийн бодлогын газрын дарга, Сэр-Одын Ган-Очир АМГТГ-ын Хайгуулын хайгуул ашиглалтын газрын дарга, Мөнхсайханы Эрдэнэтулга АМГТГ-ын Кадастрын хэлтсийн дарга гэсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн хүрэлцэн ирсэн байна.

Хуулийн төсөлтэй холбоотой хууль санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Батнайрамдал, Мөнхсоёл гишүүнээр тасаллаа. Ирцийн дарааллаар Үүрийнтуяа гишүүнээс эхэлнэ. Үүрийнтуяа гишүүний микрофоныг өгье.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Ашигт малтмалын хууль хэлэлцэх эсэхээ ярихаар орж ирж байгаад нь би бүүр талархаад байгаа юм. Энэ хуулийг бид зайлшгүй ярих ёстой, зайлшгүй өөрчлөх шаардлагатай болчихсон ийм хууль. Бараг өөрчлөгдөөгүй зүйл заалт байна уу гэж үзвэл цөөхөн байх. Энэ 16 жилийн хугацаанд бараг эрэмдэг зэрэмдэг болгоод энд тэндээс нь оочин цоочин болгочихсон, хоорондоо уялдахаа байчихсан энэ хуулийг өөрчлөх нь зүй ёсны хэрэг юмаа. Тэгээд надад нэг 3 асуулт байна.

1 дүгээрт, одоо энэ баяжмал дээр бид нар хувь хүдэр, баяжмал, бүтээгдэхүүн гээд 3 төрлөөр нь гаргаж байгаад АМНАТ авах хувь хэмжээ өөр өөр байгаа. Татварын хэмжээнүүд өөр өөр байгаа. Гэтэл тухайлах юм бол төмрийн хүдэр дээр агуулахаас нь хамаараад ийм хэмжээтэй агуулгатай байх юм бол нөгөө чанараас нь хамаараад ийм байвал хүдэр гэж үзнэ, ийм байвал баяжмал гэж үзнэ гээд ингээд гаргачихсан. Яг хүдэр нь өөрөө баяжмалын хэмжээний чанартай байгаад баяжмалаар гаргасан тохиолдолд бид нар хүдрээр нь татвар авч чаддаггүй баяжмалаар нь аваад явж байсан тохиолдол байсан шүү дээ. Тэгээд энэ хуулийн төсөл дээр яг энийг зохицуулсан хаасан заалт ерөөсөө орж ирээгүй байх юм. Энийг яаж хаах юм. Маш өндөр чанартай баяжмал юу хүдэр гаргангуутаа түүнийгээ огт баяжуулаагүй мөртөө баяжмалаар гаргаад хүдрээр гаргах ёстой байсан, төлөх ёстой байсан татвараас зугтсан асуудлууд байдаг. Үүнийг яаж хаах вэ нэг.

2 дугаарт, энэ АМНАТ гэдэг нэр томъёо өмнөх хууль дээр байж байгаад сүүлд өөрчлөлтөөр нь аваад хаячихсан. Яг энэнээс болоод Эрдэнэт үйлдвэр дээр маш том асуудал Сангийн яам Татварын ерөнхий газартайгаа Эрдэнэт үйлдвэр шүүхдээд эцсийн дүндээ ялчхаад явж байгаа шүү дээ. Өөрөөр хэлбэл АМНАТ гэдэг бол эдийн засгийн хувьд үр ашигтай, үр ашиг өгөх тэр ашигтай ашигт малтмалаас л бид нар төлбөр авна уу гэхээс биш дагалдах элементэд нь ороод хор болж байгаа нөгөө хорт бодис болж байгаа эргээд роялти буюу нөгөө финалти буюу төлбөр төлж байгаа энэ эрдсүүд дээр нь аваачаад ашигт малтмалын татварыг автоматаар аваачаад тавьчихдаг. Шууд агуулгынх нь хувь хэмжээг нь хараад л салгаж болохгүй зүйл дээр тоос болоод хаягдаж байгаа эрдсүүд дээр нь аваачаад АМНАТ тавьчихдаг дэлхийн хаана ч байхгүй жишиг. Энийг хааж зохицуулсан зохицуулалт нь жишээлбэл хаана байна вэ?

3-т нь Эрдэнэтийн АМНАТ-ийг хэвээр нь үлдээнэ ээ гээд ингээд орж ирж байгаа юм. Энэ Эрдэнэт гэж ер нь яачихсан газар юм бэ. Яагаад энэ хуулийн өөрчлөлтөд хамаарч болохоо байчихсан юм бэ. Онтре ОТ гээд ярихаараа хөрөнгө

оруулалтын тусгай гэрээ гэж хийж байгаад янз бүрээр бууруулаад байдаг. Ганц ажиллаж байгаа үйлдвэрээ ингээд бүх зүйлээр нь дарамтлаад татаад байдаг энэ үйлдвэр өөрөө цаашид яаж хөгжих юм бэ. Ямар ч хөрөнгө оруулалт хийх боломжгүй боллоо шүү дээ. Цаашдаа энэ төсөл ер нь нөөцөө нэмэгдүүлээд дахиад 100 жил явна гээд байдаг. Энэ 100 жил ер нь яаж оршин тогтнох вэ. Ядаж төсөвт нөлөөлнө гэж байгаа бол...

Б.Заяабал: Нэг минутыг нэмж өгье Үүрийнтуяа гишүүний.

Д.Үүрийнтуяа: Хэрвээ үнэхээр одоо энэ АМНАТ-ийн өөрчлөлт нь орж ирээд төсөвт огцом нөлөөлөх гээд байна гэж байгаа бол ядаж үе шаттайгаар өөрчлөх асуудлыг нь оруулдаггүй юм уу. Эрдэнэт үйлдвэр өнөөдөр борлуулалтын орлогынхоо 50 хувийг бүх төрлийн татварт өгч байгаа шүү. Борлуулалтын орлогынхоо 50 хувийг. Ийм ААН хаа ч байхгүй. Тэгээд яаж хөрөнгө оруулалтаа цааш нь авч явах юм. Дээр нь ашгийнх нь 50 хувиар юу ноогдол ашиг авч байгаа юм. Тэгээд яаж хөгжих юм. Та бүхний баталж өгөөд байгаа тэр нөөцийг ашиглаад цаашид энэ 70, 80 жил чинь энэ үйлдвэр юугаараа хөрөнгө оруулалтаа хийх юм татаад л байвал. Аюулгүй байдал хүнийхээ эрсдэлгүй аюулгүй байдлыг яаж хангаж ажиллах юм, ажилчдынхаа ахуй хангамжийг яаж сайжруулж ажиллах юм. Энэ үйлдвэртээ нэг боломж олгохгүй юм уу. Тэгээд ингэж ялгаж үйлчилж байгаад би үнэхээр сэтгэл дундуур байна. Энэ дээр эсрэг байгаа. Гэхдээ энэ хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, засаж сайжруулаад явах нь зүйтэй гэж бодож байгаа. Эдгээр асуултууддаа хариулт авъя.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 5 номерын микрофон Дамдинням сайд.

Г.Дамдинням: Би сүүлийн 2 асуултад нь хариулъя. 3 дахь эхний асуултад манай газрын дарга хариулна аа. Манай Үүрээ гишүүн бол ёстой нөгөө зовлон үзсэн хүн дээ. Энэ уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийг удирдаж байсан энэ газрын амьдралыг бүрэн мэдэж байгаа. Зэсийн салбарт яг гардаж ажиллаж байсан яг л зовлонг нь хэлж байна. Аж үйлдвэрийн эрдэс баялгийн яамны хувьд салбарынхаа ганц одоо энэ бахархал болсон үйлдвэрээ аль болох урт удаан хугацаанд аваад явчих юмсан гэсэн бодолтой байдаг. Ийм зарчмаар бид хуулийн төслөө боловсруулсан. Эрдэнэт үйлдвэрийн АМНАТ-ийг хэвээр үлдээнэ гэдэг дээр бид уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийнхэнтэйгээ зөвшилцсөн юм манай яам ажлын хэсгийнхээ хүрээнд уг нь. 4 жилийн хугацаанд одоо байгаа 21.6. 15 хувийн АМНАТ-аараа яваад ингээд тэрнээс цааш буулгаад ингээд явъя гээд зөвшөөрсөн юм. Бас салбараа өөд нь татъя бид нар хүлээн зөвшөөрөе өө төсвийн орлого бас тасраад байж магадгүй гэж.

Ингээд Хууль тогтоомжийн тухай хуулиараа хууль өргөн барихад Сангийн яам, ХЗДХЯ-аас зөвшөөрөл авдаг. Тэгэхээр энийг хугацаагүй болгохгүй бол энэ хуулийг чинь өргөн барихыг зөвшөөрөхгүй ээ гэдэг ийм шаардлага тавиад байгаа. Тэгэхээр Үүрээ гишүүнтэйгээ санал нэг байна. Сорчилж олборлох л байхгүй юу яг үнэндээ. Ингээд ийм өндөр АМНАТ-аар явбал. 100 жил ашиглах уурхайг 80 жил болгоно. Нэг тонн шороог ухаж гаргаж ирээд, хүдрийг ухаж гаргаж ирээд 10 гр зэс авах боломжтой байсан бол ийм өндөр АМНАТ-тай байхаар 20 гр авахтайг нь ухаад л 10-ыг нь хаяад явдаг хайран орд байхгүй юу. Мэргэжлийн яамны хувьд бол ийм байр суурьтай байгаа. Улсын Их Хурлын ажлын хэсэг дээр засаад явах боломжтой гэж үзэж байгаа юм.

Дагалдах элемент мөн ялгаагүй. Дагалдах элемент дээр зардал гаргадаг болохоос орлого олдоггүй үнэн, судалгаа байгаа. Дагалдах элемент дээр АМНАТ тавьсан бараг цор ганц улс байгаа байх манайх. Би одоо салбарын сайдын хувьд бол салбарынхаа энийг бол хэлж байна. Гэхдээ өргөн барьсан хууль дээр бол нөгөө зөвшөөрөл маань болоогүй учраас арга буюу ингээд орчихсон. Гэхдээ Улсын Их Хурал дээрээ энийгээ засаад яриад явчихад боломжтой гэж үзэж байгаа. Үлдсэн нэг асуултад манай Уул уурхайн бодлогын газрын дарга Намчинсүрэн хариулна.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон нэг минут.

Г.Намчинсүрэн: Үүрийнтуяа гишүүний асуултад нэмж хариулъя. Ашигт малтмалын хуульд бол суурь 5 хувийн АМНАТ дээр нэмэгдүүлэх өсөн нэмэгдэх АМНАТ-ийг хүдэр баяжмал бүтээгдэхүүнд зах зээлийн үнийн өсөлтөөс хамааруулж ноогдуулах зохицуулалттай. АМНАТ-ийг ингээд ийнхүү төмөр дээр жишээ нь татаад сая та ярилаа. Тэгээд төмөр дээр ноогдуулахдаа бид нар хүдэр баяжмал бүтээгдэхүүний нөгөө ангилалд тооцсон Засгийн газрын 2011 оны 193 дугаар тогтоолд заасны дагуу агуулгаар нь тодорхойлж зааж өгдөг. Энэ агуулга дээр бол 57-оос дээш хувийн агуулгатайг бүтээгдэхүүнийг бол төмрийн баяжмалд хамруулахаар, 20-57 хүртэлхийг нь бол хүдрээр тооцохоор бол тусгасан байдаг. Энийг бол цаашлаад бид нар холбогдох стандартад нь өөрчлөлт оруулаад, стандартад оруулсан өөрчлөлтөө Засгийн газрын тогтоолд давхар өөрчлөлт оруулах замаар энэ асуудлыг шийдвэрлэх боломжтой.

Б.Заяабал: Үүрийнтуяа гишүүн тодруулга.

Д.Үүрийнтуяа: Тэр Засгийн газрын тогтоолоор ингээд агуулгаар нь заачихсан байгааг чинь мэдээд байгаа юм л даа. Бид нар энэ дээр тавьдаг хяналт гэж байхгүй байна шүү дээ. Баяжуулах процесс яваагүй байхад хилээр баяжмал гээд гарч байгаад нь бид нар хяналтаа тавьж чадахгүй байгаад байна шүү дээ. Тэгээд ямар стандартыг яаж өөрчлөх юм энэний дараа. Ямар журамд ямар өөрчлөлт оруулах гэж байгаа юм. Тэрийгээ тодорхой хэлж өгөөч. Энд би ямар механизм, ямар процесс хийх гэж байгаа юм бэ? Процесс нь хаягдаад байна аа гэж асуугаад байгаа байхгүй юу.

Б.Заяабал: Ажлын хэсэг хэдэн номер вэ гараа өргөөрэй. 6 номерын микрофон.

Г.Намчинсүрэн: Хүдэр, төмрийн хүдрийн техникийн зохицуулалт шаардлага гээд бол Стандартчилал хэмжил зүйн газраараа 2 жилийн өмнө манай яам батлуулсан байгаа. Уул нь бол энэ стандарт дээрээ бол бид нар баяжуулсан бүтээгдэхүүн гэж юу хэлэх юм бэ гэдэг нь дан ганц агуулга биш хүдрийн ширхэглэл ч гэдэг юм уу ийм ийм зохицуулалтуудыг тэдээс тэдэн миллиметрийн хооронд ингэж буталсан бүтээгдэхүүнийг баяжуулсан процесс орсны дараа баяжмал гэж үзнэ ээ ч гэдэг юм уу ийм бол шаардлагуудаа тавьчихсан. Эсрэгээрээ нөгөө АМНАТ ноогдуулах зорилгоор баталж байгаа аргачлал маань бол зүгээр агуулга заачхаад байгаа юм. Тэгээд бид нар бол ийм бүтээгдэхүүн стандартаа аль болох үндэсний хэмжээнд мөрдөж байгаа стандартаа энэ Засгийн газрын 2011 оны 193 дугаар тогтоолдоо оруулж өгөх чиглэлийг л баримтлан ажиллаж байгаа юм.

Б.Заяабал: Баярлалаа. Одоо Батнайрамдал гишүүний микрофоныг нээе.

О.Батнайрамдал: Ашигт малтмалын тухай хууль олон жил өөрчлөгдөөгүй явж ирж байгаад шинэчлэлүүд орох шаардлагатай гэдэг дээр 100 хувь санал нэгдэж байгаа тиймээ. Миний зүгээр санаа зовоод байгаа зүйл ерөөсөө л зэсийн АМНАТ-ийг бусад АМНАТ-аа хөндөхгүйгээр зөвхөн зэсийн АМНАТ-ийг яг энэ Онтрегийн хэлцлийн үеэр хөндөх нь асуудалтай байна л гэж байгаа шүү дээ. Тэгээд ямар ч байсан хоёулаа Дамдинням сайд энэ дээр одоо ингээд олон нийт ч бас харж байх шиг байна. Ингээд ойлгомжтой болгох хэрэгтэй. Өчигдөр МАН-ын бүлгийн хурлаар орж танилцуулсан. Тэрэн дээр бол бид нар байр суурь нэгдсэн бүлэг шийдэл гаргасан нэг зүйл бол зэсийн АМНАТ-ийг Онтрегийн хэлцэл дуустал хөндөхгүй. Энэ зарчмаар энэ Ашигт малтмалын тухай хуулийн хэлэлцэх эсэхийг шийдээд ингээд цаашдаа явна аа гэдэг. Энийгээ бүгдээрээ олон нийтдээ ойлгомжтой болгох хэрэгтэй. Яагаад гэхлээр энэ үр дагавар нь бусад 20 төслөө нийлүүлээд тэд нараас 10 дахин үржсэнтэй том хэмжээний хэлцэл Онтре өөрөө дангаараа байхгүй юу. Удахгүй 2, 3-хан жилийн дараа дэлхийн гуравдагч том зэсийн олборлогч болох ОН-н геологийн нөөцийнхөн геологийн нөөцийн 30 хувь нь Онтре дээр байгаад байна шүү дээ.

Дээрээс нь Онтре гэдэг чинь тэр чигээрээ алтны маш өндөр агууламжтай. Онтрегийн ТЭЗҮ-гээр аваад үзэх юм бол нэг тонныг олборлох нийт зардал нь хөрөнгө оруулалтаа ороод шүү өртөг нь 3 мянган доллар байхгүй юу. Өнөөдөр үнэ 14 мянга байгаа. Ер нь алтаар хамаг зардлаа хаагаад, цэвэр зэс нь тэр чигээрээ ашиг болж үлдэх ийм л төсөл байхгүй юу ер нь бол. Тийм учраас энэ Онтрегийн хэлцэл ач холбогдлын хувьд үр дагаврын хувьд энэ хэдэн их наяд, хэдэн тэрбумаар яригдах юмаа. Тэгэхээр ийм том гэрээ хэлэлцээр явж байх үед бид нарын энэ АМНАТ өөрчилж байгаа нь бид нарт сул тал болчих вий л гэж болгоомжилж байгаа л зүйл байгаа юм.

Тэгэхээр энийгээ та бас нэг маш ойлгомжтой хэлээд энийг олон нийтэд ч гэсэн ойлгомжтой болгох хэрэгтэй. Тэгээд ер нь хүлээлт ч үүсэх ёстой. Цаашдаа энэ дээр ажлын хэсэг гараад явахад ч гэсэн зэсийн АМНАТ-ийг Онтрегийн хэлцэл дуустал хөндөхгүй шүү. Энэ дээр бүгдээрээ байр суурь нэгдэх ёстой байхгүй юу. Яагаад гэх юм бол энэний үр дагавар дахиад дараагийн 10, 20 жилдээ яригдах тийм том хэмжээний орд мөн шүү дээ Онтре дангаараа. Энэ дээр Дамдинням сайдаас тодруулга авчихъя.

Д.Үүрийнтуяа: 5 номер Дамдинням сайд.

Г.Дамдинням: Тийм Батнайрамдал гишүүндээ талархал илэрхийлье. Би бас санал нэг байгаа. Энэ стратегийн орд газруудын хэлэлцээр Хөрөнгө оруулалтын тухай хуулиар явагдаж тусгайлсан АМНАТ тооцож ингэж явдаг ч гэсэн энэ том хэлэлцээр явж байгаа үед бас хардлага сэрдлэг дагуулаад яах вэ. Энэ ашигт малтмалын хууль маань 14 жил 12, 13 дахь жилдээ яригдаж байж орж ирж байгаа. Тийм болохоор том хэмжээ нь энэ олон өөрчлөлтүүдийн зөвхөн нэг нь зэсийн АМНАТ юм байгаа юм. Тэгэхээр энэ хэсэг дээрээ бол ойлголцоод тэгээд Батнайрамдал гишүүнийгээ ингээд ажлын хэсэгт ороод ажиллаач ээ гэж урьж байгаа. Тэгээд энэ АМНАТ-тай холбоотой асуудлууд тэр зэсийн АМНАТ-ийг бол Онтрегийн хэлэлцээрийг дуустал хойшлуулах тал дээр бол Засгийн газар байр суурь нэг байгаа.

Нэг зүйлийг тодотгож хэлье. Монголчууд бүгдээрээ нэг баг. Газрын хэвлийн баялгийнхаа үр өгөөжийг ард түмэндээ авч өгөхийн төлөө Засгийн газар, Улсын Их

Хурал ард иргэд бүгд нэг баг болж ажиллаж байгаа. Бидний дунд дайсан байхгүй. Үндсэн хуулиар 6.2-т Газрын хэвлийн баялгийг дийлэнх олонх буюу 51-ээс дээш хувийг ард иргэдэд үнэ төлбөргүй авчирч өгнө өө гэдэг ийм өгөөжийг нь өгнө өө гэдэг заалттай. Үндсэн хуулиас дээгүүр гарсан гэрээ, Үндсэн хуулиас дээгүүр гарсан бусад хууль гэж байхгүй. Тэгэхээр Онтрегийн орд газрын Онтре гэдэг компанийн Онтре л гэж нэршихээд байгаа юм л даа. Уг нь лиценз нь Шивээ Толгой, Жавхлант гэдэг 2 одоо лицензийн талбайн орд газрын ОТ-н бүлэг орд газрын хэсэгт орж байгаа энэ талбайн өгөөжийн 51 хувь Монголын ард түмэнд ирнэ хамгийн багадаа. Түүнээс дээш ирүүлэх чиглэлд хэлэлцээр үргэлжлээд явж байна. Тэгээд тантай санал нэг байгаа. Сая би бас танилцуулга дээрээ уншихлаа Батнайрамдал гишүүн ээ тийм. Тэгээд ард түмэндээ бас нээлттэй ингээд хэлчихсэн нь дээр байх тийм.

Д.Үүрийнтуяа: Батнайрамдал гишүүн тодруулъя.

О.Батнайрамдал: Тэгэхээр ямар ч байсан зэсийн АМНАТ-өө бүгдээрээ Онтрегийн хэлцэл дуустал хөндөхгүй гээд тохирчихлоо гэж ойлгож байгаа шүү дээ. Тэгэхээр түрүүнд Та бас дурдаж байна. Яг энэ хэлэлцээр дээр би Хянан шалгах түр хорооныхоо 3 өдөр маш олон удаа давтаж байсан. Монголын тал бид нар бүгдээрээ нэг талдаа гарна аа. Нам хамаарахгүйгээр, улс төр хамаарахгүйгээр Монгол Улсын эрх ашиг гэсэн ганцхан зүйл ОТ-н хэлэлцээр Онтрегийн хэлэлцээр дээр байгаа. Асуудалтай эсвэл асуудал дагуулахаар эсвэл сул талтай юм байвал зад шүүмжилнэ ээ. Гэхдээ эцсийн эцэст бүгдээрээ Монгол Улсын эрх ашгийн төлөө л явж байгаа. Онтре дээр нэг заавал нэг түүхэн гэрээ байгуулагдах ёстой юмаа. Ингэж байж бид нар дараа үедээ өөрсдийнхөө үедээ үүрэх ачаагаа хариуцлагатайгаар үүрч, дараа нь дахин Хянан шалгах түр хороо байгуулагдахгүй хэмжээнд энэ гэрээ хэлэлцээр явагдах ёстой юмаа. Тэгээд энэ дээр Засгийн газрыг дэмжиж байгаа.

Д.Үүрийнтуяа: Хариултаа авч байж сонгох юм байна та. Хариулт Дамдинням сайдын микрофоныг өгье 5 номер.

Г.Дамдинням: Батнайрамдал гишүүн бас дэмжиж байгаад бид бас өчигдөр нэлээн ярилцаад ойлголцолд хүрсэн. Тэгээд бид нэг талдаа байгаа. Одоогийн ОТ-н хөрөнгө оруулалтын гэрээний алдаа руу бид нар оруулахгүй. Тусад нь хөрөнгө оруулалтын гэрээ болгоно. Өмнө нь алдсан бүх алдаагаа засаж, ирээдүйн алдаа дутагдал гаргахгүй байх тал дээр Засгийн газар, Улсын Их Хурал ард иргэд, эрдэмтэн мэргэдтэйгээ хамтарч бүгдээрээ урагшаа явна аа гэдэг зарчмын байр суурь дээр санал нэг байна аа.

Д.Үүрийнтуяа: Уянгаа гишүүн асуултаа асууя.

Б.Уянга: Яг энэ зэсийн АМНАТ-тай холбоотой тодруулаад нэмэлт хариулт авъя. Тэгэхээр ер нь ОТ-н бүлэг орд дээр нэмэлтээр байгуулагдах гэж байгаа хөрөнгө оруулалтын гэрээнд энэ хуулийн төсөлд орж ирж байгаа 10 хувь таазтай зэсийн АМНАТ л орохгүй гэж ойлгох уу? Яагаад гэхээр манай энэ Ашигт малтмалын тухай хууль дээр болохоор 10 хувиар орж ирээд ингээд хэлэлцүүлэгдээд явж байна шүү дээ тиймээ. Тэгэхээр буурч байна аа гэсэн үг. Тэгэхээр зүгээр одоо гарах гарцаа юу гэж харж байгаа юм бол? Дагаж мөрдөх журмын тухай хууль гаргаж байгаад яг ОТ бүлэг орд дээрээ нэмэлтээр хөрөнгө оруулалтын гэрээ хийж дуустал ОТ-н бүлэг ордын хувьд яг энэ хуучин зохицуулалтаар явна аа гээд Дагаж мөрдөх журмын тухай хууль гаргах юм уу. Энэ болохоороо Их Хурал дээр хийдэг л асуудал болох байх. Эсвэл Эрдэнэт үйлдвэр дээр нэг Улсын Их Хурлын тогтоол орж ирэх гэж

байгаа шүү дээ тиймээ нөгөө АМНАТ-ийг нь хэвээр нь байлгана гээд. Яг одоо бид нарт тараагдсан дээр харагдахгүй байна. Яг тэрэнтэй адилхан нэмэлт Улсын Их Хурлын тогтоол гаргаад яг энэ ОТ-н бүлэг ордод энэ хамаарахгүй ээ гэж гаргах юм уу. Ирээдүйд удахгүй орох гэж байгаа зэсийн төслүүдээ бид нар ОТ дээр нэмж байгуулагдах Хөрөнгө оруулалтын гэрээнээс болоод гацаагаад байж болохгүй гэж бодож байна. Тэгэхээр яг энэнийхээ гарцыг манай энэ хуулийн төслийг боловсруулсан ажлын хэсгийнхэн юу гэж харж байна вэ? Эхний асуулт.

Дараагийнх нь хуулийн төсөлд зүгээр энэ аж үйлдвэр эрдэс баялгийнхан орон нутагт хөлтэй болоод тэрийгээ бэхжүүлэх зүйлээ оруулах байсан юм биш үү. Ингээд олон тусгай зөвшөөрлүүд олгогдсон яах вэ одоогоор яг үнэндээ тийм газар нутгийн хэмжээтэйгээ харьцуулах юм олон тусгай зөвшөөрөл байхгүй. Гэхдээ газар дээр нь очоод хянаж байдаг, харж байдаг тийм орон нутагт хөл байхгүй байсаар ирсэн. Хэдхэн жилийн өмнө нэг 7 газар бүс гэж байгуулаад нэг овоо олон хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллуулж байсан нь тус бүрдээ 2, 2 хүнтэй АМГТГ-т байгаад байгаа байхгүй юу. Тэрийг зүгээр Аж үйлдвэр эрдэс баялгийн яам өөрийнхөө доор аваад бүүр аймаг бүрдээ яг энэ хянаж байдаг, хэрэгжилтийг нь хангаж байдаг хөл дутагдаад байгаа юм шиг харагдаад байгаа юм. Тэгээд энэ хуулийн төсөлд орж ирээгүй энийгээ яаж оруулж ирэх вэ? энэ бол 2 дугаар асуулт байгаа юм.

3 дахь нь Маркшейдерийн тусгай зөвшөөрлийг шинээр бий болгож байна аа. Маркшейдерийн ер нь бол тусгай зөвшөөрлүүдийг шинээр нэмэхгүй, тусгай зөвшөөрөл олгоно гэсэн нэг харилцаа үүснэ. Аж үйлдвэрийн яам нь энийг олгох юм байна. Яг үндсэн шаардлага нь юу байгаа юм бэ? Ийм 3 асуулт асууя.

Д.Үүрийнтуяа: Дамдинням сайд 5 номер хариулъя.

Г.Дамдинням: Сүүлийн асуултаас нь эхэлье ээ. Ашигт малтмалын салбарт Маркшейдер гэдэг хүн бол яг хэмжилт хийдэг хүн. Өөрөөр хэлбэл нүд нь, жин нь метр нь байхгүй юу тиймээ. Нөгөө Уянга гишүүн бол манай салбарын дэд сайдаар ажиллаж байсан энэ геологийн салбарын доктор хүн. Маш сайн мэдэж яг л чухал асуултууд асуугаад байна. Тэгэхээр сүүлийн үед бас ийм маркшейдерийн тусгай зөвшөөрөл өгч энэ хүмүүст хариуцлага тооцдог болохгүй бол хөндлөнгийн хэмжилт хийж энийг чинь шалгаж байхгүй бол байгаа баялгийг их багаар үнэлэх тухай асуудал яригдаад байдаг болчихоод байгаа юм. Хөрсний сийрэгжилтийн асуудал яригдаад байдаг болчихоод байгаа юм. Хулгай зэлгийн асуудал яригдаад байдаг болчихоод байгаа юм. Тэгэхээр энийг хянадаг байя л гэж байгаа юм. Хяналт шалгалт дарамтыг бууруул гэдэг нь зөв. Тэгэхдээ баялгийн салбар дээр хэдүүлээ бас нэг чангахан шиг байхгүй бол болохгүй байна аа, алдаад байна. Ийм учраас энийг оруулж ирж байгаа юм. Олон хүн биш байх салбараа тэр чигт нь муухай хэлээд яах вэ. Цөөн тооны зарим санаатай этгээдүүдийн үйлдэл байна аа.

2 дугаар асуудал орон нутагт хөлтэй болох тухай асуудал. Яах вэ ийм л юм даа. Одоо Монгол Улсын нийт төсвийн орлогын 30 хувийг бүрдүүлж ДНБ-ий 34 хувийг бүрдүүлээд орж ирж байгаа шинэ 100 доллар болгоны 95-ыг нь оруулж ирдэг салбар аа манай салбар. Тэгэхдээ 17 яамны 17 дахь бага төсөвтэй яам байдаг аа өөрөө. Энэндээ гомдоллодоггүй бид нар. Төсөв хүнд байгаа энэ үед бид нар шинэ орон тоо үүсгээд ингээд явна гэхээсээ илүүтэй байгаа нөөц бололцоогоо ашиглаад явъя л гэж үзэж байгаа үнэн. Улсын хэмжээнд 7 хүн л хяналт тавьдаг. Гэхдээ бас нэг зарчмын ойлголт байгаа юмаа Уянга гишүүн ээ. Юу вэ гэхээр өөрөө зөвшөөрөл

өгөөд ингээд явуулдаг салбар нь өөрөө өөрийгөө хянах чинь бас нэг их тийм зохистой биш байгаад байгаа байхгүй юу.

Тийм учраас одоо энэ байгаль орчны салбарт энэ нөхөн сэргээлт хариуцлагатай уул уурхайтай холбоотой хяналтыг өгч байгаа. Байгаль орчны салбар бол сум болгонд байгаль орчны байцаагчтай. Орон нутгийн сумын засаг дарга, аймгийн засаг дарга нар энэ хариуцлагатай уул уурхай байгаль орчинтой холбоотой нөхөн сэргээлтийг 100 хувь хариуцах нь бас нөгөө талдаа зохимжтой байгаад байгаа юм. Хянах ёстой байхгүй юу өөр салбараас энийг. Ийм учраас бид нар энийг оруулж ирсэнгүй ээ. Онтретэй холбоотой асуудал дээр эхний асуулт Онтрегийн хэлэлцээртэй холбоотой асуудал дээр энэ зэсийн АМНАТ-ийг ингээд түр зогсоохдоо хэд хэдэн хувилбар байна. Хэдүүлээ ажлын хэсэг дээрээ яриад явчихвал хувилбар гарна байх гэж бодож байна.

1 дүгээрт бол дагаж мөрдөх журмын тухай хуулиар хийж зохицуулж болж байна.

2 дугаарт тусгайлсан тогтоол дагуулж гаргаж болж байна. Тэгээд энэ 2 хэлбэрийг ажлын хэсэг дээрээ ярьж байгаад хэдүүлээ шийдээд явчих боломжтой гэж харж байгаа. Хуулийн төсөл өргөн барьчихсаны дараа яригдсан асуудал учраас ингэж шийдэх гарц байгаа тийм.

Д.Үүрийнтуяа: Уянгаа гишүүн тодруулъя.

Б.Уянга: Чухал ашигт малтмалын зохицуулалт дээр нэмээд асуулт асууя. Одоогоор төсөл дээр болохоор чухал ашигт малтмалын төрөл чиглэл тус бүрээр бодлого, стратеги, замын зураг боловсруулах, хэрэгжүүлэх гээд Засгийн газарт газрын үүрэгт оруулж өгсөн л заалт байна. Тэгээд яах вэ тодорхойлолтыг нь оруулж өгсөн байна. Чухал ашигт малтмал дээр тэгвэл хайгуул хийж байгаа эсвэл олборлолт явуулж байгаа явуулах гэж байгаа ААН-үүдээ тодорхой хэмжээнд нь дэмжих чиглэлд ямар зохицуулалт орж ирэв ээ? Яваандаа чухал ашигт малтмал нь явсаараа байгаад стратегийн ашигт малтмалын орд болоод л бүүр хатуураад явчих вий дээ. Уул нь яг энэ заалт орж ирж байгаагийнх дээр энэ чиглэлийг хөгжүүлээд өгөөч ээ, хайгуулыг нь хийгээд өгөөч, судлаад өгөөч л гэсэн ойлголт байх ёстой. Тэгэхээр яаж дэмжих вэ? Дэмжсэн агуулга нь хаана байна вэ?

Д.Үүрийнтуяа: Хэн хариулах вэ? Дамдинням сайд 5 номерын микрофоныг өгье.

Г.Дамдинням: Чухал ашигт малтмал бол геополитик болчихоод байна. Үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал болчихоод байгаа. Тэгэхээр чухал ашигт малтмал гэж Монгол Улсын хувьд юу вэ гэдгээ 1 дүгээрт тодорхойлно. 2 дугаарт тухайн чухал ашигт малтмалын салбарт хэнтэй хамтарч ажиллах юм бэ гэдгээ Засгийн газар шийдвэрлэнэ, танилцуулна. 3 дугаарт тусгайлсан бодлого гаргаж геологи эрэл судалгааны ажлын чиглэлд нь дэмжлэг үзүүлж төсөв хөрөнгө тавих чиглэлд дэмжлэг үзүүлнэ гэсэн ийм л одоо чиглэлтэй байгаа.

Д.Үүрийнтуяа: Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуултаа асууя.

Б.Мөнхсоёл: Өдрийн мэнд. Би бараг асуулт гэхээсээ илүү өөрөө ажлын хэсэгт орж ажиллаж байсан. Энэ засгаас орж ирэхээс өмнө Их Хурал дээр бас анх

Амарбаясгалан дарга байхад ажлын хэсэг үүсгээд Уянгаа гишүүн ахал луу, Үүрийнтуяа гишүүн, Наранбаатар гишүүн ахлаад бид хэд ажиллаж байсан юм. Тэгээд өөрчлөлт орсон байна.

Тэгээд хуулийн төсөл нь 1 дүгээрт геологи хайгуулын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх. 2 дугаарт хувийн хөрөнгөөр геологийн суурь судалгаа эрлийн ажил хийлгэх. 3 дугаарт чухал ашигт малтмалын бодлого тодорхойлох. 4-д баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд зохицуулах. 5-д уурхайн хаалт нөхөн сэргээлтийн санхүүгийн баталгааг сайжруулах. 6-д орон нутгийн оролцоо ба ил тод байдлыг нэмэгдүүлэх гээд ийм чухал зорилгууд уг нь байгаа. Энэ зорилгынхоо хүрээнд би өөрөө дэмжиж байгаа энэ хуулийг хэлэлцэх хэрэгтэй. Гэхдээ хэлэлцэхдээ маш олон заалтуудыг чухалчлан харахгүй бол нийгэмд ч гэсэн үүсээд байгаа асуудлууд зөрчлүүд үүсчхээд талцаад байна шүү дээ. Тэгэхээр давхардал байна аа. Хамгийн гол асуудал хөрөнгө оруулагчийн олон нийтийн эрхийн тэнцвэр алдагдах эрсдэл бас байна гэж харж байна. Тусгай зөвшөөрөл олгох өрсөлдөөнт зарчмыг зарим нэг хэсэгт сулруулсан харагдаж байна. Бид нар уг нь хайгуулын лицензийг олгоод энэ уул уурхайн салбарыг эргэлтэд оруулъя гэсэн зорилго байгаа. Гэтэл нөгөө механизм дээрээ алдчихвал эргээд зөрчил үүснэ ээ.

Тэгээд чухал ашигт малтмалын тодорхойлолтын талаар сая Уянгаа гишүүн асууж байна. Жагсаалтад оруулах хасах шалгуур тодорхойгүй байна аа гэж харж байна. Хэрвээ энэ тодорхойгүй байдал явах юм бол татвар, зөвшөөрөл, төрийн дэмжлэг, экспортын бодлого дээр маргаан үүсэх ийм эрсдэл үүснэ тиймээ маргаан бий болох. Тэгээд жагсаалтад оруулах шалгуурыг хамгийн наад захын доод түвшинд тогтоох хэрэгтэй гэж үзэж байна. Эдийн засгийн ач холбогдол нь нийлүүлэлтийн эрсдэл, өндөр технологи, тэгээд эрчим хүчний шилжилтэд шаардлагатай байдал энэ тэр гээд нарийвчилж оруулах хэрэгтэй гэж бодож байгаа шүү. Чухал ашигт малтмалын жагсаалттай холбоотой. Тэгээд жагсаалтыг 3 жил тутам шинэчилж мэргэжлийн байгууллага тэгээд Засгийн газар тэгээд иргэний нийгмийн байгууллага гэсэн энэ 3 талт энэ хэлэлцүүлгээ явуулах ёстой, саналыг нь авах ёстой гэсэн ийм саналтай байна.

Дараагийн нэг чухал асуудал нь баяжуулах үйлдвэрийг тусгай зөвшөөрөлтэй болгох нь уг нь гарал үүсэл тодорхойгүй ашигт малтмал баяжуулах, химийн хорт бодис, хаягдал, ус ашиглалтын эрсдэлийг бууруулах ач холбогдолтой шүү дээ. Энэ дээр эргэж анхаарах ёстой гэж бодож байна. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж өөрийн олборлолтоо баяжуулахад давхар зөвшөөрөл шаардахгүй гэдэгтээ бол дэмжиж байна аа гээд ингээд саналаа оруулчихъя. Тэгээд хэлэлцэх эсэхийг дэмжиж байгаа. Дараа нь ажлын хэсэг үүсэхэд орно гэсэн ийм төлөвлөгөөтэй байна аа.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Мөнхсоёл гишүүн санал хэллээ. Ганбатын Очирбат гишүүн асуултаа асууя.

Г.Очирбат: Энэ Монгол Улсын эдийн засагт хамгийн том байр суурь эзэлдэг экспортын 90 орчим, экспортын орлогын 90 орчим хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 80 орчим хувь, аж үйлдвэрийн салбарын 72 орчим хувь, төсвийн 30 орчим хувь, ДНБ-ий 27 хувийг эзэлдэг ийм том салбарын хууль эрх зүйн шинэчлэлтийн орж ирж байгаа юм. Тэгээд орж ирэхдээ эдийн засагт ингэж томоор нөлөөлдөг юмыг зөвхөн ингээд зэсийн АМНАТ дээр илүү тийм тодруулж томруулаад оруулж ирж байгаа нэг дэх агуулга нь.

2 дахь нь энэ хувийн хэвшлээр энэ суурь судалгаа, хайгуул хийлгэнэ гэгчихсэн нэг ийм агуулгатай л орж ирж байна гэж хараад байгаа юм. Тэгэхээр ер нь одоо ингээд цаашдаа бид нар энэ уул уурхайн салбарыг чинь зөвхөн зэс гэж харах юм уу, алт, зэс, төмөр, жонш энэ газрын доорх баялгаа нийтэд нь харж оруулж ирэх юм уу гэдэг нэг асуулт байна. Яагаад гэхээр ингээд та хэд энэний өмнөхөн энэ Газрын тосны тухай хуулийг бид нар хэлэлцлээ. Бадамсүрэн гишүүн 2 мянга түрүү жилийн 7 сард 2025 оны 7 сард энэ хуулийн төслийг өргөн барьсан. Энэ хууль дээрээ та хэд маань яам нэгтгээд ажиллах боломж байсан. Их Хурлын гишүүдийн өргөн барьж байгаа хуулийн төслүүд бол нээлттэй байдаг. Энэ хүмүүстэй нь уулзаад нэг мөр энэ том хуулийн төсөл дээр оруулж ирээд асуудлыг шийдээд явчих боломжууд байхад энэ боломж бололцоогоо манай Засгийн газрынхан эрэлхийлэхгүй байна гэж харж байгаа шүү.

2-т улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сүүлийн 5 жилд, сүүлийн 5 жил гайгүй л байсан. Ямар хэмжээний үр дүн гарсан юм бэ? Энгийг нэг асуучихъя. Тэгээд яагаад одоо хувийн хэвшлээр хийлгүүлэх гэж байгаа юм гэдэг асуулт байна. Та хэд санаж байвал ер нь энэ уул уурхайн салбар тогтвортой хөгжихгүй бол цаашаа хөгжил хөгжлийн бодлого цаашаа хэрэгжиж явахгүй ээ. Энэ 2018 онд санагдаж байх юм. Энэ Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.13-ыг 26.9-ийг ашиглаад Засгийн газар шийдвэр гаргаад дүйцүүлэхээр талбай өгсөн. Тэр талбайг шийдвэр гаргасан Ерөнхий сайд нь огцорсон, шорон оронд бүүр явсан. Ер нь цаашдаа ингээд уул уурхайн салбар дээр ийм шийдвэр гаргахад шоронжуулаад аваачсан шийдвэр гаргасан хүмүүсийг нь ялтан болгоод байвал гадаадын хөрөнгө оруулалт Монголд яаж орж ирэх юм.

Миний авч байгаа мэдээллээр бол бараг энэ 150 орчим ААН, 100 гаран 150 орчим ААН энэ урт нэртэй хууль болон төв зам орсон төмөр замын трасс орсон ингээд явсан. Тэгээд эд нар дээр ер нь ямар одоогийн байдлаар хохирол үүсчхээд байгаа юм. Тэгээд эхлээд та хэд энэ хөрөнгө оруулалт хийчихсэн компаниудынхаа асуудлыг шийдээгүй байж байж дахиж баахан хувийн хэвшлээр та хэд өөрсдөө хайгуул хийх юм бол 2 жилийн дараа бид нар лицензийг чинь ямар нэгэн өрсөлдөөн шалгуургүйгээр өгнө өө гээд хуулийн төслөө оруулаад ирж байгаа. Тэгэхээр энэ нөгөө эрх ашиг нь хөндөгдсөн байгаа энэ ААН-үүдийнхээ асуудлыг яаж шийдсэн юм. Ингээд үндсэн 3 асуултад хариулт авчхаад тодруулъя тэгэх үү.

Д.Үүрийнтуяа: Дамдинням сайд хариулъя 5 дугаар микрофон.

Г.Дамдинням: Очирбат гишүүний асуултад хариулъя. Энэ аягүй чухал байгаад байгаа юмаа. Манай улсын эдийн засаг өөрөө нүүрснээс хамааралтай эдийн засгийн бүтэцтэй болчихоод байна. Дэд бүтэц нь хүртэл нүүрсний дэд бүтэцтэй. Тэгэхээр нүүрсний үнэ унахтай зэрэг л эдийн засаг хүндэрчихдэг, нүүрс сайн байвал сайжраад байдаг бусад түүхий эдүүд дээрээ ер нь уул уурхайн бодлого бол түүхий эд болгон дээрээ бодлого хийж явдаг ийм л салбар юм. Алийг нь өргөх юм, алийг нь жоохон барих юм гээд ингээд явдаг. Хаашаа барьж явах юм гэдгээ. Тэгэхээр манайх бол одоо 2 дахь эдийн засгийн хөдөлгөгч хүч суурь бол зэс гэж харж байгаа. Энэ үндэслэлтэй юу вэ гэхээр нүүрсний зах зээл дэлхийд 850 тэрбум долларын зах зээл байгаад байгаа юм одоо. Зэс бол 500 тэрбумын зах зээл. 2 дахь том нь энэ. Газрын ховор элемент гээд л яриад байдаг. 15 тэрбум долларын зах зээл дэлхийн жилдээ. Уран бас нэг 10 орчим тэрбумын л зах зээл байхгүй юу. Тэгэхээр улс төрийн, геополитикийн, эдийн засгийн ач холбогдолтойгоос нь ингэж

харж байгаад бид бол зэсийг дараачийнх нь гэж харж байна. Үргэлжлүүлээд одоо бусад том хэмжээний нөлөө үзүүлэх салбаруудыг энэ чухал элементүүдийнхээ томьёолол эрэл судалгаанаасаа томилоод явна аа гэж харж байгаа юм.

2-т нь Газрын тосны хуулийн асуудал ярьж байна. Газрын тосны хуультай холбоотой асуудал дээр бид одоо манай яам хууль бэлдээд явж байгаа. Тэгээд одоо энэ Улсын Их Хурлын гишүүд бол өөрсдөө хууль санаачлаад явах эрхтэй учраас бид одоо энд боль зогс гэж хэлж чадахгүй. Тэгэхээр Газрын тосныхоо хуулийг боловсруулаад энэ орж ирсэн хуультай уялдуулаад нэгтгээд явъя гэсэн ийм байр суурьтай байгаа. Ер нь энэ хаврын чуулгандаа багтаагаад өргөн барьчихъя гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сүүлийн 5 жилд хийсэн ажилтай холбоотой мэдээллийг манай геологийн албаны дарга өгнө. 9.1.13-тай холбоотой асуудал, дүйцүүлэхтэй холбоотой асуудал, дүйцүүлэхтэй холбоотой асуудал бол үнэхээр зовлонтой асуудал. Энийг шийдэх хууль нь байгаа. Шийдээд хууль эрх зүйн ял шийтгэл рүү яваад орчихсон. Үнэнийг хэлэхэд салбарын сайд хийгээд хуулийн дагуу асуудал шийдсэнийхээ төлөө элдэв хариуцлага хүлээх зориг алга. Тэгэхээр энэ ний нуугүй хэлэхэд би бол манай салбарын асуудлаас өөр ганц салбарын асуудал болов уу л гэж хараад байгаа юм.

Д.Үүрийнтуяа: Үндэсний геологийн албаны дарга Мөнхбилэг 3 номер хариулъя.

Н.Мөнхбилэг: Гишүүний асуусан асуултад хариулъя. Сүүлийн 5 жилийн байдлаар улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн судалгааны ажлын үр дүнг бид үндсэндээ 2 байдлаар томьёолж болно. Нэг нь мэдээж зураглалын ажил буюу геологийн суурь судалгаа хийгдсэн талбайн хэмжээ, нөгөөдөх нь болохоор зэрэг ерөнхий эрлийн ажлын үед тогтоогдсон баялаг. Баялгийн хувьд бид сүүлийн 5 жилийн хувьд баялгийн тоо хэмжээг нэг бүрчлэн танд тухайлсан ажлын шугамаар хүргүүлъя. Зүгээр хамрагдсан талбайн хувьд бид ердөө 1 нийт газар нутгийн 3 хувь 3-5 хувийг л хамраад байна. Тэгээд энэ хуульд орж ирж байгаа гол санаа нь юу вэ гэхээр зэрэг бид улсын төсвийн хөрөнгөд дулдуйдаж нийт нутаг дэвсгэрийн судалгааг хийх юм бол энэ маань дахиад одоо бидэнд хийгдээгүй...

Д.Үүрийнтуяа: Гүйцээж хариулъя 5 номер Дамдинням сайд.

Г.Дамдинням: Энэ эрлийн ажил гэдэг бол зөвхөн ашигт малтмалын салбарт зориулагддаггүй ажил. Энэ онцгой байдал, үер ус, хот байгуулалт, ХАА, газар тариалан гээд ингээд бүх асуудлуудаа хэрэгтэй судалгааг дэлхийн бүх улс орнууд хийдэг. Энэнд харамсалтай нь төсвийн хөрөнгө бага байна аа гээд мөнгө тавьж өгдөггүй. Эрлийн ажлыг хийхгүйгээр геологийн ажил явахгүй, геологийн ажил хийхгүйгээр уул уурхай байхгүй. Өөрөөр хэлбэл Монгол Улс өнөөдөр 1990 оноос өмнөх эрэл судалгааны ажлын үр дүнгээр амьдарч байгаа. Ирээдүйн үр хүүхдийнхээ хоол хүнсийг бид нар бэлдэх ёстой. Энэний тулд бид нар хувийн хэвшлийн хүчийг татаж оруулж ирье. Улсын төсвийн хөрөнгөд найдахад их удаан явахаар байна. Энэ жишиг шинэ жишиг биш. Канад, ОХУ, Казахстан гээд энэ уул уурхай явж байгаа улс орнуудад хийгдэж байгаа аргачлалыг оруулж ирж байгаа. Хувийн хэвшил энэн дээр эрлийн ажил хийгээд ингээд улсад хүлээлгэж өгдөг энэ тогтолцоо, энэ шинэ боломжийг ашиглая гэж байгаа юм.

Д.Үүрийнтуяа: Нэмж хэн хариулах вэ? Хариулт болоогүй байна гэж байна. 7 номер.

Гишүүний асуултад хариулъя. Ер нь бол 50 мянганы зураглалын ажил хийсэн талбай нэг 50 хувьд байгаа. Тэгэхээр жишээлбэл энэ жилийн хувьд 20 тэрбум төгрөгөөр улсын төсөвт тусгаад явна гэх юм бол дахиад 20 жил шаардлагатай. Бид бүхэн гэрээний талбайг нэг дунджаар 90 мянган га-гаар гээд ингээд тооцоод үзвэл нэг 280 орчим гэрээ байгуулагдана. Энэ дээр 280-300 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татаж энэ эрэл үнэлгээний ажлыг хийх боломжтой гэж үзэж байгаа.

Д.Үүрийнтуяа: Үндэсний геологийн албаны дарга 3 номер. Гишүүний асуултад тодорхой хариулж өгөөрэй.

Н.Мөнхбилэг: Өнгөрсөн 5 жилийн хугацаанд үндсэндээ улсын төсвийн хөрөнгө дээр 110-аад тэрбум төгрөг тавигдсан боловч эдгээр дүнгийн 40 тэрбум нь зөвхөн агаарын геофизикийн судалгаанд зориулагдсан байгаа. Бусад нь л зураглал болон эрлийн ажил тавигдсан гэсэн үг.

Д.Үүрийнтуяа: 2 номер. Ашигт малтмал газрын тосны газрын Кадастрын хэлтсийн дарга Энхтулга нэмж хариулъя.

М.Энхтулга: Гишүүний асуултад хариулъя. Энэ урт нэртэй хууль болон Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.13 гээд 2 зохицуулалт байгаад байгаа юм. 9.1.13 дээр бол хохирсон ААН өнөөдрийн байдлаар нэг 20 орчим ААН байгаа. Урт нэртэй хуультай холбоотой асуудал бол таны хэлж байгаа 100 орчим байгаа. Энэ 9.1.13-ыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар тайлбарласан зохицуулалтаар бол нөхөн олговрын асуудлыг 9.1.13-д зааснаар нөгөө улсын чанартай авто зам болон нөгөө бүтээн байгуулалттай холбоотой тусгай хэрэгцээнд авсан газруудтай тусгай зөвшөөрлүүд хамрагдана аа. Урт нэртэй хууль бол хамрагдахгүй. Нөхөн олговрынх нь асуудал мөнгөн хэлбэрээр явагдана аа гээд тайлбарлачихсан байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа. Мөн тухайн ААН-үүдэд тодорхой хэмжээний хэлцэл хийсэн байгаа. Хохирлын хэмжээ энэ 20 орчим ААН-ийн хохирлын хэмжээ өнөөдрийн байдал...

Д.Үүрийнтуяа: Очирбат гишүүн тодруулъя.

Г.Очирбат: Харин ингээд нөгөө асуудлыг нэг ийм өнгийн хэлбэрээр шийдэж болохгүй ээ Дамдинням сайд аа. Наад салбарынхаа түүхийг хараад наад түрүүний ярьдаг 100-аад ААН чинь гадна дотнын зах зээлээс хэдэн 100 тэрбумын хөрөнгө оруулалт татаж авчирч ирээд энд гацаачихсан байгаа вэ гэдгээ эхлээд бодох ёстой. Тэгээд наадхаа эхлээд явуул л даа. Хөрөнгө оруулалт хийчихсэн ААН-үүдээ эхлээд ажлыг нь явуулахгүй байж байж одоо дахиад хуулийн төсөл оруулж ирээд та хэд хувийн хэвшил өөрсдөө хайгуул хийчих ээ. Тэгээд дараа нь 2 жил наад хайгуул юм хум чинь гараад ирвэл бид нар лицензийг нь ингээд олгоод өгье өө гэдэг ийм чихэр долоолгож байгаа шилний цаанаас чихэр долоолгож байгаа юм чинь эдийн засагт яг бодитой хөрөнгө оруулалт болж орж ирэхгүй шүү.

Тэгэхээр эхний ээлжинд бол наад хохирчихсон байгаа ААН-үүдийнхээ асуудлыг шийд. Тэгж байж гадна дотнын хөрөнгө оруулагч нар итгэл төгс цаашаа энэ ажил явна аа. Тэгэхгүй та одоо айж агшаад хэрэггүй шүү дээ. Дамдинням сайд маань ажил хийх гээд л байдаг юм шиг байна. Засагтайгаа муудалцаад тэр засаг нь

дэмжихгүй байгаад байгаа юм байна шүү дээ. Тэгэхээр айхгүй наад хуулийн төслөө энэ...

Д.Үүрийнтуяа: Шинэбаярын Бямбасүрэн гишүүн асуултаа асууя.

Ш.Бямбасүрэн: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе ээ. Надаа нэг 3 асуулт байна. Энэ Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйл бол Засгийн газрын бүрэн эрхээр бүрэн эрхээр зохицуулсан байдаг. Тэгээд энэ зүйлд нэмэлт оруулахаар төсөлд тусгасан юм байна. 9.1.19-д чухал ашигт малтмалын жагсаалтыг батлах гэж Засгийн газарт эрх өгч байна аа. Тэгээд нэгэнт хуулийн 4.1.32 дээрээ чухал ашигт малтмал гэж энийг ойлгоно гэхихсэн атлаа ахиад 9.1.19 дээрээ Засгийн газар жагсаалт батална гээд байх юм. Энэ ямар утга учиртай юм бэ? Энийг асууя гэж бодож байна.

2 дугаарт бол хуулийн төслийн 47.20-д үндсэн ашигт малтмалын бүтээгдэхүүн дагалдах эдийн засгийн ач холбогдолгүй тодорхой хэмжээний эрдэс металлд АМНАТ ногдуулахгүй байж болно оо гэсэн байна. Тэгээд би энэ заалтыг бол тодорхой хэмжээнд хардаж байгаа юм. Жишээ нь ОТ-н ордын үндсэн ОТ-н ордын үндсэн ашигт малтмал нь зэс дагалдах гээд цагаан алт, алт гээд явдаг юм шүү дээ. Дорнодын Шинь Шинь полиметалл гэхэд л дагалдах маш олон металл байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ бүхэн чинь тэгээд АМНАТ-өөс чөлөөлж болохоор, Засгийн газар энийг нь ингээд шийдвэрлэж болохоор ингээд харагдаж байна. Тэгээд энийг нэг тайлбар авъя гэж бодож байна.

Гуравдугаарт нь энэ бичил уурхайтай холбоотой асуулт асуумаар байна. Энэ хуулийн төслийн 28.3-д ашиглалт баяжуулалтын үйл ажиллагааны явцад үүссэн үүсмэл ордыг бусад этгээд ашиглах тохиолдолд баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглана гэсэн байгаа байхгүй юу. Тэгээд яг энэ хуулийн нэр агуулгаар нь уншихаар ингээд бичил уурхайтай холбоотой заалт юм шиг байгаа юм. Яах вэ та хэд бол Эрдмэн, Ачит эх эд нар гээд хэдэн компаниудыг төсөөлж бол бодсон байх л даа. Тэгэхдээ энэ яг агуулгаар нь ингээд үзэхээр ингээд бичил уурхайг хэлээд байгаа юм. Тэгээд бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааг энэ зохицуулсан зохицуулалт ер нь эрх зүйн зохицуулалт ер нь манай улсад ер нь аягүй зохицуулалтгүйгээс болоод аягүй олон асуудал дагуулсан шүү дээ өнгөрсөн хугацаанд бол.

2008 онд нэг Бичил уурхай эрхлэгчдийг дэмжих үндэсний хөтөлбөр гэж батлагдсан. Тэрнээс өөрөөр ямар ч ер нь зохицуулалт байхгүй байгаа. Тэгэхээр энэ бичил уурхайтай холбоотой энэ хуулийн төсөл ер нь яг яаж орж ирж байгаа юм бэ? Энийг ер нь бичил уурхайг ер нь дэмжих гээд байна уу, зогсоох гээд байна уу? Ер нь яах гээд байна?

Д.Үүрийнтуяа: Дамдинням сайд хариулъя 5 номер.

Г.Дамдинням: Бямбасүрэн гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт бол Бямбасүрэн гишүүн ээ, энэ 4.1 дээр нь нөгөө хуулийн нэр томъёоны хэсэг байгаад байгаа юмаа. Тэрийг хэлчихсэн байгаа. 9.1.19 дээр бол өөрөөр хэлбэл олон улсад байгаа практикаар бол Засгийн газар нь тухайн ашигт малтмалыг өөрөө ингээд чухал юм уу, биш юм уу гэдгээ томъёолоод явдаг байа гэдэг ийм зохицуулалттай олон улсын стандарт байдаг юм байна лээ аргачлал.

Тэрүүгээр нь явна аа гэсэн. Зарим үед орж ирээд, зарим үед хасагдаад ингээд яваад байдаг юм байна лээ. Энийг хэлж байгаа юм.

2 дугаарт дагалдахтай холбоотой асуудал дээр бол бид бүх АМНАТ-ийг авна, авдаг хувиргаад авдаг, үндсэн түүхий эд дээр нь шилжүүлээд тооцоод ингээд аваад явдаг. Тэгэхээр энэ дээр бол Засгийн газрын журам гарч жагсаалт баталж ингэж явдаг. Энэ нь хууль тогтоомжийнхоо хүрээнд алдахгүй байх чиглэлээр ер нь авах талдаа л дандаа явдаг, явж байдаг ингэж шийднэ. Тэгэхгүй бол энэ чинь бас янз янзын нөхцөл байдал гарч ирээд байдаг юм.

Бичил уурхайг бол Бямбасүрэн гишүүн ээ хариуцлагажуулна аа. Хариуцлагажуулахгүй бол бас үнэхээр болохгүй байна яг үнэндээ. Бүртгэгдээгүй нөхөрлөлүүдийг бүгдийг нь бүртгэлжүүлнэ 1 дүгээрт, 2 дугаарт АМНАТ төлөгч болгоно. 3 дугаарт бол уулын ажлын тайлан өгдөг болгоно. Тэгэхгүй бол одоо бол ёстой дураараа байгаа байхгүй юу задгай бүүр. Тэгээд ингээд 5 хүртэл га-гаар олгоно гэххээд 5, 5, 5 гээд бүүр 20 га-д ингээд бүтэн уурхай явах жишээний ийм юмнууд хийгээд байгаа. Тэгэхээр энэ бол тэртээ тэргүй л байгалийн хэвлийн газрын хэвлийн баялгийг ашиглаж байгаа учраас хариуцлагатай, зохион байгуулалттай, бүртгэлтэй, уулын ажлын төлөвлөгөөтэй, бүүр АМНАТ төлдөг болгоё гэсэн ийм зохицуулалтыг бид нар оруулж ирж байгаа.

Үүсмэл орд дээр болон энэ баяжуулалтын үйлдвэрийн тусгай зөвшөөрлийг хийж өгөхгүй бол одоо ер нь ямар ч зохицуулалт байхгүй байгаад байгаа юм. Одоо хуульгүй байгаа яг энэ баяжуулах үйлдвэрүүд бол. Өөрийн орд газаргүй ААН-үүд бусдын түүхий эдийг авч баяжуулах гэж байгаа бол зохицуулалтгүй байгаад байгаа юм. Энийг зохицуулъя л гэж байгаа юм.

Д.Үүрийнтуяа: Тодруулъя Бямбасүрэн гишүүн тодруулъя.

Ш.Бямбасүрэн: Одоо Засгийн газар энэ нь чухал ашигт малтмал, энэ нь одоо хасна, нэмнэ гээд өөрсдөө ингээд батлаад л явах юм байна л даа. Тэгэхдээ энэнтэй холбоотой татварын орчин тогтворжуулалтын асуудлууд ингээд гэрээ хэлэлцээрийн асуудлууд гарна аа. Тэгэхээр энэ нь бас ер нь яаж зохицуулагдаж явах юм бол доо гэдэг асуулт байна.

Хоёрдугаарт тэр бичил уурхайтай холбоотой ер нь энэ бичил уурхай чинь нэг хэсэг нь бол нөхөрлөл хэлбэрээр явж байгаа нутгийн иргэд одоо тухайн байгаа орчиндоо нөгөө багахан хэлбэрээр олборлоё гэдэг хэсэг байгаа. Гэтэл нөгөө талд нь бичил нэртэй нэг техникжчихсэн, хөрөнгөжчихсөн тэгээд энүүгээр ингээд ялгаж салгахгүй бол таны хэлж байгаа түрүүний хэлж байгаа чинь бол түрүүний нөхдүүд байхгүй юу тэр техникжчихсэн, хөрөнгөжчихсөн одоо уул уурхай хийгээд байгаа нөхдүүд байхгүй юу. Тэгэхээр бид нар яг энэ бичэлгийг бас ер нь бараг ингээд энийг дагаад чангалах гээд байна уу. Та энийг бас ингээд ялгаж салгаж ярихгүй болов уу л гэж.

Д.Үүрийнтуяа: 5 номер Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Тийм энэ татвар хураамжтай холбоотой асуудлууд бол хууль дээр тусгагдсан хэлбэрээрээ одоо ингээд нэг тогтвортой байгаа хэлбэрээрээ л явна. Уг нь бол бид манай анхны боловсруулаад Сангийн яаман дээр дэмжигдээгүй төсөл бол хөнгөлөлт урамшуулалтай байхаар уг нь тусгасан байсан юм. Чухал ашигт

малтмалын жагсаалтад оруулчихвал хөнгөлнө өө, дэмжинэ ээ гэдэг. Тэгэхдээ яах вэ одоогоор бол бид нар дандаа нөгөө нэг хайгуулын түвшний ордуудтай байгаа. Тэгэхээр энийг бол бас түрдээ орхисон. Бичил дээр санал нэг байна аа. Үнэндээ бол энэ чинь уурхайн ажил хийгээд байгаа байхгүй юу зарим нь. Зарим нь бол үнэхээр байгалиа сэргээгээд яваад байгаа юм. Тэгэхээр тэр бүртгэлжүүлээд, уулын ажлын төлөвлөгөө аваад, АМНАТ төлдөг болгоно оо л гэсэн үг. Яг уурхайтай ижилхнээр хандаж явдаг болно оо л гэсэн үг. Ингэж байж нэг цэгцлэхгүй бол энэ бүүр арай дэндүү замбараагүй байгаад байгаа юм тийм.

Д.Үүрийнтуяа: Жаргалсайханы Золжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Золжаргал: Ашигт малтмалын тухай хууль ярихаар нөгөө зэсийн АМНАТ-аас болоод нөгөө ОТ-н Онтрегийн асуудалтай эсрэгцэл үүсээд байгаа юм шиг ийм юм яриад төөрөгдөөд байна аа. Би энэ дээр нэг 2 зүйл хэлье гэж бодож байна.

Нэгдүгээрт нь ОТ өнгөрсөн жил 360 мянган тонн зэсээр 14 тонн алт олборлож борлуулсан байна. Зэсийн үнэ ямар байгаа билээ, алт ямар байгаа билээ. Түүхэн дээд хэмжээнүүд. Ирэх 5 жилдээ бол маш өндөр ашигтай ажиллана. Магадгүй ирэх 5 жил хамгийн өндөр агуулгатай хэсгээ бараг олборлоод дуусах байх. Тэгэхээр энэ хугацаанд бид нар ОТ-той Рио Тинтотой хэлэлцээрээ Засгийн газар эхлүүлсэн юмаа дуусгах хэрэгтэй байгаа юм. Энэ маш чухал байна.

1 дүгээр асуудал нь байна шүү дээ ноогдол ашиг авах хугацааг наашлуулах талаар.

2-т нь зээлийн хүү дамжуулан зээлдэг юм гэж бол байж болохгүй ээ.

3-т нь нөгөө менежментэд оролцох зүгээр хараад суух биш оролцдог ийм менежментийн гэрээг бид нар хийх хэрэгтэй байна.

Энэ ажлуудыг хийхгүй бол энэ дээр ямар нэгэн тохиролцоо байхгүй бол Онтрегийн талаар ярих юм байхгүй. Тэр бол угаасаа хуулиараа Монгол Улсын Засгийн газартай хэлэлцээр хийж, Улсын Их Хурал дээр шийдэгдэх ёстой асуудал. Тэгээд ийм байр суурь маш хатуу тавих хэрэгтэй гэж бодож байна. Бид нар ямар эрх зүйн орчноо өөрчлөөд л АМНАТ бол 5 хувийг л төлж байгаа шүү дээ урт хугацаандаа. Тэрийг өөрчилье гэсэн тийм давруу юм яриагүй шүү дээ. Улайм цайм шударга бус дамжуулан зээлдүүлдэг юмыг нь багасгая. Хамтарсан компани юм бол үйл ажиллагаанд нь өөрсдөө оролцож хяная. Тэгээд тэр ноогдол ашгийг наашлуулах цаашлуулах чинь бол төлбөртэй л холбоотой асуудал. Ямар 10 хэдэн мянга зэс болчихно гэж бодож байсан биш. Ирэх 5 жил ингээд гол нөөцөө дуусчихна гэж бодож байсан биш. Тэгэхээр энийг ярих хэрэгтэй.

Энийг ярихад энэ хууль дээрх зэсийн АМНАТ саад болохгүй. Одоо бол 5 хувийн АМНАТ төлж байгаа ОТ. Эрдэнэт 20 гаруйг төлж байгаа. Тэгээд бусад нь төлөхөд тэр 5 хувиар тулчихсан юмнаас 20 авна гэж угаасаа байхгүй. Тэгэхээр энэ хуулиар чинь одоо 5-10 хувийн АМНАТ орж ирж байна. Дээрээс нь суурь нь 5, өсөн нэмэгдэх нь 5, нийлээд 10 дээрээс нь хэрвээ Онтрег хувь эзэмшлийн асуудал ярих юм бол тусгай АМНАТ нэмэгдэнэ. Үгүй бол хувиа эзэмшээд 10 хувиа авна. Тэгээд 20 гэсэн юм угаасаа яригдах үндэс байхгүй. Тийм болохоор энийг орж ирснээр тэр гэрээ хойшлогдоно гэсэн тийм уялдааг ерөөсөө харахгүй байгаа юм. За ингээд ямар ч байсан Улсын Их Хуралд хамгийн олонх болсон намын бүлгийн хурлаар АМНАТ-

ийн асуудлыг хойшлуулаад бусдыг нь ярья гэж шийдвэр гаргасан болбол миний бодлоор салбарын сайдад зүгээр санал болгоход Засгийн газар та бүхэн энэ хуулиа буцаагаад ер нь авчихвал яасан юм. Энэ гол асуудал чинь одоо хөрөнгө оруулалт татах, дээрээс нь 34 хувь...

Д.Үүрийнтуяа: 5 номер Дамдинням сайд хариулъя. Та нэмж дараа нь хариултаа авчхаад нэмж болно.

Г.Дамдинням: Золоо гишүүний асуултад хариулъя. Манай салбарын л хүн. Та бас энэ хууль хэчнээн удаж байж орж ирж байгааг мэдэж байгаа байх. Олон Засгийн газар, олон Их Хурал, олон сайдын гар дамжсан. Үнэнийг хэлэхэд би тэнэгтээ оруулж ирж байгаа даа. Маш галтай хууль шүү дээ. Тэгэхээр одоо ороод ирчихсэн төсөл дээрээ хэдүүлээ ажлын хэсэг дээрээ засаад сайжруулаад явчихвал дээр байх аа. Нэг ч гэсэн дуусдаггүй яриаг дуусгаж ажил болгоё.

2 дугаарт бол дагаж мөрдөх журмын тухай хуулиар эсвэл тогтоолоор энэ зэсийн АМНАТ-ийг шийдэж болно боломжтой. Ажлын хэсэгт та бас ороод ажиллачхаач ээ гэж хүсье. Ноогдол ашгийг наашлуулах, зээлийн хүүг бууруулах менежментэд оролцох бүүр тэр битгий хэл энэ АМНАТ-д суурилсан гэрээ болгож хөрөнгө оруулалтын гэрээгээ сольё оо гэдэг асуудлыг Монгол Улсын Засгийн газар маш хатуу тавьдаг, хэлцлүүд хийгдэж байна. Таны зөв. Ер нь бол одоогийн байгаа эрх зүйн орчин энэ Онтред нөлөөлөхөөргүйгээр л бид нар хийж болох боломжтой. Гэвч бас элдэв хардлага болоод улс төр болчих байх аа. Тийм учраас зэсээ түр хойшлуулаад энэ чинь олон сайн зүйл байгаа шүү дээ. Лицензээ чөлөөлж байна, хариуцлагатай болгож байна. Бичил уурхай гэсэн замбараагүй юмыг цэгцэлж байна. Уул уурхайн хаалтын нөхөн сэргээлтийн зардлыг урьдчилж авдаг болж байна. Орон нутгийн АМНАТ-ийг орон нутгийн иргэд бас хэлье. Аймаг орон нутгаар 21 аймгаар яваад хэлэлцүүлэг хийхэд бараг 100 хувь дэмжиж байна лээ. АМНАТ-ийн тодорхой хэсгийг хариуцлагатай уул уурхайг дэмжиж байгаа орон нутгууддаа өгье. Ингэж байж энэ уул уурхайг эсэргүүцэх байр суурь арилна гэдгийг дэмжиж байгаа.

Тэгэхээр энэ дотоодын үйлдвэрлэл ч одоо аж ахуй энэ биржийн хууль энэ дагаж байгаа хууль явж байгаа. Дотоодын худалдаагаа нээгээд дотоодын зогсчихсон байгаа 70 гаруй баяжуулах үйлдвэрүүдээ хөдөлгөө. Ухаад ачаад шууд гаргадаг энэ байдлаасаа больё оо гэдэг өөрчлөлтүүд энэ хуулиар орж ирж байгаа. Тэгэхээр та бас бодож үзээч ээ л гэж хүсье. Бид бас ажлын хэсгийнхээ түвшинд хэдүүлээ хэлэлцэх эсэхээ шийдчихээд яаралтай яриад шийдчих хувилбарууд бас байгаа тийм.

Д.Үүрийнтуяа: Золжаргал гишүүн тодруулъя.

Ж.Золжаргал: Асуултад бол тэр 34 хувь хайгуул хийчхээд хөрөнгө оруулагч тэрнээс илүү эзэмшиж болохгүй гэдэг заалт бол Монгол руу ирэх бүх юмыг хаачихсан угаасаа. Аль ч ашигт малтмал дээр стратеги болж болзошгүй гээд. Энийг ер нь та бүхэн бодож үзсэн юм уу?

Асуултаас гадна би дээр нь нэмээд хэлчихье ээ. Энэ баяжуулах үйлдвэрийг дэмжих бодлого энд байхгүй байна аа. Баяжуулах үйлдвэрт тусгай зөвшөөрөл олго гэдэг бол хэтэрхий тийм мэргэжлийн явцуу зүйл. Үүсмэл орд ашиг нөөц ашиглаж байгаа бол тусгай зөвшөөрөл авдаг болохоос биш үйлдвэр барихад тэр чинь техник аюулгүй байдлынхаа стандартаар л явна. Маркшейдер гээд нэг мэргэжил байна. 39

мэргэжил байна гээд ШУТИС-хантай ярьсан би. Нэгийг нь сонгож аваад тусгай зөвшөөрөл одоо яах юм геологичид бас худлаа ярьж магадгүй гээд тусгай зөвшөөрөл олгох юм уу. Тусгай зөвшөөрөл олгодог даргаар үнэн худлыг шийдэхгүй ээ. Энэ бол салбарын стандартууд явах ёстой.

Биржийн тухай хууль дээр аман нөхцөлөөр авдаг боломжийг нээж байгаа юм байна. Хил гэдгээ больж байгаа юм байна. Цөмийн энерги дээрээс газрын оврыг цөмийн эх үүсвэр гэдгийг больж байгаа...

Д.Үүрийнтуяа: Дамдинням сайд 5 номер хариулъя.

Г.Дамдинням: Тэгээд нөгөө яах вэ одоо боломжит хувилбараар нь л бид нарын оруулж ирж байгаа нь энэ. Тэгээд Их Хурал дээрээ засаж залруулаад явчих бас боломжууд байгаа байгаа Золоо гишүүн ээ. Бид нарын хувьд бол тэр хянаж шалгах асуудлыг хийхгүй бол болохгүй байна. Хулгай зэлгийд оролцоод байна, стандарт нормоо мэдээж чангална. Баяжуулах үйлдвэрүүдийг одоо өнөөдөр бид нар зохицуулах хуульгүй байгаад байна шүү дээ үүсмэл орд дээр. Ямар ч хууль байхгүй байна шүү дээ. ТЭЗҮ-ийг нь хэн авах юм тодорхойгүй, хяналт шалгалтыг нь хэн хийх юм тодорхойгүй, хэрэглэж байгаа химийн бодисынх нь хэмжээ, тун хор хэмжээг нь хэмжиж шалгах ямар ч боломжгүй, хариуцлага тооцох боломжгүй, дэмжих боломжгүй ийм л нөхцөлтэй байгаа юм. Тэгэхээр энийг бас ойлгоод хэдүүлээ ажлын хэргийн шугамаар ярилцаад энэ ажлын хэсэг дээрээ яриад шийдээд явчихъя аа. Таны саналуудад бас авах юм байгаа байгаа тийм.

Д.Үүрийнтуяа: Батбаярын Жаргалан гишүүн асуултаа асууя.

Б.Жаргалан: Ашигт малтмалын тухай хуулийн төслийн талаар нэлээн их хүлээлт нийгэмд байсан. Дотоод, гадаадын хөрөнгө оруулагч нарын хувьд ч гэсэндээ хүлээлт байгаа. Иргэд ААН-үүдийн хувьд ч гэсэн хүлээлт байгаа. Бас эдийн засгийн өсөлтөд эерэг хувь нэмэр оруулах болов уу. Ер нь цаашдын эдийн засгийг яг тэлэх явдалд бас хөрөнгө оруулалт татах явдалд эерэг хувь нэмэр оруулах болов уу гэсэн хүлээлт бол байсан. Тэгэхээр яг тэр хүлээлтэд нийцэх хэмжээний өөрчлөлт орж ирж байгаа эсэхэд эргэлзэж байна. Нөгөө талаасаа энэ хууль яагаад ийм удаан орж ирэхгүй байгаад гацсан бэ гэхлээр ер нь сүүлийн хэдэн жил чинь бид нэг ийм нөгөө нүүрсний халуурал дунд л амьдарлаа шүү дээ. Тэгээд л нөгөө нүүрсний экспортоо тэдэн сая тонноор нэмэгдүүлье, нөгөө зөвшөөрлөө тээврийн зөвшөөрөл нь ингэнэ, тэгнэ энэ тэр гэсээр байгаад бусад уул уурхайн салбарын хөгжлийн талаар ер нь огт бодолцоогүй гэж хэлж болно.

Тэгээд нөгөө Монголын заяа их гэдэг шиг нөгөө нүүрс нь үнэ нь буураад эхлэнгүүт, хөөрхий минь нөгөө зэсийн үнэ нэмэгдээд манай бас энэ экспортын дутагдлыг нөхөөд ингээд явж байгаа учраас л гэнэт нөгөө зэсээ санасан гэдэг шиг одоо энэ Ашигт малтмалын тухай хуулийг ч гэсэндээ оруулж ирэх бас нэг үндэс болж байх шиг байна. Тэгээд би бол энэ салбарын яамыг хариуцлагагүй ажилласан гэж харж байгаа. Яагаад вэ гэхлээр одоо энэ зэсийн АМНАТ-тай холбоотой маргаан гараад байна шүү дээ. Тэгээд ердөө хагас жилийн өмнө Улсын Их Хурал дээр ОТ-н төслийн Түр хянан шалгах хороо ажилласан. Улсын Их Хурлаас 120 дугаар тогтоол батлагдсан. Мөн одоо хөрөнгө оруулагч талтай Засгийн газрын нөгөө хэлэлцээр хийх үйл ажиллагаа эхэлсэн тиймээ. Тэгээд тэр чинь ерөөсөө хагас жилийн өмнөх л асуудал шүү дээ. Тэгээд Онтред дээр ийм хэлэлцээр явагдана гэсэн хүлээлт хаа хаанаа байсан шүү дээ. Тэгэнгүүт та хэд болохлоор тэр хүлээлтийг

ингээд шууд эвдээд хаячхаж байгаа байхгүй юу. Одоо бид нар ямар ч тогтоол шийдвэр гаргасан бас нэг хүлээлт үүсчихлээ шүү дээ. Эд нар ер нь энэ зэсийнхээ АМНАТ-ийн тогтолцоог ингэж бууруулах юм байна тийм биз. Тэгэхээр тэр хүлээлтийг бид нар яаж ч чадахгүй. Тэгэхээр та хэд анхнаасаа ийм юм оруулж ирэх шаардлагагүй л байсан гэж би хэлэх гээд байгаа юм. Яагаад гэхлээр тэр Онтрегийнхээ тэр хэлэлцээрийнхээ үйл явцыг эрчимжүүл л дээ. Ер нь тэр чинь юу болж байгаа юм? Яг Онтрегийн асуудал дээр тодорхой зүйл юу яригдаж байгаа юм? Энэ 120 дугаар тогтоолоор Улсын Их Хурлаас Засгийн газарт даалгавар болсон зүйл бол яг ямар хэрэгжилттэй байна аа гэдэг асуудал.

2 дугаар асуудал. Энэ чухал ашигт малтмал гээд л бид нар зөндөө ярилаа. Гэтэл энэ хуульд чинь ерөөсөө чухал ашигт малтмал гэдгийг нэг тодорхойлсон байна. Тэгээд Засгийн газарт бас нэг юу гэдэг юм жагсаалт батлах, бодлого тодорхойлох эрх үүргийг өгсөн байна. Тэгээд энэ асуудал чинь яг ямар хэмжээнд явж байгаа юм? Ер нь чухал ашигт малтмалынхаа бодлогыг юу гэж үзэж байгаа юм? Европын холбоо гэхэд парламентаараа бодлогоо баталчихсан байж байна шүү дээ. Чөлөөлье л гээд байгаа Засгийн газар чинь. Тэгэнгүүт энэ хуулиараа 2, 3 тийм тусгай зөвшөөрөл оруулаад ирж байгаа юм. Энэ Баяжуулах үйлдвэрийн тусгай зөвшөөрөл 5 жилээр олгоод, 5 жилээр сунгана гэдэг мэдэхгүй ээ ийм богино хугацаанд баяжуулах...

Д.Үүрийнтуяа: Хариулъя 5 номер Дамдинням сайд.

Г.Дамдинням: Жаргалан гишүүний асуултад хариулъя аа. Баяжуулах үйлдвэрээс эхлээд хариулъя. Би баяжуулах үйлдвэрийн тусгай зөвшөөрөл хийхгүй бол хулгайн баяжуулалт явагдаж байна. Зөвшөөрлийн хуулийн үндсэн үзэл санаа хэрэгжихгүй байна. Газрын хэвлийн баялаг дээр бол тусгай зөвшөөрөл заавал авна аа гэдэг чиглэлтэй байгаа. Чөлөөлөх ёстой юмыг чөлөөлнө өө. Ингээд яаж дэмжих вэ гэдгээ бас энэ зөвшөөрөлтэй болгочхоод шийдэхгүй бол болохгүй байна аа. Ачит Ихт гээд компани байгаа. Зэс эрдэнийн хувь гээд компани байгаа. Эрдэм нь гээд компаниуд байгаа юм. Энэ компаниудын энэ үйлдвэрүүдэд бид нар тусгай зөвшөөрөл өгч чадахгүй байна шүү дээ, хянаж чадахгүй байна шүү дээ, хэмжээ хязгаарыг нь тогтоож чадахгүй байна шүү дээ, болохгүй байна шүү дээ, баялаг шүү дээ энэ чинь бас. Баялаг боловсруулж орлого олж байгаа шүү дээ. Зохицуулах ёстой.

2 дугаарт Онтретой холбоотой асуудал дээр Монгол Улсын Засгийн газрын байр суурь ямар байгаа вэ гэхээр менежментийн төлбөр зээлийн хүүгийн хэмжээг бууруулсны дараа л Онтрег ярина аа. Онтрег хамгийн түрүүнд ярихгүй. Яагаад гэвэл Онтрег хөрөнгө оруулагч талаас хамгийн түрүүнд ярья гэдэг юм. Монгол Улсын Засгийн газар бол үгүй ээ, өмнөх гэрээн дээрээ байгаа алдаа дутагдлаа зассаны дараа цаашаа хөдөлнө өө гэж байгаа юм. Засахгүй бол хөдлөхгүй бид нар. Улс орныхоо тэр баялгийн өгөөжийг өмнө нь ингээд бас алдаатай гэрээгээр алдчихсан учраас тодорхой хэмжээнд урагшилсан ч гэсэн хүссэн хэмжээндээ хийж чадаагүй учраас сайжруулж байж цаашаа явъя гэж байгаа. Хэлэлцээр явна.

3 дугаарт зэсийн АМНАТ-ийг бид нар оруулж ирэх ёстой. Энэ дээр манай Батнайрамдал гишүүн ч гэсэн санал нэг байгаа. Одоогийн байгаа бодлогоор явбал Жаргалан гишүүн ээ, Рио Тинто гэдэг ганцхан хөрөнгө оруулагчаас Монгол Улсын зэсийн салбар манай энэ орлого хамаатай байгаад байгаа. Дахиад нэг зэсийн том төсөлтэй болчихвол ядаж бид хааж зогсоож байгаад ч хамаагүй бид нар хийж

чаддаг болно оо, шахалт үзүүлж чаддаг болно. Өнөөдрийн байдлаар зэсээс 1.8 их наяд төгрөгийн АМНАТ орж ирж байгаа. Энэний 900 тэрбумыг нь ОТ өгч байгаа. Цаана нь бас улс орон нутгийн төсөвт төлж байгаа татвар байгаа. Төсвийн орлого тасрах энэ нөхцөл байдалд орчхоод байгаа учраас бид нар хүчтэй шахалт үзүүлж чадахгүй байна шүү дээ. Тэр бусад төслүүдээ нээмээр байна. Одоогийн байгаа бодлогоор бол бид нар хоёрхон төсөлтэй л байна. Нэгхэн хөрөнгө оруулагчаас хамааралтай л байна.

Би бас энэ салбарын судлаач хүн, дандаа улс төрч байгаагүй. Салбараа бас гадарлана аа, судалдаг аа, мэднэ ээ тодорхой хэмжээнд. Ашигт малтмалын салбарыг удирдана гэдэг бол тухайлсан салбар болгоных нь түүхий эд болгон дээр нь тусгайлсан бодлого хийж байж удирдаж авч явдаг салбар. Тийм учраас би энэ өөрийнхөө оруулж ирж байгаа бодлогод итгэл төгс байгаа, буруудахгүй байх гэж бодож байна. Энэ дэлхийн уул уурхайн салбарт тэргүүлж байгаа улс орнуудын л барьдаг бодлогууд. Олон төсөлтэй болох, олон түүхий эдийг гаргаж ирэх, түүхий эдийн уналт өсөлтийн циклийг тооцож эдийн засгаа тогтвортой авч явах бол бодлого. Манай улсын бодлого байх ёстой. Тантай санал нэг байна. Нүүрсний нүүрснээс өөр юмгүй зах эдийн засаг босгочихсон байхгүй юу бид нар. Нүүрс уналаа будаа, нүүрс сайжирлаа хөөрлөө. Хэрвээ та ажиглавал нүүрсний үнэ унахад зэсийн үнэ өсдөг юм. Зэсийн үнэ тогтворжиход нүүрсний үнэ өсөж байдаг хамгийн шилдэг жишээ нь Канад улс байгаа. Тэгэхээр бид нар энэ ийм түүхий эдээ салбарлуулж хөгжүүлж байж л бид нар энэ хөрөнгө оруулагчид зарим хөрөнгө оруулагчдын нөлөөллөөс гарна аа л гэж харж байгаа.

Д.Үүрийнтуяа: Жаргалан гишүүн тодруулъя.

Б.Жаргалан: Рио Тинтотой хэлэлцээр хийх маш тодорхой үүрэг даалгаврыг Улсын Их Хурлын 120 дугаар тогтоолоор өгчихсөн байгаа. Тэгээд энэ дээр танай хэлэлцээрийн баг хамт олон болохлоор менежментийн төлбөрийг буурууллаа гэдэг нэг зүйл ярьсан.Тэр нөгөө зээлийн хүүгийн асуудал бусад зүйлүүд нь юу болж байгаа талаар нэг тодорхой мэдээлэл өгмөөр байна тиймээ.

Тэгээд бид эдийн засгаа солонгоруулж байж олон төслүүдтэй болж байж зөвхөн уул уурхай гэлтгүйгээр олон салбаруудаас экспортын орлогоо бүрдүүлж байж уул уурхай дотроо бас түүхий эдээ эдээр нь төрөлжиж байж хөгжинө гэдэгтэй санал нэг байгаа. Гэхдээ асуудал яг юунд байгааг мэдсээр байж байж одоо юу гэдэг юм нэг шат дараалсан байдлаар бодлогоо оруулж ирэхгүй тиймээ одоо нэг асуудлаа шийдээгүй байж байж дараачийн асуудал руу ингэж үсчдэг ийм байдлаар явах юм бол ингээд бид нарын нийтлэг эрх ашиг ерөөсөө хангагдахгүй байна аа л гэсэн зүйл. Тэгээд Эрдэнэтийг яахлаараа дандаа ингэж дээрэлхдэг юм.

Д.Үүрийнтуяа: 5 номер Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Эрдэнэтийг Аж үйлдвэр эрдэс баялгийн салбарын хүн сайдын хувьд дээрэлхээгүй ээ. Эрдэнэтийгээ бусадтай ижилхэн авч үзнэ гэдэг байр суурийг илэрхийлж байгаа. Сангийн яамны өгсөн зөвшөөрлийн дагуу л ингээд ороод ирчихсэн ажлын хэсэг дээрээ засъя гэдэг байр суурийг илэрхийлсэн. Монгол Улсын Засгийн газраас Ерөнхий сайдын 68 дугаар захирамж гарч намайг менежментийн төлбөрийг 50 хувь хүртэл буулгаад ир ээ гэдэг даалгавар өгсөн. 50 хувь буулгаад ирсэн. Би өөрийнхөө хариуцсан энэ удаан хугацаанд яригдсан төлбөрийг бууруулсан. Ингэснээр 2.2 тэрбум долларыг Монгол Улсдаа авч үлдсэн. Хүмүүс

зургаахан хувийн менежментийн төлбөртэй гээд хараад байдаг юм шиг байна лээ. Нэмэлт 2 төлбөр байдаг юм шүү дээ. Энийг нь хэн ч ярихгүй байгаад байгаа юм. Рио Тинтогийн менежментийн төлбөр гэсэн нэмэлт төлбөр байгаа, зээлийн хүүгийн шимтгэл гэсэн нэмэлт төлбөр байгаа, энэ нь нийлээд 9 хувь давчихдаг юм, 10 хувь хүрдэг юм ер нь зарим хугацаанд. Тэгэхээр энийг бид нар бууруулсан.

Д.Үүрийнтуяа: Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуултаа асууя.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд хүргэе. Өнгөрсөн 7 хоногт БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг Улсын Их Хурлаар хүчингүй болгуулсан байгаа. Тэр нь юу гэж байгаа вэ гэхээр ерөнхийдөө ТӨК-удад Эрдэнэс Монгол Эрдэнэт үйлдвэр гэх мэт ТӨК-иудаас гадна орон нутгийн өмчит жижиг Таван толгой гэж нэрлэсэн гэх мэт тэр компаниуд дээр ер нь БЭТ цаашдаа томилох ёсгүй юмаа гэдэг ийм шийдвэр гарсан. Ер нь бол тэр Үндсэн хуулиас өмнө байсан 1991 оны хуулийг хүчингүй болгох нь Үндсэн хуультайгаа нийцүүлсэн ийм том алхам байсан гэж харж байгаа. Тэгтэл бас нэг зүйл маань Ашигт малтмалын тухай хууль дээр 2024 оны нэмэлт өөрчлөлтөөр энэ БЭТ томилох асуудлыг шигтгэж өгсөн байдаг аа. Энэ нь болохоороо ямар агуулгаар байдаг вэ гэхээр 9 дүгээр зүйл дээр Засгийн газрын бүрэн эрх дээр 9.1.16 дээр энэ хуулийн 5.7-д заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хуулийн этгээдийн удирдах хуулийн хэрэгжилтийг хангуулахаар бүрэн эрхт төлөөлөгч томилно оо гээд заасан байгаа юм л даа. Тэгээд 5.7 нь болохоороо нөгөө маргаан болоод байдаг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 34 хувиас дээш хувь аливаа этгээд дангаар болон нэгдмэл ашиг сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшихийг хориглоно оо гэдэг. Энийг биелүүлэхийн тулд БЭТ томилно оо. Хэрвээ эсэргүүцэж байгаа ямар нэгэн хөрөнгө оруулагч байх юм бол БЭТ томилно гэсэн агуулга байгаад байгаа юм.

Тэгээд яах вэ би гайхаж байгаа юм нь болохоороо ер нь энэ Ашигт малтмалын тухай хуульдаа 34 хувиа хувиас дээшийг эзэмшиж болохгүй ээ. Тийм дээр эсрэг байгаа тохиолдолд БЭТ томилно оо гэсэн улс ер нь байдаг юм болов уу? Хэрвээ бид нар одоо энэ БЭТ-ийн заалтыг байлгаж байгаа юм бол шинээр орох би одоо өмнөх маргаануудыг дурдмааргүй байна. Зүгээр шинээр стратегийн орд газар нээн илрүүлээд ашиглалтад оруулахад хөрөнгө оруулагч тал ер нь энэ заалтыг зөвшөөрч орж ирэх магадлал ер нь хэр их байдаг юм бэ? Бид нар ер нь нөгөө стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын тухай яриад байгаа юм. Өнөөдөр байж байгаа 10 хэдэн заалт нэг ордуудыг ингээд гаргаад ирчихсэн байгаа. Тэр нь аягүй маргаан дагуулсан асуудал байгаад байгаа шүү дээ. Гэхдээ ганцхан энүүгээр дуусчихгүй ахиад ч Монгол Улсад зөндөө олон нөөц бололцоонууд бий.

Тэгэхээр нөгөө шинэ ордуудыг ашиглалтад оруулах, хөрөнгө оруулагч нараа татахад энэ 9.1.16 гээд байгаа энэ бүрэн эрхт төлөөлөгч томилох гэдэг заалт өөрөө байх нь хэр зүйтэй байдаг юм бэ? Энэ дээр бас одоо хөндөж байгаа заалтууд дотор энэ заалт орсон байгаа юу гэдгийг асуумаар байна.

Д.Үүрийнтуяа: 5 номер Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Стратегийн орд газар гэдэг ойлголт Монгол Улсаас өөр газар байдаггүй. Гэхдээ би Монгол Улсын Засгийн газрын гишүүний хувьд бас Улсын Их Хурлын гишүүний хувьд хэлэхэд Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдчихсан байгаа энэ ойлголтыг үгүйсгэх боломж байхгүй. Тэгэхээр 2 дугаар асуудал бол түрүүн

Золоо гишүүн асуугаад байсан. Та бас асуугаад байна. Нөгөө нэг энэ 5.7 34-өөс дээш хувийг эзэмшиж болохгүй гээд байгаа энийг бол бид нар хүчингүй болгоод ороод ирсэн байгаа шүү дээ тийм нэг этгээд гэдгийг байхгүй болгоод ороод ирчихсэн байгаа. 5.7, 5.8 хоёрыг. Энэ БЭТ-тэй холбоотой асуудал бол таны батлуулсан хуулийн дагуу шийдэгдээд явах байх л гэж харж байгаа шүү дээ тийм.

Д.Үүрийнтуяа: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуултаа асууя.

П.Сайнзориг: Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд явахыг зарчмын хувьд дэмжиж байна. Нэг 3 асуулт эхлээд тодруулъя. Ер нь зүгээр 2027 оны төсвийн төслийг боловсруулах энэ үйл ажиллагаа гэдэг юм уу, 2027 оны төсөвтэй энэ хуулийн нэмэлт өөрчлөлтийг ер нь уяж бодож Засгийн газар дээр ярилцсан уу? Сангийн яам зөвшөөрлөө өгсөн үү эсвэл энэ бол одоо өөрчлөлтүүд 2027 оны төсөвт ямар нэгэн нөлөө үзүүлэхгүйгээр бодож байгаа юу? 1 дүгээрт энэ нэг цаг хугацааны дэс дарааллын хувьд юу гэж бодож байгаа вэ нэг байр суурийг асуугаадахъя.

Дамдинням сайд маань энэ Онтретой гэрээг байгуулагдах хүртэл хугацаагаар АМНАТ-ийн асуудлыг зэсийн хувь дээр ярихгүй ээ л гээд байгаа юм. Энэ Онтрегийн асуудал хэзээ ер нь шийдэгдэх юм? Ингэж одоо бодлогоо бүүр ойлгомжгүй болгож зарлаж болдог юм уу? Би ерөөсөө ойлгохгүй байна. Тэгээд ерөөсөө нэг Эрдэнэт болон ОТ гээд хоёрхон зэсийн үйл ажиллагаа явуулж байгаа компанид эдийн засгийнхаа байдлаараа хараат гэдэг юм уу иймэрхүү юмнаас л хамжаатай болчихоод энэнээсээ гарах бодлогоо уг нь бол ойлгуулаад л явах ёстой шүү дээ. Ойлгуулаад л явах ёстой. Би зүгээр энэ салбарууд дээр ирсэн хүмүүс бол зүгээр сайд байж байгаад явсан гэж бодоод байгаа юм. Таныг нэг ажил хийх гээд байгаа юм байна. Сая би зүгээр хариулт сонсоод сууж байхад би тэнэг тулдаа л энийг оруулж ирж байна. Үгүй энэ дээр чинь ажил хийх гэж л очно шүү дээ. Ажил хийж байгаа хүн тэнэг гэж болох ёстой юм бол мэдэхгүй ер нь бүгдээрээ тэнэг байвал яадаг юм Дамдинням сайд аа. Тэгэхээр би энийг зүгээр хариултуудаа тоглоом наргиа гэхээсээ илүүтэй энэ үе үеийн өмнөх таны сайдууд чинь ажил хийгээгүй шүү. Одоо энэ сайд хэн сайд болж байгаа хүмүүс ажил хийж энэ дээр зэлтэрийн гацаанд орчихоод байгаа энэ бодлого энэ үйл ажиллагааны хэрэгжилтийг гаргана. Ингэх гэж та сайд болсон, ингэж байж таныг Ерөнхий сайд сайдаар томилсон байх. Тийм учраас энэ институц хоорондын гэдэг юм уу энэ ер нь яагаад Засгийн газарт орж ажилладаг юм гэдэг энэ зүйлүүдийг жоохон хүндэтгэлтэй хариулъя аа. Тэрнээс биш одоо би жоохон тэнэг учраас сайд болоод энд бодлого оруулж ирж байгаа юм, би ойлгохгүй байна. Эсвэл одоо тэнэг болчихоод байгаа бол ер нь ажлаа өгчих хэрэгтэй. Би энийг шулуухан ёс зүйн хувьд танд бас хэлчихмээр байгаа юм зүгээр.

Ер нь зүгээр энэ орон нутгийн хөгжлийг дэмжихэд энэ Ашигт малтмалын хуулийн өөрчлөлт ер нь ямар хэмжээнд нөлөө үзүүлэхээр байна? Энийг нэг бодлогын хүрээнд нэг хариулчаач.

2 дугаарт би энэ Эрдэнэтийг 20 хувиар үлдээж байгааг жоохон ойлгохгүй байна аа. За яах вэ зүгээр төсвийн нөхцөл байдалтай бодож байгаа боловч ингэж ялгавартай байдлаар хандаж болох юм уу? Тэгэхээр энийг зүгээр цаг хугацааны хувьд ямар хугацаатай үргэлжлүүлэхээр орж ирж байгаа юм? Энийгээ бас нэг тодорхой хэлчихмээр байна.

Дээрээс нь яах вэ энэ Онтре ОТ гэхээсээ гэж бас нэг саад бэрхшээл ч юм уу энийг хийхэд бас нэг зэсийн асуудал дээр яригдаад байгаа боловч нөгөө талдаа ер нь зүгээр бүхий л салбарт энэ лицензийн төлбөр...

Д.Үүрийнтуяа: 5 номер Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: 2027 оны төсөвтэй уялдаж байгаа Сайнзориг гишүүн ээ. Юуны Сангийн яамнаасаа санал авч байгаад оруулж ирж байгаа хууль, зөвшөөрлийг нь бас авсан. Онтрегийн асуудлыг ярихгүй биш ярина аа, яриад явж байгаа. Ойрын үед эрчимтэй хэлэлцээд дуусгачихъя гэсэн байр суурьтай байгаа. Онтрегийнхнийг бол яаралтай ирж хэлэлцээрээ хий, үгүй бол Монгол Улс аяа бодъё оо гэдэг хатуу шаардлагыг тавьчихсан байгаа. Эзэмшигч нь Онтре Ресурс гэж компани байгаа. Рио Тинтогийн Монголын Засгийн газар хоёрын хамтарсан төсөл ОТ төсөлтэй хамтруулж энийг олборловол эдийн засгийн хувьд ашигтай байдаг. Тийм учраас гурвалсан хэлэлцээр үргэлжилнэ. Гэхдээ энэний өмнө бид энэ зээлийн хүүгээ бууруулах асуудлыг шийдүүлнэ гэсэн хатуу шаардлагатай явж байгаа.

Энэ зэстэй холбоотой асуудал дээр Эрдэнэт дээр манай гишүүд маань энэ ууган үйлдвэрээ ойлгоод байгаа гээд бас талархал илэрхийлье. Манай санал бол Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэртэйгээ ярьж байгаад 4 жилийн хугацаанд одоо энэ 21.6 шүү дээ. Бүүр 20 биш 21.6 бүүр. Торгуультай элемент дээр нь хүртэл тавьчихдаг юм. Тэр нь 21.6 хувийнх нь АМНАТ-ийг 4 жил явуулаад тэгээд бусадтай ижилхэн буулгая гэдэг ийм зорилготой байсан ойлголцолтой. Тэгээд Сангийн яам маань энийг урт хугацаанд аваад явна аа гээд байгаа. Тэгэхээр Улсын Их Хурал дээрээ ярьж байгаад энийг ажлын хэсэг дээрээ шийдээд явсан нь боломжтой гэж үзэж байгаа. Ажил хийх тухайд бол хийгээд зүтгэж байгаа Сайнаа гишүүн ээ. Ер нь урдах урдах ажлаа бол дуусгаад ингээд зоригтойхон шиг барьж аваад энэ дуусдаггүй олон яриануудыг дуусгаад ингээд явчихъя гэж бодож байна. ОТ-н хэлэлцээр дээр 2 үр дүн миний ахалсан ажлын хэсгээс гарсан.

1 дүгээрт зээлийн хүүгийн хэлэлцээрийг 7 жилээр түгжчихсэн байсныг авч хаясан. Энэ бол миний ажилласан ажлын хэсгийн үр дүн. Зээлийн хүүг буулган буулгахад л энэ хэлэлцээр үргэлжилнэ гэдэг тохиролцоонд хүргэж чадсан.

2-т нь менежментийн төлбөрийг бууруулах. Менежментийн төлбөрийг бууруулах Засгийн газрын өгсөн үүрэг даалгаврыг 3.95 нэмэлт төлбөрүүд байхгүйгээр буулгасан. 9 орчим хувь байдаг юм. 3 төлбөр нэмэгдээд бас зарим хүмүүс энэ зөвхөн Эм Эс Пи гээд менежментийн үйлчилгээний төлбөрийг нь л харчхаад яриад байдаг юм шиг байгаа юм. Нэмэлт 2 төлбөртэй байдаг. Тэгээд ингээд энийг бууруулах ажлыг хийсэн.

3 дугаарт бол энэ түлш шатахуунтай холбоотой асуудлуудыг тасралтгүй л хөөцөлдөөд явж байна. Өнөөдрийн байдлаар Монгол Улс евро 5 төрлийн А92 авто бензинийг ОХУ-аас 430 төгрөгөөр хямдхан хэрэглээд явж байгаа. Бас л ажлын үр дүн манай Засгийн газрын. Түрүүн би бас одоо тэнэг гээд хэлчихсэндээ уучлал хүсье. Ер нь ний нуугүй хэлэхэд улс төрийн зориг гаргаж л авч орж ирж байгаа тийм. Улс төрийн зориг гаргаж л авч орж ирж байгаа галтай. Маш олон сайд нар энийг барьж орж ирэх гээд бэлдээд л бэлдээд л орхиод байсан юм байна лээ. Тэгээд хүн бас ажил хийж байгаа учраас энэ ний нуугүй хэлэхэд би 2014 оноос хойш сайд хийсэн. Сайд болгоны ажлын үр дүн энэ дотор явж байгаа шүү. Тэр сайд нар хөөрхий судалгаа шинжилгээ хийсэн, хэлэлцүүлэг хийсэн, тодорхой ойлголтуудыг

хийж явсан юмнууд байгаа. Тэгээд энэ цаг үед одоо зориглоод оруулаад ирлээ. Тэгээд та бүхэн маань бас дэмжиж өгөхийг хүсье ээ.

Б.Заяабал: Сайнзориг гишүүний микрофон нээе тодруулъя.

П.Сайнзориг: Энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт орон нутгийн хөгжилд ер нь ямар тус дэм болох гээд байна хариулчхаарай. Лицензийн төлбөрийн асуудал маш бага байгаа. Энэ өөрөө эргээд лицензийн төвлөрөл ингээд ашиглалтын лиценз олгогчлоод байтал энийгээ бид нар бодоод төсвөө бодоод төлөвлөөд байдаг. Гэтэл үйл ажиллагааг эхлүүлэхгүй байгаа энэ юунууд дээр лицензийн төлбөрүүдийг нэмэгдүүлээч ээ, хугацааг богино болоод шахаач ээ, ингэвэл энэ чинь АМНАТ-ийг бас бодлогоо хүлээхгүйгээр нэг бол үйл ажиллагаагаа эхэлбэл эхэлнэ, нэг бол төрд буцаагаад энэ лицензийг өгөх ёстой байхгүй юу. Тэгээд өгүүлэхгүй юм. Энэ дээр ямар өөрчлөлт байна?

2 дугаарт би энэ ОТ дээр гарч байгаа тэр зээлийн хүүг бууруулах менежментийн тэр асуудал дээр ойлголоо. Тэгэхдээ энэ зүгээр байгаа хэмжээнээс гоё сонсогдоод байгаа боловч яг эцсийн дүндээ зардал өсөж байхад менежментийн төлбөр угаасаа л өснө. Би энийг хүссэн үр дүн гэж ойлгохгүй байгаа. Тийм учраас энэ ОТ дээр үндсэндээ энэ тусгай АМНАТ-аар 34 хувиа орлуулаад бид хэд ер нь гарах хэрэгтэй шүү дээ. Ингээд менежментэд нь оролцож чадахгүй байж байж...

Б.Заяабал: Нэмэлт ажлын хэсэг 5 номер Дамдинням сайд.

Г.Дамдинням: Сайнзориг гишүүнтэй санал нэг байна аа. Лицензийн төлбөрийг бол өсгөж байгаа тийм. 2500 төгрөг байсан, 250 төгрөг байсан. 3500 болгож байгаа юм. Жилд нэг дундаж лицензийн хэмжээ 3500 га байдаг юм байна лээ тийм дунджаар метр кв. Тэгэхээр энэнийг нэг 7 сая төгрөг орчмоор л хадгалаад байсан юм байна лээ. Одоо хамгийн багадаа 100 гаруй сая төгрөг төлнө. Энэ эхний жилийнх нь шүү. Тэгээд лицензийн хайгуулын лицензийн хугацааг 6 жил болгож байгаа. 2 дахин бууруулж байгаа. Яг олон улсын жишиг рүү нь оруулж байгаа. Өөрөөр хэлбэл авахад хөнгөн, хадгалахад хүнд хайгуулаа хийхгүй бол болдоггүй яг мэргэжлийнхэн орж ирдэг ажил хийгдэнэ. Орон нутагт өгч байгаа хэмжээ суманд 2 хувь очдог байсан бол 4.5 хувь очно АМНАТ-ийн. Ингэж өснө.

Б.Заяабал: За хариулт хангалтгүй. Нэмэлт тодруулга Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Онтрегийн асуудал явж байгаа гэж байна. Та яг надад албан ёсоор нэг бичиг хийж өгөөч. Онтрегийн талбай ашиглагдаагүй байгаа юу? Би одоо жоохон эргэлзээд байна. Наад Рио ОТ чинь ер нь Онтрегийн талбай руу орчихсон хэлэлцээрээ хийж байгаад дараа нь ингээд асуудлуудаа цэгцэлнэ гээд байгаа юм биш биз дээ. Хэрэвзээ Рио ОТ-ынхон Онтрегийн талбай руу ороод ашиглалт хийчихсэн бол наадах чинь энэ гэрээг цуцлах хүчингүй болгох үндэслэл болно шүү. Тэгэхээр энэ дээр яг салбарын сайдын хувьд баталгаа гаргаж яг албан ёсоор бичгээр хариу ирүүлээч ээ. Тэгэхгүй ингээд одоо нэг ийм цаг идээд байгаа ч юм шиг, хаанаа ямар асуудлууд нь гацаад байдаг юм? Би бол наад уул техникийн нөхцөл байдлаас чинь Онтрегийн талбай руу аль хэзээ орчихсон гэж ойлгоод байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр ер нь Уул уурхайн яам хяналтын байгууллага яг ямар байгаа юм? Энийг олон нийтэд ил тод болгосоор байна. Одоо энэ гаднын хөрөнгө оруулагчтай бас яг дүрмийн дагуу л тоглоё л доо. Тэгээд эд нараар ингээд

чадуулаад дотоодын улс төр нь ингээд хөгжөөд байж байдаг. Эд нар ширээний ард дурамжхан суудаг.

Б.Заяабал: 5 номер Дамдинням сайдын микрофон нээе.

Г.Дамдинням: Тантай санал нэг байгаа, шахаж ажиллаж байгаа. Онтрегийн талбай руу орох уулын ажлын энэ нөгөө уул уурхайн үйлдвэрлэл чинь өөрөө уулын ажлын төлөвлөгөө батлуулж явдаг. Бид уулын ажлын Онтрегийн талбай дээрх уулын ажлын төлөвлөгөөг баталж өгөхгүй байгаа, хийлгэхгүй байгаа. ТЭЗҮ-ийг хурдан батал гэдэг шахалт улс төрийн шахалт ирдэг. ТЭЗҮ-ийг нь лицензтэй талбайнхаа хүрээнд л хийж ирвэл батална аа гэдэг шахалтыг тавьж байгаа. Хэмжилтийг хийж байгаа. Одоо бол хийчихсэн байгаа ТЭЗҮ нь Онтре Ресурс болон ОТ компанийн нийт бүлэг ордынх нь хэмжээнд хийчихсэн ТЭЗҮ байгаа. Хэрвээ энэ ТЭЗҮ-г Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам хувааж хүлээж авлаа л бол Онтрег бэлэглэж байна гэсэн үг. Одоогийн бүтэшгүй жоохон хэл амтай байгаа энэ хөрөнгө оруулалтын гэрээний доогуур оруулаад мөрдүүлэх гэж байна аа гэсэн үг. Тийм учраас бид уулын ажлын төлөвлөгөөгөө тусад нь гарга, ТЭЗҮ-гээ тусад нь гарга гэдэг...

Б.Заяабал: Батболд гишүүн асуулт асууя.

Р.Батболд: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг бол дэмжиж байна аа. Энийгээ цааш нь аваад явах хэрэгтэй юмаа. Бид одоо Ашигт малтмалын тухай хуульд шинэчлэн найруулах тийм ажлын хэсэг байгуулаад бараг 2 жил ажилласан тийм. Одоо хүртэл одоо л нэг юм хууль нь орж ирж байна. Тэгэхээр энэ хуулийнхаа өөрчлөлтүүдийг маш хурдан хийгээд явах уул нь шаардлагатай байгаад байгаа юм. Бид нар хуулиа шинэчилчхээд энэ уул уурхайн салбартаа бас нэг шинэчлэл хийх хэрэгтэй байгаад байгаа юм. Энэ уул уурхайн салбартаа шинэ тоглогч оруулж ирэх тэгээд хайгуулын ажлаа эрчимжүүлэх, еще боловсруулалтын түвшнээ нэмэгдүүлэх байдаг юм уу. Одоо энэ зохицуулалтуудаа хурдан хурдан хийгээд явахгүй бол болохгүй нь ээ. Тэгээд сая зүгээр мэдээлэл харж байхад энэ МАН-ын бүлгийн хурлаас энэ АМНАТ-ийнх нь асуудлыг хойшлуулъя гэдэг ийм хугацааг нь хойшлуулъя гэдэг юм уу ийм асуудал ороод ирэх шиг боллоо. Тэгээд Онтре Онтре гэж ярьсаар байгаад л энэ АМНАТ-ийг л хойшлуулчих шиг боллоо л доо уул нь хэрэгжих хугацаагий нь. Тэгэхээр бид одоо хэзээ энэ Онтретой гэрээгээ хийж дуусгах юм. Энэ Онтре чинь энэ хууль нь байлаа байлаа гэж бодоход энэ 5 дээр нэмэх 15 АМНАТ-ийнхаа энэ 20 хувиар гэрээ хийх юм уу, хийхгүй шүү дээ. Би бол хийхгүй гэж бодож байна. Энийг уул нь бас нэг шударга шууд хэлчихдэг л баймаар байгаа юм. Яаж ч бодоод нэг тогтворжуулсан хувь ч юм уу, тэгээд нэг хуулиар ч юм уу нэг хувь хэмжээ орж ирээд тэрүүгээр л хийж таараа. Мэдээж АМНАТ-ийг 20 хувиар гэж Онтре л лав гэрээ хийхгүй байх.

Ерөнхийдөө ОТ бол тэртээ тэргүй Онтрегийн талбай руу нэг жоохон булан орчихсон нэг юу мэдээлэл байгаад байдаг шүү дээ. Нэг булан орчихсон. Зүгээр ОТ-тойгоо цуг ашиглалтын явцад тэрийгээ цуг ашиглаад явахгүй бол дараа нь бид нар маш өндөр зардлаар дахиад ОТ-н хэмжээний зардал гаргаж бараг ийм гүний уурхай явуулах ийм нөхцөл байдал бас үүсчхээд л байгаа юм байна лээ шүү дээ. Тэгэхээр энийгээ хурдан шийдээд явуулсан нь дээр байх аа гэдэг ийм саналтай байна.

Зүгээр асуулт нь тэр Онтретой холбоотой бид нар тийм 20 хувиараа ийм АМНАТ тавиад гэрээ хийж чадах юм уу, чадахгүй юм уу? Энийг уул нь энэ Батнайрамдал гишүүнээс асуучихмаар байгаа юм. Ийм боломж байгаа юм уу? Дэлхий дээр бид нар өөрсдөө 5-аас нэг 12, 13 хувийн хоорондох АМНАТ ингээд дэлхий даяараа ийм иймэрхүү нөхцөл дундаж хувьтай байгаад байхад 20 хувиа тавьчихаад яваад байдаг. Энэ нь ерөөсөө л нэг болохгүй л байгаад байгаа юм даа. Тэгээд энийг нэг хойшлуулахгүй оруулж ирэх бас боломж байгаа юм уу? Энэ хугацааг нь ер нь мөрдөх хугацаа нь хэвээрээ байвал яасан юм гэдэг саналтай байгаа юм.

Б.Заяабал: Ажлын хэсэг 5 номер Дамдинням сайдын микрофон өгье.

Г.Дамдинням: 1 дүгээрт АМНАТ-ийн асуудал дээр бүрэн хэмжээнд хойшлуулаагүй ээ. Зэсийн АМНАТ дээр л түр зохицуулалт хийе л гэж байгаа юм. Дагаж мөрдөх журмын тухай хууль бичигдэж таарах байх. Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр Онтре 2 дээр зориулагдсан дагаж мөрдөх журмын тухай хууль шинээр бичиж оруулаад ингээд шийдчихье гэж байгаа юм. Бусад төслүүдэд хамаарахгүй байдлаар шийдье гэсэн ийм хувилбартай байгаа. Энэ одоо сүүлд гарч ирсэн өргөн барьснаас хойших хувилбар. Өргөн барьсан хувилбар бол шинэ хувилбараараа л явж байгаа шүү дээ.

Онтретой холбоотой асуудал. Онтретой холбоотой асуудал дээр Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2-ыг л мөрдүүлнэ ээ. Тэр одоо бусад хэм хэмжээ ерөөсөө хамаагүй шүү дээ ер нь бол цагаа тулбал. Нийт өгөөжийн 50 дээр нэмэх нэг хувийг хамгийн багадаа авна аа гэдэг энэ зохицуулалтыг ямар нэг байдлаар бид нар хийнэ. Хамгийн шилдэг жишээ одоогийн байдлаар байгаа нь Ораногийн төсөл дээр хийсэн жишээ байгаа. Орано дээр 5 хувийн суурь АМНАТ нэмэх нь 4 хувийн 9 хувийн өсөн нэмэгдэх АМНАТ нэмэх нь тусгай АМНАТ 5 хувь, тэгээд тусгай төлбөр гэдэг эд нар бүгд нийлээд энэ 3 АМНАТ нийлээд 51 хувьд хүрэхгүй бол тохируулгын төлбөр гээд нэмэлт төлбөр хийхээр ингээд зохицуулсан. Тэгээд энэ загвар луу оруулаад хийх боломж бид нарт байгаа.

Б.Заяабал: Гишүүд асуулт асууж дууслаа. Одоо хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж гишүүд нэрсээ өгнө үү. Үг хэлэх гишүүдийн нэрс авъя аа. Сайнзориг гишүүнээр, Жаргалан гишүүн, Очирбат, Үүрийнтуяа гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофон өгье. Ирцээрээ Үүрийнтуяа гишүүнээс эхлэх юм байна. Үүрийнтуяа гишүүний микрофон өгье.

Д.Үүрийнтуяа: Хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж байгаа. Тэгэхдээ хэлэлцэхэд олон асуудал байна. Ажлын хэсэг энэ дээр маш сайн ажиллах хэрэгтэй болж байгаа юм. Тэгэхээр ер нь бид ингээд гишүүд ажлын хэсэг байгуулагдаад ингээд асуудал хэлэлцэхээр ажлын хэсэгт маш олон гишүүд ордог. Ажлын хэсгийн хуралдаанд ирж байгаа нь маш цөөн, ирц бүрддэггүй. Хэлэлцэхэд үнэхээр асуудлуудыг үүсгэж байна аа. Тийм учраас энэ чухал чухал хуулиуд дээр үнэхээр нэг ажлын хэсгийг бодож бүрдүүлэх хэрэгтэй байна. Орсон гишүүд нь хариуцлагатай ажиллах хэрэгтэй байна гэдгийг юуны өмнө 1 дүгээрт хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Яг энэ хуулийн төсөл дээр хэлэлцэх эсэхийг дэмжээд явах үед би Эрдэнэтийн асуудлыг ярих ёстой, онцгойлон авч үзэх ёстой. Энэ тусгайлж ингэж хуулиас гадуур

ялгаж орхиж байгаа. Энэ чинь хууль тогтоомжийн үндсэн шаардлагаа хангахгүй байна шүү дээ энэ хууль чинь өөрөө. Эрх тэгш байх ёстой шүү дээ. Хуулийн чинь үндсэн хууль боловсруулахад баримтлах үндсэн зарчмаа бид нар хангаж чадахгүй байна шүү дээ. Ийм ялгаатай байдлаар оруулж ирж байгаагаараа. Тэгэхээр энэ асуудлыг засах ёстой. АМНАТ-ийн асуудлыг бүх түвшинд нь ярьж энэ хуулиа нэгмөсөн гаргах ёстой. Би ийм байр суурьтай байгаа.

Нөгөө талдаа энэ яг амьдрал дээр хаягддаг асуудлууд их орхигдсон байна аа. Тэгэхээр ажлын хэсгийн явцад яах вэ хуулийн хэлэлцүүлгийг нэлээн сайн хийх хэрэгтэй. Ялангуяа энэ газрын хэвлийн баялгийг ашиглаж ажиллаж байгаа төрийн болон хувийн энэ компаниудын асуудлуудыг хууль хяналтын байгууллага, аудитын энэ хяналт шалгалтын байгууллага хийдэг албан тушаалтнуудыг оролцуулсан энэ асуудлуудыг ярих хэрэгтэй. Би түрүүн тэр төмрийн АМНАТ дээр ярьдаг. Төмрийн хүдэр, төмрийн баяжмалын агуулгатай чанартай тийм чанартай төмрийн хүдрийг баяжмалаар гаргаад л бид нар татвараа алдаж байгаа байхгүй юу. Баяжмалаар гаргаад байхдаа л мэдэхгүй сууж байгаа шүү дээ. Тэрэн дээр зөвхөн нэг стандарт яриад байж болохгүй л дээ. Засгийн газрын тогтоол өөрчлөх тухай яриад байж болохгүй л дээ. Энэ чинь баяжуулах процесс хийгдэж байна уу, үгүй юу гэдэг дээр тавих хяналт байх ёстой шүү дээ.

Геологийн мэдээ юу гаалийн мэдээ тэртээ тэргүй гарч байгаа шүү дээ. Баяжмалаар гарч байна уу, хүдрээр гарч байна уу гэдэг гаалийн мэдээ чинь гарч байгаа. Тэрийгээ аваад л тухайн салбар дээр яг ийм хэмжээний баяжуулалтын процесс явж байгаа юм уу, үгүй юм уу гэдэгтээ л бид нар хяналтыг л гаргах ёстой шүү дээ. Тэгээд зүгээр ийм процессын зүгээр заавал хуульчлах ёстой ч юм уу, үгүй ч юм уу ийм асуудлууд дээр хүртэл бид нар алдаж байгаа энэ зохицуулалтыг хүртэл хаягдуулж болохгүй оруулах ёстой. Дээр нь АМНАТ гэдэг юу юм бэ гэдгээ заавал тодорхойлолтод оруулах ёстой. Би энэ процесс дээр шүүх процесс тулаад явж байсан хүний хувьд АМНАТ гэдэг тодорхойлолт чинь байхгүй байна аа гэж байгаа байхгүй юу Ашигт малтмалын хууль дээр чинь. Тэгээд аргаа ядаад яамнаас хүртэл шинжээч томилуулж АМНАТ гэдэг тодорхойлолтыг гаргуулаад өгөөч ээ гээд нэг тойруулсан бөөрөнхийлсөн юм хүртэл авч л явсан шүү дээ. Ядаж л энэ хууль хяналт дээр очоод шүүхийн маргаан дээр хүртэл очоод эцэслэгдэж чадахгүй маргаан дагуулаад байгаа зүйлээ энэ хуулиараа нэг талдаа гаргачихмаар байна шүү дээ. Тэгж байж энэ чинь энэ хуулийн өөрчлөлт нэмэлт, өөрчлөлт орж байгаагийн үр дүн нь харагдана. Тэр асуудлуудыг шийдэж чадахгүй бол бид нар зүгээр тойрсон ийм өөрчлөлт оруулсан нэр зүүгээд хэрэггүй л дээ.

Тийм болохоор энэ хуулийн төсөл дээр дорвитойхон шиг ажиллах ёстой. Нэлээн өөрчлөх зүйлүүд Засгийн газрын өргөн барьснаас өөрчлөх зүйлүүд бас нэлээдгүй байна гэж харж байна. Мөн Уянгаа гишүүн санаачилсан энэ нөгөө стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын асуудлаар тусгайлан хууль санаачлаад, шинэ хууль санаачлаад ороод ирснийг нь энэ хуультай нэгтгэе гэж хэлээд аваачаад нэгтгэж тэр хуулийн төслийг нь оруулаагүй байгаа шүү дээ. Гэтэл яг тэр бүрэн агуулгаар би Уянгаа гишүүний хэлсэн тэр маш их судалгаа тооцоололтой анхдагч хуулийн төсөл дээр орсон гол үзэл санаа концепцууд энд хаягдчихсан байгаа байхгүй юу. Бараг тэр хуулийг нь дангаар нь явуулчихмаар санагдаж байна шүү дээ өнөөдөр энэ байдлаар. Тийм учраас анхаарах асуудлууд олон байна шүү гэдгийг хэлээд хэлэлцэх эсэхийг дэмжиж байна.

Б.Заяабал: Баярлалаа. Очирбат гишүүн үг хэлнэ. Очирбат гишүүний микрофон өгье.

Г.Очирбат: Их тийм ядмаг нэг шилний цаанаас чихэр долоолгосон судалгаа тооцоо, суурь судалгаанууд байхгүй, асуудлаа өргөн өнцгөөр харж том зургаар нь шийдье гэж бодоогүй ийм хуулийн төсөл орж ирж байна гэж харж байгаа юм. Хоёрхон эрх ашиг. Нэг нь зэсийн АМНАТ-ийг бууруулж байна. Тэр дундаа Монголыг өнөөдрийг хүртэл авч явсан Эрдэнэттэй холбоотой Эрдэнэтийг хэвээр нь үлдээгээд бусад тэр шинэ төслүүд гэдэг юм уу, явуулах гэж байгаа юу гэдэг юм манай зарим гишүүдийн энэ хардаад байгаа ОТ-той холбоотой, Онтретой холбоотой эд нарт зориулсан хуулийн төсөл орж ирж байна гэж харж байгаа нэг.

2 гэх юм бол Монгол Улсын энэ уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хийчихсэн байсан. Түрүүн энэ салбарынхан хэллээ шүү 120 орчим ААН-үүдийн өнөөдрийн хийчихсэн байгаа хөрөнгө оруулалтыг бүрэн шийдэж чадахгүй байж байж чихэр долоолгож байгаа байдлаар дараагийн хувийн хэвшлийнхэн маань ороод ир ээ, тануус хайгуулаа хий. Үнэхээр хайгуулаас чинь үр дүн гараад ирэх юм бол бид нар лиценз олгоё оо нэг ийм л хуулийн төсөл орж ирсэн. Одоо хувийн хэвшлийнхэн чинь та хэдэд итгэхгүй шүү дээ. Хөрөнгө оруулалт хийхгүй. Эхлээд нэг дэх асуудлаа эрэмбэлээд хамгийн 1 дүгээрт Монголын энэ уул уурхайн салбарыг орж ирсэн хөрөнгө оруулагч нар, дотоодын хөрөнгө оруулагч нараа дэмж ээ. Тэгж байж дараа дараагийн ажил чинь явна аа.

Тэгээд зөвхөн зэсийг энэ дээр хардаг бол буруу шүү Дамдинням сайд аа. Та бүхэл бүтэн энэ чинь Эрдэс баялаг аж үйлдвэрийн УУЯ-ны сайд хүн. Олон салбар танд хариуцаж байгаа, хамаарч байгаа. Энэ Үүрийнтуяа гишүүний яриад байгаа тэр төмөр дээр яг үнэн шүү дээ. Стандарт гэдэг нэг тоо тавьчихсан, баяжмалынхаа хэд хэдээр яаж гарч байгаа нь мэдэгдэхгүйгээр л та хэд бараг баяжуулчихсан юмыг хилээр гаргаад л явуулж байгаа шүү дээ. Тэгээд энийгээ сайжруулаад орж ирэх ёстой шүү дээ энэ хуулийн төсөл чинь. Алт, жонш, зэс, газрын доорх бүх баялаг энэ Ашигт малтмалын тухай хуультай чинь хамааралтай шүү дээ. Зөвхөн нэгийг нь салгаж оруулж ирж байгаад асуудлыг ийм ядмагханаар шийднэ гэвэл Эдийн засгийн байнгын хорооны мэргэжлийн Их Хурлын гишүүд сууж байгаа гэж харж байгаа. Мэргэжлийн байнгын хороо байгаа. Тэгээд энэ хуулийн төслийг дэмжихгүй байх Дамдинням сайд аа.

Их Хурлын гишүүдийн өргөн барьж байгаа хуулийн төслүүд бас байгаа. Энийг та хэд үнэхээр сэтгэлтэй санаачилгатай бол түрүүлж аваад уншаад, санаачилсан гишүүдтэй нь уулзаад энэ хууль дээрээ давхар таны яг ярьж байгаа энэ асуудлыг чинь шийдье. Таны ярьж байгаа энэ асуудал чинь ингээд ороод ирэх юм байна. Нэгдсэн Ашигт малтмалын энэ тухай хууль чинь бол нийтлэг энэ салбарт бүтэн үйлчилж байгаа болохоор хамтад нь аваад явчихъя гэдэг манлайллыг манай Засгийн газар үзүүлэхгүй байна.

Дамдинням сайд бол түрүүн ингээд бүтэн олон гишүүдийн асуултад хариулаад сууж байна. Ажил хийх гээд байгаа нэг ийм чин сэтгэл үнэртээд байна. Тэгээд цаана нь Ерөнхий сайд нь л ажлыг нь хийлгэхгүй байгаа л юм байна л даа. Үгүй засаг нь шийдэхгүй, Ерөнхий сайд энэ салбарын сайд нараа дарамтлаад байдаг юм уу? Үнэн асуудлаа оруулж ирээд ингээд ажил явуулъя гэхээр Дамдинням сайд би айж байна гэж байна шүү дээ. Намайг шоронд явуулах гээд байна гэж байна шүү дээ бараг. Энэ асуудлыг чинь би шийдчих юм бол хүндрэх гээд байна гээд.

Тэгээд ингэж болохгүй шүү дээ. Бүхэл бүтэн кабинетын засгийн олон Их Хурлын гишүүдийн дэмжлэг аваад Ерөнхий сайд энэ гүйцэтгэх засаглал удирдаж байгаа хүн салбарынхаа сайдын зөв болгох гээд асуудлыг шийдэх гээд хуулийн төсөл оруулж ирэхээр тэрийг нь дэмждэггүй. Тэгээд тодорхой энэ эдийн засгийг тэлчихээр том том төслүүдээ явуулчихъя гэхээр сайд нь айгаад сууж байна шүү дээ. Тэгээд ийм байж болохгүй шүү дээ.

Цаашдаа энэ Монгол Улсын эдийн засагт хамгийн ийм нөлөөтэй байгаа энэ уул уурхайн салбар, аж үйлдвэрийн салбар, эрдэс баялгийн салбарыг Их Хурлын гишүүд болон байнгын хороо ер нь бүх ард түмнээрээ дэмжихгүй бол болохгүй байна шүү.

Б.Заяабал: Жаргалан гишүүн үг хэлнэ. Жаргалан гишүүний микрофон өгье.

Б.Жаргалан: Энэ парламентын бүрэн эрхийн хугацаа яг талдаа орж байгаа. Энэ хаврын чуулган дууссанаар яг 2 жил болох гэж байна. Энэ хугацаанд бол бид Засгийн газраас энэ томоохон бодлого дээрээ ийм дорвитой шинэчлэл реформын шинж чанартай хуулийн төслүүдийг өргөн бариад шийдүүлэх байх аа гэсэн хүлээлттэйгээр ингээд 2 жил болчихлоо. Тэгээд Засгийн газар ийм хуулийн төслүүд өргөн барьдаг. Гэтэл тэд нар нь болохлоор яг ингээд ийм нийгмийн хүлээлтэд хүрдэггүй, тодорхой асуудлуудыг шийдээгүй, дутуу дулимаг яг иймэрхүү байдлаар орж ирээд чухал асуудал учраас энэ асуудал дээр иргэд олон нийт энэ Засгийн газраас төдийгүй парламентаасаа шийдэл хүлээж байгаа гэдэг үндэслэлээр нөгөө хэлэлцэх эсэхийг нь дэмжээд явчихдаг. Тэгэнгүүт нөгөө ажлын хэсэг байгуулагдаад явдаг. Тэгэнгүүт нөгөө анх орж ирсэн төсөл нь болохлоор ингээд дутуу дулимаг учраас нөгөө ажлын хэсгийнх нь ажилд нэлээн хүндрэл учирдаг энэ тэр ажил тийм асуудал зөндөө гарч байна аа.

Тэгээд энэ бол бас л дахиад л яг л тэр замаар орох гээд байна л даа. Тухайлах юм би түрүүн бас асуугаад байгаа энэ чухал ашигт малтмалын бодлого ерөөсөө тусгагдаагүй байна аа. Нэг нэр томьёо л орсон байна. Тэгээд Засгийн газар дээрээ жагсаалт батлах барих энэ тэр эрхийг авчихсан. Тэгээд энэ чухал ашигт малтмалынхаа бодлогынхоо хүрээнд энэ зэсийнхээ асуудлыг ч гэсэндээ оруулаад энэ бусад улс орнуудын нэгэн адилаар энэ одоо хөрөнгө оруулалт татах энэ Саплей Чэйнийхээ асуудлыг шийдэх мэдэхгүй нэг тэр арай ийм дорвитойхон байдлаар энэ шинэ эдийн засагт чинь нийцэж байгаа энэ дэлхий дахины трендүүдийг дагасан нэг тийм бодлого оруулж ирж болоогүй юм уу гэдэг асуулт.

Тэгэхээр нэгэнт одоо энэ та хэдийн оруулж ирж байгаа төсөл дээр энэ чухал ашигт малтмалын бодлого байхгүй байгаад байгаа учраас магадгүй тийм бие даасан хуулийн төслийн хүрээнд явах юм уу гэдэг асуудал гарч ирнэ. Яагаад гэхлээр ажлын хэсэг дээр энийг чинь шийдэх боломж байхгүй тийм гэх мэтчилэн ингээд ийм дутуу дулимаг байдлууд бий болоод байна аа.

Тэгээд өнөөдөр Дамдинням сайд их тийм аягүй сонин 2 үзүүртэй зүү шиг зөндөө юм ярилаа шүү дээ. Би бол хувь хүний хувьд салбараа асар сайн мэдээд байдаг судлаач хүн. Гэтэл засаг чинь ингээд байна аа. Тэгээд одоо мэдэхгүй хэрэв нэгэнтээ салбарын сайдаар томилогдоод ингээд явж байгаа нөхцөлд кабинетынхаа тэр шийдвэрүүдийг хамгаалдаг энэ тэр байх хэрэгтэй шүү дээ. Тэгэхгүй ингээд нэг ийм сонин 2 үзүүртэй зүү шиг юм яриад би бол дэмжээд байгаа засаг дэмжээгүй юмаа ч гэж байх шиг. Тэгэхээр чинь энэ хүмүүс одоо эргэлзэх нь аргагүй биз дээ

танай Засгийн газрын бодлогод. Энэ чинь танай Засгийн газраас ямар ч тийм манлайлал харагдахгүй байгаад байна шүү дээ. Тэгээд 1 сайд нь орж ирээд нэг ийм юм яриад одоо энэний араас тэр бизнесийн эрх чөлөөний хууль орж ирнэ. Аягүй бол бид нар ёстой чөлөөлөх гэж байгаа барих гэж байгаа тусгай зөвшөөрөл ийм тийм энэ тэр гээд л бас л шал тэс хөндлөн юм ярина шүү дээ. Тэгэхээр танай Засгийн газрын тэр манлайллын бодлого чинь хаана байгаа юм.

Эцэст нь ОТ-н гэрээ байгуулагдаад даруй 17 дахь жил болж байгаа. Тэгээд сая бид нар тэр 16 жилийнх нь ойгоор гэдэг шиг Их Хурал дээр тэр Түр хянан шалгах хорооны сонсгол хийгээд гээд өчнөөн олон хоног судалгаа шинжилгээ хийгээд, сонсголын хүрээнд 3 өдөр асуудлуудыг сонсоод ингээд явсан. Тэгээд үр дүнд нь тэр 120 дугаар тогтоол гээд тэр тогтоол батлагдсан. Маш тодорхой заалт бүхий. Тэгээд Улсын Их Хурлаас Засгийн газарт ийм тодорхой үүрэг чиглэл өгсөн тогтоол энд таны тэр сайдын хувиар юу бодох чинь хамаагүй. Тэгээд тэр тогтоолын хэрэгжилтээ л бид нар танаас нэхээд байгаа. Тэгэнгүүт яг үндсэн тэр нөгөө асуудал руугаа орохгүй энэ хэлэлцээр эхлээд одоо даруй хагас жил болж байхад тиймээ яг тэр тогтоолын тэр нэр бүхий 5 зүйл дээр тодорхой ахиц дэвшил гаргахгүй тэгээд зүгээр тэр нөгөө хэлэлцээр хийх тэр зээлийн хүү хүүний талаар хэлэлцээр хийх 7 жилийг ингэсэн тэгсэн энэ тэр гээд зүгээр нэг ийм дайвар зүйлүүдийг л яриад шоудаад байх юм. Тэгээд үр дүн чинь хаана байгаа юм бэ. Ямар хугацаанд энэ хэлэлцээр чинь үргэлжлэх юм. Хагас жил боллоо шүү дээ хангалттай шүү дээ.

Тэгэхээр энэ дээрээ л үр дүн гарга. Уул уурхайн сайдаас бөгөөд энэ Засгийн газраас ерөөсөө энэ ОТ-н хэлэлцээр дээр л үр дүн гаргахыг л хүлээж байгаа шүү яг цагаа тулахлаар. Түүх тэрийг л...

Б.Заяабал: Сайнзориг гишүүн үг хэлнэ. Сайнзориг гишүүний микрофон өгье.

П.Сайнзориг: Би ямар ч байсан энэ хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байна аа. Тэгээд мэргэжлийн байнгын хороо Эдийн засгийн байнгын хороо маань маш сайн нягт үзээд бас цаг алдмааргүй байна. Одоо яг иймэрхүү юмыг буцаачихаар дахиж нэг хэсэгтээ орж ирэхгүй байх аа. Бид хэд нөгөө хамтарсан Засгийн газар байгуулагдаад л иймэрхүү бодлогууд орж ирнэ гээд нэлээн хүлээлттэй байсан. Тэгээд өнгөрчихсөн байхгүй юу. Уг нь 2 нам хамтарч байхдаа л асуудлуудаа шийдчихсэн бол гэж ойлголцол илүү байх байсан болов уу гэж зүгээр хувьдаа боддог байсан. Тэгээд тэр улс төрийн боломжийг бид хэд ашиглаж чадаагүй. Тэгэхдээ бүгд л парламентад суугаад Монгол Улсын хөгжлийн төлөө байгаа учраас нам харгалзахгүй зөв бодлого дээр хамтдаа байх байх. Тийм учраас ингэж итгэж байгаа учраас ажлын хэсгээ гаргаад явъя аа.

Үүрийнтуяа гишүүнтэй санал нэг байна. Ялангуяа би тэр ажлын хэсэг байгуулах асуудал дээр нь ажил хэрэгч гишүүдээсээ гадна ашиг сонирхлын зөрчлөөс янз янзын эрх ашиг төлөвлөдөг хүмүүсээс хол энэ ажлын хэсгийг гаргаасай гэж хүсэж байна. Сүүлдээ одоо хувийн хэвшлээ ялгаварлан гадуурхдаг байсан бол одоо улсын гэдэг юм уу, төрийн өмч энэ орон нутгийн асуудлыг ялгаварлан гадуурхдаг болж байна. Тийм учраас Эрдэнэт дээр жишээ нь ингэж 20 хувийг дангаар нь үлдээж болохгүй ээ. Энэ маш буруу жишиг болно. Харин Эрдэнэт дээр дагаж мөрдөх журмын зохицуулалтаар дараагийн хэдэн жилийн татварыг урьдчилж авдаг ч юм уу иймэрхүү зүгээр хуулийн хүрээнд шийдэж болох тиймэрхүү юмнуудаар явна уу гэхээс Эрдэнэт дээр 20 хувийг үлдээххээд бусад юмыг өөрчилж болохгүй. Би Батнайрамдал гишүүн ээ, өөрөө би саналаа л хэлж байна. Та бүх

салбарыг ганцаараа уул уурхайг мэддэг хүн биш шүү дээ харин тийм. Тэгэхээр ингээд зүйлүүдийг зөв ойлго л доо. Тэгэхээр ийм зүйл байна аа. Тэгэхээр энэ ингээд юмыг ингээд оочин цоочин янз янзаар хийнэ ээ гэдэг чинь бид хэд дараа нь хөрөнгө оруулалтын гэрээ болоод энэ хөрөнгө оруулалтыг татахад хөрөнгө оруулагч нар эргэлзэнэ ээ, орж ирэхгүй. Тийм учраас зарчмаа ил тод нэг л тогтоо. Тэгээд энэ зарчимд нийцэж байгаа бол бүгдтэй нь ижил тэгш хандаач ээ л гэдэг зүйл байна.

ОТ дээр тэр Онтрегийн асуудлыг маш сайн нягтлаарай. Энэ бол угаасаа тусдаа хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах гэдгийг хөрөнгө оруулагч талд хатуу байр сууриа хэлмээр байгаа юм. Улсын Их Хурал ч гэсэн тэгж үзэж байгаа байх. Тэрнээс биш энэ одоо өмнөх байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээ нь нэг хэсэг гэж явж чадахгүй ээ бид нар. Энийгээ ингээд хэлчихмээр байна. Харин энэ өмнөх Хөрөнгө оруулалтын гэрээ буюу одоо явж байгаа энэ асуудал дээрээ тусгай АМНАТ дээр 34-өө орлуулаад ер нь гарвал яадаг юм. Менежментийн төлбөрийг буурууллаа гээд л баяр ташаад л байна. Яг эцсийн дүндээ зардал өсөхөд үр дүн гарахгүй ээ л гэсэн үг. Одоо зээлийн хүүгийн хэлэлцээрийг бууруулах 7 жилийг бид нар байхгүй болгочихлоо. Тэгээд хэдэн жил үргэлжилнэ гээд бид нар ингээд эдийн засгаа ингээд агшаагаад борц шиг хатаагаад байлгаад байх юм. Тэгэхээр наад одоо ийм даварчихсан яриа хэлэлцээрийн хувьд яг эрх тэгш нэг суучхаж чадахгүй тэгээд асуудлуудаа яагаад ер нь тэгээд яах вэ хэдүүлээ яг амсах ёстой эсвэл зовлонгоо амсаад ер нь шийдэх ёстой шүү дээ.

Тэгээд бүх зүйлүүдийг ингэж ганцхан ОТ болон энэ Онтрегоос болоод эдийн засгаа ингэж царцаагаад, багш эмч нарынхаа хүүхдүүдийнхээ асуудлаа шийдэж чаддаггүй, эрүүл мэнд, нийгмийн даатгалынхаа асуудлаа шийдэж чаддаггүй, бүтээн байгуулалтуудаа шийдэж чаддаггүй, ийм байдал дээр ингээд өөр өөрсдөө ингээд хүзүүндээ олс хийхээд ингээд байгаад байж боломгүй байна аа. Тэгээд алтан хувьцаагаа аваад, хориг тавих эрхээ аваад тэгээд тэр 34 хувиа хэдэн хувийн АМНАТ-өөр байдаг юм ингээд солиод наад менежментдээ оролцоно зээлийн хүүг бууруулна гээд үлгэр шилний цаанаас мөхөөлдөс долоохоо ер нь боливол яадаг юм одоо. Наадах чинь бүтэхгүй байхгүй юу. Үсрээд л 1, 2 пунктээр л бууна. Тэгээд угаасаа сэтгэл ханамж ард түмэн Монголын талд бол хэзээ ч байхгүй.

Тэгээд ер нь шулуухан хувилбар луугаа ороод олон нийтдээ ойлгуулах тал руугаа орохгүй бол тэгэх гэж байна, ингэх гэж байна. Хэзээ ч ноогдол ашиг чинь бараг 50 хувь хүртэл байхгүй. Магадгүй тусгай АМНАТ-өөр орлуулахад жилд 360 мянган тонн зэс гаргаж байгаа бол энийгээ бид нар бараг дабльдаж авах гээд байна шүү дээ энэ хэмжээн дээр одоо АМНАТ-өө. Ингээд өнөөдрийнхөө асуудал энэ дэд бүтцийнхээ асуудлыг шийдмээр байна шүү дээ. 50 оныг бид нар хүлээгээд мэдэхгүй дараа нь юу болчихсон байх бол. Нөгөө нүх л үлдэх байх даа.

Б.Заяабал: Шижир гишүүн үг хэлнэ. Шижир гишүүний микрофон өгье.

Ө.Шижир: Өдрийн мэнд. Ер нь бол төр өөрөө ялгаварлалгүй ялгаж харьцдаггүй ийм хандлагыг өөрөө эхнээсээ бий болгож өгөх ёстой юм. Тэгэхгүй бол одоо энэ нэмэлт өөрчлөлтөөр чинь Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг дагаж мөрдөх журмын тухай гээд ганцхан Эрдэнэтийг салгаад аваад үлдчихэж байгаа юм. Тэгээд энэ улсын өмч 100 хувь юм чинь хамаагүй АМНАТ-өө 21.6 хувиар төл, бусад нь 5 хувиар төл гэдэг ийм ялгаатай байдлыг хуульчилж өгөх гээд байна л даа энэ төслөөрөө. Тэгээд энэ чинь нөгөө хар цагаанаар нь ялгаж байгаатай л яг адилхан л даа. Тэгээд ийм байж 1 дүгээрт болдог

юм уу. Энэ чинь нөгөө Үндсэн хуулийн зөрчил биш юм уу. Аль алийг нь ААН гэж үзэх юм бол 2 ААН-ийг яагаад ирээдүйд ашиглалтад орох ААН-үүдийг яагаад өмнө нь ашиглалтад орсон ААН өөрөөр ялгаж үзээд, татварын ялгаатай бодлого бий болгох гээд байгаа юм. Энэ чинь бас их сонирхолтой. Ямар зорилго байгаа юм. Нөгөө үнээгээ үхсэнийх нь дараа сүүтэйг нь мэднэ гэдэг шиг Эрдэнэт үйлдвэрээ байдгаар нь сааж саачхаад бүх авч болох татвар шимтгэл, торгууль, баяжмалаас нь хүртэл нөгөө АМНАТ татаж авчхаад бусад төслүүдээс нь тэгвэл 5 хувиа өг өө гэдэг ийм яагаад ялгаатай байдлыг энэ хуулийн төслөөр оруулж ирж байгаа юм бэ.

Ер нь өөрөө төр ойлгомжтой бөгөөд тодорхой байх ёстой. Хөрөнгө оруулагчийг гадаадын болон дотоодын гэж ялгах ёсгүй юм. Дотоодын хөрөнгө оруулагч гэхээр яагаад 2 дугаар эгнээнд суух ёстой юм яг бодитоор. Тэгэхээр бид нар ийм зүйлүүдийг хүртэл ингээд энэ хуулийн төслийг дахиад харах хэрэгтэй байгаа юмаа. Одоо дахиад нэг үүсэж байгаа нэг маш том асуудлууд нь байдаг. Төр болно оо гээд тусгай зөвшөөрлийг нь олгочихдог. Болно болно та нар наадхаа хий гээд. Тэрийг нь одоо гадаадын хөрөнгө оруулагч авна уу, дотоодын хөрөнгө оруулагч авна уу хамаагүй тэр бол 77 дахь асуудал. Тэгээд тухайн төслийнхөө ач холбогдлынхоо ойлголтыг буруу өгдөг эсвэл өгдөггүйгээс болоод хөрөнгө оруулж байгаа тал болон нутгийн иргэд 2-ын хооронд бараг иргэний дайн болдог. Үүнийг төрийн байгууллагууд нь хараад яаж ч чадахгүй нүдэн балай, чихэн дүлий сууж байдаг. Тэгсэн мөртөө Өмнөговь аймагт явж байгаа ЭТТ, Орхон аймагт явж байгаа Эрдэнэт хоёрынхоо орлогыг хуу хамж аваад нөгөө аймаг сумдууд нь амьдраад байдаг. Тэгээд шинэ төсөл хөтөлбөр хийе, хайгуул хийе гэхээр тэнд нь очоод ингээд шанаган дотор нь ороод ингээд зарим нэг нь ороод хэвтчихдэг. Ингээд үйл ажиллагааг нь явуулдаггүй. Энэ бол өөрөө юу вэ гэхээр төрийн өөрийнх нь сүр хүч, иргэдийн итгэх итгэл муу байна аа гэсэн үг байхгүй юу. Тэгээд энийг одоо бид нар яаж зохицуулах юм. Энийг зохицуулахгүй бол бид нар хэдий болтол ганцхан Эрдэнэт, ганцхан ОТ-тойгоо ингээд байж байх юм. Тэгээд энэ юмнуудыг бид нар яаж өөрчлөх юм.

Нэгэнт төр өөрөө зөвшөөрлөө өгсөн л бол хэвийн үйл ажиллагаа явах боломжийг нь яаж хангаж өгөх юм гэдгийг энэ хуулийн төсөл дээр оруулмаар байгаа юмаа. Тэгэхгүй бол цаашдаа ингээд бид нар олон бид нар чинь угаасаа л уул уурхайгаас, эдийн засгаас хамааралтай улс. Алт, нүүрс, зэсээ зараад нэмэх нь нэг жоохон ноолуур зарж байгаа байх. За ингээд эндээс олсон орлогоороо 21 аймаг 330 сумдаа хуваарилаад тэгээд амьдардаг. Тэгээд орлогоо яаж нэмэгдүүлэх юм, төслүүдээ яаж нэмэгдүүлэх юм. Ингээд үйл ажиллагаа явах боломж дээр нь ингээд зохион байгуулалттайгаар турхирч байгаа үйл ажиллагааг нь бид нар яах юм. Энэ чинь дандаа зохион байгуулалттай юм байна лээ шүү дээ ихэнх нь. Энэ зохион байгуулалтын үйл ажиллагааг ингээд турхираад ингээд явуулж байхад бид өнөөдөр энэ Ашигт малтмалын хуульд мянган удаа гоё өөрчлөлт оруулаад, татварын эрх зүйн орчин хэчнээн л гоё болоод энэ үйл ажиллагаа чинь явахгүй шүү дээ.

Тэгээд бид нар эхлээд ер нь энэ талынхаа ажлыг илүү хийх ёстой юм байна аа гэж ингээд бодож байгаа юм. Тэгээд бодвол ажлын хэсэг гарах байлгүй. Ажлын хэсэг дээр ингэж ялгаатай байгаа, ялгаатай хандаж байгаа байдлыг ахиж битгий оруулаарай. Тэнд нь янзлаарай. Тэгэхгүй бол энэ чинь бүр арай дэндүү л ялгавартай хандаж байна шүү дээ. 21.6 хувь, 5 хувь гэдэг чинь яаж хоорондоо өрсөлдөх юм. Яаж энэ бизнесийн орчин чинь эрүүл болох юм яг бодитойгоор. Тэгэхээр энэ дээр илүү их та хэд маань бас ажлын хэсэг гарах бол тэрэн дээр анхаараарай гэж хэлэх гэсэн юм.

Б.Заяабал: Батнайрамдал гишүүний микрофон өгье. Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: За тэгэхээр ямар ч байсан Онтрегийн хэлцэл болтол яг тэр зэсийн АМНАТ бууруулж байгаа тэрийгээ хөндөхгүйгээр Ашигт малтмалын тухай хуулиа хэлэлцээд явна гэж ойлголоо шүү дээ тиймээ. Тэгэхээр би зүгээр бас нэг хэдэн статистик хэлчихмээр байна л даа Онтре гээд яриад байгаа.

Бид нар Онтрегийн зөвхөн Хойд Хюгогийн үргэлжлэл нэг ёсондоо яг уул уурхайд ороод олборлолт эхлэх боломжтой тэр нь Хойд Хюгогийн үргэлжлэл дээр байгаа зэсийн нөөц нь өөрөө бид нарын Эрдэнэт дээр байгаа Эрдэнэтийн сая Оюут Оюутын ордоос 3 дахин их зэсийн нөөц байхгүй юу. Тэгэхээр бид нар Онтрегийн асуудлыг шийднэ гэдэг чинь 3 Эрдэнэт Оюутын ордыг шийдэж байгаатай хэмжээний том мөнгөн урсгал ярьж байгаа юм. 2.5 дахин Цагаан суваргаас том. Тэгэхээр энэний ач холбогдол нь өөрөө тэгэхээр маш өндөр учраас хэлээд байгаа юм л даа. ОТ одоо нийт бүлэг ордын нөөцийн геологийн нөөцөөр нь Онтрегийн лиценз дээр 5.5 сая тонн зэс, 192 тонн алт байгаа байхгүй юу даа. ОТ-н тэр бүлэг ордууд дотроо хамгийн өндөр алтны нөөцтэй нь Онтрегийн талбай бүхий Хойд Хюгогийн үргэлжлэл дээр байгаад байгаа.

Тийм учраас энэ хэлцэл маш чухал байна аа. Энэийг ОТ-н тэр түрүүн Жаргалан гишүүн бас яриад байна. Өөрөө Хянан шалгах түр хорооны гишүүн байсан шүү дээ. Тэгэхээр энэ Хянан шалгах түр хорооноос гарсан 120 дугаар тогтоол дээр маш ойлгомжтой уул нь байгаа шүү тиймээ. Түрүүн бас Золжаргал гишүүн ноогдол ашгийн тухай ярьж байгаа юм л даа. 2026 ондоо бид нар ноогдол ашиг авах боломж байгаа шүү дээ. Энэ хувь нийлүүлэгчийн гэрээгээр зохицуулдаг заалт. Хувь нийлүүлэгчийн гэрээ гэрээн дээр бүх зээлүүдийн хэлбэр төлөгдсөний дараа ноогдол ашиг яригдана гэсэн тэр заалт л байгаа байхгүй юу. Тэгэхээр энэийг 120 дугаар тогтоолоор хувь нийлүүлэгчийн гэрээг харилцан дүгнэлцээд шинэчилнэ гэсэн чиглэл өгөгдсөн байна. Тэгэхээр 120 дугаар тогтоол дотор наадах чинь бүрэн байгаа зүйл ээ. 2026 онд ОТ 5.2 тэрбум долларын эерэг мөнгөн урсгалтай. Free and leverage cash flow англиар энэ нь эерэг мөнгөн урсгал гэсэн үг. Нийт зардлаа хасаад үлдэх мөнгөний урсгал нь 5.2 тэрбум доллар байна гэж Морган Стэнлийн хөрөнгө оруулалтын банкны судалгаа байгаа юм. ОТ-н өөрсдийнх нь эхний улирлын байдлаар гаргасан 1 дүгээр улирлын тайлан дээрээ бол энэ жилдээ нэг 2.6 тэрбум долларын эерэг мөнгөн урсгал. Тэгэхээр ер нь бол нэг 3-5 тэрбум долларын хооронд эерэг мөнгөн урсгал нь буюу ноогдол ашиг хэмжээнд тараах хэмжээний хангалттай мөнгөн урсгал байх нь ээ. Тэгэхээр энэ өрөм нь явж байгаа үедээ бид нар урьтаж нэг ёсондоо хамтдаа өрмөө хуваалцаад явахгүй бол энэ өрөм чинь цаг хугацааны л асуудал байхгүй юу.

Ер нь түрүүн бас Сайнаа гишүүн ч хэлж байна л даа. Тэр ноогдол ашиг тэр 37, 38 онд тэр бол үлгэр шүү дээ ер нь үнэн шүү дээ. Яагаад гэх юм тэр үед чинь энэ Фамил 1, 2 лифт 1, 2 чинь явчихна. Тэрний дараа дахиад том хөрөнгө оруулалт орж байж нэмэлт орлого орох ийм л модельтой шүү дээ. Тийм болохоор Онтрегийн хэлцлийг бас цаг хугацаанд нь амжиж энэ зэсийн үнэ өндөр байгаа дээр энэийгээ бид нар яаравчлах ёстой. 120 дугаар тогтоол хэрэгжих хэрэгтэй. Ер нь ОТ дээр алдсан боломжийг бид нар Онтре дээр л нөхөх ингэж байж ОТ бүлэг ордоос 51 хувь дээр 50 дээр нэмэх нь нэг хувь авах ийм л боломж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэийг л бид нар алтан боломжоо заавал ашиглах ёстой л гэдэг ийм л юм хэлээд байгаа юм.

Б.Заяабал: Баярлалаа. Би бас үг хэлье гэж бодож байна. Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт орж ирсэн. Энийг би зарчмын хувьд дэмжсэн ийм байр суурь дээрээс үг хэлнэ ээ. Үнэндээ Монгол Улсын эдийн засаг өнөөдрийн байдлаар ямар байгаа билээ. Яг мэргэжлийн байнгын хорооны гишүүд бид нар бүгдээрээ л мэдэж байгаа. Эдийн засаг нефтийн үнээс хамаараад тэрний шат дараалсан давлагаат энэ цохилтын үр дүнд эдийн засаг удааширчихсан, инфляц өндөр болчихсон, эдийн засаг энэ нь эргээд эдийн засгийн идэвхжилийг унагаачихсан ийм хүнд цаг үед 1 дүгээрт болж байна.

2 дугаарт дэлхийн зах зээл дээр яг энэ үед энэ ховор ашигт малтмал, чухал ашигт малтмалуудын үнэ нэлээдгүй өндөр байгаа. Тэр дундаа манай энэ зэсийн үнэ бол өндөр байгаа. Ирэх 2, 3 жилийн үед ч гэсэн прогноз нь бас өндөр байхаар ийм төлөвтэй байгаа. Энэ үед бид нар энэ эдийн засгийг идэвхжүүлэх, эдийн засгийн идэвхийг нэмэгдүүлэх үүднээс дээрээс нь өөрийнхөө байгаа баялгаа өндөр үнэтэй ийм байгаа үе дээр бид нар ашиглахаас өөр одоо бид нарт өөр сонголт байхгүй. Монгол Улс бид нар дундаж орлоготой ийм орны тоонд ороод ирчихсэн. Энэ орлогын хэмжээг бид нар хадгалж, эдийн засгийн идэвхжилийг авч явахын тулд бид нар уул уурхай дээр түшиглэсэн ийм бодлогыгоо эргэж харж, илүү түлхэц өгсөн ийм бодлогыг авч явах ийм зайлшгүй шаардлага байгаа.

Мэдээж Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга гэж олон жил ярьсан. Олон сайдын үед ч гэсэн ярьсан. Одоо ингээд нэмэлт, өөрчлөлт хэлбэрээр ингээд орж ирж байгаа нь яах вэ хэдий шинэчилсэн найруулга орж ирээгүй ч гэсэн яг чухал чухал заалтуудаа бас оруулаад ороод ирсэн юм болов уу гэж ингэж бодож байгаа. Тухайлбал энэ геологийн суурь судалгаагаа бид нар хийж чадахгүй байгаа. Нэгийг харьцах 50 мянгын масштабаар судалгаа хийе гээд олон жил бид нар төрийн бодлогынхоо баримт бичгүүд тусгаад явсан. Өнөөдөр хүртэл хийж чадахгүй л байгаа. Энийгээ бид нар хувийн хэвшлийг оруулж ирээд эрлийн гэрээ хийгээд ингээд ашиглаад явъя аа. Эрлийн гэрээн дээр үндэслээд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл дээрээ дүгнэлтээ гаргаад тэрэн дээр нь үндэслээд энэ хайгуулынхаа судалгааныхаа лицензүүд талбайнуудыгаа олгоод явъя аа, хайгуулын лиценз талбай олгохдоо бас хариуцлагатай явъя. Өмнөх шиг өгөөд алга болдог биш илүү хариуцлагатай явъя гэсэн ийм гол заалтууд орж ирж байгаа.

Мөн түүнчлэн энэ хамгийн их асуудал яригддаг энэ уурхайн хаалт нөхөн сэргээлттэй холбоотой асуудлуудыг тусгай сан байгуулж тэрэн дээрээ мөнгөн хэлбэрээр байршуулж явдаг болъё оо. Эргээд бас уул уурхай ашиглаж байгаа ААН-үүдийг эргээд ийм хяналттай явдаг ийм системийг оруулж ирж өгч байгаа. Ашигт малтмалын баяжуулалтын үйл ажиллагаа эрхэлдэг зохицуулалтуудыг бас илүү нарийвчилж оруулж ирж байгаа. Одоо бид нар бүгдээрээ л мэдэж байгаа. Хортой цианит энээ тэрээ бодисыг энд тэнд ашиглачихлаа гэдэг асуудал ярьдаг. Өнөөдөр яг уул уурхайн баяжуулалтын чиглэлээр төрөөс барьж байгаа хянаж байгаа бодлого нь маш сул байгаа. Энийг бол энэ зохицуулалтуудыг оруулж ирж уул уурхайн салбарын үйлдвэрлэж байгаа энэ бүтээгдэхүүнүүдийн гарал үүслийг тодорхой болгох чиглэлээр оруулж ирж байгаа энэ заалтууд нь маш зөв заалтууд гэж би үзэж байгаа.

Дээрээс нь сая ярьсан энэ зэстэй холбоотой асуудлууд байгаа. Зэсийн АМНАТ-ийг бууруулж орж ирж байгаа. Тэр дундаа түүхийгээр нь зарах юм бол өндөр. Монгол Улсад нэмүү өртөг шингээд ингээд явах юм бол баяжуулаад тэгээд дээрээс нь эцсийн одоо таван 9-тэй зэс үйлдвэрлээд явах юм бол бүүр бага болгож

ингэж өөрчилж орж ирсэн байгаа. Энэ нь бол яг энэ яахын аргагүй бид нар энэ бодлого энэ орж ирсэн нэмэлт өөрчлөлтийг бид нар хэлэлцэх эсэхийг нь дэмжээд дараагийн шатад манай гишүүдийн яриад байгаа энэ саналуудыг аваад, ажлын хэсэг гаргаад илүү нухацтай аваад, тэр саналуудыг нь тусгаад сайжруулаад явах ийм боломжтой гэсэн ийм байр суурьтай байгаа гэдгийгээ бас та бүхэнд илэрхийлж хэлье ээ.

Ингээд Их Хурлын гишүүд Байнгын хорооны гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг үндэслэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна аа. Гишүүдийг санал хураалтдаа бэлдэхийг хүсье. Санал хураалтдаа бэлдье. Танхимд 16 гишүүн бүртгүүлсэн байна. Саналын томьёоллыг уншъя.

1.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

60 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2.Хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

52 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

3.Хамт өргөн мэдүүлсэн Уул уурхайн биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

60 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

4.Хамт өргөн мэдүүлсэн Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

60 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

5.Хамт өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

60 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

6.Хамт өргөн мэдүүлсэн Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

60 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

7.Хамт өргөн мэдүүлсэн ТХГН-ийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

52 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

8.Хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

60 хувийн саналаар уг санал дэмжигдлээ

9.Хамт өргөн мэдүүлсэн Газрын хэвлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Цэнгүүн гишүүн горимын санал гаргая.

С.Цэнгүүн: Төхөөрөмж ажилласангүй. Санал хураалтыг дахин явуулахыг хүсье.

Б.Заяабал: Цэнгүүн гишүүний гаргасан горимын саналаар саяын явуулсан санал хураалтыг хүчингүй болохыг тооцъё гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт.

56 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Тэгэхлээр 9 дэх заалтыг 9 дэх томьёоллоор санал хураалтыг дахин явуулъя. Унших шаардлагатай юу, шаардлагагүй юу?

Газрын хэвлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор дахин санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

60 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

10.Хамт өргөн мэдүүлсэн Гол мөрний урсац бүрэлдэх эх усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Одоо 2 байгаа.

56 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

11.Хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

64 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

12.Хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

64 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэн танилцуулна аа.

Хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа.

15.20 цаг

Дараагийн асуудалд оръё.

Зургаа.Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Б.Заяабал: Одоо Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя аа. Ажлын хэсгийг урья.

Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Жадамбын Энхбаяр танилцуулна аа. Энхбаяр сайдын микрофоныг нээе. 5 номер ажлын хэсгийн 5 номерын микрофон нээе.

Ж.Энхбаяр: Эрхэм Байнгын хорооны дарга аа, Байнгын хорооны гишүүд ээ,

Бизнесийн орчин хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл түүнийг дагаж Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Зөвшөөрлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, бусад дагалдах хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Эдгээр хуулийн төсөл нь бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг явуулахад хүндрэл болж буй саад бэрхшээлийг арилгах, таатай, тогтвортой орчныг бүрдүүлэх, ажил олгогч, баялаг бүтээгчдээ дэмжихэд чиглэсэн болно оо.

Ингээд та бүхэнд Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон бусад холбогдох хуулийн төслийн талаар танилцуулъя.

Слайд бизнесийн эрх чөлөөний тухай хууль. Эхэнд Монгол Улс дэлхийд хөрөнгө оруулагчдад ээлтэй байдлын үзүүлэлт их хангалтгүй гарч байгаа судалгаагаар. Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексээр бид нар 2025 онд 184 улсаас 74 дүгээр байранд эрэмбэлэгдэж байгаа хэдий ч эрх зүйн болон бодлогын орчныг сайжруулах олон асуудал байна. Ялангуяа хөрөнгө оруулагчдад ээлтэй

байдлын үзүүлэлтээр бид нар 109 дүгээр байр буюу нэлээн хойгуур эрэмбэлэгдэж байгаа. Гадаадын хөрөнгө оруулалтын орчин гарч байгаа гомдол маргааныг шийдвэрлэх тогтолцоог сайжруулах ийм шаардлага байгааг энэ харуулж байна.

Дараагийнх нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хөрөнгө оруулалтын тухай хууль 2013 онд батлагдсан. Тэгээд уг хуулиар хөрөнгө оруулалтын хэлбэр, татварын болон татварын бус дэмжлэг, татварын орчныг тогтворжуулах болон Засгийн газартай гэрээ байгуулах зэрэг зохицуулалтууд туссан байдаг. Хөрөнгө оруулагчид хууль эрх зүйн орчин, тогтвортой байдал, ил тод, урьдчилан таамаглах боломжтой нөхцөл хөрөнгө оруулалтын баталгаанд үндэслэн шийдвэр гаргаж байгаа. Иймд одоо энэ хөрөнгө оруулалт 2013 оны гадаад хөрөнгө оруулалтын хууль, хуулийнхаа суурийг хадгалаад, ингээд цаашаа сайжруулан тогтвортой хэрэглэх нь зүйтэй гэж үзэж энэ нэмэлт өөрчлөлтийг оруулж байна.

Хөрөнгө оруулалтын тухай хууль батлагдсанаас хойш 13 жилийн хугацаанд нийт 17 удаа өөрчлөлт орсон боловч дийлэнх нь бусад хууль дагасан өөрчлөлтийг дагалдаж орсон өөрчлөлтүүдээс холбоотой бөгөөд хуулиар зохицуулж буй зарим харилцааг тодруулах, хууль хоорондын уялдааг сайжруулах, хуулийн хэрэгжилтийг хангах хэрэгцээ шаардлага байсаар байна гэж үзсэн. Мөн хөрөнгө оруулагчдын гомдлыг үр дүнтэй шийдвэрлэх тогтолцоо бүрдээгүйгээс өнгөрсөн хугацаанд 7 хөрөнгө оруулалтын маргаан олон улсын Арбитрт томоохон маргаанууд очиж очсон байна.

Эдийн засгийн хөгжлийн яам Хөрөнгө оруулалтын эрх ашиг хамгаалах төв байгуулаад ингээд өнгөрсөн 6 сарын хугацаанд бүх салбарыг хүлээж авч, 7, 7 хоног арга хэмжээ болгож бүх санал гомдлыг сонссон. Нийтдээ нэг 145 гомдол хөрөнгө оруулагчдын гомдолтой холбоотой асуудлууд гарч ирж байна. Хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар арга хэмжээг авч гомдлыг шийдвэрлэх үүргийг холбох байгууллагуудад өгч, Засгийн газрын хуралдаанаар 3 удаа оруулж, тогтоол гаргуулан шийдвэрлэж ажиллалаа. Дэлхийн банкнаас 2023 онд гаргасан Дэлхийн хөрөнгө оруулалтын өрсөлдөх чадварын тайланд дурдсанаар Монгол Улс нь хууль бусаар хөрөнгө хураан авах, валютыг хөрвүүлэх, шилжүүлэхэд хязгаар тавих асуудлаар эрсдэлтэй орны тоонд багтсан. Олон улсын судалгаагаар гэрээгээ зөрчсөн тохиолдолд 3 хөрөнгө оруулагч тутмын нэг нь хөрөнгө оруулалтаа эргүүлэн татах шийдвэр гаргадаг бол хөрөнгө хураах тохиолдолд 50 хувь нь хөрөнгө оруулалтаа цуцалдаг байгаа.

Тэгэхээр манай энэ өмчийн халдашгүй дархан байдал, бизнесийн нэр хүнд, ялангуяа ингээд олсон ашиг орлого, валютын хөрвүүлэг шилжүүлэхэд хязгаарлалтууд олон зохицуулалтууд маань манай хөрөнгө оруулалтын орчныг их сул эрсдэлтэй гэж үзэх ийм байдал үүсгэсэн байна. Ингээд ирсэн гомдлуудыг ингээд 5 төрөлд ангилж гаргасан судалгаанууд.

1 дүгээрт, төрийн байгууллагын үйл ажиллагаатай үүн дотор мөн орон нутгийн иргэд олон нийтийн байгууллага буюу ТББ-тай холбоотой гомдол их өндөр байгаа. Энэ бол уул уурхай тойрсон нөгөө л янз бүрийн жагсаал цуглаан захиалгатай энэ арга хэмжээнүүдийг энэ дээр нэлээн олон гарна.

2 дугаарт, иргэний эрх зүйн гэрээний харилцаанд үүссэн маргаан бүхий 22 гомдол гарлаа.

3 дугаарт, мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой гомдлууд ялангуяа бизнесийн харилцаанд орж яваад шууд эрүүгийн хэрэг болж хувирч байгаа байдлууд нэлээн их асуудлыг гаргаж байна.

4 дүгээрт, татварын маргаантай холбоотой жишээлбэл хөрөнгө оруулалтын хуулиар олгосон хөнгөлөлт чөлөөлөлт татварын хуулиар энд үйлчлэхгүй байх жишээтэй буюу зохицуулалтууд тус тусдаа гарч ирээд ингээд татварын байгууллага болохоор татварынхаа хуулийг бариад асуудлыг шийдчихдэг, хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтынхаа хуулиа барьдаг, бүтээгдэхүүн хуваах гэрээнийхээ хуулийг гэрээгээ барьдаг гэх мэтийн маргаанууд нэлээн холбоотой 13 гомдол маргаан үүсэж байна.

5 дугаарт шүүхийн шийдвэр гүйцэтгэх холбоотой 12 гомдол. Асуудал хөөцөлдөөд шүүх дээр гараад шийдвэр гардаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл дээр хэрэгждэггүй, ойлгомжгүй, тодорхойгүй. Ингээд 5 жил, 8 жил болсон олон шүүхийн шийдвэрүүд хөрөнгө оруулагчтай холбоотой энэ гомдлууд үүссэн байна аа гэж.

Нийт 41 хуулийн хүрээнд 49 заалт буюу зохицуулалтаар гадаадын хөрөнгө оруулалттай ААН-ийн үйл ажиллагаа явуулж, хөрөнгө оруулалт хийхийг шууд болон шууд бусаар хориглож хязгаарласан байдаг. Ийм байна манайх. Их олон салбарыг хамарсан. Банк санхүү, соёл урлаг, үйлдвэрлэл, харилцаа холбоо, мэргэжлийн үйлчилгээ, ойн аж ахуй, хэвлэл мэдээлэл гээд ер нь олон салбаруудад гадаадын хөрөнгө оруулалтыг хориглож хязгаарласан байгаа бол хөдөө аж ахуй, эрчим хүч, барилга, боловсрол, аялал жуулчлал, эрүүл мэнд, төмөр зам, уул уурхайн салбаруудын зарим үйл ажиллагааг бодлогын түвшинд шууд бусаар хязгаарлачихсан ийм зохицуулалтууд хуулиуд дээр их байна. Ингээд хөрөнгө оруулалтыг гадаад, дотоодоор нь ялгах ийм ялгаварлан гадуурхах ажлууд бас их өндөр байна. Ингээд зах зээлийн зарчмаар зөрчилдөх энэ орон зайнд нэлээн асуудал үүссэн байна аа гэж гарч ирж байгаа юм.

Дараа нь ийм асуудалтай холбоотойгоор гадаадын хөрөнгө оруулалт орох урсгал одоо 2025 онд 3.8 тэрбум доллар гарч өмнөх оноос 8 хувиар буурлаа. Нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын 40 хувь нь зөвхөн ОТ-н төсөл харагдаж байгаа эзэлж байна. Хэдийгээр яах вэ сүүлийн 3 жил орох урсгал харьцангуй тогтвортой байгаа ч нөгөө талдаа бид нар хөрөнгө оруулагч нартаа буцаан төлөх валютын гарах урсгалууд нэмэгдэж эхэлсэн. Тэр доод талд гарч байгаа шүү дээ. Тэрбум 200. 2025 гэхэд 1.2 тэрбум ам.долларын эргэн төлөлт гарч байна гэсэн үг буюу хөрөнгө оруулагч нар гадагшилж байна гэсэн үг. Энэ их том сигнал өгч байгаа. Ялангуяа уул уурхайн салбарт энэ гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарласан хууль, тогтоол шийдвэр, орон нутгийн байгууллага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, иргэний төлөөллийн байгууллагуудын янз бүрийн нөлөөгөөр энэ хөрөнгө оруулалт огцом ингэж буурч байна.

Мөн гадаадын хөрөнгө оруулагч нарт улс төр бодлогын энэ тогтворгүй байдал их нөлөөлж байна. Өмчийн эрхийн баталгаа их сул байна, баталгаа болж чадахгүй байна. Авлига, хүнд суртал, шүүхийн удаашрал, давхардсан хяналт, энэ иргэний нийгмийн нэр барьсан байгууллагуудын эсэргүүцэл, ажиллах хүчний төлбөр квот гээд олон хүчин зүйл манай энэ гадаадын хөрөнгө оруулалтын орчныг муутгаж байгаа ийм үзүүлэлтүүд гарч байна аа. Дараа нь гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд ер нь Монгол Улсад ер нь ямар үр нөлөөтэй юм бэ гээд олон хүн асууж гайхаад байгаа юм. Монгол Улсад бүртгэлтэй нийт 213 мянган ААН байна Монгол

Улсад. Үүний 4.8 хувь буюу 10.2 мянга нь гадаадын хөрөнгө оруулалттай компани үйл ажиллагаа явуулж байна. Энэ 10.2 мянган гадаадын хөрөнгө оруулалттай компаниас 4 мянган компани үйл ажиллагааг тогтмол явуулж чадаж байна. Энэ 4 мянган компани Монгол Улсын нийт ААН-үүдийн орлогын албан татварын 24 хувь, 4-ний 1-ийг дангаараа бүрдүүлж байна. Нийт цалингийн сангийн 15 хувийг бүрдүүлж байна. НДШ төлөлтийн дүнгийн 18 хувийг гадаадын хөрөнгө оруулалттай компани бүрдүүлж байна аа гэсэн үг. Тэгэхээр гадаадын хөрөнгө оруулалтын ач холбогдлыг нь зөвхөн татвар хураамж дээр ирж байгаа ачаалал. Тэгэхээр бид нар гадаадын хөрөнгө оруулалттай энэ хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, олон компани гадаадын хөрөнгө оруулалтыг оруулах, зах зээлээ нээх ийм зайлшгүй шаардлага байна гэж үзэж байна аа.

Одоо Бизнес эрх чөлөөний тухай хуулийн талаар. Дараагийн хуулийнхаа талаар танилцуулъя.

Ийм төрлийн хуульд эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал нь адил төстэй орнуудад бизнес эрх чөлөөг хамгаалж, хэт хяналт, баримт бичгийн шаардлагыг багасгаж, төр бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг хуульчилсан байдаг. Бид одоо энэ нэг Вьетнам, Гүрж, Казахстан, Киргиз, Эстони гээд энэ улсад бизнес эдийн засгийн эрх чөлөөг хангах бие даасан хууль эрх зүйн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгааг судалсан. Энэ бол хамгийн сайн хэрэгжиж байгаа ийм орнууд байна. Уг хуулийн төслийг 2 хуудас бүхий бизнесийн эрх чөлөөний тунхагийг баталгаажуулсан малгай хууль байдлаар боловсрууллаа. Энд бол өмчийн эрх, бизнесийн эрх, бизнесийн нэр хүнд энэ асуудлыг нэлээн суурь болгож оруулж ирж байна.

1 дүгээрт бизнесийн эрх чөлөөг хангах зарчмыг баталгаажуулж байна. Төрийн оролцоог багасгаж, бизнес эрхлэгчдийн дарамтыг бууруулах асуудлыг оруулж байна. Төрийн байгууллага байгууллагуудын үйл ажиллагаанд хориглох зүйлсийг жагсааж, бизнес эрхлэгчдийн хууль ёсны эрхийг хамгаалах асуудлыг орууллаа.

Бизнесийн дараагийн слайд. Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийг дагалдуулан Хөрөнгө оруулалтын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон бусад 97 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар бэлтгэлээ.

Одоо Хөрөнгө оруулалтын тухай хуулийн гол 6 өөрчлөлт юу вэ? Үүнд:

1 дүгээрт, хөрөнгө оруулагчдын гомдол шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх асуудал их чухал байсан. Маргааныг олон улсын арбитраар шийдвэрлэх эрхийг баталгаажуулах асуудлыг тусгалаа.

2 дугаарт, хөрөнгийн зах зээлд шинэ хөрөнгө оруулалт татах татварын таатай орчин буюу санхүүгийн салбар энийг олон тулгуурт болгох...

Б.Заяабал: Ажлын хэсгийн 5 номерын микрофон өгье.

Ж.Энхбаяр: Манай санхүүгийн салбар үндсэндээ арилжааны банкн дээр 95, 96 хувийн хамаарал бүхий ийм орчин байгаа. Иймд бид нар бусад хөрөнгийн зах зээл, хөрөнгө оруулалтын сан болон бусад санхүүгийн орон зайг нэмэх үүднээс тэнд учраад байсан татварын нөхцөлийг их сайн таатай орчныг бүрдүүлэх ийм өөрчлөлтүүд орж байгаа. Төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгож,

хяналт шалгалтын давхардлыг бууруулах асуудал орж ирж байгаа. Тогтворжуулах гэрээ хөрөнгө оруулалт хийсэн ААН-үүд тогтворжуулалтын гэрчилгээ олгох, түүний шалгуурыг хялбаршуулах, хугацааг нэмэгдүүлэх зохицуулалтуудыг орууллаа.

Мөн гадаадын хөрөнгө оруулалтын зарим хязгаарлалтууд байсан. Үүнийг арилгаж байгаа. Хөрөнгө оруулалтын баталгаа суурь зарчмыг олон улсын жишгийн дагуу энэ хуульд тусгахаар орууллаа.

За ингээд 6 өөрчлөлтийг нэг бүрчлэн танилцуулбал нэлээн цаг алдана. Ингээд хэлэлцүүлгийн явцад цаашаа явъя.

Зөвшөөрөл мэдэгдлийнхээ хууль руу очоод. Зөвшөөрөл мэдэгдлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр бизнесийн үйл ажиллагаан дахь төрийн дарамтыг арилгана гэсэн зорилго тавьж, Зөвшөөрөл мэдэгдлийн тухай хуульд өөрчлөлт оруулж байна. Манай улс бизнес шинээр эрхлэх үйл ажиллагаа өргөжүүлэх зэрэг бүхий л үе шатад зөвшөөрөл гэж нэрлэгдээгүй боловч бизнесийн үйл ажиллагаанд шаардагддаг төрийн байгууллагаас олгодог баримт бичгүүдийг энэ дээр та нарт гаргалаа. Гэрээ бүртгэл, дүгнэлт, тодорхойлолт, гэрчилгээ, сертификат, лиценз, магадлан итгэмжлэл, батламж, эрх олголт гээд энэ болгон өөрөө гох дэгээ төрийн алба албан тушаалтнаар дамжиж байгаа ийм зүйлүүд байгаа. Энийг бол Бүтээмжийн хорооноос судлаад Монгол Улсын хуулиуд бүртгэл 264, дүгнэлт 232, гэрчилгээ 132, магадлан хяналт 30, сертификат 9 гээд ийм дүнгүүдийг гаргасан.

Тэгээд цаашид энэ шинээр бий болгоход зохицуулалтын үр нөлөөллийн үнэлгээ хийдэг. Нэг удаагийн шинжтэй эрсдэлийн түвшин багатай ААН-д үйл ажиллагаа шууд мэдэгдлээр ингээд эрхэлдэг, зөвшөөрөл эрхлэх үйл ажиллагааг зорилго нөхцөл, онцлог эрсдэлээс хамааруулаад ингээд ангилаад нийт энэ 251 тусгай энэ зөвшөөрлөөс 233-ыг нь цахим хэлбэрээр авах бололцоотой болгосон. Үүнтэй холбоотой ажил Засгийн газар дээр хийгдээд явж байна. Явцын хяналт шалгалтаар үйл ажиллагаа нь хэвийн тохиолдолд энэ зөвшөөрлийн хугацааг шууд сунгадаг. Энэ хяналт шалгалт гэж давхардсан асуудлууд их. Зарим компани дээр жилийн дотор 27, 28 удаа очиж салбар салбараас хяналт хийгдсэн ийм юмнууд ер нь олон гарсан. Тэгэхээр энэ хяналт шалгалтын үйл ажиллагааг тодорхой болгож байгаа. Зөвшөөрлийн хугацааг уртасгах зохицуулалтууд орсон, богино хугацаанд өгөөд дахин дахин анхнаасаа дахин бичиг цаас бүрдүүлдэг ажлыг өөрчилж байгаа.

Төрөөс олгож байгаа 120 зөвшөөрөл байгаа. Зөвшөөрлийг мэргэжлийн холбоод руу шилжүүлэх бололцоотой гэж үзэж энэ хуульд оруулсан буюу салбарууд өөрөө илүү хариуцлагатай байж өөрөө салбараа, өөрөө бодлогоо зохицуулаад, өөрөө хяналтаа тавиад, өөрсдөө үнэлгээгээ хийгээд, энэ үүргийг мэргэжлийн холбоодод төр шилжүүлэхэд бэлэн байна гэдгээ илэрхийлж өөрчлөлт оруулж байна.

Нөгөө талаар И-бизнес системд хаана юу хийхээ мэдэгдээд хүлээлгүй шууд эрхлэх энэ гэрээ бүртгэл, гэрчилгээ, лавлагаа зэргээр зүс нэр нь өөрчлөгдсөн олон ийм зөвшөөрөл хөөцөлдөхгүйгээр И-бизнес системд шууд хандаад шууд эхэлнэ. Шууд мэдэгдээд шууд эхэлсэн иргэндээ төр очно оо. Мэдэгдээд үйл ажиллагаа эхэлснээс хойш төр 30 хоногийн дотор хаяг байршилд нь очиж үйлчилгээ үзүүлнэ. Галын дүгнэлт, хогийн гэрээ гээд шаардлагатай ийм гэрээнүүдийг төр өөрөө очно гэсэн ийм зохицуулалт хийсэн.

Дараагийнх нь Бизнесийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төслийн хүрээнд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Зөвшөөрөл мэдэгдлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт болон бусад дагалдах хуулиуд нийлсэн 99 хуулийн төсөлд нэмэлт болон өөрчлөлт ингэж орж байна аа. Тэгэхээр бид энэ 99 хуулийн хүрээнд ер нь өнгөрсөн 35 жил гэж үзэхэд 35 жилийнхээ энэ бизнес хөрөнгө оруулалтын орчин дээрээ нэлээн сайн суурьтай дүгнэлт хийж, бүх салбарыг тойрсон хэлэлцүүлгүүдээ хийж, саналыг тусгаж, эхний ээлжид энэ 99 хуулийн өөрчлөлт бүхий энэ багц асуудлыг оруулж байна аа. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

Б.Заяабал: Энхбаяр сайдад баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя аа. Энхбаяр Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД, Сүрэнхорол Ерөнхий сайдын ажлын албаны ажлын алба Ерөнхий сайдын зөвлөх, Тэнгис Ерөнхий сайдын ажлын алба Ерөнхий сайдын зөвлөх, Жавхлантөгс Шадар сайдын ажлын алба Шадар сайдын зөвлөх, Зандан Хөрөнгө оруулалт худалдааны газар, Хөрөнгө оруулалт худалдааны газрын дарга, Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Төгөлдөр Эдийн засгийн хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Хөгжлийн төсөл хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга, Пүрэвсүрэн Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга, Золзаяа Эдийн засаг, хөгжлийн яамны Бизнесийн орчны бодлогын газрын Зөвшөөрлийн нэгдсэн сангийн хөгжүүлэлт хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн, Мягмарсүрэн Эдийн засаг, хөгжлийн яамны хуулийн зөвлөх гэсэн ийм ажлын хэсгийн гишүүд хүрэлцэн ирсэн байна аа.

Хуулийн төслийн талаар хууль санаачлагчаас асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя аа. Батнайрамдал гишүүнээр тасалъя. Соронзонболд гишүүн асуулт асууна. Соронзонболд гишүүний микрофоныг нээе.

Л.Соронзонболд: Энэ Бизнес эрх чөлөөний тухай хуулийн төслийг дэмжиж байгаа. Тэгэхээр миний хувьд энэ шарк Энхтүвшин гишүүний ахалсан зөвшөөрлийн ажлын хэсэгт ажилласан. Тэгээд тэр зөвшөөрлийн ажлын хэсэг дээр хэд хэдэн асуудлууд байсан. Жишээлбэл зөвшөөрлийн зөвлөлөөр батлагдаагүй байгаа зөвшөөрлүүд байна. Мөн одоо энэ зарим яамдууд нь өөрсдөө болохоор энгийн зөвшөөрлөө байлгах гээд байгаа зүйлийг нь мэдэгдэл болгосон байна эд нар гээд асуудлууд гарч ирсэн. Тэгээд энэ асуудлууд ер нь яаж шийдэгдсэн бэ? Дээрээс нь болохоор энэ зарим яамдуудаас энэ хөндөгдөх шаардлагатай зөвшөөрлүүдийг оруулж ирээгүй байна гэсэн асуудлууд яригдаж байсан. Жишээлбэл Хот байгуулалт, орон сууцын яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам эд нар гээд. Мөн одоо хоорондоо зөрчилтэй давхардсан зөвшөөрлүүд байна гээд. Эдгээр асуудлуудыг ер нь энэ дагуулж орж ирж байгаа зөвшөөрөл мэдэгдлийн тухай хууль дээр яаж тусгасан бэ гэдэг 1 дүгээр асуулт байна аа.

2 дугаар асуулт дээр тэр гадаад, дотоодын зах зээлээс татсан эх үүсвэр төлж байгаа хүүгийн орлого дээр ногдож байгаа нөгөө давхар татварын гэрээтэй болон гэрээгүй байгууллагууд дээр татварын өөрчлөлт оруулахаар тусгасан байсан. Тэгэхээр энэ заалт маань зөвхөн банк болон санхүүгийн байгууллагууд гэдэг байдлаар орж ирсэн байна гэж ойлгосон. Тэгэхээр энэ дээр нөгөө бусад хувийн секторын компаниуд өөрсдөө л гаднын гадаад зах зээлээс эх үүсвэр татсан

тохиолдолд энэ асуудал татварын хувь нь буурахаар байгаа юу, ямар байгаа вэ? Энэ дээр нэг хариулт өгөөч.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 5 номерын микрофон өгье. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Сүрэнхорол зөвлөх эхний асуултад хариулаарай. Би сүүлийн асуудал дээр. Энэ ийм хуулийн зохицуулалттай явж байсан юм. 22 бишээ. Монгол Улсын банкны Монгол Улсын арилжааны банкны гадаад, дотоодын эх үүсвэрээс татсан зээл, өрийн хэрэгслийн хүүгийн орлогод 5 хувь гэж, бусад салбар бол 20 хувьтай. Тэгэхээр бидний бодлого арилжааны банканд дээр тулгуурласан санхүүгийн секторыг өргөжүүлж гээд бусад санхүүгийн гэдгээр хязгаарласан. Та бол одоо уул уурхай, барилга, худалдаа, бусад салбарт яриад байна шүү дээ. Энэ бол ер нь санхүүгийн сектор гаднаас татсан эх үүсвэр тэр зээл өрийн хэрэгслийн хүүгийн олзанд олдсон хувь 5 хувь байдаг ба арилжааны банк 5 байдаг бол бусад санхүүгийн салбар мөн адилхан 5 байгаа. Одоогоор 20 хувь гэсэн өндөр босготой байгаа нь манай санхүүгийн салбарыг гадаадын хөрөнгө оруулалт оруулах өргөжихөд нэлээн саад болж байна гэж үзэж энийг чөлөөлж байгаа. Тэгэхээр бусад салбарыг тусгаагүй зөвхөн санхүүгийн салбар гэж үзэж байгаа.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 2 дугаар микрофон нээе. Нэмэлт хариулт өгье.

С.Тэнгис: Соронзонболд гишүүний асуултад 1 дүгээр асуултад хариулъя. Ерөнхий сайдын зөвлөх Тэнгис байна. Зөвшөөрлийн тухай хуулийн өмнө нь өргөн мэдүүлсэн ажлын хэсэг дээр бид нар бүгдээрээ хамт ажилласан. Бараг 40 орчим хэлэлцүүлгийг Энхтүвшин гишүүнээр ахлуулаад бас нэлээн олон асуудлууд гарч ирсэн. Тэгэхээр энэ удаагийн төслөөр бол яг тэр тухайн Улсын Их Хурал дээр ярьсан асуудлуудыг хууль зүйн техникийн хувьд засах боломжтой хэсгүүдийг бүгдийг нь зассан байж байгаа. Мөн яамдаас энэ хуультай холбогдуулан дахиж энэ зөвшөөрөлтэй холбоотой дутуу орхисон зүйлийн саналыг бол авсан.

Мөн гишүүний асуусан нөгөө зөвшөөрлийн зөвлөл зөвшөөрөл нэмэхэд ашиглах тэр эрсдэлийн үнэлгээний журам бол энэ Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэн найруулснаас хойш батлагдаагүй 3 жил болчихсон байсан. Тэгээд энэ батлагдаагүй 3 жил хүлээгдсэн зөвшөөрөл бий болгоход шаарддаг тэр эрсдэлийн үнэлгээний журмыг сая 1 сарын өмнө Засгийн газар.

Б.Заяабал: 2 номерын микрофоныг дахин нэг минутаар нь нээж өгье. Хариултаа бүр.

С.Тэнгис: Засгийн газрын хуралдаанаар зөвшөөрлийн эрсдэлийн үнэлгээний журмыг баталсан. Мөн 10 хоногийн өмнө Зөвшөөрлийн зөвлөлийг бас шинэчилсэн. Шинэчлээд Эдийн засаг, хөгжлийн яамны бүрэлдэхүүн болон хувийн хэвшил, мэргэжлийн холбоодын төлөөллийг оруулсан. Тэгэхээр одоо энэ цаг хугацаанаас эхлээд шинээр зөвшөөрөл бий болгоход шаардлагатай зөвлөл болон Засгийн газраас батлах ёстой журмууд нь ингээд Засгийн газарт бий болчихсон. Тэгэхээр түүнээс хойш ирсэн зөвшөөрлийн хүсэлтүүдийг зөвшөөрлийн зөвлөл дээр ирэхэд нь яах вэ Засгийн газраас зохих тэр үнэлгээгээр нь оруулаад явна гэсэн үг.

Б.Заяабал: Баярлалаа. Батнайрамдал гишүүний микрофоныг нээе. Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Өдрийн мэнд хүргэе. Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан Бизнесийн эрх чөлөөний тухай хууль орж ирж байна. Зарчмын хувьд бол хуулийг дэмжиж байгаа. Боомилж байгаа хүчин зүйлүүдээ бид нар чөлөөлөх ёстой. Надаа маш тодорхой хэдэн асуултууд байна.

1 дүгээрт хуулийн 4.2 дээр бизнес эрхлэгчдийн нэр хүндэд хандсан халдсан үндэслэлгүй мэдээлэл гаргах, түгээхийг хориглоно оо гэж байгаа юм. Үндэслэлгүй мэдээлэл гаргах, түгээхийг хориглоно оо. Одоо тэгэхээр үндэслэлгүй гэдэг чинь аягүй нааштай цаашдаа л даа. Яг энэ үндэслэлгүй гэдгийг хэн тодорхойлох юм. Хууль дээрээ үндэслэлгүй гэхээр миний хувьд үндэслэлтэй байгаад байтал нөгөө хүний хувьд бизнесийн хувьд үндэслэлгүй байж болно. Энэ хуулийн маргаан дагуулах биш үү. Үндэслэлгүй гэхээр. Тэгээд энэ чинь бас жоохон цаашлуулах юм бол энэ чинь хүний нөгөө үг хэлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөө. Тэгээд одоо жишээлбэл би одоо ОТ дээр юм ярихаар бизнесийн нэр хүндэд халдсан гээд энэ хуулийн 4.2-ыг зөрчсөн болж надаа харагдаад байна л даа. Тэгэхээр энэ дээр нэлээн тодорхой хариулт авмаар байна.

2 дугаарт бас нэлээн олон бараг энэ чинь 100 орчим дагалдсан хуульд өөрчлөлт оруулж ирж байгаа юм байна тиймээ. Тэд нарыг яг үнэнийг хэлэхэд бүгдийг нь ингээд харж л байна. Гэхдээ уншиж арай дуусаагүй байна. Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр бас нэг асуулт байна. Энэ дээр 4.2 дугаар зүйлийн 20.5.7, 20.5.8 дээр манай нөгөө сонгон шалгаруулалт лицензийн сонгон шалгаруулалт маань оноожуулалтаар явагддаг. Тэгээд энэ дээр нийлбэр оноогоор 2-т орсон оролцогчид шууд нөгөө эхнийх нь хүчингүй болох юм бол шууд 2 руугаа очно гэсэн энэ зохицуулалтыг хуулиар оруулж ирж байгаа юм байна. Энийг уул нь бид нар журмаа өөрчилж байхдаа энийг бөөн юм болж байж энийг алга болгосон юм л даа. Яагаад гэхлээрээ яг энэ хайгуулын сонгон шалгаруулалт дээр ямар асуудал үүсдэг вэ гэхээрээ 1 дүгээрт нь гээд маш өндөр үр дүн тавиад худлаа орж ирчхээд, тэрийгээ татаж аваад 2 дугаарт нь ингээд маш хямдханаар ингээд авдаг ийм нэг ёсондоо харилцан тоглолт яваад байсан юм. Тэгэхээр энийг уул нь Уянгаа дэд сайд бид нар байж байхдаа энийг янзалсан юм. Энэ тэгсэн чинь хууль болоод орж ирэх юм. Энийг нэмэлт тайлбар авмаар байна.

Дараагийнх дээр нь би нэмэлт цагаа дарга аа авчихъя. Хөрөнгө оруулалтын тухай хууль дээр бас нэмэлт өөрчлөлтүүд орж ирж байна. Шадар сайдын презентаци дээр ер нь гарч байна л даа. Гадаадын хөрөнгө оруулалт дээр Тогтворжуулалтын гэрчилгээ Монгол Улс олгодог байгаа. Тэгэхээр энэ Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 16.2 дээр хөрөнгө оруулалтын хэмжээ болон тогтворжуулалтын хугацааг хугацааг нь бол 15 байсныг 20 болгож байгаа юм байна тиймээ. Тэгээд энэ нь уул уурхайд хамаарах хэсэг нь үү, эсвэл уул уурхайд хамаарахгүй гэж 2 байгаа шүү дээ одоогийн Хөрөнгө оруулалтын тухай хуульд. Энэ дээр аль дээр хамаарч байгаа нь одоо шинээр орж ирж байгаа нь юм бол оо?

Б.Заяабал: Ажлын хэсгийн 5 номерын микрофон Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Хөрөнгө оруулалтын хууль 16.2 өөрчлөлт. Монгол Улсын нутаг дэвсгэрт 5-аас доошгүй жилийн хугацаанд төсөл хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын хэмжээ нутаг дэвсгэрээс хамаарч дор дурдсан хугацаагаар тогтворжуулах гэрчилгээ олгоно оо гэж. Энд бол салбар хамаарахгүй, бүхий л салбарыг хамарч байгаа. Өмнө нь бол салбараар ангилдаг байсан юм. Одоо бол бүх салбарт хөрөнгө оруулалт. Улаанбаатар хот 20-50 тэрбум, 50 тэрбумаас 100

тэрбум гэсэн мэтээр ингээд бусад гээд 100-50, 50-иас 100 тэрбум гээд энэ чинь 10 жил, 15 жил гээд ийм 20 жил гээд 100 тэрбумаас дээшээ бол 20 жилээр гээд хугацаануудыг нь заачихсан. Тэгэхээр бүхий л бизнест бид нар ялгаварлалтай хандахгүй ээ.

Бизнесийн нэр хүндтэй холбоотой асуудал байна. Ялангуяа төр өөрөө бизнесийн нэр хүндэд халдах асуудал нэлээн гомдлууд ирсэн. Тэр хууль дээр 4 дүгээр зүйл нь өөрөө төрийн бодлого үйл ажиллагаанд хориглох зүйл гэж байгаа юм. Тэгэхээр төр бодлого, үйл ажиллагаандаа аливаа бизнесийн нэр хүндэд халдаж, үндэслэлгүйгээр мэдээлэл гаргаж, түгээх хориглоно оо гэж байгаа юм. Ингээд төр ингээд санаачилгаараа нэр хүндэд халдаад ингээд юм явчихдаг нөгөө ААН тайлбарлаж чаддаггүй. Тэр тэрний хойноос хөөцөлдсөөр байтал нөгөө аль хэдийн нөгөө хор хохирол, зах зээл гээд олон юм нөлөөллөө. Хувьцаа үнэт цаас гээд олон юм нөлөөлөл гарчихдаг. Тэгэхээр ямар ч нөхцөлд төр бизнесийн нэр хүндэд хүндэтгэлтэй хандаж, төрийн бодлого үйл ажиллагаандаа хориглоно оо. Нэр хүндэд халдах тэр агуулга байгаа юм шүү. Тэнгис дараагийнх нь юуг хариулаадах.

Б.Заяабал: Ажлын хэсгийн хэдэн номер вэ. 2 номерын микрофон нээе. Нэг номерын микрофон нээчих 2 биш 1.

Х.Сүрэнхорол: Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн боловсруулалтыг Засгийн газар дээр яг хариуцсан яамных нь саналын дагуу боловсруулалтыг хийж орж ирсэн. Ашигт малтмалын тухай хуулийн 20.5.7 дээр нэмэлт өөрчлөлтийн энэ хуулийн 20.5.5-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд нийлбэр оноогоор 2-т орсон оролцогч тусгай зөвшөөрлийг олгох гэж заасан байгаа. Тэгэхлээр нөгөө Ашигт малтмалын тухай хуулийнхаа 20.5.5 дээр ямар зохицуулалт байна гэхээр энэ хуулийн 20.5.3, 20.5.4-д заасны дагуу төлбөрийг төлөөгүй бол төрийн захиргааны байгууллагын мэдэгдлийг хүчингүй болгож энэ тухай бичгээр эсхүл энэ хуулийн 17.1-д заасан цахим хэлбэрээр ажлын 2 өдөрт мэдэгдэх гэж байна. Тэгэхээр нөгөө эхний оролцогч маань оролцох боломжгүй нөхцөл байдалд орчихлоор 2 дахь оролцогч оролцогчийг сонгож оруулж ирж байгаа л зохицуулалт байгаа.

Б.Заяабал: Батнайрамдал гишүүн нэмэлт асуулт.

О.Батнайрамдал: Харин тийм. Тэгэхээр нөгөө ашиг дээр яг асуудал нь яг наана чинь байсан байхгүй юу. Эхний оролцогч нь нэг ёсондоо хуурамчаар хамгийн өндөр дүн өгчхөөд тэгээд хэргээр төлбөрөө төлөхгүй гарангуут 2 дахь нь автоматаар авдаг нэг ёсондоо 1, 2 хоёулаа 1 хүн байсан байхгүй юу. Ийм тохиолдол олон гарсан учраас энийг бид нар хориглосон юмаа. Тэгэхээр энийг бол маш нухацтай бид нар дахиж авч үзэх ёстой 1 дүгээрт.

2 дугаарт хөрөнгө оруулалтын юу хамаарахгүйгээр уул нь хуулин дээр бид нар чинь уул уурхайн салбар уул уурхайн бус гэж явж байсан тиймээ. Тэгээд одоо ингээд нэгтгээд хөрөнгө оруулалтын хэмжээ эрс багасаад ороод ирчихсэн байна л даа. Уул уурхайн салбар дээр бол 500-аас дээш бол 15 жилээр тогтворжуулсан, одоо 20 болж байгаа юм байна. Бид нар бизнесийн эрх чөлөө цаашаагаа илүү сайжраад явахдаа ер нь олон улсын жишиг рүүгээ л ойртох ёстой. Тэрнээс биш бид нар шинэ юм огт эндээс гаргана гэж бараг байхгүй. Олон улсын жишиг рүү бид нар ойртох тусмаа бизнесийн эрх чөлөө ингээд дүрэм журмаараа улам сайжрах ёстой юм.

Дарга аа, нэмэлт нэг минут авчихъя тэгэх үү хүрэхгүй байна. Тэгэхээр олон улсын.

Б.Заяабал: Нэг минут нэмж өгье.

О.Батнайрамдал: Тэгэхээр олон улсын зарчим 1990-2000 оны хавьцаа ер нь хөрөнгө оруулалтыг тогтвортой байлгахын тулд тогтворжуулалтын гэрчилгээ юм уу хугацаагаар олгодог байя гэдэг энэ тухайн үед явж байсан. Уул уурхай том дэд бүтцийн төслүүд дээр. Энэнээс хойш та нар Өү Си Ти-гийн 2026 оны хөрөнгө оруулалтын гайдлайныг харах юм бол энэ чинь өөрчлөгдөөд байгаа байхгүй юу. Энэ чинь эсрэгээрээ аягүй олон сул талууд ялангуяа хөгжиж буй орнууд дээр үнэ өсөхөд гарч байжээ. Тэгэхээр энэ тогтворжуулалтын хугацааг эсрэгээрээ улам наашлаад байгаа юм л даа. Та нар одоо олон улсын жишгийг аваад үзэх юм бол Латин Америк 10-11 жил байна, Африк 10-12 жил, Төв Ази 10 жил, Зүүн Өмнөд Ази 8-12 жил болчихсон. Тэгэхээр бид нар олон улсын жишиг дээр энэ дээр эсрэгээрээ яваад байна л даа. Бид нар 20 болгосноороо хөрөнгө оруулалт татна гэдэг бол ер нь нэг тийм ач холбогдолтой биш. Тэрний оронд улс төрийн тогтвортой байдлаа бид нар илүү чухалчлах нь чухал байхгүй юу. Тэгэхээр энэ дээр олон улсын жишгийг та нар харсан уу? ямар байсан бэ гэж асууя.

Б.Заяабал: Ажлын хэсэг гараа өргөөрэй. 4 номерын микрофон ажлын хэсэг өөрийгөө танилцуулаад.

Б.Төгөлдөр: Эдийн засаг хөгжлийн яам Төгөлдөр. Тогтворжуулах гэрчилгээний юун дээр болохоор тогтворжуулах гэрчилгээний яг үндсэн яг өнөөдрийн байдлаар нийтдээ 17 тогтворжуулах гэрчилгээ олгогдсон байгаа. Хүчинтэй байгаа 5 гэрчилгээ байгаа. Хүлээгдэж байгаа нэг 12, 13 гэрчилгээнүүд байгаа. Яг энэ тогтворжуулах гэрчилгээний гол юу маань болохоор өмнө нь хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа гэдэг ийм хугацаа байсан. Энэ хугацаагаараа хөрөнгө оруулалтаа оруулах, тэгээд эргээд тэр хөрөнгө оруулалтынхаа хийсэн хугацаагаараа тэр хөрөнгө оруулалтаа нотлох гэсэн ийм юуны процедурууд байдаг байсан. Энэ процедуруудаа энгийн болгоод яг бүс нутаг гэж бас ялгасан байсныг баруун бүс, зүүн бүс, төвийн бүс гэсэн байсан. Эд нарыг бүгдийг нь энгийн болгоод Улаанбаатар ба бусад гэдгээр ингэж оруулж ирсэн. Бусад орны туршлагаудыг бид нар Казахстан, Вьетнам гэсэн улсуудын Хөрөнгө оруулалтын тухай хуулиудаар юуны...

Б.Заяабал: Нэмэлт 7 номерын микрофон. Нэг минут нээе. Товчхон хариулаарай.

Г.Жавхлантөгс: Сайн байцгаана уу? Шадар сайдын зөвлөх Жавхлантөгс байна. Батнайрамдал гишүүний асуултад хариулахад ер нь олон улсын жишгээрээ бид нар яг Монгол Улсдаа ингээд хөрөнгө оруулалт татах нөхцөл байдал нэлээн дордчихсон ийм байгаа үед бусад улсуудтай татварын болон татварын бус урамшууллаараа ингэж өрсөлдөж байгаа. Тэгээд энэ нөхцөлд бол бид нарын хувьд яг төсвийн байдлаас хамаараад татварын урамшууллуудыг өгөх ер нь боломж маш бага байгаа. Тийм учраас тогтворжуулалтын гэрчилгээ дээрээ аль болохоор хугацааг нь нэмж бусад салбаруудаа оруулж ирж ер нь бүхий л салбарууддаа гадаадын хөрөнгө оруулалтыг татаж, тэр чинээгээрээ эдийн засагт үр нөлөөгөө бас үзүүлнэ ээ гэж ингэж үзэж энэ дээр ийм өөрчлөлтийг хийсэн байгаа. Бусад улсуудын

жишигтэй ерөнхийдөө яг өрсөлдөхүйц байхуйцаар яг энэ саналаа оруулж ирж байгаа юм шүү. Баярлалаа.

Б.Заяабал: Номинчимэг гишүүний микрофон нээе. Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Бизнесийн эрх чөлөөний тухай хууль болон дагаж орж ирсэн энэ хуулиудыг ерөнхийд нь харж байна. Нэлээн олон хууль байна. Бүүр нарийвчилж бүгдийг нь харж амжаагүй байна. Нэн яаралтайгаар орж ирсэн учраас. Тэгээд ганц 2 асуулт асуух гэсэн юм.

1 дүгээрт, энэ малгай болж орж ирж байгаа Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийг харахаар нэлээн тийм тунхгийн шинж чанартай. Яг ямар зарчим барьж, юун дээр тэр нь хэрэгжээд явах юм гэдгээ нэг их ойлгомжгүй. Ерөнхийдөө бол байх ёстой ардчилсан нийгэмд хууль дээдлэх ёс байдаг бол мөн чөлөөт зах зээл хувийн өмчийг хамгаална гээд бид нар Үндсэн хуульдаа тусгачихсан бол тэнд байдаг л ерөнхийдөө зарчмууд байгаа байхгүй юу. Тэгээд дундуур нь болохоор нэлээн яах вэ ингээд асуулт асуухаар юмнууд нарийвчлан харах юм бол зөндөө байна. Жишээ нь бизнес эрхлэгчийн нэр хүндэд халдсан, үндэслэлгүй мэдээлэл гаргах, түгээхийг төрийн бодлого, үйл ажиллагаандаа хориглоно оо гээд орчхож байгаа юм. Тэгээд төрийн бодлого үйл ажиллагаанд хориглоно гэхээр эзэн биегүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг ингээд үнэхээр бизнес эрхлэгчийн нэр хүндэд зүй ёсны бусаар халдаад эхлэх юм бол ямар арга хэмжээ авах юм. Хэн нь авах юм, ямар хуулийн дагуу авах юм гэдэг нь байхгүй. Дагаж яг энэнтэй холбоотой тэгвэл тусгайлсан эрүүгийн байдаг юм уу, ямар нэгэн зөрчлийн байдаг юм уу, хариуцлагын юм орж ирээгүй байна. Тэгэхээр энийг жишээ нь яаж хэрэгжүүлэх юм?

2 дугаарт энэ ер нь яах вэ ингээд тунхгийн шинж чанартай байгаад болохоор яах вэ энэ нь ингээд нэг ийм зорьж байгаа, хүсэж байгаа юм нь байгаа юм байна аа гэж бодож байгаа юм. Тэгээд ингээд дагасан хуулиудыг нь харахаар ихэнх нь өмнө нь орж ирсэн Зөвшөөрлийн хууль байгаа шүү дээ тиймээ. Тэгээд хөрөнгө оруулалтын хууль нэлээн ингээд өөрчлөгдөж орж ирсэн. Тэгэхээр хөрөнгө оруулалтын хуулийг ер нь ямар үзэл санаагаар хөндөж энэ асуудлуудыг нэмж оров оо гэдгийг би 1 дүгээрт тодруулмаар байгаа юм. Яагаад гэхээр энд нөгөө хөрөнгө оруулалтын хууль дээр олон улсын нийтийн эрх зүйн нэг төрлийн хэлбэр болгох олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйд хэрэглэдэг энэ ингээд зарчмуудыг бол бүр ингээд хуульдаа суулгахаар оруулчихсан байгаа байхгүй юу. Тэгээд энэ яагаад олон улсын нийтийн эрх зүйд ийм зарчмууд байдаг вэ гэхээр нөгөө гадаадын хөрөнгө оруулалтыг капитал экспорт хийдэг газруудаас авахын тулд л байдаг юм. Тэгэхээр энэ Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт орж байгаа зүйл чинь энэ чиглэл рүүгээ яваад байгаа юм уу эсвэл хөрөнгө оруулагч гэдэг дээрээ дотоодын хөрөнгө оруулагч бизнесүүдийгээ ч гэсэн юм бодоод эд нартаа бас илүү ээлтэй гэдэг бодлогыг оруулах гэж оруулсан юм уу. Үзэл баримтлалын хувьд юу бодож та хэд маань энэ хөрөнгө оруулалтын хуулиудыг өөрчлөх энэ заалтуудыг оруулсан юм гэдэг дээр хариултаа авъя.

Тэгээд энэ дээр нэг 3.1.15 дээр үндэсний таатай нөхцөл гэдэг тодорхойлолтыг оруулсан байгаа юм Хөрөнгө оруулалтын хууль дээр. Тэгэхдээ Үндсэн хууль дээр нь энэ тодорхойлолттой холбоотой нэг ч үг үсэг байхгүй. Тэгэхээр яагаад энэ үндэсний таатай нөхцөл гэдгийг та бүхэн тодорхойлолт хэсэг дээр энэ хуульд оруулчихаад яг бусад хөрөнгө оруулалтын одоогийн хууль, өөрчлөгдөж байгаа хууль дээр чинь ч гэсэн энэ нэр томъёог ерөөсөө хэрэглээгүй байгаа юм.

Тэгэхээр ингээд би ингээд жижиг сажиг юмнаас нь авхуулаад ямар учиртай яагаад гэдгийг нь ерөөсөө хуулиас хараад ойлгохгүй байгаа болохоор, ойлгомжгүй байгаа болохоор та бүхнээс ямар үзэл баримтлалаар энийг юу ч гэсэн оруулж ирэв ээ гэдгийг асуучихъя.

Б.Заяабал: 7 номер ойлгомжтой хариулъя.

Г.Жавхлантөгс: Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Ерөнхийдөө хөрөнгө оруулалтын хуулийн үзэл санааны хувьд бол аль аль одоо зүйлүүд нь байгаа. Нэг ёсондоо гаднаас хөрөнгө оруулалт татах Монгол Улсдаа татах тэр зүйл байгаа. Мэдээж хөрөнгө оруулалтын хууль учраас бас дотоодын бизнесүүдтэй одоо тэр дагалдах хуулиар зөвшөөрлийн хуулиар ч гэдэг юм уу бусад хуулиудаараа бизнесийн орчныг сайжруулах ийм үзэл баримтлалаар бол орж ирж байгаа. Үндэсний таатай нөхцөлийн хувьд бол олон улсын жишгээр явдаг ийм зүйлүүд байгаа. Тэгэхээр хуульдаа ингээд ишлэж оруулах тэр тал дээрээ бас яах вэ алдсан байж болно. Ер нь бол гол зүйл нь бусад бүхий л улсуудад үндэсний таатай нөхцөл гэдэг маань гадаадын хөрөнгө оруулагчид, дотоодын хөрөнгө оруулагчид олгодог нөхцөлөөс дордуулахгүй, дордохгүй тийм ижил нөхцөл байдлыг олгоно оо гэсэн ийм одоо олон улсын зохицуулалт байдаг учраас энэ зохицуулалтыг нь бол аль болохоор оруулж энэ шинэлэг трендүүдийг оруулъя гэсэн ийм үзэл суртлаар хийсэн байгаа.

Ер нь бол тодорхой нөгөө хариуцлага тооцох дээр бол мэдээж сайжруулах зүйлс байгаа байх. Одоо тухайлбал дагах хуулиудаараа ч байдаг юм уу ер нь аль болохоор бид нар энэ дагах хуулиудаар нь тухайлбал орон нутгийн засаг захиргаатай ч юм уу хариуцлага тооцох гэдэг юм уу тодорхой хөрөнгө оруулалтад садаа болж байгаа газрууд байх юм бол энэнтэй нь ажиллах ийм заалтууд байгаа тийм.

Л.Соронзонболд: 4 номерын микрофоныг нээе.

Б.Төгөлдөр: Эдийн засаг хөгжлийн яам Төгөлдөр. Хөрөнгө оруулалтын тухай хууль дээр гол яг концепц шинэчлэл хийж байгаа юу байна гэхээр хөрөнгө оруулагчийн ирүүлсэн гомдлыг шийдвэрлэдэг тогтолцоотой больё. Тэгээд эргээд маргаан олон улсын арбитраар шийдвэрлэх эрхийг нь баталгаажуулах талаар илүү тусгаж өгсөн. Мөн төрийн байгууллагуудын чиг үүргүүдээ тодорхой болгож өгсөн. Төрийн байгууллага Засгийн газрын эрх үүрэг, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн захиргааны байгууллагуудын чиг үүргүүдийг тодорхой болгож өгсөн байгаа. Мөн олон улсын энэ түрүүн таны дурдсан хөрөнгө оруулалтын баталгаа, суурь зарчмуудыг бүгдийг нь тусгаж өгсөн байгаа. Үндэсний таатай нөхцөлд гэж байгаа яг юугаар болохоор манай улс 43 оронтой хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах хэлэлцээр байгуулсан байгаа. Энэ хэлэлцээрүүд дээрээ бид нар үндэсний нөхцөл болон үндэсний таатай нөхцөл гэдгийг олгож байгаа. Тэгээд энэ нөхцөлүүдийг олон улсын гэрээ эрх зүйн тусгасан юунуудаа бид нар бас энэ хөрөнгө оруулалтын хууль дээрээ тусгаж ингэж оруулж ирж өгч байгаа.

Л.Соронзонболд: Сэддорж гишүүнийг асуух гишүүдийн нэрсэнд нэмье. Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Тийм энэ олон улсын нийтийн эрх зүйн, хөрөнгө оруулалтын эрх зүйн ямар ч мэдлэггүй хүмүүс энэ хуулийг бичиж байгаа учраас ийм аюултай юм орж ирж байгаа байхгүй юу. Хөрөнгө оруулалтын гэрээнүүд чинь Ви Ай Ти буюу 2 улсын хооронд хийгддэг. Тэр улсын юутай л холбоотой. Тэгтэл та нар энэ зарчмыг өөрсдийнхөө дотоодын хууль тогтоомжид бүгдээрэнг нь оруулаад ирэхээр бүх улсуудаас орж ирэх хөрөнгө оруулалт чинь энэ нөхцөлийг хангах гэж байгаа юм шиг. Тэгсэн мөртлөө хуульд чинь байхгүй. Тэгээд ингээд ороод ирэхээр яах вэ гэхээр нөгөө дотоодын үйлдвэрлэлээ дэмжье, тендерт юу гэдэг юм худалдан авалт нь дотоодын юмаа илүү байя эсвэл ЖДҮ эрхлэгчдээ дэмжье гэдэг. Бид нар хууль тогтоомжоороо энэ бодлогыг гаргах боломжгүй болчихдог. Гадаадын компаниуд нь ч гэсэн та нар надад дотоодын ингээд таатай нөхцөлд яасан юм чинь би ч гэсэн адилхан орох хэрэгтэй гэдэг юмаа хэлдэг байхгүй юу. Тэгэхээр ямар ч ийм бодлого байхгүйгээр ийм нарийн нарийн их л гоё сонсогдохоор нь л оруулаад ирчихсэн юм шиг харагдаад байна л даа. Тэгэхээр энэ асуудлуудаа нэлээн сайн харах хэрэгтэй.

Тэгээд дээр нь тэр нөгөө тунхгийн шинж чанартай юмнууд дээр хэрвээ бизнесийн нэр хүндэд яачих юм бол ямар арга хэмжээ хэн авах юм. Тэрийг тодруулаад өгөөч. Миний асуултад дутуу хариулчихлаа.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 4 номер.

Б.Төгөлдөр: Эдийн засаг, хөгжлийн яам Төгөлдөр. Бизнесийн эрх чөлөөний анхдагч хуулийн юун дээр төрийн бодлого гэдэг дотор бизнес эрхлэгчийн бизнесийн үйл ажиллагаанд аливаа ямар нэгэн хэлбэрээр нэр хүндэд халдахгүй ээ гэж тусгасан байгаа. Энэ тусгаж байгаа зүйл заалт нь болохоор эргээд бизнес эрхлэгч төртэй маргалдах, төртэй шүүх дээр очиход энэ заалтаараа өөрийгөө хамгаалах, өөрийгөө нэг ийм зүйл заалт болж болно оо гэдэг талаасаа бид нар оруулж ирсэн байгаа юм.

Л.Соронзонболд: Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Тийм нөгөө асуулт тодорхой байхад хариулж чадахгүй байна гэдэг маань яг нарийн бодож орж ирсэн үү эсвэл яаравчлаад л гоё сонсогдож байгаа болохоор бичээд ороод ирсэн үү гэдэг дээр маш тодорхой л байр суурь нь харагдчихлаа гэж бодож байна. Тэгээд энэ мэтчилэн ингээд нэлээн нарийн юмнууд байгаа байхгүй юу. Энэ чинь одоо 100 хэдэн хууль, зарим нь яах вэ тэр өмнө нь орж ирсэн Зөвшөөрлийн хууль бодвол алдаануудаа засаад орж ирсэн байх. Тэгтэл энэ мэтчилэн ямар дараа нь үр дагавар гаргах юм бэ гэдгийг нь бодохгүйгээр маш ийм либерал маягаар ингээд сайхан сонсогдох юмнуудаа оруулаад ирдэг. Гэхдээ энэ бол цаашдаа одоогийн нөхцөл байдлаа үнэлэх тийм үү олон улсад болон Монгол Улсад болж байгаа нөхцөл байдлаа үнэлээд манай улсын бизнесийн эрх чөлөөнд ер нь юу болохгүй байгаад байгаа юм гэдгээ онилоод, тэрийгээ сайн тодорхойлоод, яг тэр лүүгээ чиглэсэн юм хийгээгүй л байна гэж би бол харахаар байгаа байхгүй юу. Уг нь бол энэ нөгөө нэг танилцуулга эд нартай юу нь болохгүй байгаа гэдэг тэр дүгнэлтүүд нь бол маш сайн гаргачихсан байдаг. Тэгээд энийгээ хийхийн тулд тэгвэл ямар хуулиудтай суурь хуулиудаа яаж шинэчлэх вэ гэдэг юм байхгүй нэг иймэрхүү юм байхаар би бол энэ хуулийг гаргаад үнэхээр бизнес эрх...

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 8 номер хариулъя.

Б.Зандан: Хөрөнгө оруулагчийн гомдол гэж төрийн байгууллага албан тушаалтны үйлдэл эс үйлдэхүйтэй холбоотойгоор хөрөнгө оруулагчаас эрх хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар энэ хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу гаргах хүсэлтийг гэж байгаа юм. Тэгэхээр энэ маань өөрөө бас түрүүчийн Номинчимэг гишүүний хэлсэн асуудалтай холбоотой. Гомдлын механизмыг илүү дэлгэрэнгүй болгож оруулж ирсэн заалт болохоор яг одоо төрийн байгууллагын эсрэг хөрөнгө оруулагчид гомдол мэдүүлэх эрхтэй. Энэ асуудлыг яг яаж шийдвэрлэх вэ гэсэн механизм нь тодорхой болж орж ирж байгаа. Тэгэхээр энэ дээр жишээлбэл хөрөнгө оруулагч нь төрийн байгууллага албан тушаалтны хууль бус үйлдэл эс үйлдэхүйн улмаас сонирхол нь хөндөгдсөн талаар энэ гомдлыг хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад буюу манай хөрөнгө оруулалт худалдааны газар луу гаргах ийм эрхтэй болж байгаа юм. Тэгэхээр эндээс одоо холбогд...

Л.Соронзонболд: Гүйцээгээд хариулчих. 8 номерын микрофоныг нээе.

Б.Зандан: Хөрөнгө оруулалт худалдааны газрын дарга Зандан. Тэгээд үргэлжлүүлээд Хөрөнгө оруулалт худалдааны газраас холбогдох төрийн байгууллага руу санал дүгнэлт хүргүүлнэ. Цаад төрийн байгууллага нь эргээгээд хэрэгжилтийн талаар эргэж мэдэгдэж тайлагнана гэдэг ийм механизм оруулж ирснээрээ онцлог байгаад байгаа. Тэгээд Номинчимэг гишүүний ярьж байгаа тэр асуудал яалт ч үгүй илүү шүүхээр явахаар удаан процесстой байдаг болохоор хөрөнгө оруулалтад сөрөг нөлөө үзүүлдэг. Тэгэхээр болж өгвөл шүүх рүү очихоос өмнө маргааныг бас эвээр ингэж шийдэх ийм нөхцөлийг бий болгох зорилготой байгаад байгаа юм. Эхлээд гомдлыг шийдвэрлэж болохгүй бол үргэлжлүүлээд эв зүйгээр эвлэрүүлэн зуучлах механизм үйлчилнэ. Дараа нь болохгүй бол шүүх рүү явна аа гэсэн ийм зохицуулалтыг оруулж ирсэн байгаа.

Л.Соронзонболд: Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Ямар ч байсан гэсэн Энхбаяр сайдын танилцуулгаас авсан нэг тааламжтай зүйл нь юу вэ гэхлээр өнгөрсөн 10 гаруй жилийн хугацааны алдаатай бодлогын үр дүнд Монгол Улсад ер нь эдийн засгийн эрх чөлөө үгүй болсон, зах зээлийн зарчмаар асуудал явахаа байсан. Дотоод, гадаадын хөрөнгө оруулагч бизнес эрхлэгчдийн эрх ашиг ноцтойгоор зөрчигдөх болсон гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа явдал нь сайшаалтай байна. Тэгээд энэ нөхцөл байдлаасаа хэрхэн яаж гарах вэ гэдэг чиглэлээр энэ хуулийн төслийг оруулж ирж байна гэж ойлгож байна. Тэгээд энэ Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл нь яаралтай горимоор орж ирсэн байж байгаа. Тэгээд өмнө нь болохлоор бас хэд хэдэн хувилбар явчихсан байж байгаа тиймээ бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Занданшатар сайдын үед бол бас Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл гэдэг нэршлээр орж ирээд бас Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдаад ингээд явсан. Энэ дагалдахаар орж ирж байгаа Зөвшөөрлийн тухай хууль болон түүнтэй холбоотой бараг тиймээ нөгөө 100-аад хуулийн төсөл байгаа гээд байгаа нь болохлоор Зөвшөөрлийн тухай хуулийн хүрээнд орж ирчхээд, ажлын хэсэг байгуулагдаад, Энхтүвшин гишүүн ахалж ажиллаад өчнөөн олон удаагийн уулзалт хийчихсэн одоо ийм бүх зүйлүүдийг нэгтгээд нэрийг нь өөрчлөөд энэ Бизнесийн эрх чөлөөний тухай хууль гээд оруулаад ирчхэж л байгаа юм байна л даа.

Тэгээд яах вэ Зөвшөөрлийн тухай хууль дээр ч гэсэндээ зөндөө асуудлууд байсаар л ирсэн та бүхэн бүгдээрээ л мэдэж байгаа. 2022 онд анх батлагдаад

тэрнээс хойш бараг жил болгон л янз бүрийн өөрчлөлтүүд ороод ирсэн. Тэгээд ийм зөвшөөрлийн бас нэгдсэн тогтолцоогоо нэг яг жинхэнэ утгаар нь хийж ч чадахгүй өнөөдрийг хүрчхээд байж байна. Тэгсэн хэрнээ тэгээд л энэ дагалдах хуулиудыг нь ингээд шигтгэсэн байдлаар харахлаар бас нэг жижиг сажиг зөрчлүүд харагдаад л байна. Тэгэхээр яах вэ энэ хэтэрхий нүсэр л ийм ажлыг л бид нар ингээд аягүй богино хугацаанд хийхийг л зориод байна л даа. Тэгээд нэршил өөрчлөх гэх мэттэй холбоотойгоор бас баахан тийм механик өөрчлөлтүүд орчихсон харагдаж байна. Тэгэхээр ийм их нөгөө механик ажил орохыг нь мэдсээр байж байж заавал одоо нэршлийг нь өөрчлөөд нөгөө зөвшөөрөл мэдэгдлийн хууль болгох шаардлага байсан уу?

Энэ хөрөнгө оруулалтын хууль болохлоор шинэ байгаад байгаа юм. Тэгээд энэ Хөрөнгө оруулалтын хуультай холбоотой хүмүүс гишүүд нэлээн асуултууд асуугаад байна л даа. Тэгэхээр хэрэв гадаад зах зээлтэй тодорхой дохионуудыг мессежүүдийг өгөхийг зориод байгаа хөрөнгө оруулалтын хуулиа энэнээс салгаад тусад нь оруулж ирээд, тусад нь хэлэлцүүлээд энэ дээрээ бас нэлээн ач холбогдол өгөөд ярих ёстой байсан уу, үгүй юу гэдэг асуудал.

Сая яг энэ хуулийн өмнө Ашигт малтмалын тухай хуулийн төсөл орж ирлээ. Тэгээд уул нь бол Учралын Засгийн газрын өргөн бариад байгаа 2 хуулийн төсөл тиймээ хоёулаа маш ач холбогдол бүхий. Гэтэл ингээд хоорондоо нэлээн зөрчилтэй зүйлүүд харагдаад байна аа. Нөгөө цагаа нэмээд авчихъя тэгэх үү.

Л.Соронзонболд: Жаргалан гишүүнд нэг минут нэмье.

Б.Жаргалан: Тэгээд юу болсон бэ гэхлээр Ашигт малтмалын тухай хууль бас л маш их хүлээлттэй ийм хуулийн төсөл орж ирсэн. Гэтэл нөгөө чөлөөлье гээд байгаа та хэдийн ярьж байгаа зүйлээс бас л нөгөө нэг тэс хөндлөн хэд хэдэн тусгай зөвшөөрлийг нэмчхэж байгаа. Тэгээд тэр нь одоо эргээд энэ нөгөө хэлэлцэх гэж байгаа хууль дээрээ бас ямар байдлаар яаж тусгаж орж ирэх юм? Дахиад л одоо энэ зөвшөөрлийн хуулиа хөндөх шаардлагатай болно. Тэгээд энэ Засгийн газрын бодлоготой чинь уялдахгүй байгаад байгаа юм биш үү гэхлээр үгүй ээ, зарим салбарт ийм хатуу гар хэрэгтэй энэ тэр гээд л яриад сууж байгаа.

Дээрээс нь одоо энэ Бизнесийн эрх чөлөөний тухай хууль дээр чинь болохлоор ийм өмчийн хэлбэрийг үл харгалзан дотоод, гадаад гэдгийг үл харгалзан ерөөсөө бүх хөрөнгө оруулагчтай бизнес эрхлэгчдийн эрх ашгийг жигд хангана аа гэхихсэн байж байгаа. Гэтэл энэ Ашигт малтмалын тухай хуулиар орж ирж байгаа асуудал дээр зэсийн АМНАТ дээр гэхэд нөгөө муу Эрдэнэтийгээ болохлоор баахан дээрэлхээд, нөгөө өндөр АМНАТ-тай нь ингээд үлдээчихсэн нэг ийм асуудал...

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номерын микрофоныг нээе.

Ж.Энхбаяр: Өнгөрсөн 10 жил ер нь Монгол Улсын эдийн засаг юу болов оо гэж. Бид ДНБ-ээ 4 дахин өсгөсөн байна. Нэг хүнд ноогдох ДНБ 2 дахин өссөн байна. Монгол Улс дунджаас дээш орлоготой орон болсон байна. Бас чамгүй үзүүлэлт 10 жил. Энэ 10 жил Монгол Улсын эдийн засаг тогтвортой, өсөлтөө хадгаллаа. 10 жилийн өмнөх юм та жоохон улс төр яриад байна, нам яриад байна. Уул нь энэ эдийн засаг, бизнес орчноо жоохон бүгдээрээ жоохон либералчлаад, жоохон гох дэгээг нь арилгаад, хөрөнгө оруулалт бизнесийн таатай орчин бүрдүүлчихвэл тун сайн. Энэ бол Засгийн газрын хууль гэхээсээ илүү манай парламентын гол нэрийн

хуудас болсон хууль болоосой гэж би бодож байгаа юм. Их Хурлын дарга ажлын хэсэг байгуулаад намын гишүүдийг, бүлгийн гишүүдийг тэгш оролцоог нь хангаад ингээд хамтраад нэг шийдүүлэх сайхан мессеж болно. Улсын баяр наадмын өмнө.

Эдийн засаг 2012 онд, 2008-2012 онд 17 хувь 17.3 хувийн өсөлт хийсэн. 2012-2016 онд Монгол Улсын эдийн засаг 17 дахин унасан. Яагаад унасан гэвэл хууль эрх зүйн орчны асар их өөрчлөлт гарсан юм. Бүхий л салбарыг хамарсан. Ялангуяа гадаадын хөрөнгө оруулалт, бизнес орчин, уул уурхай, ашигт малтмал, газрын тос, бүтээгдэхүүн хуваах гэрээ тойрсон хууль эрх зүйн өөрчлөлт, үр дагавар эдийн засаг хүчтэй унасан. Монгол Улсын валютын нөөц тэглэсэн. ОУВС-ийн хөтөлбөрт хамрагдахаас аргагүй байдалд орсон. Дубайн гэрээг очиж хийх буулт хийхээс аргагүй байдалд орсон. Ингээд Хөгжлийн банк тойрсон маргаан үүссэн ийм л зүйл болсон. Тэгэхээр бодлогын алдаа гэдэг бол эдийн засагт яаж нөлөөлдөг нь энэ сүүлийн 10 жил. Энэнээс 10 жил бол илүү хурдтай, илүү өсөх өдийд бид чинь нэг хүнд ноогдох 10 мянга давуулчихсан Зүүн Европын орны түвшинд оччих тийм бололцоотой. Монгол Улс дараагийн Катар, Кувейт болж байгаа ийм үйл явц явж байсан үе шүү дээ. Тэгэхээр энийг цэгцлэх хэрэгтэй байна аа, бүгдээрээ ингээд нийлээд нэг. Тэгэхээр нэг Ардын намын 10 жил гээд байвал Ардын намын 10 жил илүү бүтээл өндөр байгаа шүү. Тогтвортой эдийн засаг тогтвортой өсөөд явж байгаа гэдгээ нэг хэлэхийг хүсэж байна.

Л.Соронзонболд: Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Би яах вэ ерөнхий зүгээр зарчмын хувьд энэ хуулийг хэлэлцэхийг дэмжээд байгаа юм. Тэгэхдээ яг энэ нөгөө танилцуулж байсан үзэл баримтлалаас дагаж орж байгаа хуулиуд бол үнэхээр асуудалтай байна аа. За би энэ Арбитрын хуулиас нь эхэлье. Арбитр гэдэг бол талуудын харилцан тохиролцож, сонгож хэрэглэж маргаанаа шийдвэрлэдэг ийм зүйл. Нэг онцлог нь талууд л өөрөө зөвшөөрөөгүй бол Арбитрын хэлэлцэж байгаа энэ асуудал нууц байдаг байхгүй юу. Эндээ ч онцлог нь байдаг. Тэгсэн чинь одоо энэ зарчмаас нь шууд эсрэгээр нь аваачиж оруулж ирээд талууд тохиролцоогүй бол бүх юм ил тод байна. Улам Арбитраас хэлэлцэхгүй байх нөхцөлийг энэ хуулиар бүрдүүлж байгаа байхгүй юу. Суурь конвенцуудыг нь судалсан уу? Яг нөгөө би уг нь аймаар итгэл үнэмшлийн хувьд ингээд дэмжмээр байдаг. Тэгээд яг ингээд дагаж байгаа хуулиудыг нь харахаар үнэхээр одоо суурь зарчмуудын яг эсрэг. Одоо би энэ согтууруулах ундааны хууль аялал жуулчлалыг дагаад бараг энэ зөвшөөрлүүдийг чинь архидан согтууруулахыг шууд задгай тавьж байна шүү дээ. Ингэж болж байгаа юм уу. Согтууруулах ундааны энэ хууль дээр орж ирж байгаа өөрчлөлт нь арай бас ингэж задгай тавьж болохгүй шүү дээ.

Би зүгээр суурь үзэл баримтлал буюу Ж.Энхбаяр сайдын хэлж байгаа энэ бизнесийн ерөнхий орчныг сайжруулах юман дээр чинь дэмжээд байгаа шүү дээ. Гэтэл салбарын онцлогуудын юмыг шууд ингэж хуу татаж хаяад байгааг би ойлгохгүй байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль чинь зорилго нь өөр. Тэгсэн чинь бүр сүүлдээ цахим бизнес эрхлэгч гэж энд тодорхойлолт оруулж байгаад Цахим бизнес эрхлэгчдийн бүртгэл хөтлөх, бүртгэлийн дугаар олгох, төрийн цахим үйлчилгээ авах нөхцөл бүртгэлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмыг батлах гээд. Нөгөө нэг үйл ажиллагаануудыг журамлахгүй гэсэн баахан журам гаргана гээд Үндсэн энэ нийтийн мэдээллийн хуулийн бүр үзэл баримтлалыг байхгүй болгоод Бизнесийн бүртгэлийн хууль болгоод энэ чинь арай ч дээ ингэж болох юм уу.

Улсын бүртгэлийн хууль. Суурь бүртгэл гэж иргэний бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэл, эд хөрөнгийн бүртгэл байдаг. Тэгсэн чинь одоо суурь бүртгэлийн мэдээллийг хийхдээ төрөлжсөн мэдээллийг буюу ашиглаж хийнэ гэж байгаа байхгүй юу. Суурь бүртгэлийг тэгж хийдэггүй юмаа. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн концепц чинь суурь бүртгэл нь үнэн байж байж төрөлжсөн мэдээллүүд нь зөв болдог байхгүй юу. Тэгсэн чинь одоо суурь бүртгэлийн мэдээллийг аваачаад төрөлжсөн мэдээллээс татаж авч хийнэ гээд Тэнгис ээ, манайхаан. Би энэ бизнесийн эрх чөлөөний хуулийг дэмжиж байна. Та нар яг энэний араас залгуулаад энэ оруулж ирээд байгаа хуулиуд чинь болохгүй байна шүү дээ зарим нь. Үнэхээр одоо бас ингээд зарим зүйлүүдийг нь дэмжмээр байдаг. Ингэж байтал ингээд суурь үзэл баримтлалаар нь эвдээд өнөөдөр бүртгэлийн систем л худлаа бол Монгол Улсад бизнесийн бүх зүйл байхгүй болно шүү. Төрийн бодлого худлаа болно.

Бүртгэл гэдэг чинь Монгол Улсын иргэн төрөөд үхэх хүртэл түүнтэй холбоотой бүртгэл байдаг юм. Монгол Улсад өмчийн бүх хэлбэрүүдийг үүсэж байгаа энэ өмчүүдийн бүртгэл байдаг. Энэ хуулийн этгээдийн бүртгэл байдаг байхгүй юу. Тэгтэл энийг одоо ингээд...

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 5 номерын микрофоныг нээе.

Ж.Энхбаяр: Гишүүд сайн идэвхтэй оролцоод бас үнэтэй санал бодлоо өгөөд, ажлын хэсгийн хүрээнд бүгдээрээ засаж янзлах юм байвал засаад явъя. Ямар ч байсан бүгдээрээ энэ эдийн засгийнхаа орчин, бизнесийн орчин, хөрөнгө оруулалтын орчноо л нэг сайжруулъя. Энд хэний өөрийн нам харгалзах юм алга. Энэ парламентын энэ 4 жилийн сайн нэрийн хуудас болсон ийм хууль болгоод хөрөнгө оруулалтаа татъя, хувийн хэвшлээ дэмжье, эдийн засагт төрийн оролцоог багасгая. Бизнес тээд болж байгаа аливаа тэр саад тотгорыг багасгая, энэ хуулиа гаргая. Тэгэхээрээ ажлын хэсэг дээрээ сайн детальный ярилцах. Одоо ингээд яривал ингээд хэлэлцүүлэг маргаан үүсээд, улс төржвөл улс төр болоод ингээд явчих гээд болгоомжлоод байна л даа. Сүрэнхорол хариулт өгөх үү? Тэнгис 2 саяын тайлбар дээр.

Л.Соронзонболд: Ажлын хэсгийн 1 номерын микрофон.

Х.Сүрэнхорол: Хөрөнгө оруулалтын тухай хуульд, Арбитрын тухай хуульд орсон өөрчлөлттэй холбогдуулаад олон улсын туршлагаас хуваалцъя. Энэ дээр болохлоор нөгөө Юнситралын ил тод байдлын дүрэм гэж байгаа. Энэ 2014 оноос хойш яг энэ ил тод байдлын дүрмээ хэрэгжүүлээд явж байгаа. Олон улсын чиг хандлага маань юу руу явж байна гэхлээр хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэхдээ ил тод байдлыг хангаж ажиллах ёстой гэдэг дүрмийг батлаад улс орнууд яг энийг хэрэгжилтийг нь хангаад явж байгаа. Тэгэхлээр яг энэ зарчмыг л бид нар Арбитрын тухай хууль руу суулгаж орж ирж байгаа. Үүнээс гадна нөгөө Маврикийн конвенц гэж байгаа. Маврикийн конвенц дээр арбитрын арилжааны арбитрыг илүү жоохон хаалттай байдлаар явуулах ёстой гэдэг олон улсын чиг хандлага байгаа.

Хөрөнгө оруулалтын гэрээтэй холбоотой маргаануудыг илүүтэй талууд харилцан тохиролцоогүй бол ил тод байдлаар явуулах гэдэг олон улсын жишиг зарчим явж байгаа учраас тэр жишиг зарчмыг нь хууль руу суулгаж оруулж ирж байгаа зохицуулалт байгаад байгаа юмаа. Тэгэхлээр талууд хоорондоо...

Л.Соронзонболд: Гүйцээж хариулъя. Нэг номер.

Х.Сүрэнхорол: Талууд хоорондоо харилцан тохиролцсоны үндсэн дээр өөрөөр хэлэх юм бол Хөрөнгө оруулалтын гэрээний маргаанаа ил тод байдлаар шийдвэрлэх тэр нөхцөлийг л оруулж ирж байгаа. Тэгэхлээр нөгөө талууд харилцан тохиролцоогүй бол гэдэг зохицуулалтыг урд талд нь жишиг болгоод зохицуулалтыг нь тусгаад оруулаад ирээд тусгачихсан байгаад байгаа юм. Улсын бүртгэлтэй холбоотой асуудал дээр Тэнгис зөвлөх.

Л.Соронзонболд: Улсын бүртгэлтэй асуудлаар ажлын хэсгийн 2 номер хариулъя.

С.Тэнгис: Энэ дээр зарчмын хувьд бол Сайнзориг гишүүний зөв байгаа. Яагаад гэхээр улсын бүртгэл маань маш чухал хариуцлагатай суурь бүртгэлийг хийдэг газар мөн. Үүнийг бид нар маш олон жил ярьж байгаа. 2023, 2022 онд цахимжуулах төрийн үйл ажиллагаа, төрийн одоо төрд байгаа мэдээллийг яах вэ хүн хуулийн этгээдээс дахиж шаардахгүй солилцох хүн одоо нэг л газар мэдээллээ өгөөд бүртгүүлдэг байх гэдэг зарчмыг хангах гээд маш олон ярьсан. Цахим хөгжлийн багц хууль Сайнзориг гишүүн өөрөө тухайн үед ахалж байсан санагдаж байна. Нийт дараа нь 109 хууль дээр мөн одоо энэ мэдээлэл солилцох хэсэг оруулсан.

Энэ удаа Улсын бүртгэлийн тухай хуульд орж байгаа өөрчлөлт бол 1 дүгээрт болно гэж байгаа юм. 2 дугаарт энэ практик дээр ямар асуудал үүсээд байна гэхээр явж явж улсын бүртгэл өөрөө ганцхан цаасанд суурилж бүртгэл хийдэг байгууллага болж үлдчихээд бусад төрийн байгууллагууд системээс систем хооронд нөгөө баталгаатай технологиор мэдээллээ солилцоод...

Л.Соронзонболд: Сайнзориг гишүүн үү. Тодруулга.

П.Сайнзориг: Тийм би тэгэхээр хэлэлцэхийг дэмжиж байна. Тэгэхээр ийм илүү дутуу юмнуудыг ажлын хэсэг дээр сайн ярина аа. Тэнгис ээ. УБЕГ-ын энэ 1 дүгээр давлагааны дараа яагаад ажил явахаа байсан бэ гэхээр хөрөнгө оруулалт нь байхгүй байгаад байгаа байхгүй юу. Өөрөөр хэлэх юм энэ мэдээллүүдийг шууд программчилал дээр боловсруулалт хийдэг программ энэ программ Софтвэрын шинэчлэл дээр хөрөнгө оруулалт хийхгүй байгаа учраас хоцорчихсон юм. Түүнээс биш энэ хуулийн чиний энэ томъёоллоос асуудал үүсээд байгаа юм байхгүй. Суурь мэдээлэл рүүгээ ингэж хаа хамаагүй баталгаажаагүй мэдээллийг авч ашиглаад мэдээллийн сан бүрдүүлбэл энэ Монгол Улсад байгаа бүх мэдээлэл чинь худлаа болох гээд байгаа байхгүй юу. Та нар энийг ингэж эвдэж болохгүй ээ. Энийг л бид нар одоо бас анхаарах нь зөв.

Тэгээд ер нь зүгээр энэ архидан согтууруулахтай хууль энэ тэр дээр хаа хамаагүй ингэж задгай тавьж болохгүй ээ. Бизнесийг дэмжих гэж байна гэж байгаад шууд ингээд л задгай зөвшөөрлүүдийг өгнө. Ийм зүйлүүдийг жоохон хэдүүлээ ярилцах нь зөв. Бусад тэр бизнесийн орчинд татвар байдаг юм уу, энэ уул уурхайн салбар тэр маргааныг шийдэх энэ тэр дээр ярилцах хэрэгтэй. Ийм юм гол юмнуудаа аваачаад та нар ийм завсар...

Б.Заяабал: Ажлын хэсгийн хэдэн микрофон хэдэн номер болчихсон уу. За санал хэллээ. Мандхай гишүүн асуулт асууна аа.

М.Мандхай: Зарчмын хувьд энэ хуулийг дэмжиж байгаа. Гэхдээ одоо нэгэнт сайд өөрөө ингээд сайжруулж ажиллая гэдэг дээр ингээд бас саналаа удаа дараа илэрхийлж байгаа учраас би нэг ийм ажил хэрэгч санал хэлчихмээр байгаа юм. Одоо энэ жишээлбэл энэ зөвшөөрлийн хуультай холбоотойгоор тодорхой хэмжээний ингээд зөвшөөрлийг сулруулж байгаа ийм саналууд орж ирж байгаа. Тэгэхлээр энэ үйл ажиллагааг зөвшөөрлийг сулруулна гэдэг чинь тэр хэмжээгээр үүсэх эрсдэлийг бизнес эрхлэгч өөрөө даах гээд байгаа байхгүй юу үүрэх гээд байгаа юм. Тэгэхлээр хэрэв янз бүрийн эрсдэл үүслээ, хохирол гарлаа гэж бодоход хяналт ингээд бага байгаа учраас энэ үүсэх эрсдэлийг бид нар даатгалын тогтолцоогоор хамгаалдаг ийм механизмыг оруулж өгмөөр байна аа.

2 дугаарт, яг энийг дахиад бататгах нэг санал хэлмээр байна. Энэ дээр ингээд үйл ажиллагаа дээр жилдээ 2 удаа ийм тогтмол хяналт тавих юм байна энэ хуулиар. Тэгэхлээр энэ одоо жишээлбэл ингэнэ гэсэн үг. Нийтийн эрх ашгийг хангасан бизнесүүд гэж байгаа шүү дээ. Жишээлбэл байгаль орчин, хүнс, хөдөлмөр, аюулгүй байдал ч гэдэг юм уу ийм эрсдэл өндөртэй бизнесүүд байгаа. Ингээд санаандгүй байдлаар санамсаргүйгээр ч юм уу үүсэх нэг эрсдэл гарлаа гэхэд 2 удаагийн шалгалтаар яваад нөгөө бизнесийн үйл ажиллагааг зогсоочихно, царцаачихна. За ингээд царцаахаар яана гэхлээр гомдол гаргана. За ингээд нөгөө үйл ажиллагааг нь буцаад нөхөж ажиллагаанд оруулахын тулд хугацаа орно оо, прокурор дээр очно. Цагдаа бүр зарим тохиолдолд бүр шүүхээр яваад тэр тэнд үүсэж байгаа бизнесийн цаана гарах санхүүгийн маш олон ийм хохирлууд үүснэ ээ. Тэгтэл энэ дээр ингээд хамгаалах ямар ч механизм харагдахгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгээд яараад биччихсэн. Цаана нь яг хэрэгжилт дээр буугаад ийм үр дагавар гарвал яах вэ гэдэг юмыг ерөөсөө тооцоогүй.

Тэгэхээр энэ дээр юу хийх вэ гэхлээр энэ даатгалын энэ СЗХ-ноос хүн байхгүй юм уу? Энд суумаар байгаа байхгүй юу. Бүхэл бүтэн даатгал хариуцаж байгаа зохицуулах байгууллага энэ хууль дээр ийм бизнесээс үүсэх эрсдэл, зөвшөөрөл эрсдэл буурахад хяналт 2 удаа явахад санаандгүйгээр эрсдэл үүсэхэд даатгал өөрөө тэрийг нь зохицуулаад тэр бизнесийн санхүүгийн эрсдэлийг нь хамгаалаад байж байх ёстой механизм байхгүй дутагдаад байгаа учраас энийг бүүр ажил хэрэг болгож оруулж өгөөч ээ гэж хэлмээр байгаа юм. Тэгээд би энэ дээр бүүр ингээд саналаа хэлээд зарчмын зөрүүтэй санал гаргая.

Тэгээд энэ дээр би дахиад яг энэ хууль дээр ямар зохицуулалт оруулж ирсэн бэ гэдгийг би шалгана аа. Тэгэхээр энэ дараагийн удаа энэ СЗХ-г оруулж ирээд ямар ажил хэрэгч энэ даатгалын зохицуулалтыг оруулах боломжтой тэр механизмынхаа саналыг оруулж ирээд тайлбар хиймээр байна.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 5 номер Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Таны саналыг ойлголоо. Тэгээд засаг өргөн бариад хуулийн төсөл маань Их Хурлын мэдэлд шилжчихлээ. Энэ дээр АН маань эдийн засгийн эрх чөлөөний хууль давхар явж байгаа. Өргөн баригдчихсан. Тэгээд энийг нийлүүлээд Их Хурал дахь бүлгүүдээс хамтарсан ажлаас гаргаад ажлын хэсэг ажиллах байх гэж ойлгож байгаа. Тэр хүрээнд саналуудаа гаргаад бүгдээрээ дутуу орхисон зүйлүүд нэлээн байж болно. Бас шаардлагагүй цаг нь арай эрт болсон зохицуулалтууд байж

болно. Тэгээд ажлын хэсэг дээрээ сайхан ярьж байгаад ингээд шийдээд шийдэх бололцоотой. Тэр хяналт шалгалттай холбоотой зүгээр мэдээлэл өгөхөд энэ Төрийн хяналт шалгалтын тухай хууль Улсын Их Хурал үүрэг өгөөд энэ хуулийг өөрчил, хяналтын байгууллагууд нэгтгэ гэдэг ийм үүргийг Засгийн газарт өгчихсөн.

Тэр ажлын хэсэг хариуцаад бид төр иргэний хяналт шалгалтын тухай гээд ийм хуулийг бэлдчихсэн. Бүтцийг зурчихсан өргөн барихад бэлэн болж байгаа. Тэрний агуулга дотор нь энэ хяналт дотроо иргэний хяналтын ийм зөвлөл иргэний оролцоог нэлээн нэмэгдүүлсэн. Ийм маягаар хэзээ шалгах вэ, хэдэн удаа шалгах вэ. Шалгалтад хориглох олон зүйлүүдийг тодорхой болгосон. Эхлээд анхааруулна, эхлээд зөвлөнө, анхааруулна, шаардана, тэгээд сүүлдээ акт торгууль тавиад дараа нь хамгийн сүүлд хаадаг зогсоодог гэх мэтийн ингээд ийм процессын юмнуудыг нэлээн сайн ялгаад салбарын хяналт, мэргэжлийн хяналт, төрийн хяналт шалгалт эд нарыг нэгтгэсэн нэг ийм зохион байгуулалт хуулийн өөрчлөлт бэлэн болсон байгаа. Тэгээд бид нар яг энэ хуулиа дагуулаад өргөн барья гээд бэлдэж байгаа. Тэгээд Их Хурлын даргатай ярьж байгаад оруулчих байх аа.

Б.Заяабал: Сэддорж гишүүн асуулт асууна аа. Сэддорж гишүүний микрофон.

Р.Сэддорж: Хуулийг их сайхан нэртэй хууль аа. Дэмжиж байгаа. Тэгээд яг нэр шигээ л сайн, маш сайн боловсруулж хийх хэрэгтэй. Тэгээд 2 төрлийн асуулт байгаа. Тэгээд Биржийн тухай хууль дээр бүх тээвэрчид Монгол Улсын үндэсний тээврийн ААН-үүд ингээд дампуураад бараг дуусаж байх шиг байна. Тэгэхээр энэ биржийн тухай хуулиас болж төрийн худалдан авах ажиллагаагаар тээврийг уул уурхайн бүтээгдэхүүний тээврийг олж өгдгөөс болж худалдан авах ажиллагааны хуулиар хамгийн бага үнэ өгсөн ААН-ээр тээвэрлүүлдэг энэ зүйлээс болж Монгол Улсын тээврийн бизнес эрхэлдэг бүх иргэд, хувь хүмүүс, айл өрхүүд, компаниуд дампуураад хэцүү байгаа. Тэгээд маш олон хүн тэр зээлийн хүнд дарамтад байгаа. Энэнээс үүдэж маш олон хүндрэлтэй асуудлууд болж байгаа. Тэгэхээр энэ дээр ямар зохицуулалт орж болох вэ? Тээврийг энэ биржийн хуулиас салгаж чөлөөт өрсөлдөөнөөр явж байсан хуучинд нь оруулах ямар боломж байна вэ?

Дараагийн асуудал нь бол дотоодын металлургийн үйлдвэрүүд бүгд түүхий эдгүй болсон биржийн хуулиас болж. Энэ дээр ямар өөрчлөлт хийх гэж байна аа? Энэ 2 чинь бол нэлээн том асуудал шүү. Олон мянган тээвэрчдийн хувь заяаг шийдэх асуудал аа. Энэнээс болж зөвхөн гадаадын ААН-үүд л тэр хамгийн бага үнийг өгнө. Гадаадын компаниуд л хийж байгаа тэр тээврийг. Тэгэхээр дотоодын энэ хүмүүсээ яагаад дэмжихгүй байгаа юм бэ? Энийгээ ингээд өөрчлөлт оруулахгүй их удсан байна аа. Энэ хуулиараа өөрчлөлт оруулчих боломж байна уу? Энийг болгохын талаас нь бүгдээрээ ажиллах ийм санаа санаачилга байна уу? Санаачилга гаргавал та нар дэмжих үү?

Б.Заяабал: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон нээе.

Ж.Энхбаяр: Уул уурхайн биржтэй холбоотой ямар нэгэн асуудлыг хөндөөгүй. Шинэ тулгар үйл ажиллагаа нь овоо тогтворжоод явж байна. Энэ ашигт малтмалыг уул уурхайн биржээр зардаг арилждаг болсонтой холбоотойгоор үнэ их шударга тогтож, арилжааны үнүүд дандаа өсөж тогтдог их нээлттэй болсон. Тэр үнэ гэхэд л нүүрсний үнэ гэхэд бирж дээр 1.4 дахин их өндөр тогтож байгаа. Дуудлага худалдааны зарчмаар явж байгаа болохоор. Тээврийн асуудалтай холбоотой асуудал гарлаа. Тэгэхээр энийг энэ хуулиар үндэсний компаниуд тээвэр нүүрсний

тээвэр хийнэ гэдэг юм уу ийм маягаар зохицуулах бололцоогүй. Миний бие экспортын ажлын хэсгийг ахалж ажиллаж байгаа. Энэ хүрээнд хоёулаа нэг уулзалт хийгээд энэ дотоодын тээврийн компаниудтай холбоотой асуудлуудыг зохицуулах энэ хувилбар дээр хамтран ажиллахад бэлэн байна аа. ХАА-н бирж дээр бол нэлээн хэдэн санал орж нэлээн өөрчлөлтүүд орж байгаа.

Б.Заяабал: Ажлын хэсгээс нэмэлт хэдэн номер вэ? Дотоодын үйлдвэрүүд түүхий эдгүй болж байгаатай холбоотой асуулт. Хэн хариулах вэ? Ажлын хэсэг гараа өргөөрэй. За 5 номерын микрофон нэмж өгье.

Ж.Энхбаяр: Энэ Эрдэс баялаг, УУЯ-аас өргөн барьж байгаа энэ хуулиар дотоодынхоо үйлдвэрүүдийг түүхий эдээр эн тэргүүнд хангана гэсэн ийм зохицуулалт орж байгаа. Одоо кокс боловсруулж байгаа, хорголжин хийж байгаа бусад цемент гэдэг юм уу ямар нэгэн нэмүү өртөг үйлдвэрлэж байгаа боловсруулах үйлдвэрүүдээ ашигт малтмал түүхий эдээр эн тэргүүнд хангана аа гэсэн ийм бодлого орж ирж байгаа.

Б.Заяабал: Гишүүд асуулт асууж дууслаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Мөнхсоёл гишүүнээр тасалъя. Ирцийн дагуу Батнайрамдал гишүүний микрофоныг нээе.

О.Батнайрамдал: Хуулийг зарчмын хүрээнд дэмжиж байгаа. Ер нь эдийн засагт илүү ээлтэй байх тэр орчныг бүрдүүлэх хуулийг бол дэмжинэ. Гэхдээ яах вэ зүгээр яг бусад гишүүд хэлж байна л даа. Санаа зовж байгаа зүйл бол маш олон дагалдах хуулиуд дундуур элдэв янзын бид нар одоо буруу ойлголттой ч юм уу эсхүл бас ийм хавчуулагдсан байх вий л гэж харж байгаа юм л даа. Тэгээд яг түрүүн би хэлсэн нөгөө Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр бол яг нэг 20.5.7, 20.5.8 гэсэн тэр 2 заалт ер нь дараа нь тэрийг авахгүй болохгүй л дээ. Бид нар чинь Уул уурхайн яаман дээр тэр асуудлыг шийдэхийн тулд нэг ёсондоо урьд нь явж байсан тэр жоохон залилан маягийн тэр асуудлыг шийдэхийн тулд тэрийг нь журмаараа ингээд авч хаяж байсан байхгүй юу. Тэгэхээр энэ бол ингээд хууль дотор ороод ирчихсэн байна.

Тэгээд дээрээс нь бас урьд нь нөгөө журмаар зохицуулж оноожуулалт явдаг байсан. Тэгэхээр одоо энэ дээр бас нөгөө 60 оноо гээд хууль дээрээ бид нар оруулаад ирчхэж байгаа юм. Уул нь анх бол энэ 75 оноогоор эхэлж байсан жишээний. Тэгэхээр нөгөө бид нар зөвшөөрөл эсвэл журмаа алга болгоод хууль руу оруулахдаа тэр зүйлүүдээ маш нухацтай авч үзэх зайлшгүй шаардлагатай гэсэн үг.

Тэгээд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн өөрчлөлтүүд дотор тэр нөгөө бид нар чинь тогтворжуулалтын гэрчилгээ олгодог шүү дээ. Тэгэхээр ер нь энэ тогтворжуулалтын гэрчилгээг бид нар ер нь үндсээр нь авч үзэх хэрэгтэй. Яг Монгол Улс шиг хөрөнгө оруулалтын тогтворжуулалтын гэрчилгээгээ хэвлэж өгдөг орон бараг өнөөдөр дэлхий дээр бараг байхгүй шүү. Түрүүн сая 2 жишээ хэлж байна. Тэр 2 жишээ хоёулаа буруу хэлж байна шүү. Казакстаныг хэллээ. Уучлаарай Казакстан чинь 10 жил шүү. Тэгээд 10 жил нь 500 сая доллароос дээш хөрөнгө оруулалт байх юм бол 10 жилээр тогтворжуулна гэсэн ганцхан заалттай. Тэгэхээр бид нар чинь Казахстанасаа эсрэг 20 жил болгоод яваад байна шүү дээ. Вьетнам бол ийм тогтворжуулалтын заалт байдаггүй юм. Вьетнам тогтворжуулдаггүй. Тэд нар юу

гэдэг юу гэдэг вэ гэхээрээ хууль хэрвээ өөрчлөгдөх юм бол тэрэн дээр нь баталгаа үзүүлэх ч юм уу өөр зарчмаар ажилладаг байхгүй юу.

Тэгэхээр энэ тогтворжуулалтын гэрчилгээгээ уул нь одоо илүү жоохон олон улсын жишиг рүү бид нар аваачих хэрэгтэй юм л даа. Тэгэхээр энэ Хөрөнгө оруулалтын тухай хуулийн яг ялангуяа тэр хэсэг дээр бид нар ялангуяа Өү Си Ти-гийн Зөвлөмж маш ойлгомжтой байгаа юм. Олон улсын яг зарчмыг тусгасан. Тэгэхээр тэр зарчим руугаа л бид нар ер нь ойртох хэрэгтэй. Бид нарын ер нь тухайн үедээ оруулж байхад энэ чинь яг уул уурхайн салбар болон томоохон дэд бүтцийн төслүүд хэрэгжүүлдэг хөгжингүй орнууд дээр л байсан жишиг энэ. Тогтворжуулалтын гэрчилгээ гэхээсээ илүүтэйгээр тогтворжуулалтын клоз буюу тиймээ зүйл, заалтууд байсан. Одоо энэ ингээд өөрчлөгдөөд хамгийн гол асуудал нь юу болж гарч ирсэн бэ гэхээрээ ялангуяа уул уурхайн салбар дээр үнэ өсөж байхад үнийн өсөлтөө хуваалцаж чадахгүйгээс болоод маш олон маргаанууд гарч байсан түүхтэй. Тэгээд энэ нь нөгөө тогтворжуулалт дээрээ юу оруулах вэ, юу оруулахгүй вэ гэдэг маргаанууд гарч байгаад ер нь олон улсын жишиг бол эндээсээ ер нь өөрчилье өө. Харин илүү хөрөнгө оруулалтын гэрээ бүтээгдэхүүн хуваах гэрээ гэх мэтчилэн олон улсын гэрээний зохицуулалтыг илүүд үзэж энүүгээрээ илүү явсан нь олон улсын зарчим руу дөхнө өө гэдэг ийм зөвлөмжийг ер нь өгдөг болсон байгаа юмаа.

Тэгэхээр бид нар яах вэ Тогтворжуулалтаа 20 жил гэхээр яг үнэнийг хэлэхэд дэлхийн хамгийн урт хугацаагаар тогтворжуулж байгаа 5 орны нэг болох нь байна шүү дээ. Хамгийн өндөр орон дээр Азербайжан нэг 30, 30 жилээр тиймээ, манай Узбекистан эд нар ч гэсэн 10 жилээр л байдаг шүү дээ. Тийм учраас энийг 15-20 болгох биш эсрэгээрээ бараг 15-аа 10 болгодог ч юм уу эсвэл тогтворжуулалтын гэрчилгээг илүү одоо олон улсын хэлэлцээр гэрээ рүү оруулах энэ зарчим руу оруулсан нь зөв болов уу гэж бодож байна. Тэгээд зарчмын хүрээнд хуулиа дэмжээд ажлын хэсгийн хүрээнд энэ дээр нэлээн суугаад дэвшилтэт өөрчлөлтүүдийг авчрах боломжтой гэж харж байна аа. Баярлалаа.

Б.Заяабал: Мөнхсоёл гишүүний микрофон нээе.

Б.Мөнхсоёл: Энэ ажлын хэсгийнхний юуг танилцсан. Тэгээд Бизнесийн эрх чөлөөний тухай хууль, Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль гэж өмнөх Ерөнхий сайдын үед орж ирсэн энэ асуудал яригдаж байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд энэ дотор хамгийн чухал нэг тулгамдсан бас шийдвэл зохистой зүйл нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл байгаа шүү дээ. Тэгээд яагаад энэ хууль маань чухал болчхов оо гэвэл өнгөрсөн 4 жил ч гэсэн энэ хууль ороод буцаагдсан. Тэгээд одоо шийдэхгүй бол Монголд одоо хөрөнгө орж ирэхгүй байна. Гадаадын байтугай дотоодын хөрөнгө оруулалт ч гацаж байна. Эдийн засаг царцаж байна. За тэгээд нөгөө ядуурал маань өндөр хэвээр, ажилгүйдэл бас өндөр хэвээр гээд энэ үед хөрөнгө татах чухал. Тэгэнгүүт энэ доторх орсон заалтууд яригдаж байгаа. Тогтворжуулалтын гэрээ энэ тэр гээд манай Батнайрамдал гишүүний хэлж байгаа санаа энэ тэр байгаа. Нэг өнцгөөсөө зөв. Тэгэхдээ энэ төрлийн механизмууд орж байж энэ олон улсуудаас өрсөлдөх чадвараа нэмэх гээд байгаа нэг арга замуудын хайлтуудын нэг гэж үзэж байгаа. Тэгээд тогтворжуулах гэдэг нь татварыг гэнэт бууруулах, хэт одоо дотоодтой харьцуулахад хөнгөлөх гэсэн үг биш. Одоогийн байгаа түвшиндээ тогтвортой байлгах буюу одоо нөгөө Засгийн газар нь тогтворгүй, улс төр нь хэт их ийм манайх шиг улсад огцом ийм сөрөг өөрчлөлт гарахгүй юмаа гэдгийг л баталгаажуулах ийм хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх гээд ядаад байгаа

гэсэн үг шүү дээ тийм үү. За гэх мэт ингээд ямар ч байсан өрсөлдөх чадвар бусдыг татах энэ чадвараа хууль эрх зүйн орчинд бий болгохгүй бол манайх шиг эрсдэлтэй гэж тооцогдож байгаа улсад бол ийм механизмууд хэрэгтэй. Тэгэхдээ бусад гишүүдийн хэлж байгаачлан хэлэлцэх эсэхийг дэмжчихээд дахиад нарийн энэ хуулиуд руугаа гүйцэд орж судлах, сайжруулах шаардлага байна гэж харж байна.

Тэгэхээр би бол энэ хуулийг дэмжиж үг хэлж байгаа. Тэгээд олон жил наана цаана уягдсан ийм чухал энэ хуулийн асуудал актаа бол дэмжээд хэлэлцэх нь зүйтэй гэдэг дээр санал нийлж үг хэллээ.

Б.Заяабал: Баярлалаа. Номинчимэг гишүүний микрофон нээе.

О.Номинчимэг: Тэгээд энэ хуулийг мэдээж бизнесийн эрх чөлөөгөө дэмжье. Энэ чөдөр тушаа болоод байгаа юман дээрээ больё гэдэг юм бүгдээрээ дэмжиж байгаа. Гэхдээ энэ дээр бид нар нөгөө маш нухацтай бас харахгүй бол би бол ийм санал хэлэх гээд байгаа юм. Энэ хуулийг дагаж орж ирсэн Зөвшөөрлийн тухай хуультай өмнө нь Улсын Их Хурлаар орж ирээд Энхтүвшин гишүүн ажиллаж байсан олон хууль байгаа. Тэр дахиж орж ирсэн тийм үү. Дахиад нэг хөндөх ёстой заалтуудаа хөндлөө гээд. Тэрийг нь тусдаа ялгаж аваад тэрэн дээр нь нэлээн суучихсан ажлын хэсэг байгаа учраас тэрийгээ тэгээд хурдан шуурхай журмаар нь явахад бол асуудал байхгүй. Нэлээн хаваржингаа ажиллачихсан хуулиуд байхгүй юу.

Тэгтэл яг шинээр орж ирж байгаа нь Хөрөнгө оруулалтын тухай хууль байна. Архидан согтуурах байна, өөр юу юу гэххэв Арбитрын хууль гээд байна шүү дээ. Энийгээ бол бид нар нухацтай ажлын хэсэг гаргаад тэгээд тал талаас нь хэлэлцээд явах нь зүйтэй. Тэгэхгүй бол би одоо ингээд сонсохоор тэр Арбитрын тухай хууль дээр ч гэсэн тайлбарлаж байгаа нь хөрөнгө оруулалтын маргааныг бол ингэдэг юмаа гээд тийм. Гэхдээ тэр хөрөнгө оруулалтын маргаан гэдэг чинь олон улсын эрх зүйгээр явдаг маргаан байхгүй юу. Монгол Улсын хууль тогтоомж хамаагүй болчихдог шүү дээ. Тийм нөхцөлд улсын эрх ашиг хөндөгддөг учраас нээлттэй болгоё гэдэг юм явдаг байхгүй юу.

Би яагаад энийг яриад байна гэхээр би улсынхаа эрх ашгийг хамгаалахын тулд тэр олон улс дээр чинь очиж маргаанд нь орж тиймээ, зовлонг нь мэдэж байгаа. Яагаад бид нар ийм 90-ээд онд нөгөө юм мэдэхгүйгээсээ болоод баахан давхар татварын гэрээ, баахан 2 талт нөгөө хөрөнгө оруулалтын гэрээг гадаадуудыг татах гэж байна гээд маш ийм найрсаг ийм нөхцөлөөр өгчихсөн байхгүй юу. Гэхдээ тэрэнтэйгээ дүйцэх үүрэг даалгавар байдаггүй. Тэгээд яадаг вэ гэхээр тэр систем рүү очихоор бид нар манай улсынхаа үнэхээр ашиг сонирхлыг хамгаалж чадах уу гэдэг дээрээ тулдаг. Энэ дээр би эмзэглэж явдаг. Тэгсэн чинь тэр ойлголтыг олон улсын эрх зүйн ойлголтыг дотоодын хууль тогтоомж руугаа оруулаад одоо үр дагаварт нь яах гэж байна гэхээр Монгол Улсын өөрийнхөө бодлого гаргах асуудлыг нь бүүр хумиад, дотоодын ААН энэ дээрээ гарах арилжааны гэрээний эрх зүй нь ч гэсэн олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу эрх зүйн зарчмын дагуу шийдэгдэх юм руу бүгдээрэнг нь хөрөнгө оруулалт ингээд явчхаж байгаа байхгүй юу. Ийм холион бантан байсан байж болохгүй. Ялгаж салгах хэрэгтэй гэх мэтчилэн энд концепцын хувьд эд нарыгаа ярилцаад засаад, нарийвчлаад ингээд явахгүй бол нуухыг нь авах гэж байгаад нүдийг нь сохлов гэдэг л үнэхээр болно. Бид нар бол мэдээж хөрөнгө оруулалтын асуудлыг сайжруулах ёстой. Тэрэн дээрээ зөвшөөрч байгаа. Гэхдээ Хөрөнгө оруулалтын хуульдаа бол байдаг асуудал их бага шүү дээ. Хөрөнгө

оруулагч нар юунаас болоод байна гэхээр ерөөсөө л энэ төрийн өөрсдийнх нь байж байгаа асуудал, улс төрийнх нь асуудал, улс төрч нь ихдээд, бодлого нь тодорхойгүй байгаа л асуудал шүү дээ. Тэгээд энэнээсээ эхэлж ажиллахгүй хөрөнгө оруулалтын хуулийн буруу юм шиг байгаа тэрийгээ ингээд байх бол их зохимжгүй.

Маргаан таслах тийм зөвлөлтэй байхыг дэмжиж байгаа. Урьдчилан сэргийлээд тэр маргаанаас гарах зардлыг багасгах дээр бол байх ёстой. Тэгэхдээ тэр маргааны чинь цар хүрээ юу байх вэ гэдгийг маш нарийн хийх ёстой байхгүй юу. Тэгээд олон улсын эрх зүйн зарчмуудыг дотоодын хууль тогтоомжтойгоо бүгдийг нь холиод, бүгдээрээ хөрөнгө оруулалт гоё гээд ингээд орж ерөөсөө болохгүй бүүр холион бантан. Тэгэхээр энэ мэтчилэн юмнуудаа засах ёстой. Тэгээд бэлэн болчихсон нэлээн сайн ажиллачихсан зөвшөөрлийн хуулиудаа салгаж аваад хурдан хэлэлцдэгээрээ хэлэлцээд явахад бол асуудал байхгүй биз ээ. Энхтүвшин гишүүн бол нэлээн чамбай ажлын хэсэг нь бол ажилласан гэж бодож байгаа. Тэгээд ийм л байр суурь илэрхийлье.

Б.Заяабал: Баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11-ийн дагуу хуулийн төсөл болон хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна аа. Гишүүдийг хуралдааны танхимд хүрэлцэн ирэхийг урья. Бас зэрэгцээд Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороон дээр 44 саналын томьёоллоор санал хураалт явж байгаа тул бас хүлээгээч ээ гэсэн гишүүд санал ирүүлээд байна. Тийм учраас гишүүдийг бусад гишүүдийг хуралдааны танхимдаа хүрэлцэн ирэхийг урья аа.

За гишүүдийг санал хураалтдаа бэлдэхийг хүсье. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Булгантуяа гишүүн уншуулаагүй байна, Мандхай гишүүн бас уншуулаагүй байна. Мөнхсоёл гишүүн орчихсон. Танхимд байгаа гишүүд бүгд оролцож болно. Саналын томьёоллыг уншиж танилцуулъя аа.

Бизнесийн эрх чөлөөний хуулийг дагаж нийтдээ 99 хууль нийтдээ 100 хуулийн нэмэлт, өөрчлөлт дагалдаж орж ирсэн байгаа. Ингээд нийтдээ 100 санал хураалт явуулна тийм биз.

1.Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2.Хамт өргөн мэдүүлсэн Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

57.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

3.Хамт өргөн мэдүүлсэн Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

4.Хамт өргөн мэдүүлсэн Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

53.8 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

5.Хамт өргөн мэдүүлсэн ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

57.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

6.Хамт өргөн мэдүүлсэн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

57.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

7.Хамт өргөн мэдүүлсэн Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

61.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

8.Хамт өргөн мэдүүлсэн Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

65.4 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

9.Хамт өргөн мэдүүлсэн Архив, бичиг хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

65.4 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

10.Хамт өргөн мэдүүлсэн Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

61.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

11.Хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

61.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

12.Хамт өргөн мэдүүлсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

13.Хамт өргөн мэдүүлсэн Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

65.4 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

14.Хамт өргөн мэдүүлсэн Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

65.4 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

15.Хамт өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

61.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

16.Хамт өргөн мэдүүлсэн Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

57.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

17.Хамт өргөн мэдүүлсэн Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

61.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

18.Хамт өргөн мэдүүлсэн Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

65.4 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

19.Хамт өргөн мэдүүлсэн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

61.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

20.Хамт өргөн мэдүүлсэн Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

65.4 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

21.Хамт өргөн мэдүүлсэн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

61.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

22.Хамт өргөн мэдүүлсэн Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

61.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

23.Хамт өргөн мэдүүлсэн Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

53.8 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

24.Хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

53.8 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

25.Хамт өргөн мэдүүлсэн Газрын хэвлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

57.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

26.Хамт өргөн мэдүүлсэн Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

53.8 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

57.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

28.Хамт өргөн мэдүүлсэн Геодези зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

57.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

1 дүгээрт энэ шатахууны нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах онцгой чухал байна. Дутагдал биш нийлүүлэлтээ хангах нь Засгийн газрын гол зорилт болж байна. Бид нар үнийн асуудал дээр нөлөөлөл үзүүлэх боломж хязгаарлагдмал. Гол нь тасралтгүй нийлүүлэлтийг хангах үүднээс зорилгыг нийлүүлэгч хөрш орнуудтай хамтран ажиллаж гэрээ хэлэлцээрүүд салбарын сайд нар энэ чиглэлээр идэвхтэй ажиллаж байна аа. Энийг шатахууны нийлүүлэлтийг тогтвортой байдал хангах хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний үнийн огцом өсөлтөөс урьдчилан сэргийлэх ийм шатахууны нөөцийг бүрдүүлэх хүрээнд хувийн хэвшлийн агуулах, савны багтаамж, нөөцийг оновчтой ашиглах төлөвлөгөөг боловсруулан гаргаж байна.

Шатахууны хөрөнгө оруулалт дэмжсэн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгүүд явагдаж байна. Шатахууны сав олон газар баригдаж байна.

Нөгөө талаар шатахуун импортлогч ААН-үүдийн агуулахын үлдэгдлийг байнгын хянах ийм системийг ашиглалтад оруулахаар ажиллаж байна. ОХУ-ын төр хувийн хэвшлийн удирдлагуудтай тогтмол гэрээ хэлэлцээрүүд хийх, шаардлагатай хэлэлцээрийг байгуулах ажлууд хийгдэж байна. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий тосоор хангах хүрээ асуудал онцгой чухал байна. Монгол Улсын хамгийн эрсдэлтэй, хамгийн эдийн засагт хүчтэй нөлөөлж байгаа шатахууныг дотооддоо үйлдвэрлэх энэ газрын тос боловсруулах Алтан ширээ төслийг эрчимжүүлэх их чухал байна. Энэтэй холбоотойгоор Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой БНХАУ-ын хөрөнгө оруулагч Даньшань болон Петро Чайна...

Б.Заяабал: Ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг нээе.

Ж.Энхбаяр: Дачин Тамсаг Петрочайна компанитай үүссэн бүтээгдэхүүн өгөх гэрээтэй холбоотой, татварын акт тавигдсантай холбоотой үүссэн маргааныг шийдвэрлэхээр Засгийн газар ажлын хэсэг гарган Эдийн засаг хөгжлийн яам хариуцан ажиллаж байна аа. ХХАА-н бүтээгдэхүүн нийлүүлэлтийг тогтвортой байдлыг хангах нь чухал байна. Инфляцын гол нөлөөлөл нөөцийн махны борлуулагдаагүй үлдэгдлийг 6 сардаа багтаж нийслэлийн сүлжээ дэлгүүр худалдааны төвөөрөө жигд хуваарилан нийлүүлэх ажлыг зохион байгуулж байна. Стратегийн гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэгчээс хэрэглэгчид шууд нийлүүлэх боломжийг үе шаттай бүрдүүлэх, дамлан үнэ хөөрөгдөхөөс урьдчилан сэргийлэх ажлууд хийгдэж байна.

Улирлын шинжтэй махны үнийн өсөлтийн эрсдэлийг бууруулах зорилгоор махны нөөц бүрдүүлэлтийн үйл ажиллагааг нийтэд ил тод, нээлттэй зохион байгуулах, биржээр худалдаалах тогтолцоог нэвтрүүлэхийг холбогдох байгууллагад үүрэг өгөөд ажиллаж байна. Мөн орон нутагт мах бэлтгэл нийслэл Улаанбаатар хотод нийлүүлж байгаа ажлыг урамшуулах, идэвхжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг хийж байна аа. Цаашид бол энэ төрөөс ХАА-н салбарт олгож буй татаас дэмжлэг энэ бодлогод үр ашгийн шинжилгээ хийж нэг шийдэх ийм зайлшгүй шаардлага үүсэж байна.

Эдийн засгийн өсөлтийг хадгалах гол зорилт нөгөө талын хүрээнд хамгийн их нэрвэгдэж байгаа эмзэг бүлгийг хамгаалах нь онцгой чухал болж байна. Эдийн засгийн өсөлтөө дэмжих, өсөлтийг хадгалах хүрээнд уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг эрчимжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх, биржийн арилжаагаар борлуулсан бүтээгдэхүүн тээвэрлэлт, бүртгэл бүрдүүлэлт гээд хил гаалийн байгууллагатай холбоотой боомтын нэвтрэх хүчин чадалтай холбоотой бодлогын арга хэмжээнүүдийг мөн ажлын хэсэг гаргаад Эдийн засаг хөгжлийн яам хариуцаад, экспортыг идэвхжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Нийгмийн халамжийг үнийн өсөлтөд хамгийн их өртөж буй ядуу болон эмзэг бүлгийн хүнсний аюулгүй байдлыг хангах нөхцөлд тусламж хэлбэрт шилжүүлэх ийм зайлшгүй шаардлага гарч байна. Энэтэй холбоотой бас санал санаачилгууд, төсөв хөрөнгөний асуудлыг Засгийн газарт танилцуулаад ажиллаж байна аа. За танилцуулж дууслаа. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Заяабал: Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Батхүү Эдийн засаг хөгжлийн яамны ТНБД, Мөнх-Эрдэнэ Эдийн засаг хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Хишигдалай Аж үйлдвэр эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга байгаа юм уу? Мөнхдэлгэр Эдийн засаг хөгжлийн яамны Эдийн засгийн бодлого төсөөллийн хэлтсийн дарга, Амина Эдийн засаг хөгжлийн яамны Эдийн засгийн бодлого төсөөллийн хэлтсийн мэргэжилтэн гэсэн ийм ажлын хэсгийн бүрэлдэхүүнүүд байна аа.

Эдийн засаг хөгжлийн сайдын мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? 3 гишүүнээр тасаллаа. Би өөрийгөө яаж нэмэх билээ. За Соронзонболд гишүүнээр тасаллаа. Жагсаалтын дагуу Соронзонболд гишүүний микрофоныг нээе ээ.

Л.Соронзонболд: Энэ танилцуулга ерөнхий нэлээн дэлгэрэнгүй сайн болсон байна аа. Тэгэхдээ энэ дээр нэг анхаарах юмнууд байна. Энэ экспортын орлогоо ингээд уул уурхайн бүтээгдэхүүнээр бичихдээ жоохон алдаатай л биччихсэн юм шиг байгаа юм. Тэгэхээр Эдийн засгийн хөгжлийн яам маань Улсын Их Хуралд танилцуулж байгаа юман дээрээ жоохон анхааралтай хандахгүй бол энэ экспортын хэсгийг буруу л биччихсэн юм шиг санагдаад байгаа юм.

Одоо тэгээд энэ түрүүн Сэддорж гишүүн бас асуугаад байсан. Яах вэ уул уурхайн манай экспорт ингээд биржээ дагаад сайн өсөж байгаа юм байна аа. Гэтэл одоо уул уурхайг дагасан тээврийн салбар нь уналттай харагдаад байдаг. Уул уурхайн биржээр худалдан авалт хийж байгаа компаниуд нь өөрсдөө тээврээ зохицуулдаг энэ байдал чинь Монгол Улсын тээвэр эрхэлж байгаа 20 гаруй мянган жолооч нарт нэлээн хүнд тусаж байгаа тухай мэдээлэл бол ирж байгаа. Тэд нар улсад ББСБ-аас зээлтэй, арилжааны банкнуудаас зээлтэй, зээлээ төлж чадахгүй хэмжээнд тэр худалдан авалт хийж байгаа компаниудын тээвэрт оролцож байгаа компаниуд чинь өртгөөсөө доогуур үнийн санал өгөөд байгаа байхгүй юу. Тэгтэл уул нь одоо Монополын тухай хуулиар монополын эсрэг хуулиар энэ чинь бодит өртгөөс нь доогуур үнийн санал өгч байгаа зүйлийг Монгол Улсын бирж дээр шалгаруулаад байгаа асуудал гараад байгаа юм биш үү? Энэ дээр ер нь Эдийн засаг хөгжлийн яам маань ер нь ямаршуу бодлого барьж энэ чинь нэг бүхэл бүтэн ийм салбар тэр чигээрээ унах гээд уначхаад байна шүү дээ. Маш олон жолооч нар зээлтэй, өртэй, тэгээд зээлээ төлж чаддаггүй. Зээлээ яагаад төлж чадахгүй байна гэхээр авч байгаа тээврийн үйлчилгээний хөлс нь өөрсдийнх нь өртгөөс нь бүр хэд дахин бага, хэд дахин хувиар бага байгаа ийм асуудал үүсээд байна. Энэ дээр ямар асуудал байна вэ гэж. Энэ дээр ямар бодлого барьж байна вэ? Энэ талаар нэг тайлбар өгөөч?

Б.Заяабал: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Уул уурхайн бүтээгдэхүүн экспорт бүгд биржээр арилжиж байгаа. Энэ бол ил тод байдлыг хангах, өрсөлдөөнийг хангах үүднээс хийж байгаа. Энэ бол их оновчтой бодлого гэдэг нь улам тодорхой болж үнэ байнга өсөж арилжаалагдаж байгаа. Тээвэр дээр энэ талаар мэдээлэл тодруулга авахад тендер нээлттэй тендер зарлаад хамгийн бага үнэ хэлсэн ААН-үүд тээвэр дээр шалгарч байгаа. Эдийн засгийн тухайд тээврийн салбар энэ нийт 23.8 хувийн өсөлт үзүүлсэн байгаа юм буюу нийт эдийн засгийн 7.9 хувийн өсөлтийн 1.1 бүхлийг тээврийн салбар. Энэ бол уул уурхайн бүтээгдэхүүний экспорт биет хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой. Тэгэхээр 1 ийм л зүйл байдаг. Аж ахуйн нэг нөгөө бид чинь энэ нүүрс тойрсон том томоохон улс төржилт явагдаад ялангуяа тээвэр дээр нэлээн нугалаа

гараад тээврийн үнэ нэг хэсэг айхтар өсөөд, 2 рейс хийгээд хөрөнгө оруулалтаа нөхдөг болтол нэг асуудал үүссэн шүү дээ. Нүүрсний үнэ тонн 300 доллараас дээш өссөн үед ямар ч үнээр хамаагүй тээвэрлэж, тээвэр дээр тойрсон одоо нөгөө тойрог юу гэдэг билээ тэрийг чинь бөмбөлөг ийм юмнууд үүсээд нэг бөөн хэл ам дагуулсан. Тэгээд нэлээн хатуу чангалгаанууд нэлээн хийчихсэн. Тэгээд бүх юм тендерийн хуулийн дагуу ил тод явах ёстой гэдэг шахалттай.

Тэгэхээр тэд мэдээж тэнд шаардлагатай хэмжээнээс илүү ийм том техникүүд бөөгнөрсөн байдаг. Ингээд өрсөлдөөн үүсээд тээврийн үнэ дээр нэлээн их бага ийм тоон үзүүлэлт гараад байгаа. Тэгэхээр бид одоо бодлогоор төрийн өмчит Таван толгой Эрдэнэс Таван толгойг одоо тээврийн үнээр төд гэж үнэ зааж, төдөөр тээлгэ гэдэг юм асуудал хөндөх болчихоод байна шүү дээ. Тэр нь өөрөө хэр хууль дүрэмдээ нийцэх нь зохистой юм уу гэдэг нь нэг эргэлзээтэй байгаа. Экспортын асуудлыг Эдийн засаг хөгжлийн яам хариуцаад энэ ажлын хэсгийг зохион байгуулаад ажиллаж байгаа. Экспорт ямар ч байсан ноднингийн мөн үеэс 60 хувиар бид нар өсгөөд авлаа. Тэгэхээр энэ түрүүн Сэддорж гишүүн бас ярьсан хөндөөд байсан энэ урд говийн бүсэд байгаа тээврийн асуудал жолооч нарын асуудалтай холбоотой бид нар нэг энэ хуулиудаа нэг цэгцлээд нэг газар дээр нь очоод боомт тээвэр, гааль, ухаалаг тээвэр гарц гээд олон зүйлүүдийн асуудлууд бүтээн тэнд хийгдэж байгаа боомтын бүтээн байгуулалт гээд ажлуудаа газар дээр нь очоод үзээд зохион байгуулалтын ийм арга хэмжээнүүдийг авъя гэж төлөвлөөд ажиллаж байгаа. Тэгэхээр одоо бол энэ дээр нэг ингэх ёстой гээд ярьчих жоохон тийм зохимжгүй байна. Ямар ч байсан ажиллая. Ер нь шаардлага бол байгаа. Нүүрс маань манай хамгийн төсвийн гол суурь. Нөгөө талаас хамгийн их баялгийн хуваарилалт дахь уул уурхайн бусад бүтээгдэхүүнээс хамгийн харьцангуй өргөн хүртээмж өгч байгаа ийм салбар.

Нүүрс идэвхжээд ирэхээр тээвэр, тээврээ дагаад энэ уул уурхайн хөрс хуулалт, өрөмдлөг, тэсэлгээ энэ нь одоо барилга, худалдаа, үйлчилгээ гээд Монголын бүхий л салбарт их нөлөөлдөг ийм онцгой бүтээгдэхүүн болчихлоо. Тэгэхээр нүүрс буюу нүүрс дагасан эдийн засаг дахь нөлөөллийг бид нар эерэг талд нь яаж байлгах вэ гэдэг дээр арга хэмжээ авах ёстой. Тэгээд тэр газар дээр нь ажиллаж байж нэг бодлого гаргана даа гэж бодож байна даа.

Б.Заяабал: Соронзонболд гишүүн нэмэлт тодруулга.

Л.Соронзонболд: Инфляц 11.5 гарахад ер нь 7.5 хувь нь дотоодоос хамаарсан инфляц болчихлоо. Нийлүүлэлттэй холбоотой инфляц өндөр байна аа гэдэг асуудал яригдаж байна аа. Тэгэхээр яг энэ чиглэлээр манай Эдийн засаг хөгжлийн яам бусад яамдууд дээр яг ямар тодорхой ажлууд хийгдэх гэж байна вэ? Өөрөөр хэлбэл одоо чинь дөнгөж 6 сар явж байна. Оны сүүлээр гэхэд энэ одоо дотоодын бараа бүтээгдэхүүн хүнсний бараа бүтээгдэхүүнээс хамаарсан энэ инфляцыг яг тодорхой бууруулах боломж нөхцөл яг байна уу? Энэ тал дээр төсөв мөнгөний хувьд тодотгол хийх шаардлага хэрэгцээ байна уу? Өгч байгаа татаас чинь хүрч байна уу гээд иймэрхүү бодлогын асуудал гарч ирж байна. Тэгээд энэ дээр ямар хариулт байна?

Б.Заяабал: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Ж.Энхбаяр: Инфляцын гол нөлөөлөл дотоодоос их хамааралтай байна. Үүн дотроо мах, ногоо, ногоон дотроо төмс, гурил гэсэн 3 бүтээгдэхүүн. Дандаа

дотооддоо бид нар үйлдвэрлэж, нийлүүлж зохицуулж болох бололцоотой бараатай холбоотой байгаа. Махны нийлүүлэлт нийслэл Улаанбаатар хот орон нутаг нөөцийн бодлогыг хариуцах ийм хүнсний тухай хуулиар зохицуулалттай. Энэ дээр жоохон алдаа гарсан. Хангалттай эвлэлдэж чадаагүйтэй холбоотойгоор нийслэл хотод махны үнэ өссөн. Бас нэг томоохон шалтгаан бол энэ малын гоц халдварт өвчин дэгдсэнтэй холбоотойгоор нэлээн нийлүүлэлт хорио цээрийн бүсэд орчхоод байна. Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай гээд баруун аймгууд. Энэ бас нэлээн мэдээж нэмэлт ачаалал үүсэх нь тодорхой болж байна. Улаан буудай дээр Их Хурлаар батлагдсан 2 удаагийн хууль тогтоомжийн хүрээнд нэлээн салбарыг нэлээн хямраасан.

Б.Заяабал: За нэмэлт нэг минут 5 номерын микрофон, ажлын хэсэг.

Ж.Энхбаяр: Нэлээн асуудлыг зах зээлийн бужигнуулсан. Энийгээ бид нар Их Хуралд засаж чадсан. Өнгөрсөн жил уринш боловсруулалтыг нэлээн өндөр түвшинд зардал гаргаж хийсэн. Энэ жилийн улаан буудайн тариалалт ноднингийн мөн үеэсээ эрс нэмэгдсэн. Тэгэхээр гурилтай холбоотой нийлүүлэлт дотоод нийлүүлэлтийн асуудал энэ намар бол эвтэйхэн. Энэ жилийн тариалалт маш сайн амжилттай явагдлаа. Яг тариалалтын үеэр байгаль цаг уурт таатай, чийг сайтай, соёололт их өндөр боломжийн байна. Төмс бол төмстэй холбоотой бас асуудлууд нэлээн үүссэн. Төмсний тариалалт бас нэг их хангалттай сайн нэмэгдэж чадаагүй. Тэгэхээр намар бол энэ төмс хүнсний ногоотой холбоотой нэлээн өнөөгийн үнийн өсөлтийг буулгах асуудал импортоор шийдэхээс аргагүй ийм байдлууд орох байх. Мах бол аяндаа ингээд энэ мал эмнэлэг хорио цээрийн энэ ажил амжилттай зохион байгуулагдаад бид махны нийлүүлэлт аяндаа ингээд улирлаа дагаад нийлүүлэлт нэмэгдээд үнэ тогтворжих байх. Гурил улаан буудай...

Б.Заяабал: Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэбат: Сая яах вэ ерөнхийдөө заримыг нь сонсчихлоо. Ялангуяа бага иргэдийн үнийн өсөлтийн цохилтод өртөж байна аа гэж үнэн. 1 дүгээрт үнийн өсөлтийн цохилт, 2 дугаарт энэ хүүгийн дарамт гэж байгаа. Ялангуяа бага орлоготой иргэдэд тэр болгон бас зээл олддоггүй. Тухайлбал ахмад настай хүмүүст гэхэд үндсэндээ зээлийнхээ хүүг төлөөд л, үлдсэн одоо гар дээр нь гарч үлдэж байгаа мөнгө бол тун бага байгаа учраас энэ үнэ тарифын хүнсний өсөлтийн юу бол хамгийн том цохилт болж байгаа юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд байж байна. Мөн одоо бага, дунд орлоготой иргэд.

Тийм учраас энэ тал дээр ер нь ямар бодлогыг хэрэгжүүлж гэж бодож байна вэ? Тухайлбал одоо сая бид нар энэ хойд бүсэд ахмадуудтай уулзаж байхад нөөцийн махыг нөөцлөөд намар хамгийн бага орлоготой иргэдэд тодорхой талон гэдэг юм уу ийм зүйлээр нь олговол яасан юм бэ? Тэгэхгүй бол зарим одоо зөвхөн Улаанбаатар хот гэлтгүй аймгийн төвүүд дээр нөөцийн махнууд бэлтгэх ийм шаардлагууд өндөр байна аа. Төвийн бүсэд амьдардаг хүмүүс, төв дээр амьдардаг малгүй. Тийм учраас энэ тал дээр тодорхой талонжуулах гэдэг юм уу, эс үгүй бол хуваарилж давуу эрхээр нь тэр хүмүүст өгөхгүй бол гулуузаар нь авч чадахгүй хүмүүс байгаа. Зарим нь гулуузаар нь зараад байдаг. Тийм учраас энийг шууд малчнаас нь нөгөө ХАА-н биржийг нэг их том том юм ярина гэхээсээ илүү идшээ эс үгүй авах гэж байгаа, эс үгүй бол нөөц хадгалсан хүмүүсийн тэр гэр орноор нь хүргээд өгдөг, тодорхой квотын доор. Тэгэхгүй бол магадгүй зарим нь нөгөө махны чинь нөөцийг аваачаад гадагшаа гаргачхаад байгаа тийм урсгал байгаад байгаа юм

уу гэдэг ийм хардлага бол байна. Тийм учраас энэ тал дээр ирэх жил энэ нөөцийн махыг яаж бэлдэх вэ? мах хэд болох вэ? Нөөцийн махаараа бид нар чинь үндсэндээ нэг 5 сар, 6 сарыг хүргэчихвэл болчих гээд байгаа тиймээ. Энэ зүйлийг тодруулж асуумаар байна.

Хөнгөлөлттэй зээлүүд гэж байж байна. Одоо хүмүүс ажил хийе гэж байна. Тэтгэвэр нь хүрэхгүй байж байна. Цалин нь хүрэхгүй бол давхар аж ахуй эрхэлье гэж байгаа юм. Тэгэхээр нэг зарим хөнгөлөлттэй зээлүүд нь яг нөгөө зорилтот иргэдийн одоо хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нэг аймагт ганцхан тэрбум төгрөг байгаа байхгүй юу. Тэгээд нэг 10 сая, 5 саяар нь хуваагаад өгөхөөр тэр хүн нэг хэдэн нэг табочик хийж байсан бол тэрийгээ л хийдэг. Тэгэхээр бид нар ийм ЖДҮ-лэлээрээ дор хаяж нэг 30, 40 сая төгрөгийн тоног төхөөрөмжтэй нээгээд гурвуулаа ажилладаг. Өсөн дэвжих ийм боломжийг нь энэ зээлийнх нь эх үүсвэртээ нэмээд өгвөл яасан юм бэ? Ялангуяа тэр хөдөлмөр эрхлэлтийн зээл, жижиг дундын сангийн зээлүүдийг ингээд харж байхад. Эхлээд 10 саяар өгч байсан бол дараа нь туршлагатай, мэдлэгтэй, зах зээл дээр болоод ирэх юм бол 30 сая төгрөг, 50 сая, 100 саяар нь өгөөд 3 сумын дунд ядаж нэг хогийн шүүрээ хийчихдэг нэг тийм жижиг үйлдвэр хэрэгтэй байна шүү дээ.

Тийм учраас энэ тал дээр цаашдаа бид нар энэ ажлын байруудыг бий болгох тал дээр ийм зээлийн хөнгөлөлтийн дэмжлэгийг үзүүлэх шаардлага байгаа. Энэ тал дээр ямар бодлого хийж байгаа вэ? Гурил бол та сайн энэ жил хангалттай яачихсан би асуух гэж байсан. Намар гурил дээр нь санаа зоволтгүй гэж байна. Төмсний асуудлыг одоо 88 хувь өснө гэдэг чинь бас л асуудал байна л даа. Тэгэхээр нэг том том талбай авчхаад тарьдаггүй тэгээд тэр чигээр нь хаячихдаг газрууд дээр ер нь нэг маневр селекц хийх ийм боломж бололцоо ер нь хэр байдаг юм бэ? Төмсний талбай авчихсан хүмүүс чинь тарихгүй ингээд байгаад байх шиг байгаад байх юм.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 5 номер Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Энэ төмс өөрөө гар ажиллагаа ихтэй, ажиллах хүч их зарцуулж байна л даа. Тэгэхээр энэ тэр онцлох ажлын онцлогтой холбоотойгоор тарих сонирхол багасаад нөгөө масс бусад тэжээлийн таримал, бусад улаан буудай, бусад үр сорт луу их түлхүү орж байгаа байдал байна. Ноднин бол ган болж яг төмсний гол бүс нутагт хүчтэй ган болсон. Нийлүүлэлт эрс буурсан. Гэхдээ энэ жилийн тарилт бол гайгүй. Одоогоор цаг уурын байдал эвтэйхэн явж байна. Тэгээд ургацын төлөв байдлаас шалтгаална. Бид нар чинь төмсөө дотроо 100 хувь тарьчхаад бүр экспортолсон шүү дээ. Энэ Төв азийн орнууд, ОХУ-ууд манай төмсөөр их амт сайтай гээд гаргаж байсан. Тэгээд ер нь зохион байгуулалттай ажлуудын арга хэмжээгээ сайн хариуцлагатай, хариуцсан хариуцсан яамдууд агентлагууд ажлаа сайн хийх л асуудал байгаа.

Тэгээд энэ хөрөнгө оруулалтын өнөөдрийн орж байгаа түрүүн хэлчихсэн хуулийн хүрээнд чинь бид нар энэ гаднын банкныг оруулахын тулд хаагаад байсан тэр босгыг нь авч хаяж байна. Нөгөө талаас зээлийн эх үүсвэрийг шийдэх энэ бодлогын хүрээнд тэр энэ санхүүгийн салбарт гаднаас татан төвлөрүүлсэн байсан 20 хувь энэ татваруудыг 5 болгож буулгаж байгаа гэх мэтийн тэр хөнгөлөх бодлогууд бас яваад байна. Тэр энэ нийгмийн халамжийг энэ үнийн өсөлтөд хамгийн их нэрвэгдэж байгаа эмзэг бүлгийн энэ бүлэг рүү л гол чиглүүлэх ийм бодлогын арга хэмжээг авна. Тэгээд бусад бизнесийг дэмжих хөрөнгө оруулалтын юмнуудыг сая батлагдсан төсвийн хүрээний хүрээнд Сангийн яам төсвөө зохиож

байна. Тэрэн дээр бид нар холбогдох саналууд бодлогын уялдаагаа хангаад 9 сарын 15-нд улсын 2027 онд төсөв өргөн барих хүрээнд энэ бодлогууд орж ирнэ.

Бодит байдал дээр төсвийн орон зай бодлогын арга хэмжээ авах орон зай бас туйлын хязгаарлагдмал байгааг бүгд мэдэж байгаа тийм биз. Бид урсгал зардал, цалин тэтгэврийн нэмэгдэл дээр нэлээн их ачаалал авч байгаа. Энэнтэй холбоотойгоор бид нар эх үүсвэр дутагдана. Энийгээ нөхөхийн тулд гадаад зээлийн ашиглалтаа сайжруулах гэж 2 том төслийг гадаад зээл ашиглалтаас гаргасан. Энэ хүрээнд бас тодорхой тодорхой ийм арга хэмжээнүүд орж ирнэ ээ гэж хэлье дээ. Тэгээд орон нутгийнхад бүгд үүрэг даалгаврууд оччихсон, аймгийн дарга нар нийслэлийн захирагч нарт хуулиар хүлээсэн үндсэн хуульд заасан ажил төрлөө амжуул аа. Ахиж махны үнийн өсөлтийн асуудал Засгийн газрын түвшинд хүртэл ирдэг, нийгмийг бухимдуулдаг ийм байдлыг хүргэж болохгүй. Энийгээ зохион байгуул, төсөв хөрөнгөө батал, тэгээд дагасан хариуцлагын асуудал нь уяад нэг ийм үүрэг даалгаврууд очоод ажил явагдаж байна. Энэ жилийн мах бэлтгэл харьцангуй эрт эхлэх байх аа гэж бодож байна.

Б.Заяабал: Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүн Шижир гишүүний микрофоныг нээе.

Ө.Шижир: Оройн мэнд. Энд танилцуулсан материалыг харахад бид нар ер нь уул уурхай дахь салбарын үнийн өсөлтөөр л бусад салбарууд нь дандаа ийм уналттай л ийм байгаад байна л даа. Дан ялангуяа хамгийн их ажлын байрыг шингээдэг, хамгийн их ААН-үүд нь бүртгэлтэй байдаг, боловсруулах салбар худалдаа үйлчилгээний салбарууд нь ингээд эдийн засгийн хувьд ийм уналттай байгаад байгаа юм. Тэгээд энэ нь өөрөө юуг харуулаад байна вэ гэхээр эдийн засгийн бодлого нь буруу байна аа л гэсэн үг. Нийт дүнгээрээ том дүнгээр нь харахаар орлого олоод байдаг, өмнөх жилээсээ илүү их орлого олоод байдаг, илүү их экспортод бүтээгдэхүүн гаргаад зараад байдаг. Гэтэл яг бодит байдал дээрээ бизнесийг дэмждэг, зах зээлийг дэмждэг, ДНБ дэмждэг, хамгийн их ажлын байрыг шингээдэг боловсруулах салбар болон үйлчилгээний салбар нь уналтад орчхоод байгаа юм. Энэ нь өөрөө орлогын тэгш бус хуваарилалтыг давхар цаагуураа харуулж байгаа юм.

Тэгэхээр үүн дээр одоо яг эдийн засгийн хувьд ямар бодлого баримтлах юм бэ гэж байгаа юм. Жишээ нь 2025 оны 6 сарын 9-өөс 2026 оны 6 сарын 9-ний хооронд гол нэрийн хүнсний бараа бүтээгдэхүүн чинь дунджаар 21 хувь өссөн байна шүү дээ. Тэгээд энэ чинь юу вэ гэхээр иргэдийн халааснаас чинь нийт 100 мянган төгрөгийн чинь 21 мянган төгрөгийг нь л авчаж байна гэсэн үг байхгүй юу даа. Тэгээд дээр нь нэмэх нь инфляц болчихож байгаа юм. Тэгээд ийм байдлаар ингээд өдрөөс өдөрт амьжиргааны түвшин нь ингээд дордож байгаа бага, дунд иргэд, иргэддээ инфляц болон өргөн нэрийн бараа бүтээгдэхүүн үнийн өсөлт хамгийн хүндээр цохигддог бага, дунд орлоготой иргэдээ бид нар ямар бодлогоор яаж дэмжих юм бэ гэдэг ийм нэг ийм асуудал байгаад байгаа юмаа.

Нөгөө талдаа Засгийн газар маш их эргэж буцсан шийдвэр гаргадаг. Улсын Их Хурал нь хүртэл. 2024 онд хямд гурил иднэ гээд ХАА-н салбараа татаад унагаачихсан. Газар тариалангийн салбар нь унасан. Тэгээд үүнээс дараа нь Энхбаяр сайд сайдаар томилогдсон учраас та надаа 2023 оны ХАА-н салбарын үзүүлэлт 2026 оныхтой ямар харьцуулалттай байгаа юм бэ гэдгийг нь хэлээд өгөөч. Энэ тайлан дээр болохоор ХАА-н салбарын өсөлт гэхихсэн байгаа байхгүй юу.

2023, 2024-тэй харьцуулах юм бол уналт байгаа байх. Нийт дүнгээр нь харах юм бол. Тэгээд энийг нэг харах гэсэн юм.

2 дугаарт нөгөө жижиг дунд бизнес эрхлэгч гээд бид нар зөндөө ярьдаг. Жижиг бизнес эрхлэгч нь дунд бизнес эрхлэгч болдоггүй ээ. Дунд бизнес эрхлэгчид нь том бизнес эрхлэгч болдоггүй ээ. Жижиг нь жижгээрээ, том нь томоороо ингээд л байгаад байдаг. Энэ өөрөө бас л эдийн засгийн буруу тогтолцоо гэсэн үг. Гэтэл хамгийн их ажлын байр чинь энэ салбарууд дээр шингээд байдаг. Энэ салбаруудаа яаж дэмжих юм бэ гэдэг нэг ийм бодол асуулт байна.

Тэгээд ер нь бид нар энэ зүгээр л гоё ингээд лоозон л ярьдаг л даа. Гоё уриалга ярьдаг, гоё ийм ирээдүйд хүрэх өнгө ярьдаг. Өнөөдөр нь байдаггүй, өчигдөр нь байдаггүй. Нэг бол өчигдөр үүсээд өнөөдөр ярьдаггүй нэг ийм л юм байгаад байгаа юм. Тэгээд хэзээ жижиг бизнес эрхлэгч нь дунд бизнес болоод, дунд хэмжээний бизнес эрхэлдэг аж ахуйнууд чинь том бизнес эрхлэгч болох юм бэ? Яагаад өнөөдрийг хүртэл жижиг нь жижгээрээ, том нь томоороо сүүлийн 20 жил явчхав аа. Ямар нэгэн байдал дээр төрийн хайр энэрэл зээлд хамрагдахгүй болоод энэ чинь бүүр улам хасах руугаа яваад байна шүү дээ. Энэ нэг 2 асуултад хариулт авах гэсэн юм.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: ЖДҮ эрхлэгчид манай бизнесийн гол ажлын байрыг хангаж байгаа. Юу хэрэгтэй байна гэвэл 1 дүгээрт хямд эх үүсвэр хэрэгтэй. 2 дугаарт зах зээл хэрэгтэй. 3.5 сая хүний зах зээл маань үндсэндээ ер нь Монгол Улсын потенциал түвшин ер нь их олон үзүүлэлтүүд хамгийн дээд түвшиндээ хүрээд байна. Тэгэхээр бидэнд зах зээлээ гаргах үүднээс энэ Евро азийн эдийн засгийн холбоотой гэрээ хийгээд тэр 367 барааг татвараас чөлөөлөөд энэ Төв Азийн 9 орны Төв Азийн энэ бүс нутагт Караккийн гишүүн 9 орны зах зээлтэй чөлөөт худалдааны хэлэлцээр хийх, Өмнөд Солонгостой чөлөөт худалдааны хэлэлцээр хийх, Узбекистантай 2 улсын 2 талын хамт чөлөөт худалдааны хэлэлцээр хийх гээд ийм ажлуудыг хийж байна. Зах зээлийг тэлэх хэрэгтэй байна.

Харьцангуй манайх бол үйлдвэрлэдэг, бүтээдэг болчихоод байдаг зах зээл. Одоо дотоодын зах зээл биш гадаад зах зээл хэрэгтэй. Тэгэхээр гадаад зах зээлийг бүрдүүлэх үүднээс хийж байгаа энэ бодлогын арга хэмжээнүүд ингээд явагдаж байгаа. Энэ ЖДҮ эрхлэгчид хамгийн их сайн зээлээ төлдөг ийм масс байдаг. ЖДҮ-ийн сан гээд муу нэртэй сан бол бүрэн цэвэрлэгдсэн, цэгцэрсэн. Бүх өр төлбөрөө төлж дууссан. Гадаад одоо авсан эх үүсвэр бонд Засгийн газрын баталгааг бүрэн төлөөд эх үүсвэртэй болсон. Энүүгээрээ одоо зээл олгож байгаа, харьцангуй харин харамсалтай нь бага, эх үүсвэр нь бага байгаа. Жилдээ нэг 40 тэрбумаас илүү гарч чадахгүй байгаа. Тэгэхээр энэ эх үүсвэрийг нэмэгдүүлэх нь их чухал. Энэ бол зайлшгүй энэ их сайн ийм зээлийн багц яваад байдаг энийг ашигламаар байдаг. Хөрөнгө ХАА-н салбар өсөлттэй алдаагүй хангасан хэвээрээ байгаа. Үнэхээр өнгөрсөн хугацааны энэ цагаан алт, Атрын 4 хүнсний хувьсгал бодлогын үр дүнд бол салбарууд яваад байна. Одоо энэ экспортод гаргах гээд нэлээн бэлтгэл ажлыг хийж байна. Стандарт тоног төхөөрөмж шинэчлэл олон улс олон юмнуудаа шинэчилсэн. Сав баглаа боодлоо шинэчилцгээсэн.

2024 онд чинь МАА-н салбар чинь 28.7 хувийн хасахтай байсан юм. Ноднин 33.2 гараад энэ жил одоогийн байдлаар 11.4 хувийн өсөлттэй. Энэ эхний 5 сарын

байдлаар явж байна. Тэгэхээр ХАА-н салбарт хийсэн бодлогын арга хэмжээ их үр дүнгээ олсон. Энийгээ бид нар цааш нь үргэлжлүүлэх, хүнсний хувьсгалыг 2 дугаар хөтөлбөр болгож цааш нь явуулах ийм зайлшгүй шаардлага. Нөгөө талаар нь ХАА мөн аялал жуулчлал үйлчилгээний салбарыг онцгой дэмжих хэрэгтэй. Уул уурхайн өсөлтийн нэг энэ супер циклийн таатай энэ 4, 5 жилийн олсон үр дүнг бид нар энэ аялал жуулчлал, үйлчилгээ ЖДҮ-лэл, ХАА-н хөнгөн хүнсний үйлдвэр гэсэн энэ өөрийгөө аваад явах энэ салбаруудыг босгох нь гол бодлого байх ёстой байгаад байдаг. Харамсалтай нь бид нар тийм эх үүсвэрээ гаргаж чадахгүй л өдий хүрээд л байна. Жоохон орлого олонгуут урсгал зардлууд янзан бүрийн хуулиар энэ Их Хурал дээр батлагдаж нэмэгдээд байна л даа. Их наяд их наядын ачаалал орж ирээд байдаг. Тэгэхээр энийг бас бид нар нэг нэлээн сайн яриад ер нь энэ чиглэл рүүгээ нэлээн бодлогын арга хэмжээг хийе ээ. Нэг дэмжсэн шиг дэмжээд гаргачихмаар байгаа юм.

1, 2 жилдээ энэ орон нутагт тойрог тойрсон энэ хөрөнгө оруулалтуудаа зогсоомоор байгаа юм. Ялангуяа энэ 2027 онд чинь энэ 2026 оны хагас жилээс хойш энэ шатахууны үнийн өсөлтөөр энэ барилга байгууламжийн үнэ огцом өсөх болчихоод байна л даа. Гэхдээ энэ нь бол яг бодит зах зээлийн үнэ биш одоо гадаа тэр хямралтай холбоотой өсөлт явах гээд байдаг. Энэ өсөлт тааруулаад баахан хөрөнгө оруулалт хийх нь эдийн засагт үр өгөөжгүй ачаалалтай гэж үзэж байгаа юм.

Иймд 2027 онд ямар бодлого явуулах вэ гэдэг дээр 2027 онд энэ цалин, тэтгэвэр урамшуулал ерөөсөө хүндээ хүрсэн, хүний нийгмийн асуудлаа чиглэсэн илүү урсгал зардал дээрээ жоохон анхаарал тавиад, хөрөнгө оруулалтуудаа нэлээн багасгая гэдэг ийм бодол ийм санал гарч байгаа. Ялангуяа энэ үнийн өсөлтөд нэрвэгдэж байгаа бага, дунд орлоготой иргэдээ хамгаалах бодлогууд. Ингээд урсгал зардлын энэ цалин хөлс тэтгэврийн нэмэгдлээр чинь энэ бусад худалдаа үйлчилгээгээ хэрэглээгээ дэмжээд нэлээн яв...

Б.Заяабал: Шижир гишүүний микрофоныг нээе нэмэлт тодруулга.

Ө.Шижир: Тэгээд одоо чөлөөт худалдааны хэлэлцээр гээд гадаад зах зээлээ тэлнэ гээд байдаг. Тэгтэл бид нар чинь Японтой чөлөөт худалдааны хэлэлцээртэй. Тэгтэл зөрүүлээд Японд гаргаж байгаа юм байгаа юу гэдэг нэг асуудал байхгүй юу даа. Японы стандартыг бид нар хангаж чадаж байгаа юу? Японы үйлдвэрлэл нь манайд шууд хангачихна. Манайх Японы зах зээлд гаргах стандарттай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж чадах потенциалтай байгаа юу гэдэг энэ асуудал. Одоо жишээ нь жижиг дунд бизнес эрхлэгчид маань Японд юу юу гаргаж байгаа юм? Японы чөлөөт худалдааны хэлэлцээрээр энэ харьцаа нь хэд байгаа юм. Манайх хэчнээн долларын экспортыг хэчнээн доллароор импорт аваад байгаа юм нэг.

Хоёрдугаарх нь одоо бид нар Зүүн хойд Ази руу гэж байна. Тэр яг үүнтэй адилхан стандартыг нь хангаж чадах уу? Гаргах бүтээгдэхүүнүүд дээр стандартын харьцуулсан судалгаа хийгдсэн үү гэдэг нэг асуудал байгаа. Энэ дээр бас хариулт авъя.

2 дугаарт ЖДҮ-лэл дэмжих сан чинь 40 тэрбум гэхээр 2.5 тэрбумаар хязгаарлачихдаг шиг санагдаад байна тэр журам нь. Тэгэхээр үндсэндээ 20 компанид зээл өгөх асуудал үүсэж байгаа байхгүй юу. Тэгтэл 97 мянган жижиг дунд ААН-үүд байгаад байдаг түүний 20 нь л энэ зээлийг авах болзол хангачхаж байгаа юм.

Б.Заяабал: Энхбаяр сайдын микрофон 5 номер.

Ж.Энхбаяр: ЖДҮ-ийн зээл байгаа эх үүсвэртэй л явж байгаа. Ингэж бас тэрбум руу нь хүрэхгүй ээ. Ер нь л их жиргэдэг. Үйл ажиллагаагаа сайжруулъя, орлогоо нэмэгдүүлъя, бүтээх тоног төхөөрөмжөө сайжруулъя гэсэн энэ жижиг дунд бизнесүүд бол тэгээд дээд тал нь нэг 300 сая төгрөг хүрээнд л явж байгаа. Аль болох л олон хүртээмжтэй байх байдлаар явж байгаа. Энэнд цаашид энэ эх үүсвэрийг нэмэгдүүлж явах нь их зүйтэй. Евро Азийн эдийн засгийн холбоо руу гарах бэлтгэл ажлыг бас бид нар энэ Японтой хийсэн гэрээтэй сургамжтай холбоотой нэлээн сайн бэлдэж байгаа. 40 гаруй техникийн зохицуулалт байна. Мал эмнэлэг, хорио цээр, стандарт, лабораториуд ингээд л, тэгээд хил гааль, ургамал хамгаалал, мал эмнэлгийн байгууллагуудын хамтын ажиллагаа гээд нэлээн техникийн нарийн гадаад худалдааны зохицуулалтууд байгаа. Энэ болгон дээр үүрэг даалгавраар ажиллагаанууд явж байна. Энэ бол 367 бараа буюу манай уламжлалт дотоодын одоо гол энэ хөнгөн хүнсний үйлдвэрлэлийн бараа, татварын нэн таатай нөхцөлтэй...

Б.Заяабал: 5 номерын микрофоныг гүйцэд хариулт нэг минут сунгая.

Ж.Энхбаяр: Энэ манайх 15-55 хувийн татварын босготой байсан энэ бараанууд чинь 0 татвартай болоод ирж байгаа юм. Тэгэхээр өрсөлдөх чадвар сайжраад явж байна. Харьцангуй нөгөө стандарт нь нөгөө Япон нь тэр өндөр хөгжилтэй орныг бодвол харьцангуй боломжийн буюу бид тэнд тэр зах зээлд өрсөлдөх хэмжээтэй. Үнэхээр Япон нь муу байна гэж үзэж болохгүй. Бид Японы зах зээлд гарахын тулд бид өөрсдөө л гэрийн даалгавраа сайн хийж, чанар, стандарт, боловсруулалт дээрээ л анхаарах хэрэгтэй. Ингээд манай үйлдвэрлэгч нар нэг үеэ бодвол урагшлаад л байна, дээшлээд л байна. Сав баглаа боодол, стандарт, олон улсын нийцлүүдийг хийгээд л байна. Тэгэхээр энэ Евро Азийн зах зээл энэ Төв Азийн Каракке орнуудын зах зээлийг ингээд нээж байгаа нь манай шинэ нэг шатад гаргах дараагийн том зах зээлд гарах бололцоо нээнэ. Ялангуяа Европын Холбоо чинь аль хэдийн 2 мянган нэр төрлийн барааг нээчихсэн шүү дээ, 2 мянга бил үү, 20 мянга билүү олон жилийн өмнө нээдэг. 7300 гаруй бараа нээсэн. Гол нь бид нар тэнд тийм гарч...

Ө.Шижир: Нэмэлт тодруулга.

Б.Заяабал: Шижир гишүүн нэмэлт тодруулга нэг минут.

Ө.Шижир: Тийм. Яагаад энийг яриад байна вэ гэхээр нөгөө гадаад зах зээлээ нээнэ гээд бид нар олон улсын гэрээ хэлэлцээр ч юм уу тухайн улсуудтай ингээд чөлөөт худалдааны хэлэлцээр хийчихдэг. Зөрж бид нарт гаргаж чадах стандартыг нь хийж чадахгүй байгаа байхгүй юу даа. Тэгээд бид нар хэзээ энэ ААН-үүдийг тэр стандарт руу нь хангадаг ийм эдийн засгийн бодлого хийх юм бэ? Уул уурхайгаас олж байгаа орлого чинь эдийн засагтаа буухгүй байгаад байна шүү дээ. Яагаад гэвэл боловсруулах салбар болон үйлчилгээ худалдааны салбар чинь унаад байна аа. Тэгэхээр энэ чинь бодитоор юу байгаа юм бэ гэж.

2 дугаарт энэ он энэ сарын эцсээр гэхэд хүнсний инфляц чинь 23, 24 хувьтай гарчихсан. Үүний гол нь мах болон хүнсний ногоо байгаа байх. Тэгээд нөгөө хотын даргыг чинь махны үнэ үнэтэй байна гээд огцруулчихсан шүү дээ. Тэгээд махны үнэ

чинь хэвээрээ л байгаа буугаагүй. Тэгээд одоо яах юм. Махны үнэ бууруулж чадаагүй гээд одоогийн Засаг даргаа дахиад огцруулах юм уу. Энэ одоо улс төрийн шийдвэрийг гэх юм уу ямар шийдвэрийг би ойлгоогүй. Тэгээд яг бодитоор ингээд бид нар иргэдийнхээ амьдралыг яг бодитоор мэдэж ингээд гудамжаар захуудаар явж үзмээр байгаа юмаа. Манай энэ ялангуяа төрийн албан хаагч нар дарга нар нь.

Б.Заяабал: 5 номерын микрофон нээе.

Ж.Энхбаяр: Япон ч тэр, Солонгос ч тэр, Европын холбоо ч тэр, тэр стандарт руу л бид нар зүтгэх ёстой. Хамгийн гол нь бид Засгийн газар тэр зах зээлийг л дотоодын ААН-үүддээ нээж байгаа. Нөгөө талдаа энэ чинь бас хөрөнгө оруулагчдад нээж байгаа байхгүй юу. Монгол Улсад та бараа бүтээгдэхүүн хөрөнгө оруулалтыг үйлдвэрлээд явуулбал бид нар Япон, Солонгос, Европын Холбоонд ийм таатай нөхцөлөө бид нар бүрдүүлж чадсан. Энэ маань бас нөгөө талдаа хөрөнгө оруулалтыг татаж нэг том хөшүүрэг болно оо гэж бодож байгаа. Тэгэхээр бид одоо тэр түвшинд хүрч өрсөлдөж сайжирч байж л хөгжинө. Тэгэхээр энэний төлөө л бид нар тасралтгүй л зүтгэх ёстой. Тэрнээс одоо Японы гэрээ муу болсон та нар муу байна гээд Японыг муу болгох стандартаа буулгах боломж байхгүй л дээ. Ер нь нөгөө тохиргоо нь нөгөө гэрээн дээр бас их сайжруулах олон бас нэг заалт хувилбарууд байгаа юм байна лээ. Энэ дээр манайх ажиллаад ингээд санал тавиад 2 талаасаа ингээд хэлэлцээрийн баг гараад ажлаа урагшлуулъя гэдэг дээр бол улс төрийн яриа хэл...

Б.Заяабал: Сэддорж гишүүн.

Р.Сэддорж: Энэ Тээврийн биржийн хууль дээр одоо энэ тээврийн асуудлыг яаж шийдэх вэ? Одоо ингээд бид хэд нэг өдөрт нэг айл дампуурч байхыг үгүйсгэхгүй шүү. Тэр 350 сая төгрөгөөр бол автомашин авчихсан. Тэгээд автомашин нь одоо явах ямар ч боломжгүй. Яагаад гэхээр биржийн хуулиар хамгийн бага үнийг гадаадын компани өгдөг өгнө өөр арга байхгүй. Тийм ашиггүй үнээр явахгүй. Тэгээд энийг одоо энэ хуулиар яаж шийдэх вэ? Энэ дээр гарц гаргалгаа хэлээч.

Дараагийн асуулт нь энэ төлбөрийн тэнцэл дээр нефтид хэдий хэр мөнгө гадагшаа гарч байна, хүнсэн дээр хэд байна. Биржийн хууль гарснаас хойш тээврийн тээвэр дээр хэдэн төгрөг гадагшаа гарч байна вэ? Тэгээд энийг тооцоог хэлээч. Миний сонссоноор 600 сая доллар гарсан. Тэр монгол тээвэрчдийн авах байсан орлого 600 сая доллар гэсэн ийм зүйл сонслоо энэ дээр хариулаач.

Б.Заяабал: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон нээе.

Ж.Энхбаяр: Хүнсний бүтээгдэхүүний импорт 1.2 тэрбум доллар байна. Шатах тослох материалын импорт 2.1 тэрбум доллар байна. Тэгээд л энийг бууруулах гээд л бид нар чинь Алтан ширээгийн нефть боловсруулах үйлдвэр, энэ хүнсний хувьсгал, Атрын 4 гээд ийм арга хэмжээнд хийгээд байна. Хүнсний импорт боломжийн бас буураад эсрэгээр нь бид бас хүнс экспортлох ийм зах зээл маань шинэ одоо нэлээн орон зай үүсээд эхэлчихсэн. Экспорт гаргаад эхэлчихсэн ААН-үүд байна. Ялангуяа махан дээр бид нар чинь сүүлийн 3 жил ингээд 300-аас дээш сая долларын мах экспортолдог болчихлоо. Яг тухайн тэр тээвэртэй холбоотой асуудлыг хуулиар шийднэ гэхээр нэг яаж ямар хуулиар шийдмээр юм бэ дээ. Танд ямар арга ухаан байна? Тэгээд энэ дээрээ та санал бодлоо гаргаад бүгдээрээ энэ орон нутгаас сонгогдсон гишүүдтэйгээ хамтраад нэг арга ухаанаа олно доо. Тэнд

үнэхээр анхаарал тавих ёстой гэдгээ ойлгож байдаг. Тэгээд шийдэл их жоохон хязгаарлагдмал. Тендер зарлачихсан байдаг. Бага үнэтэй ААН-үүд тээвэр хийгээд байдаг. Одоо үнэтэй хийлгэ гэлтэй биш. Тэгэх юм бол их үнэтэй тээвэр үнэтэй болчих юм бол нөгөө нүүрсний маань өрсөлдөх чадвар уначих гээд байдаг. Аль болох бид нар нөгөө зардлыг багасгаж, орлогыг нь нэмэгдүүл гэдэг шахалт үүрэг даалгавар өгөөд энэ ЭТТ компани удирдлагуудыг бол маш сайн шахаж ажиллаж байгаа шүү дээ. Хил гааль боомтыг бол байнгын тасралтгүй амралтгүй ажиллуулж байгаа шүү дээ. Тэгэхээр нэг ийм л юмны ингээд зөрчлүүд үүсээд байна. Тэгээд бүгдээрээ ярилцаж байгаад нэг арга ухаан олоод газар дээр нь очоод нэг ярилцаад тийм. Тэгээд нарийвчилсан судалгаануудыг авах хэрэгтэй. Хэчнээн автомашин байна. Тээврийн бололцоо даац хэд байна, хэд илүү байна, хэчнээн ажлын байр илүү гарч байна. Өр зээл юу байна. Тээврийн өртөг тооцоо яаж гарах нь вэ гээд ингээд судлах юмнууд их гарах нь ээ. Ийм л хариулт өгье дөө.

Б.Заяабал: Сэддорж гишүүний асуугаад байгаа тэр 600 сая доллар гэдэг нь үнэн үү гэдэг дээр 7 номер ажлын хэсгийн 7 номер уу, 6 номер.

Б.Мөнх-Эрдэнэ: Эдийн засгийн хөгжлийн яам Мөнх-Эрдэнэ. Гишүүний асуултад хариулъя аа. Асууснаар төлбөрийн тэнцлийн статистикаар бол 2023, 2024 онд тус бүр тээврийн зардал Монгол Улсаас 1.4 тэрбум доллар, 2025 онд 1.2 тэрбум доллар гарсан. Үүн дотор ачаа тээврээр гаднын компаниар үйлчлүүлсэн ачаа тээврийн зардал 2025 онд 1 тэрбум ам.доллар гарсан. Энэ нь өөрөө цаанаа импортын болон экспортын тээвэрт задардаг. Яг тухайлсан уул уурхайн компанийн тээврийн зардлын мэдээ байхгүй байна аа.

Ж.Энхбаяр: Нэг зүйл асуугаадахъя. Өмнөговьд одоо хятад жолоочтой тээвэр явахгүй байгаа гэж би мэдээлэлтэй байгаа шүү дээ.

Б.Заяабал: Би санал хэлье. Өнөөдөр манай эдийн засгийн нөхцөл байдал яг манай Эдийн засгийн байнгын хорооны яг онцгой анхаарах ёстой асуудал аа. Өнөөдөр яг эдийн засгийн бодит байдал бол инфляц 11.2 хувьтай өнгөрсөн 5 сарынх гарчихлаа. Энэ нь эргээд иргэдийн амьжиргаанд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа, сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа. Дотоод талдаа бид нар мах, хүнсний ногооны гол нөлөө үзүүлж байгаа гэж байгаа боловчиг гадаад талдаа импортын бараануудын үнийн өсөлт бид нарт нэлээдгүй бас нөлөө үзүүлж байгаа. Энэтэй холбоотой эдийн засагчдын ялангуяа энэ НҮБ-ын Худалдаа, эдийн засгийн хөгжил худалдаа хөгжлийн байгууллагаас гаргасан судалгаануудыг аваад үзэхэд энэ Ормузын хоолойтой холбоотой эдийн засагт ийм 3 үе шаттай ийм шок явагдана аа гэж ингэж үзээд байгаа юм. Эхний шат нь бол энэ бензин шатах үнийн үнэтэй үнийн өсөлттэй холбоотой, нийлүүлэлт нь саарсантай холбоотой. Энэ эхний ийм нөлөөллүүд орж ирнэ ээ. Энэний үр дүнд зардал өснө, зардлын өсөлт нь эргээд барааны үнийг өсгөнө, инфляцыг бий болгоно, төсөв санхүү дээр дарамтыг бий болгоно эргээд энэ эдийн засгийг удаашруулна гэсэн ийм эхний ийм давлагааны нөлөөллийг ярьж байгаа.

2 дугаар давлагааны нөлөөлөл нь бензин шатахуунаасаа гадна энэ бордооны асуудал дээр бас нөлөөллийг үзүүлнэ ээ гэдэг ийм асуудал яригдаж байна. Ялангуяа манай хүнсний бүтээгдэхүүн авдаг Зүүн Өмнөд Азийн тариалалт хаврын тариалалт энэ бордоо шатахуунтай холбоотойгоор нэлээдгүй өндөр үнэтэй болчихсон. Дээрээс нь бордооны хүртээмж бага байгаа. Нийлүүлэлт бага байгаа. За энэтэй холбоотой хаврын ургац Зүүн Азийн орнууд дээр бага байна аа гэсэн

ийм судалгаа жишээлбэл явагдаж байгаа. Энэнтэй холбоотой энэ бордооны гарсан энэ хямралтай холбоотойгоор намар ургац бага авна, бага авсан ургац нь үнэтэй болно. Энэнтэй холбоотойгоор Зүүн өмнөд Азиас жишээлбэл импортолж оруулж ирдэг хүнсний бараа бүтээгдэхүүнүүдийн үнэ өсөх ийм эрсдэл ялангуяа энэ эмзэг эдийн засагтай орнууд дээр нөлөөлнө өө гэсэн ийм судалгаануудыг явуулаад байгаа юмаа.

Зүүн өмнөд Азиас бид нарын авдаг гээд бодохоор л нөгөө цагаан будаа, ургамлын тос, элсэн чихэр гээд ингээд л олон хүнсний импортын бараануудыг бид нар хэлж болно. Энэ дээрээ бид нар манай Засгийн газар онцгой анхаарч энэ хаврын тариалалт намрын ургац авах чиглэл дээр онцгой анхаарч энэ намар ирэх хүнсний бараануудын энэ энэ хомсдол үнийн өсөлт дээр онцгой урьдчилан анхаарч, богино хугацааны болон дунд хугацааны бодлогын арга хэмжээ авч явуулах зайлшгүй шаардлага байна аа гэсэн ийм зүйлийг энд онцолж хэлье ээ.

Ингээд гишүүд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Эдийн засгийн хөгжлийн сайдын мэдээлэлтэй холбоотойгоор гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

18.40 цаг

Дараагийн асуултдаа оръё асуудалд оръё.

Ес.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж эхэлье. За горимын санал. Батнайрамдал гишүүн горимын санал гэсэн учраас горимын санал өгье. Батнайрамдал гишүүний микрофоныг нээе.

О.Батнайрамдал: Баярлалаа. Өнөөдөр Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн анхны хэлэлцүүлэг бид нар өглөө орж ирэхэд нөгөө ажлын хэсэг нь хуралдаж дуусаагүй сууж хойшлуулсан. Тэгэхээр үд яг ажлын хэсгээс санал нь энэ бараг 67 хуудас бүхий бараг 70-аад зарчмын зөрүүтэй санал орж ирж байна л даа. Тэгэхээр бид нар өнөөдөр Эдийн засгийн байнгын хороон дээр маш олон хууль хэлэлцээд яг үнэнийг хэлэхэд энийг харах ямар ч боломж олгосонгүй. Тэгэхээр энэ санал хураалтыг бид бүхэнд Эдийн засгийн байнгын хорооны гишүүдэд илүү цаг өгч ажиллах, ойлгох боломж олгооч ээ. Тэгэхээр энэ удаа горимын санал гаргаад дараагийн Эдийн засгийн байнгын хорооны хурал руу хойшлуулж өгнө үү гэж санал гаргаж байна. Байнгын хорооны гишүүд маань санал хураагаад дэмжиж өгнө үү.

Б.Заяабал: Сайнзориг гишүүн горимын санал. Сайнзориг гишүүний микрофоныг нээе.

П.Сайнзориг: Би Эдийн засгийн байнгын хорооны гишүүн биш ээ. Тэгээд энэ ажлын хэсгийн дэд ахлагч. Манай ажлын хэсгийн ахлагч Үүрийнтуяа дарга байж байна. Энэ хууль бол бас Эдийн засгийн байнгын хорооны маш онцгой анхаарах

хуулийн төсөл өө гэж би зүгээр хувьдаа бодож байгаа. Өргөн баригдаад 2021 оноос хойш энэ парламент дээр гацаж байгаа хууль. Тэгээд энийг онцгой анхаарч одоо ирэх 7 хоногт л анхны хэлэлцүүлгийг хийхгүй бол энэ хууль бас ингээд намар луу батлагдахгүй байх ийм магадлал руу орж байна аа. Мэдээж энэ хуулиудыг Нийтийн өмчийн хуультай уялдуулах асуудлыг ажлын дэд хэсэг болон холбогдох нөгөө ажлууд яаж байгаа хүмүүстэй уялдуулж байгаа. Шууд хууль маань батлагдаад хэрэгжихгүй ээ 1 дүгээрт.

2 дугаарт энэ хууль Үндсэн хуулийн 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлтийн дагуу нийцүүлж орж ирэх хуулиудын нэг байхгүй юу. 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт ороод 6.2 болон бусад зүйлүүд дээр хуулиудын өөрчлөлт орчхоод байдаг. Бүхэл бүтэн 7 жил энэ хуулиуд өөрчлөгдөхгүй явж байгаа. Бид Үндсэн хуулийн энэ агуулга үзэл санааг баталгаажуулах юм уу, үгүй юу гэдэгтэй холбоотой хууль байгаа юмаа. Тэгээд энийг зүгээр би Эдийн засгийн байнгын хорооны гишүүддээ онцгой анхаарч өгөөч.

За өнөөдөр одоо яах вэ та бүгд горимын санал гаргаад асуудлаа шийдэхэд бол хүндэтгэлтэй хандаж байна. Тэгэхдээ ингэж удаа дараа бас хойшлуулахгүй байх. Яг үнэндээ хэлэхэд энэ 29 хүнтэй ажлын хэсэг хуралдуулах гэж бас л хэцүү байсан шүү. Би энийг үнэндээ хэлчихье. Бараг ажлын хэсэг дээр одоо юу гэдэг юм нэг арайхийж 15, 16 гишүүнийг бүрдүүлээд явсан. Хамгийн дээд тал нь 18-уулаа ирсэн ийм л зүйл. Тэгээд 18 хүнтэй ажлын хэсэг дээр яг ирц л бүрдэх дээд тал нь боломж бол больдог юм байна лээ. Яг 20 гарч яаж байгаа юм алга. Тэгээд ер нь зүгээр байнгын хорооны гишүүд маань тэгээд анхаарч өгнө биз дээ. Энийг ингээд удаа дараа хойшлуулах, батлахгүй байх энэ зүйлүүд дээр бид хэд бас анхаарахгүй бол нөгөө ТӨК-ийн дагасан авлигал, ашиг сонирхол, улс төрийн томилгоо, алдагдал бүгд л яриад байгаа тэгээд энэ асуудал дээрээ бас нэг энэ мэргэжлийн хүмүүс нь ажилласан ингээд байж байгаа ийм л хууль шүү гэдэг зүйлийг би хэлье.

Тэгээд уг нь бол одоо тэгээд л байнгын хороонууд хэлэлцээд л явдаг, одоо шөнө өдөргүй хуралдаж байсан тохиолдлууд ч байдаг. Үнэхээр одоо яах вэ би ойлгож байна аа, хүндэтгэлтэй хандаж байгаа шүү Батнайрамдал гишүүн ээ. Тэгэхдээ өдөржингөө л боломж байлаа. Тэгээд яах вэ бүгд л ингээд орж гараад л мэдээж асуудлууд байгаа байх мэдэхгүй ээ бүгд тэгээд л ажиллаад л болж байгаа.

Б.Заяабал: Батнайрамдал гишүүний горимын саналаар санал хураалт явуулъя. Батнайрамдал гишүүний гаргасан горимын санал болох ажлын хэсгээс орж ирсэн томьёолол нь өнөөдөр ажлын хэсэг хуралдаж дууссан томьёолол ихтэй байгаа учраас бас уншиж танилцах шаардлага байна аа гэсэн ийм тийм учраас өнөөдрийн хэлэлцэх асуудлыг хойшлуулж өгнө үү гэсэн ийм горимын санал гаргасан. Уг горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалт хүчингүйд тооцъё. Гишүүд горимын саналтай холбоотой санал хураалтдаа бэлдэнэ үү. Санал хураалт явуулъя.

Батнайрамдал гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

53.8 хувийн саналаар уг санал дэмжигдсэн тул уг асуудал дараагийн байнгын хорооны хурал хүртэл хойшилж байна аа.

Өнөөдрийн Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Өнөөдрийн хуралдаанд идэвхтэй оролцсон Ажлын хэсгийн гишүүд, гишүүд, нийт гишүүддээ баярлалаа. Байнгын хорооны хуралдаан өндөрлөлөө.

18.57 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА